



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН
ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ-2018,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
(2016-2018)**

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛУУЛАВ	6
“АВЛИГА БА ХҮНИЙ ЭРХ” БАГА ХҮРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА	8
АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН БОЛОВ	10
АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ САЛБАР ХУРАЛДААН	11
АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ОНЦЛОХ ИШЛЭЛҮҮД	13
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛУУЛАВ	14
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	15
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭВ	16
АЖЛЫН БАГУУДЫН ХАРИУЦАН АЖИЛЛАХ САЛБАР, БАЙГУУЛЛАГА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ХУВААРЬ	18
ОРОН НУТАГТ АЖИЛЛАВ	26
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАВ	28
ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ	30
ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЯНАН ҮЗЭЖ БҮХЭЛД НЬ БҮЮУ ХЭСЭГЧЛЭН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАВ	34
ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ ХЯНАВ	36
МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЛИЙН МӨРӨӨР АЖИЛЛАВ	37
САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ ЖУРМЫГ МӨРДӨЖ ЭХЭЛЛЭЭ	38
СУРГАЛТЫГ ЦОГЦ БАЙДЛААР ЗОХИОН БАЙГУУЛАВ	39
АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТАД 8497 АЛБАН ТУШААЛТНЫГ ХАМРУУЛЛАА	42
ТУСГАЙЛСАН СУРГАЛТУУД	44
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА	46
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЯН	50
ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ	52
ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ	54
ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТЫН “ОЛОН НИЙТИЙН ТӨВ”-ИЙГ БАЙГУУЛЛАА	56
“ОЛОН НИЙТИЙН ТӨВ”-Д ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ	58
САР ТУТМЫН ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ	59
ОЛОН УЛСЫН СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАВ	60
ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	63
ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ТӨВ	64
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ЦАХИМ СИСТЕМИЙГ ШИНЭЧИЛЛЭЭ	66
ХАСХОМ-ИЙГ “БАТАЛГААНЫ МАЯГТААР”-ААР БҮРТГЭН ХҮЛЭЭН АВДАГ БОЛОВ	67

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОХГҮЙ БАЙХ ХУУЛИЙН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	68
ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖСӨН БАЙЖ БОЛОХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ХОМ-ИЙГ НАРИЙВЧЛАН ШАЛГАЖ БАЙНА	70
АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО НЭМЭГДСЭЭР БАЙНА	72
МӨРДӨН ШАЛГАХ ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ	73
ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО ХОЁР ДАХИН ӨССӨН	74
МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХЭРГИЙН ТОО 4,8 ДАХИН ӨССӨН	75
МӨРДӨН ШАЛГАСАН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ	76
ЭРҮҮГИЙН 224 ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ САНАЛТАЙ ШИЛЖҮҮЛЭВ	77
ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ	78
МӨРДӨН БАЙЦААЛТЫН ШАТАНД НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ 14,6 ТЭРБУМААР НЭМЭГДЖЭЭ	79
ОФШОР БҮСЭД БАЙРШУУЛСАН МӨНГӨ МОНГОЛ УЛСАД ОРЖ ИРЭВ	81
ДҮГНЭЛТ	82
САНАЛ	85
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ГАРЧ БУЙ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ	88
АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС	117
ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	118
УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА	121
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА	122
АВЛИГЫН ХЯНАЛТ	124
ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСНЫ ИНДЕКС	125
ГУРАВДУГААР БҮЛЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (2016-2018 он)	
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (2016-2018 он)	128
ДҮГНЭЛТ, САНАЛ	258

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛУУЛАВ

Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн үдээс өмнөх нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 91.1 хувийн саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоол батлагдав.



Монгол Улс 11 зорилт бүхий бодлогын баримт бичигтэй болж, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тодорхой стратегийн дагуу 2023 он хүртэл 2 үе шаттай явуулах боломж бүрдэв.

Авлигатай тэмцэх газар нь 2007 оноос ажиллаж эхэлсэн ч 2016 оны 11 дүгээр сарыг хүртэл хугацаанд авлигатай тэмцэх үндэсний хэмжээний бодлогогүй явж ирсэн. Өмнөх парламентад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэлэлцэн батлах хүсэл зориг үгүй байв. Харин УИХ нийгмийн бүх бүлэг, давхаргад хүрч үйлчлэх, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилготой АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-ийг баталсан билээ.



Зураг дээр баруун гараас: Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр, Авлигатай тэмцэх газрын дарга Х.Энхжаргал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Тамгын хэлтсийн дарга З.Баасанням нар. 2016.11.03

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

...Авлига хэмээх хорт үзэгдлээс ангижрахгүй байгаа гол шалтгаан бол түүнтэй тэмцэх цогц бодлого үгүйтэй холбоотой байсан гэж үзэж болно. Харин 2016 оны сонгуулийн дүнд байгуулагдсан, МАН олонх болсон УИХ ийм цогц бодлогыг батлах хүсэл эрмэлзэлтэй байх шиг. Уг нь АТГ-аас АН олонх болсон өнгөрсөн УИХ-д Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлуулахаар нэг бус удаа оруулсан ч тухайн үеийн эрх баригчид түүнийг чуулганаар битгий хэл, Байнгын хорооны хурлаар ч хэлэлцэхийг хүсээгүй.

...Энэ нэгдсэн бодлогын дагуу ажиллаж байж л Монголын нийгмийг хэрээд байгаа аалзны торыг устгах ажил үр дүнд хүрнэ. Хэн эрх барих нь хамаагүй, сонгуулиар хэн нэг нь гарч ирээд өөр зүйл амласан ч цаасан дээр буусан бодлогын баримт бичгийг л дагаж мөрдөх ёстой. Энэ хөтөлбөрийг баталснаар цаашид АТГ дангаараа тэмцэх биш, төрийн байгууллагууд, улстөрчид ч хийх зүйл их байгаа юм билээ.

Сэтгүүлч Г.Цолмонгийн нийтлэлийн хэсгээс
Эх сурвалж: **"Өнөөдөр" сонин.**
2016.10.12



“АВЛИГА БА ХҮНИЙ ЭРХ” БАГА ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Авлигатай тэмцэх газар, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран “Авлига ба хүний эрх” сэдэвт бага хурлыг Гадаад харилцааны яаманд зохион байгууллаа.

Авлигын үйлдэл нь хүний эрхийг хэрхэн зөрчиж байгаад дүгнэлт хийж, уг асуудалд иргэд, олон нийтийн анхаарлыг хандуулах нь уг бага хурлын гол зорилго байв.



...Авлигатай тэмцэх, хүний эрхийг хамгаалах асуудал нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд ерөнхий утгаараа “авлигатай тэмцэнэ гэдэг нь хүний эрх зөрчигдөхөөс хамгаалж буй хэрэг мөн” гэдгийг нэн түрүүнд тэмдэглэн хэлье.

Хууль зөрчсөн л бол хариуцлага хүлээдэг тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бид ажиллах ёстой. Асуудал тулгарахад таньдаг хүн хайдаггүй байх тийм хандлагыг бий болгох ёстой. Үүнийг төрийн албанд төдийгүй нийгмийн бүхий л хүрээнд таслан зогсоохын төлөө ажиллахыг нийгэм биднээс шаардаж байна. Авлигатай тэмцэх, хүний эрхийг хангах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бүх нийтийн оролцоо, дэмжлэг нэн чухал бөгөөд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд нэгдмэл сонирхолтой, албан тушаалтны улс төрийн хүсэл зориг өндөр байх нь шударга ёсыг бэхжүүлэх гол хүчин зүйл гэдгийг энд онцлон хэлье. Энэхүү үйл ажиллагаанд шүүх эрх мэдэл, хуулийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал өндөр ач холбогдолтойг тэмдэглэж байна.

“Авлига ба хүний эрх” бага хуралд

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар

Х.Энхжаргалын тавьсан илтгэлийн хэсгээс



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ



“Авлига ба хүний эрх” бага хурал. 2016.12.07

...Хуралд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга, УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар, АТГ-ын дарга Х.Энхжаргал, Ерөнхийлөгчийн амьдрах орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх О.Чулуунбилэг, Хууль зүйн сайд С.Бямбацогт, УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, Л.Оюун-Эрдэнэ болон АТГ, прокурор, Улсын дээд шүүх, ХЭҮК-ийн албан хаагчид оролцож байна.

Бага хуралд “Хүний эрхийг хангах эрх зүйн зохицуулалт”, “Хүний эрх ба авлигатай тэмцэх бусад улсын туршлага”, “Авлига, албан тушаалын гэмт явдлаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад шүүхийн гүйцэтгэх үүрэг, анхаарах зарим асуудал”, “Хүний эрх ба авлига”, “Шударга ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалахад прокурорын үүрэг оролцоо” зэрэг сэдвээр Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Авлигатай

тэмцэх газар, “Эмнести интернэшнл төв” төрийн бус байгууллагын төлөөлөл илтгэл тавьж, хэлэлцүүлж байна.

АТГ-аас авлигатай тэмцэх үйл хэрэгт иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэг, хяналтыг бий болгоход анхаарч байна. Иймд авлигын эсрэг олон улсын өдрийг угтан гааль, татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэндийн байгууллагууд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, авлигатай тэмцэхэд иргэд, олон нийтийн хяналт харилцааг хангах, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах зорилгоор орон нутагт ажилласан юм. Мөн иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид, оюутан, сурагчид буюу олон нийтийг хамруулан илтгэлийн уралдаан, парламентын мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулсан байна.

**ТВ5 телевизийн сэтгүүлч, тоймч
Ө.Отгонбаатарын мэдээллээс. 2016.12.07**





АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН БОЛОВ



Авлигын эсрэг үндэсний чуулган. 2017.01.11

Авлигатай тэмцэх газар үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойгоо ажил хэрэгч, бүтээлч байдлаар тэмдэглэн өнгөрүүлэх хэрээнд авлигатай үр дүнтэй тэмцэх чиглэлээр асуудал дэвшүүлэн, шийдвэрлэх арга замаа тодорхойлж, цаашид нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллах зорилгоор 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн ордонд “Авлигын эсрэг үндэсний чуулган”-ыг зохион байгуулав.

Уг арга хэмжээнд Улсын Их Хурлын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нар оролцсон бөгөөд Улсын Их Хурлын гишүүд, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд, иргэний нийгмийн болон хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид хуран чуулж, авлигын эсдвээр тулгамдсан асуудал, бэрхшээл бүхнийг салбар тус бүрийн түвшинд хэлэлцэж, шийдвэрлэх арга замаа тодорхойлон ярилцав.

“Авлигатай тэмцэх асуудал ямагт нарийн

төвөгтэй, үргэлж бэрхшээл, саадтай байгаа хэдий ч цаашдын ажлын үр дүн ард түмний хүсэл зориг, хүчин чармайлт, чин сэтгэл, шударга үйлдлээс хамаарах тул нэгэн итгэлээр хамт зүтгэцгээе” хэмээн Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал илтгэлийнхээ төгсгөлд уриаллаа.

Үндэсний чуулган нь “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа”, “Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын оролцоо” гэсэн 4 салбар хуралдаанаар үргэлжиллээ. Салбар хуралдаануудыг Шадар сайд У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Сарангэрэл, Ц.Цогзолмаа нар даргалан явуулав.

АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ САЛБАР ХУРАЛДААН

Авлигын эсрэг үндэсний чуулган нь “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа”, “Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын оролцоо” гэсэн 4 салбар хуралдаанаар үргэлжилсэн юм.

I САЛБАР ХУРАЛДААН:



Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа (Их танхим)

Салбар хуралдааныг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд даргалав.

Хэлэлцүүлсэн илтгэл, сэдэв:

1. Авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлэх нь
2. Шүгэл үлээгчийн асуудал
3. Олон улсын сайн туршлага, санаачилга
4. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа:
Эрх зүйн харилцан туслалцаа, хөрөнгө буцаах асуудал
5. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудал
6. Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал

II САЛБАР ХУРАЛДААН:

Хэлэлцүүлсэн илтгэл, сэдэв:

1. Төрийн албаны томилгооны асуудал
2. Худалдан авах ажиллагааны ил тод байдал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь
3. Цахим үйлчилгээг хөгжүүлэх нь
4. Олон улсын сайн туршлага, санаачилга
5. Төрийн албан хаагчдын шударга байдал ба авлигад өртөх эрсдэл



Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал (Их Эзэн Чингис хаан танхим)

Салбар хуралдааныг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх даргалав.



АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ САЛБАР ХУРАЛДААН

Авлигын эсрэг үндэсний чуулган нь “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа”, “Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын оролцоо” гэсэн 4 салбар хуралдаанаар үргэлжилсэн юм.

III САЛБАР ХУРАЛДААН:



Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал (Жанжин Д.Сүхбаатар танхим)

Салбар хуралдааныг УИХ-ын гишүүн Ц.Цогзолмаа даргалав.

Хэлэлцүүлсэн илтгэл, сэдэв:

1. Бизнесийн ёс зүй
2. Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа, үнэлгээ хийх олон улсын туршлагаас
3. Шударга өрсөлдөөнийг дэмжих нь
4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх асуудал
5. Олон улсын сайн туршлага

IV САЛБАР ХУРАЛДААН:

Хэлэлцүүлсэн илтгэл, сэдэв:

1. Авлигын тухай шинжлэх ухааны танин мэдэхүй ба иргэний боловсрол
2. Эрх мэдэл, их мөнгийг хянах нь: Авлигатай тэмцэхэд хараат бус хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг
3. Иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг нэмэгдүүлэх нь
4. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, өнөөгийн хөгжил
5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох нь
6. Олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох талаарх олон улсын туршлага



Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагын оролцоо (“В” танхим)

Салбар хуралдааныг УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл даргалав.


АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ОНЦЛОХ ИШЛЭЛҮҮД

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал:



...Бид авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол мэдээллийг хүлээн аваад үнэн, худлыг тогтооход цаг хугацаа, бусад олон хүчин зүйл нөлөөлөхийг үл харгалзан шалгах хэдий ч хэн нэгний нэр хүндийг үндэслэлгүйгээр унагах, олон түмний сэтгэл зүйг төөрөгдүүлэхгүй байх үүднээс хууль зөрчсөн нь тогтоогдоогүй хүмүүсийн эсрэг сөрөг мэдээлэл тархан, нэр төрд нь халдахаас сэргийлж анхааралтай ажиллах болно...

СЭЗИС-ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш, доктор Б.Эрдэнэдалай:




...Монголын нам, нэр дэвшигчид хэрхэн санхүүждэг талаар нарийвчилсан судалгаа, ном, материалууд төдийлөн хангалттай бус, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа дутмаг байгаа бөгөөд иргэдийн өндөр түвшний авлигын талаарх ойлголт хангалтгүйгээс гадна авлигаас сэргийлэхэд иргэдийн оролцоо зайлшгүй чухал гэдгийг сурталчлах, судлах, өнөөдөр бий болоод байгаа үлс төрийн нам, нэр дэвшигчдийн санхүүжилтийн асуудлыг хуулийн хүрээнд өндөр түвшний авлигаас ангид байхаар зөв замаар шийдвэрлэх хэрэгтэй байна...

Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх Г.Эрдэнэбат:




...Эрх мэдэлтэй, мөнгөтэй, нийгэмд нөлөөлөх бүхий л арга хэрэгслийг хяналтдаа байлгадаг авлигачидтай тэмцэхэд зөвхөн хууль сахиулагчдын мөрдөн шалгах ажиллагааны арга хэрэгслүүд хангалтгүй бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх шууд чиг үүргийг хүлээдэггүй бусад төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагын хүч дэмжлэг гарцаагүй чухал юм...

УИХ-ын гишүүн Х.Нямбаатар:



...Авлигатай тэмцэх байгууллагынхаа чадавхийг бэхжүүлбэ, хийж байгаа ажлынх нь зөвийг дэмжээд бурууг нь засаад явъя...

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Л.Нямгэрэл:



...Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бас нэг гол хэрэгсэл бол хэвлэл мэдээллийн байгууллага бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хор холбогдлыг олон нийтэд таниулах, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сэргэмжлүүлэх чиглэлээр нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх, сурталчилгаа явуулах ажлыг зорилгоо болгож ажиллахын сацуу гэмт хэргийг сурталчилсан, гэмт үйлдэл үйлдэх арга замыг харуулсан, уриалан дуудсан агуулга бүхий контент хийхгүй, нэвтрүүлэхгүй байх зарчмыг хатуу баримтлах ёстой...

Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга М.Оюунчимэг:



...Төр, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хамтран хэрхэн яаж авлигагүй нийгмийг бий болгохын төлөө ажиллах, гарц, шийдэл юу байгааг тодорхойлох шаардлагатай байна. Үүний нэг шийдэл нь төрийн хүнд суртлыг арилгах, шат дарааллыг багасгах, цаашлаад төрийн хийж чадахгүй байгаа, хугацаа, хүч хөрөнгө ихээхэн зарцуулж, олон нийтийг чирэгдүүлдэг гэж хэлж болохоор ажлуудыг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод тодорхой шалгуур, шаардлагатай нөхцөлийн үндсэн дээр шилжүүлэх буюу гэрээгээр гүйцэтгүүлж иргэд болон хувийн хэвшилд хурдан шуурхай хүрч ажиллах юм...

"Өмгөөллийн Юник Легаль Партнерс" ХХН-ийн захирал Р.Очирбал:



...Авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйг бий болгох чиглэлд эрс шинэчлэл, манлайлал үгүйлэгдэж байна. Нийгмийн ёс суртахууны доройтол, авлигын өсөлт нь хоорондоо шууд хамааралтай учир ёс зүйтэй, шударга ёсыг эрхэмлэсэн иргэдийг бий болгох чиглэлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын хүчин чармайлт хамгийн ихээр хүсэмжлэгдэж байна. Ёс зүйтэй иргэн авлигын эсрэг хүчтэй тэмцэгч байж чадна. Иргэд авлигын эсрэг үйл ажиллагааны үр шимийг хүртэгч идэвхгүй субъект байж болохгүй...



ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛУУЛАВ

Авлигатай тэмцэх газраас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, тэдний саналыг тусган боловсруулж, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлуулав.



Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасан 216 арга хэмжээг хэрэгжүүлэхэд Авлигатай тэмцэх газар арга зүйн зөвлөмж өгөх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах зэргээр голлох үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

“Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл”-ийг боловсруулсан үе шат

1

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжиж эхлэх үеийн гарааны нөхцөл байдлыг тодорхойлохоор яам, агентлаг, аймаг, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд ажиллав.

2

Төрийн бүх шатны байгууллага дахь авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг тогтоосон байна.

3

Сэдэвчилсэн хэлэлцүүлгүүдийг өрнүүлэн иргэд, олон нийтийн саналыг авав.

4

“Авлигын эсрэг үндэсний чуулган”-д оролцогчдоос гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэж хургуулав.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” явдал бөгөөд уг зорилгод хүрэхээр 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт

1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх
2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх
3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх
4. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх
5. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах
6. Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх
7. Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих
8. Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх
9. Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх
10. Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх
11. Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх



ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ШИЛЖҮҮЛЭВ

Байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын алба”-ыг байгуулснаар тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, Засгийн газраас баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах боломж бүрдэв.

Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын алба /цаашид “Ажлын алба”/ ажиллана. Ажлын алба хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санал зөвлөмж, аргачлал боловсруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд, олон нийтэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэх, хэрэгжилтийн байдлыг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Ажлын албанд хүргүүлнэ. Авлигатай тэмцэх газар тайланг нэгтгэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал дүгнэлтээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна



“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын алба”-ны хамт олон 2017 он



“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын алба”-ны хамт олон 2019 он



2017

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2017 оны гүйцэтгэл, үр дүнг үнэлж, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг дээшлүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 2017 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 114 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийн, холбогдох санал, дүгнэлтийг 2017 оны Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын танилцуулгын хамт товхимол хэлбэрээр бэлтгэж Улсын Их Хуралд хүргүүлэв.

2018

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын танилцуулгыг, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2017 оны тайлан, 2018 оны төлөвлөгөөний биелэлт, Авлигатай тэмцэх газрын ажлын багуудын 2017, 2018 онд яам, агентлаг, төрийн өмчит байгууллагуудад ажилласан тайлан, холбогдох бусад мэдээллийн хүрээнд нэгтгэн боловсруулав.



АЖЛЫН БАГУУДЫН ХАРИУЦАН АЖИЛЛАХ САЛБАР, БАЙГУУЛЛАГА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ХУВААРЬ

Авлигатай тэмцэх газрын нийт албан хаагчдыг 7 багийн бүрэлдэхүүнд хуваарилан томилж, үйл ажиллагааг нэгдмэл байдлаар явуулах нөхцөлийг бүрдүүлээ.



Э.Идэрцог ахлагчтай 1 дүгээр баг.

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
 - Биеийн тамир, спортын газар
 - Соёл, урлагийн газар
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Архангай аймаг
- Хөвсгөл аймаг
- Орхон аймаг
 - Сонгинохайрхан дүүрэг
- Улсын Их Хурлын Тамгын газар
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
- Хүний эрхийн үндэсний комисс
- Эрдэнэт үйлдвэр
- Монгол кино нэгтгэл
- Буянт-Ухаа спорт ордон
- Техник спортын төв
- Эрдэнэтийн ДЦС
- Эрдэнэт Булганы ЦТС
- Хөвсгөл дулааны станц
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 11

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-2 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-3 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-5 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-1 ажилтан



Х.Хашбаатар ахлагчтай 2 дугаар баг.

- Барилга, хот байгуулалтын яам
 - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
- Зам, тээврийн хөгжлийн яам
 - Иргэний нисэхийн ерөнхий газар
- Эрчим хүчний яам
 - Эрчим хүчний зохицуулах хороо
 - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
- Хэнтий аймаг
- Дорнод аймаг
- Сүхбаатар аймаг
 - Багануур дүүрэг
- МИАТ ТӨХК
- Монголын төмөр зам
- УБТЗ ХК
- УБДС ТӨХК
- ТОСК
- УБЦТС
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК
- Эрчим хүчний хөгжлийн төв
- Дулааны цахилгаан станц-2
- Дулааны цахилгаан станц-3
- Дулааны цахилгаан станц-4
- Диспетчерийн үндэсний төв
- Зам, тээврийн хөгжлийн төв
- Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ
- Авто тээврийн үндэсний төв
- Авто-Импекс ХК
- Багануур ХК
- Дорнод бүс ЭХС
- Багануур-Зүүн өмнөд бүс ЦТС
- Багануурын ДЦС
- Барилгын хөгжлийн төв
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 12

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-2 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-3 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-3 ажилтан



Г.Азжаргал ахлагчтай 3 дугаар баг. Албаны дарга Ц.Шинэбаяр.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
 - Цаг уур, орчны шинжилгээний газар
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
 - Мал эмнэлэг, үржлийн ерөнхий газар
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
 - Ашигт малтмал, газрын тосны газар

- Төрийн албаны зөвлөл

- Дундговь аймаг
- Өмнөговь аймаг
- Өвөрхангай аймаг
 - Баянзүрх дүүрэг
 - Багахангай дүүрэг

- Эрдэнэс Монгол ХХК
- Хөдөө аж ахуйн бирж ХХК
- Монголросцветмет ХХК
- Эрдэнэс Оюу толгой ХХК
- Эрдэнэс Таван толгой ХК
- Гашуун сүхайд авто зам ХХК
- Оюу толгой ХК
- Эрдэнэс метан ХХК
- Эрдэнэс шивээ Энержи ХХК
- Мон-Атом ХХК
- Эрдэнэс Ашид ХХК
- Эрдэнэс стийл ХХК
- Эрдэнэс ассет менежмент
- Тавантолгой ХК
- Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ
- Геологийн төв лаборатори
- Геологийн судалгааны төв
- Шингэн түлш шилжүүлэн ачиг байгууламж ТӨҮГ
- Гермон газ ХХК
- Эгийн голын ҮЦС
- Аялал жуулчлалын хөгжлийн төв
- Хөдөө аж ахуйн давхар даатгал
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд Шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
- Биокомбинат ТӨҮГ
- Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори
- Монгол Үс ТӨҮГ
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 15

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-4 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-2 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-5 ажилтан



Т.Төгөлдөр ахлагчтай 4 дүгээр баг.

- Сангийн яам
 - Гаалийн ерөнхий газар
 - Татварын ерөнхий газар
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
 - Үндэсний хөгжлийн газар

- Баянхонгор аймаг
- Говь-Алтай аймаг
- Завхан аймаг
 - Баянгол дүүрэг

- Монголбанк
- Үндэсний аудитын газар
- Үндэсний статистикийн хороо
- Санхүүгийн зохицуулах хороо

- Төрийн банк
- Хөгжлийн банк
- Арилжааны төлбөр тооцоо
- Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв ТӨҮГ
- Хадгаламжийн даатгалын корпораци
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
- Монголын хөрөнгийн бирж
- Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 11

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-2 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-2 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-2 ажилтан
Тамгын хэлтэс-1 ажилтан



Л.Сүх-Очир ахлагчтай 5 дугаар баг.

- Гадаад харилцааны яам
- Батлан хамгаалах яам
 - Зэвсэгт хүчний жанжин штаб
 - Онцгой байдлын ерөнхий газар
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
 - Стандарт, хэмжил зүйн газар
 - Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
 - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар
 - Харилцаа, холбооны зохицуулах хороо

- Ховд аймаг
- Баян-Өлгий аймаг
- Увс аймаг
 - Чингэлтэй дүүрэг

- Сонгуулийн ерөнхий хороо

- Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар
- Батлан хамгаалах Аж үйлдвэрийн нэгдэл
- Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ
- Монголын цахилгаан холбоо
- Мэдээлэл холбооны сүлжээ
- Монгол Шуудан ТӨХК
- Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК
- Ховд дулааны станц ТӨХК
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 13

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-3 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-4 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-2 ажилтан



Ц.Цэцэгдэлгэрэх ахлагчтай 6 дугаар баг.

- Хууль зүй, дотоод хэргийн яам
 - Цагдаагийн ерөнхий газар
 - Хил хамгаалах ерөнхий газар
 - Улсын бүртгэлийн ерөнхий газар
 - Архивын ерөнхий газар
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
 - Гадаадын иргэн, харьяатын газар
 - Оюуны өмчийн газар
 - Тагнуулын ерөнхий газар

- Булган аймаг
- Дархан-Уул аймаг
- Сэлэнгэ аймаг
 - Сүхбаатар дүүрэг

- Улсын Ерөнхий Прокурорын газар
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Улсын дээд шүүх
- Үндсэн хуулийн цэц

- Цагаан шонхор ТӨҮГ
- Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК
- Дарханы дулааны сүлжээ
- Дулаан шарын гол ТӨХК
- Булган Хангал спорт бэлтгэлийн төв ТӨҮГ
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 12

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-2 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-4 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-2 ажилтан



Т.Баярхүү ахлагчтай 7 дугаар баг.

- Эрүүл мэндийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
 - Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
 - Нийгмийн даатгалын ерөнхий газар
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
 - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

- Төв аймаг
- Говьсүмбэр аймаг
- Дорноговь аймаг
 - Хан-Уул дүүрэг
 - Налайх дүүрэг

- Ерөнхийлөгчийн Тамгын газар
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

- Уламжлалт анагаах ухаан үйлдвэрлэлийн корпораци
- Шивээ-Овоо ХК
- Монгол газрын тос боловсруулах үйлдвэр
- Налайх дулааны станц
- Орон нутаг дахь АЗЗА
- Бусад байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд

Багийн гишүүд 11

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс-3 ажилтан
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс-2 ажилтан
Мөрдөн шалгах хэлтэс-4 ажилтан
Гүйцэтгэх ажлын хэлтэс-2 ажилтан

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх

АЖЛЫН 7 БАГ

үндсэн чиглэл



Ажлын багууд яам, агентлаг, аймаг, сум, дүүрэг, төрийн өмчит хуулийн этгээд гээд төрийн бүх шатны байгууллагыг хуваан хариуцаж, тэдгээртэй байнга хамтран ажиллаж байна.



2017 онд Авлигатай тэмцэх газрын ажлын багууд 21 аймаг, 94 сум, 11 яам, 27 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүргийн 94 байгууллагад ажиллаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны нөхцөл байдлыг тодорхойллоо.



Ц.Цэцэгдэлгэрэх ахлагчтай 6 дугаар баг Сэлэнгэ аймагт ажиллав

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын багууд 2016-2018 онд 21 аймаг, 140 орчим суманд нийт 3 удаа томилолтоор ажиллав.



3 дугаар багийн гишүүд Завхан аймагт ажиллалаа



Багийн гишүүд төрийн байгууллагуудад ажилласан тайлангаа илтгэж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөлдөн ярилцдаг

БАГУУД ЮУ ХИЙВ?



Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь эхлүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.



Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан тушаалын томилгоотой танилцан, дүн шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, зөвлөгөө чиглэл өгч байна.



Албан тушаалтны гаргасан мэдүүлэг, мэдэгдэл, бичгээр гаргасан тайлбар зэрэгтэй танилцаж, дүгнэлт хийж, зөрчил, дутагдлыг арилгуулан ажиллаж байна.



Төрийн үйлчилгээ үзүүлж буй өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, зөвлөмж чиглэл өгч байна.




Тухайн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, тэдгээрийн агуулга, шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



БАГУУД ЮУ ХИЙВ?



Төрийн байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, тушаал шийдвэрийг хянаж, хууль зүйн үндэслэл, хүнд суртал чирэгдэл, шат дамжлага үүсгэсэн эсэх, давуу байдал, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бий болгосон эсэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байдалтай танилцаж, санал дүгнэлт боловсруулав.



Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлж, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаж байна.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалтай танилцаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр ажиллаж байна.



Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн албан бичиг, Мөрдөгчийн мэдэгдэл, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажилтай танилцаж, дүгнэлт хийх, зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав.



Т.Төгөлдөр ахлагчтай 4 дүгээр баг Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудад иргэний хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулав



Орон нутагт хэрэгжүүлсэн шалган туслах ажлын дүнг 21 аймаг, сумдын удирдлагуудад танилцуулах онлайн хурал хийж хэвшив



Х.Хашбаатар ахлагчтай 2 дугаар баг орон нутагт шалган туслах ажлыг хийж байгаа нь

“Төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг хангаагүй байна” гэсэн дүгнэлтийг Авлигатай тэмцэх газрын ажлын багууд хийжээ.

Төрийн бүх шатны байгууллагын удирдах албан тушаалтнуудад шалгалтын дүнг танилцуулж, Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, шалган туслах ажлыг эрчимжүүлсэн, салбар бүрт авлигын нөхцөл байдлын талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.


ОРОН НУТАГТ АЖИЛЛАВ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Авлигатай тэмцэх газрын ажлын багууд 2016-2018 онд 21 аймаг, 140 орчим суманд нийт **3** удаа албан томилолтоор ажиллалаа.



Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Хяналт шалгалтын албаны дарга, ахлах комиссар Л.Сүх-Очир ахлагчтай баг Булган аймагт ажиллаж байгаа нь 2018.10.27

ОРОН НУТАГТ АЖИЛЛАСАН БАЙДАЛ (оноор)



2017-2018 онд
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
7 баг
21 аймаг,
144 суманд
томиллолтоор ажиллав

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор 2018 онд 21 аймаг, 50 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулав.

НИЙТ СУМДЫН
43.6 хувьд хүрч ажилласан байна

ОНЦЛОХ:

2015 ОНД Томиллолын онцлог нь цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулж ажилласнаар урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах шалгалтад хамрагдсан байгууллага, аймаг, сумдын тоо өмнөх онуудтай харьцуулахад даруй 3 дахин нэмэгдсэн байна.

2016 ОНД Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчилж, төрийн албанд олон нийтээс тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 5400 орчим иргэнд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

2017 ОНД 21 аймаг, 94 суманд ажилласан дүнг аймгийн удирдах албан тушаалтнуудад танилцуулах онлайн хурлыг зохион байгуулж тогтоогдсон нөхцөл байдлыг танилцуулж, харилцан санал солилцов.

2018 ОНД 21 аймаг, 50 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АЖИЛЛАВ

Авлигатай тэмцэх газрын ажлын багууд хариуцсан яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тодорхой удирдамжийн дагуу ажиллан, зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, төсөв, санхүүгийн ил тод байдал, албан хаагчдын ёс зүй, хүний нөөцийн бодлого зэрэг үйл ажиллагаатай танилцаж, шалган туслах ажлыг гүйцэтгэв.



Шалгалтын ажлын удирдамж гардуулах арга хэмжээ 2018.03.02

Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон зарим төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх багуудаас хариуцсан салбар, байгууллагад ажиллах шалгалтын ажлын удирдамжийг гардуулах арга хэмжээг зохион байгуулав.

Уг арга хэмжээнд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Ерөнхий аудитор Д.Хүрэлбаатар, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо нар оролцов. Удирдамжийн дагуу Авлигатай тэмцэх газрын ажлын багууд хариуцсан яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд ажиллан, зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, төсөв, санхүүгийн ил тод байдал, албан хаагчдын ёс зүй, хүний нөөцийн бодлого зэрэг үйл ажиллагаатай танилцаж шалган туслах ажлыг гүйцэтгэв.





Төрийн бүх шатны байгууллага дахь шалган туслах ажлыг Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газартай хамтран гүйцэтгэв.



Яам, агентлагийн удирдлага, төлөөллийг оролцуулан 16 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.



Шалган туслах ажлын дүгнэлтийг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг 12 яамны Төрийн нарийн бичгийн дарга нар болон бусад эрх бүхий албан тушаалтнууд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 9 дүүрэг, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн эрх бүхий албан тушаалтнуудыг тус тус оролцуулан зохион байгууллаа.



Хяналт үнэлгээний явцад тогтоогдсон нөхцөл байдлыг танилцуулан, санал солилцож, зөвлөмж өгөв.

Яам, агентлагт ажиллах явцад өмнөх жилүүдэд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, авлига үүсэх нөхцөл боломж бүрдүүлсэн дүрэм, журмыг хүчингүй болгох чиглэлээр Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 оны 12 дугаар сард хүргүүлсэн 159 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 61 хувьтай байв.





ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Яам, агентлаг, төв, орон нутгийн төрийн бусад байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, авлигын эрсдэлийг бууруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 13 яамны сайд нарт болон Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд нарт авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Зөвлөмжийг гардуулан өглөө.



Авлигатай тэмцэх газраас Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 онд хүргүүлсэн **159** асуудал бүхий **ЗӨВЛӨМЖ**-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг тооцох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн ИТХ-ын дарга,
Засаг дарга нарт хүргүүлсэн
Зөвлөмжийн хэрэгжилт
40 хувьтай байна.

Өгсөн зөвлөмжийн дагуу зарим ажлууд жигдэрч, ахиц дэвшил гарч байна:



Эрх хэмжээгээ хэтрүүлэн баталж мөрдүүлсэн дүрэм, журам, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон шийдвэрүүд зохих түвшинд буурсан (50 гаруй шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авагдсан, оны эцэст 48 шийдвэрийг хүчингүй болгохыг зөвлөсөн).



Төрийн болон нутгийн захиргааны ихэнх байгууллагууд өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй утсыг ажиллуулах, цахим хуудсаар гомдол, мэдээлэл хүлээн авах чиглэлээр тодорхой ажлуудыг хийснээр ахиц гарсан.



2017 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулахаар ирүүлсэн тоо 844 байсан бол 2018 онд 211 болж буурсан.



Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан (А-3 сертификат бүхий)-ы тоо 2018 онд 4161 хүнээр нэмэгдэж, гэрчилгээ бүхий хүний тоо нийт 12970-д хүрч 3.1 дахин нэмэгдсэн.



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс 2017 онд нийт зарласан тендерийн 30 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулж байсан бол 2018 онд цахим системийн хэрэглээ өмнөх оноос 62.3 хувиар нэмэгдсэн болно.

ОРОН НУТАГТ ИЛЭРЧ БҮЙ ЗӨРЧЛҮҮД


Нөөц хөрөнгийн зарцуулалт дутагдалтай

- Зарим аймаг, сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмыг батлан орон нутгийн төсөвт хөрөнгө тусгаж, Засаг даргын нэгэн адил хөрөнгө захиран зарцуулж байна.
- Худалдан авах хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшээгүй, хяналт, ил тод байдлыг сайжруулах, цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх чиглэлээр ахиц гараагүй.
- Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоо дутмаг.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулдаггүй.

Үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, үр дүн хангалтгүй

- Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн цахим сан үүсгэж үйл ажиллагаандаа ашиглах замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй.
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, компанийн засаглалыг төлөвшүүлэх, төсөв, санхүү, худалдан авалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй.
- Биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ашигт малтмалын олборлолт (хоягдал нөөц ашиглах) явуулан түүнээс хандив авч, орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг.
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг байгуулахдаа хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр дагаврыг сайтар тооцдоггүй, хуулийн этгээдүүд нь үр ашиггүй ажиллаж, орон нутгийн төсвөөс татаас авдаг явдал нийтлэг болсон.

Сайд нарт зөвлөмжийг гардуулан өгөв





ОРОН НУТАГТ ИЛЭРЧ БУЙ ЗӨРЧЛҮҮД

Хүний нөөцтэй холбоотой шийдвэр, үйл ажиллагаа нь хууль бус

- Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгодоггүй.
- Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлдөг, үүний улмаас их хэмжээний төсвийн хөрөнгө нөхөн төлбөрт зарцуулагддаг.

Мэдэгдэл, тайлбар, мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг гаргадаггүй

- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилдог, томилсны дараа хянуулдаг.
- Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж хэвшээгүй.
- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргадаггүй, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийдэггүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлээгүй.
- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсч болзошгүй тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбар гаргаж ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг биелүүлж ажилладаггүй.

Зөвлөмж нь авлигын түвшинг бууруулах, эрсдэл үүсгэх хүчин зүйлийг арилгах, илэрсэн зөрчил дутагдлуудыг давтан гаргахгүй байх зорилготой юм.

Сайд нарт зөвлөмжийг гардуулан өгөв



ОРОН НУТАГТ ИЛЭРЧ БҮЙ ЗӨРЧЛҮҮД

Албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа ашиг сонирхлын зөрчилтэй

- Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцаа, хандив авах, хүсэхийг хориглосон хууль тогтоомжийг мөрдөж ажилладаггүй.
- Сахилга, ёс зүйн зөрчил болон өргөдөл, гомдолд дүн шинжилгээ тогтмол хийж, зөрчил дутагдлын шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ил тод байдлыг хангах арга хэмжээг авч ажиллаагүй.
- Хуульд эрх хэмжээ олгоогүй байхад хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлдэг, хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй атлаа дүрэм, журам батлан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг журамлах, төлбөр, хураамж тогтоож хураан авах зэрэг зөрчил нийтлэг гарч байна.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хангалтгүй

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд дангаар хариуцан болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг зохион байгуулаагүй, биелэлтийг хангаж ажиллаагүй, үр дүнг цахим хуудсанд байршуулаагүй, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлээгүй байна.

Сайд нарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Сайд нарт зөвлөмжийг гардуулан өгөв



ДҮРЭМ, ЖУРМЫГ ХЯНАН ҮЗЭЖ БҮХЭЛД НЬ БУЮУ ХЭСЭГЧЛЭН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАВ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаандаа баримтлах гол арга зүй, гарын авлага болгох зорилгоор Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/183 тушаалаар “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ыг баталсан ба дотооддоо хяналт тавих, бүртгэлжүүлэх, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд төрийн байгууллага, алба тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм журмыг хянах бүртгэлийн системийг боловсруулан дуусгаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

Авлига гарч болох нөхцөл боломжийг бүрдүүлсэн, хүнд суртал, чирэгдэл учруулсан, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй

Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”

Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаал


Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын Б/36 дугаар тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”

Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”

Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2009 оны 28/01 дүгээр тэмдэглэл

Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/18 дугаар тушаал

зэрэг **50** гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох арга хэмжээг авлаа.



Дүрэм журмыг хянах бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв

Дүрэм журам хүчингүй болгосон, өөрчилсөн дүнг аймгуудаар харуулбал:

ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт **48** дүрэм, журмыг хянан үзэж хүчингүй болгох, өөрчлөх саналыг хүргүүлээд байна

Баянхонгор



Говь-Алтай



Өвөрхангай



Завхан



Өмнөговь



Дундговь



Увс



Баян-Өлгий





ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ ХЯНАВ

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д заасан үүргийн дагуу байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн Ёс зүйн дүрмийн төслийг хянан үзэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига үүсэх эрсдэлийг бууруулах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны хүнд суртлыг халах, хуулиар хамгаалагдсан байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах зэрэг чиглэлээр холбогдох санал хүргүүлсэн байна.

Тухайлбал,



Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээлэл болон авлигын шинжтэй аливаа үйлдлийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх;

Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн албаны болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг өөрийн хамаарал бүхий этгээдийн болон бусдын ашиг сонирхлын төлөө хууль бусаар задруулж, ашиглахгүй байх, албан ёсны шийдвэр гараагүй аливаа асуудлын талаар олон нийтэд байр сууриа илэрхийлэхгүй байх;

Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухай тайлбарыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

Байгууллагын удирдлагаас ажилтны ёс зүйн зөрчлийн улмаас гаргасан үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол ёс зүйн хорооны дүгнэлт шийдвэрийг гаргаж холбогдох байгууллагад шилжүүлж, шалгуулах арга хэмжээ авах;

Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлж ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрэх, хамтран ажиллагсаддаа энэ талаар хууль ёсны шаардлага тавих **зэрэг саналыг тусгуулах арга хэмжээг авлаа.**

ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦАВ

Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр салбарт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор багийн зохион байгуулалтаар ажиллав. Тухайлбал, нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт, элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, урьдчилан сэргийлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах талаар тусгайлсан ЗӨВЛӨМЖ өгч, 2018 оны 9 дүгээр сард Нийслэлийн **1, 23, 24, 45, 84** дүгээр сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь танилцаж, илэрч хөндөгдсөн асуудлыг хянан шийдвэрлэж, олон нийтэд мэдээлэв.

МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЛИЙН МӨРӨӨР АЖИЛЛАВ

Мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан

- Гадаад хэргийн яам
- Зэвсэгт хүчний жанжин штаб
- Баянгол дүүргийн Татварын хэлтэс
- Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс
- Авто тээврийн үндэсний төв
- ТОСК
- “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК
- Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэс
- Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэс
- Нийслэлийн тээврийн газар
- Өвөрхангай аймгийн Засаг дарга
- Сүхбаатар аймгийн Мэнэнгийн талын сав газрын захиргааны дарга
- Баян-Өлгий аймгийн Засаг дарга
- Хэнтий аймгийн Засаг дарга
- Булган аймгийн Засаг дарга
- Баянхонгор аймгийн Засаг дарга
- Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэс
- Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтэс
- Дорноговь аймгийн Замын-Үүдийн гааль
- “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК
- Нийслэлийн нийгмийн халамжийн газар зэрэг болно.

- Мэдэгдлийн мөрөөр ажиллаж, 2 албан тушаалтанд эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах,
- 7 байгууллагад авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах сургалтыг нийт 108 албан хаагчийг хамруулан зохион байгуулж,
- Цагдаагийн 10 байцаагчид арга зүйн зааварчилгааг биечлэн өгч,
- 2 байгууллага дотоод хяналт шалгалт явуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн,
- 1 байгууллагын албан хаагчдаас ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх баталгааг гаргуулсан байна.
- Дүүргийн татварын хэлтсүүдэд хүргүүлсэн Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын дүнд авлигын гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөл бодитой арилаагүй байна гэж үзжээ.



“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь Мөрдөгчийн мэдэгдэлд заасан шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой, бодитой ажил огт хийгдээгүй байна.



“Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨААТҮГ-аас авч хэрэгжүүлсэн, зохион байгуулсан ажил хангалтгүй гэж дүгнэсэн байна.



Чингэлтэй, Баянгол дүүргүүдийн Цагдаагийн хэлтэст ажиллан, Мөрдөгчийн мэдэгдэлд дурдсан гэмт хэрэг гарахад хүргэсэн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр хийсэн ажлын явц, үр дүнг сайжруулах шаардлагатай гэж үзэв.



Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг бодитой арилгахад тухайн байгууллагын удирдлагын зүгээс идэвх санаачилга сул, төсөв санхүү, хяналт шалгалт, аудитын байгууллагуудтай хамтран холбогдох зөрчлийг арилгах чиглэлээр зохих түвшинд ажиллаагүй гэж дүгнэхээр байна.

САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ ЖУРМЫГ МӨРДӨЖ ЭХЭЛЛЭЭ


“Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам”-ыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэллээ.



Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулав.

Энэхүү журам нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаарт бүртгэгдэн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөх боллоо.

Энэхүү журамд заасны дагуу Авлигатай тэмцэх газраас сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн дараах мэдээллүүдээр сахилгын шийтгэлийн төрөл бүхий нэгдсэн сан үүсгэх бөгөөд уг сан нь олон нийтэд нээлттэй байх юм.



СУРГАЛТЫГ ЦОГЦ БАЙДЛААР ЗОХИОН БАЙГУУЛАВ

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтаар төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын 189047 хүнд авлигын шалтгаан, хор хөнөөл, хууль эрх зүйн зохицуулалтыг ухуулан таниулах сэдэвтэй 2-3 цагийн хичээлийг заасан бол Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойших хугацаанд нэг өдрийн танхимын сургалтыг 262 удаа зохион байгуулж **21574** нийтийн албан тушаалтныг хамруулсан байна.

2017

10 сэдвийн хүрээнд **165** удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор **11345** хүнийг сургасны 52.5 хувь нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлахад чиглэсэн.

2018

2018 онд зохион байгуулсан сургалт нь танхимын, 8 цагийн цогц сургалт байснаар онцлог байлаа. Танхимын цогц сургалтад хамрагдсанаар авлигын эсрэг боловсролыг цогц байдлаар хүлээн авах боломж бүрдсэн юм.



Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид
Авлигын эсрэг сургалтад хамрагдав. 2018.01.31



“Авлигын эсрэг
сургалт”-ын 2019
оны I улирлын
хуваарь

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ОЛОН НИЙТИЙН

2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр

№	Байгууллагын нэр	Төлөв				Нийт	даваа	хөгжилт	го
		2/26	2/27	2/28	3/1				
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	9	9	6	9	33	1	3	3
2	Хил хамгаалах ерөнхий газар	4	4	4	4	16			
3	Онцгой байдлын ерөнхий газар				2	2		3	
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	7	8	8	8	27		33	
5	Ашигт малтмал, газрын тосны газар	2				2			
6	"Багануур" ХК			5	4	9	3	3	
7	Улсын бүртгэлийн ерөнхий газар	5	5	5	6	21		1	
8	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	5	5	6	6	22	1		
9	Мал эмнэлгийн ерөнхий газар	3	2			5	1	4	
10	Зэвсэгт хүчний жажин штаб	10	10	10	7	37	3	3	
11	Нийслэлийн соёл, урлагийн газар				3	3			
12	Монголроссветмет			4	3	7	1	1	
13	Архивын ерөнхий газар		1			1	1		
14	Цагдаагийн ерөнхий газар	11	10	8	9	38	4	6	
15	Оюуны амчийн газар		3			3		1	
16	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	5		5	9	19		4	
17	Соёл, урлагийн газар								
18	Хүүхдийн төв сувилал							1	
19	Гадлаад харигцааны яам	5	3	5	6	21	2	1	
20	Улсын ерөнхий прокурорын газар	4			5	9			
21	УИХ-ын Тамгын газар				3	3	4	1	
22	Улаанбаатар чуулга		1			1		2	
23	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		11			11		4	
24	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар				1	1			
25	Хүний эрхийн үндэсний комисс	4				4		1	
26	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	3				3			
27	Зам, тээврийн хөгжлийн яам			3		3	1	1	
28	Эрчим хүчний яам			1		1			
29	Гадлаадын иргэн, харьяатын газар			1		1	1	4	
30	Хан-Уул дүүргийн ЗДТГ			1		1		4	
31	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	3	2	2	3	10		1	
32	Налайх дүүргийн ЗДТГ	1				1			
33	Баянзүрх дүүргийн ЗДТГ	2				2	1	1	
34	Өсвөр үе хүнс ОНБААТУГ							2	
35	"Багачууд хүнс" ОНБААТУГ			1		1			
36	"Улаанбаатар" чуулга			1		1		2	
37	Нийгмийн хамгааллын тусгай төв			1		1			
38	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар			1		1			
39	Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар			1		1			
40	Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар		8			8	1		
41	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар							8	
42	УБ хотын НАА-г сайжруулах II төслийн удирдах нэгж			1		1		1	
43	Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн ОНӨТҮГ								
44	Зорчигч Тээврийн нэгтгэл		4	7		11	4	8	
45	Нийслэлийн Байгаль орчны газар			1		1		1	
48	Нийслэлийн Боловсролын газар		2			2	2	3	
47	Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв								
48	Нийслэлийн Тээврийн газар	5				5			
49	Хотын төв номын сан			2		2			
60	Монголын Хүүхдийн Урлан бүтээн төв			1		1	1		
51	Хөгжлийн банкны охин компани "Ди Би Эм лизенс" ХХК								
62	Налайхын Барилгын материалын ҮТТ				1	1			
63	Барилга, хот байгуулалтын яам						2		
64	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам						2		
65	Эрүүл мэндийн яам						2		
66	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам						2		
67	Хууль зүй, дотоод хэргийн яам	14	15	15	15	59	1		
Нийт дүн		102	102	103	102	409	41	108	1
Захиргаа, удирдлагын нэгжийн дэргэ-408 хүү		Дотоод хөндөгч, аудит хариуцсан албан							

БАТЛАВ,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

ТӨВД ЗОХИОН БАЙГУУЛАХ АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТЫН ХУВААРЬ
2019 ОНЫ I УЛИРАЛ

Улаанбаатар хот

3/6	3/7	3/11	3/12	Нийт	3/13	3/14	3/15	3/18	3/19	3/20	3/21	3/22	3/25	3/26	3/27	3/28	3/29	Нийт	Нийт дүн
7				7		3			3		3	2						11	55
		2		2		3	3											6	24
		1		1				1										1	7
21	21	21	22	85	29	29	29	29	28	28	29	28	28	28	28	28	28	375	520
		4		4					5									5	11
			2	2						12								12	29
5	5	6	5	21	18	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17	222	265
10	15	10	15	50			3			5		2	2				3	15	88
2				2				3	2					5		4		14	26
5	7	7	8	25	7	7	7	7	7	7	7	7	7	6				69	137
	2			2															5
		1		1						1									10
28	28	29	28	113	14	14	14	14	14	14	14	14	14	15	15	15	15	186	347
	3			3	6	4	4											16	23
		1		1									5	10	10	10	10	45	69
																	1	1	1
	3			3										5	5	5	5	20	47
15	14	14	15	58	14	14	14	13	13	13	13	13	13	13	13	13	13	172	239
										1								1	9
															1	1	1	3	6
	5	5		10	4		4			5	8	5		4	4	4		39	64
	1			1							2				2			4	6
6			6	12			5	5			5	5						20	37
3				3															6
		6		6	10	10	10	10	10	10	10	10	10	10	10			113	124
	1			1										2	2	2		6	8
5				5	3	3	3	3										12	23
					3	3	2		2									10	15
					3		3			2		2		2		2		14	25
															2	3		5	6
										1								1	5
										1			1					2	4
																			1
	1			1									1		1			2	6
					2		2						1					5	5
												1						1	7
																			1
																			8
																			8
																			2
																			2
																			2
																			2
																			2
																			2
5	6	6	7	25							2		2				2	6	91
13	113	112	113	451	114	115	114	114	115	114	115	115	115	115	115	115	114	1490	2499
Гушаалтан-41 хүн				Санхүү, төсөв, худалдан авах ажиллагаа хариуцсан албан гушаалтан-108 хүн															



АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТАД 8497 АЛБАН ТУШААЛТНЫГ ХАМРУУЛЛАА

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Олон нийтийн төв”-д 2018 оноос эхлэн АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ-ыг үе шаттайгаар явуулж байна.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойших **2** ЖИЛИЙН хугацаанд **262** удаагийн СУРГАЛТЫГ зохион байгуулж **21574** нийтийн албан тушаалтныг хамруулаад байна.



“Авлигын эсрэг сургалт”-ын онцлог

Сургалтыг бүтэн жилийн туршид цувралаар зохион байгуулдаг.

Яам, агентлаг, аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд буюу төрийн бүх шатны байгууллагын албан тушаалтнуудыг хамруулдаг.

Төрийн албан тушаалтнуудад авлигын эсрэг хууль тогтоомж, шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг таниулан сурталчилдаг.

Төрийн албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлж, төрийн албан хаагчийн ёс зүйтэй ажиллах зан үйлд сургадаг.

Авлигатай тэмцэх газрын албан хаагчдаас гадна Удирдлагын академи, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, зарим төрийн болон төрийн бус байгууллагын зочин багш нар хичээлийг хөтлөн явуулдаг.



...УИХ-аар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг сургалтад хамруулахаар тусгасан. Энэ сургалтыг бид удирдах албан тушаалтан, хууль, хүний нөөц, төсөв, санхүү, аудит, худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагч зэргээр эрхэлж буй албан тушаалын онцлогтой уялдуулж ангилан зохион байгуулж байгаа.

Анхдугаар сургалтыг нээж Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэнгийн хэлсэн үг. 2018.01.31

Сургалтад хамрагдагсад, зорилтот бүлгээр





ТУСГАЙЛСАН СУРГАЛТУУД



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ

“Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификат олгох” сургалтад давхардсан тоогоор 102 байгууллагын **973** албан тушаалтан, Авлигатай тэмцэх газрын Иргэний хяналтын зөвлөлийн **60** гишүүнийг тус тус хамруулав.



СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ

“Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдвээр модуль гарын авлагыг боловсруулж, уг модуль, гарын авлагын дагуу сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 2018 оны 12 дугаар сард зохион байгуулсан байна.



СЭТГҮҮЛЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ

“Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо”, “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдвээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад зориулсан 4 өдрийн сургалтыг зохион байгуулав.



ОЛОН УЛСЫН СУРГАЛТУУД

“Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны сургалт”, “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын түршлага” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.

ТАНХИМЫН БУС СУРГАЛТ

Танхимын бус сургалтад нийт **6286** иргэн, нийтийн албан тушаалтныг хамруулсан байна:

- Төв аймгийн ИТХ (35)
- Үндэсний аудитын газар (25)
- Орон нутгийн дотоод аудитор (80)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (84)
- Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ (17)
- Онцгой байдлын ерөнхий газар (80)
- Татварын ерөнхий газар (110)
- ХСИС-ийн Цагдаагийн

- сургууль (54)
- Цагдаагийн ерөнхий газрын төв орон нутгийн төсөв, санхүүгийн ажилтнууд (115)
- Хууль зүйн тусалцааны төв (65)
- бусад (3446)
- Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид (96)
- Зориг сангийн Ардчиллын элч манлайллын хөтөлбөрт хамрагдсан нийслэлийн ЕБС-үүдын сурагч (17)
- “Lead Mongolia” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Гэрэл тусгая” төслийн үеэр (150) хүүхэд залуус

- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэд (70)
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт шалгалтын байцаагч нар
- Тээврийн цагдаагийн албаны бие бүрэлдэхүүн
- Хууль зүйн яамны харьяа байгууллагын санхүүгийн асуудал хариуцсан ажилтнууд
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагын удирдах албан тушаалтны зөвлөгөөнд оролцож сургалт хийсэн байна.



НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтын оролцогчид 2018.12.16

**СУРГАГЧ
БАГШ
БЭЛТГЭХ
СУРГАЛТАД**

21 АЙМГААС
63 ТӨРИЙН
АЛБАН ХААГЧ

НИЙСЛЭЛЭЭС 69

ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНИЙГ ХАМРУУЛЖ

132 СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭВ

Завхан аймагт зохион байгуулсан удирдах ажилтны анхдугаар чуулганд оролцож 300, Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан удирдах ажилтны зөвлөгөөнд оролцон 57 удирдах албан тушаалтан, 130 гүйцэтгэх албан тушаалтан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, ерөнхий инженер, хуулийн мэргэжилтнүүд болох 150 хүнд “Авлигын шалтгаан, хор хөнөөл”, “Ашиг сонирхлын зөрчил”, “Авлигын эрсдэлийг үнэлэх аргачлал”, “Авлигын гэмт хэрэг-шинэ зохицуулалт”, “Нийтийн албан тушаалтны ХАСҮМ, ХАСХОМ-ийн зөрчил, анхаарах асуудал” сэдвээр тус тус сургалт хийлээ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн наймдугаар зорилт (иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх)-ын хүрээнд “Глоб интернэшнл төв” ТББ-тай байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо” сэдэвт 2 өдрийн сургалтад хэвлэл, мэдээллийн байгууллагын 25 ажилтныг хамруулсан бөгөөд нийт 14 сэдвийг багтаасан болно. Хөтөлбөрийн “Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдвээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад зориулсан 2 өдрийн сургалтыг Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион байгуулав.



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА

“ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ДЭХ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА- ХАМТЫН АЖИЛЛАГАА” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын Хуульчдын Холбооны төлөөлүүдийг оролцуулан зохион байгуулсан хэлэлцүүлгээр гадаад улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн хэрэглээ, гэрээ, конвенцийн хүрээнд олж авсан баримтуудыг эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэх үндэслэл, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа, эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд учирч байгаа хүндрэл, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэгт оролцогчдоос хэлэлцэж, дараах зөвлөмжийг санал нэгтэй гаргав.

Зөвлөмжийг дараах байгууллагууд хариуцан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Нэг. Хууль зүй, дотоод хэргийн яам

1.1 Гадаад хэл дээр хууль зүйн мэргэжлийн орчуулга хийх чадвар бүхий хуульч орчуулагчдын баг бүрдүүлэх, тэдгээрийн талаарх мэдээллийн санг бий болгож, үйл ажиллагааг журамлах, гадаад улс орны хууль, конвенц, олон улсын гэрээ, хэлэлцээрийг албан ёсоор орчуулж баталгаажуулах, олон нийтэд нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлэх;

1.2 Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан

Авлигатай тэмцэх газар тулгамдсан асуудлуудад гарц хайх, бодлого боловсруулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор тодорхой сэдвээр хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага зохион байгуулж, талуудын байр суурийг сонсч, санал дүгнэлт боловсруулан, улмаар зохих шийдвэр гаргах түвшинд уламжилж ажиллаж байна.

2016-2018 онд нийгмийн олон талт асуудлаар, Авлигатай тэмцэх газрын санаачилгаар нийт 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан байна. Тухайлбал:



Авлигатай тэмцэх газрын санаачилгаар “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан тусалцаа-хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын их сургууль, Хуульчдын холбооны удирдах албан тушаалтнууд оролцов.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос бүрдсэн Ажлын хэсэг байгуулж, уг хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн Зөвлөмж боловсруулж, хууль хяналтын байгууллагуудад хүргүүлэв.



“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр ба төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт уулзалтыг 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав.



“СтАР” санаачилгатай хамтран хууль сахиулах байгууллагуудын дундах “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сарын 30-наас 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулав.



Хуульчдын чөлөөт хэлэлцүүлэг. 2018.12.06

туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх талаар системтэй арга хэмжээ авч, санаачилгатай ажиллах.

Хоёр. Гадаад харилцааны яам

2.1 Гадаад улсад зорчиж, оршин сууж буй Монгол Улсын иргэдийн бүртгэл мэдээллийг сайжруулах, хаягийн шинэчлэл, шилжүүлгийг холбогдох байгууллагаас тогтмол хийх, мэдээллийг шинэчлэн хяналтыг сайжруулах;

2.2 Эрх зүйн туслалцааны аливаа хүсэлтийн хариуг авах талаар гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн томилогдон ажиллаж байгаа Консулын ажилтан, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг идэвхжүүлэх, Консулын харилцааны тухай Венийн конвенциэр /Консулын харилцааны тухай 1963 оны Венийн Конвенц, 5 дугаар зүйл/ хүлээсэн үүрэг хариуцлага, олон улсын гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэхэд санаачилгатай хандах.

Гурав. Улсын Ерөнхий Прокурорын газар

3.1 Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай зарчим, гэрээг агуулгын хувьд шинэчлэх, Монгол Улс болон харилцагч гадаад улс орны эрх зүйн тогтолцооны шинэчлэл, онцлогийг тусгах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санаачилга гарган ажиллах;

3.2 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улс орнуудтай гэрээг шинээр байгуулах, авлига, мөнгө угаах, терроризм, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис наймаалах зэрэг гэмт хэрэгт мэдээ, мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр хоёр болон олон талт гэрээ байгуулж нэгдэн орох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улсад байгаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх,



хураан авах, хөрөнгө буцаах ажиллагааг явуулах зорилгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нэг удаагийн гэрээ байгуулах туршлага судлах, энэ чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.4 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллага /ХЗДХЯ, УДШ, УЕПГ, ГХЯ хууль сахиулах байгууллага/-уудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ, эх сурвалж, хүсэлтэй холбогдсон тоо баримтуудын талаархи мэдээллийн нэгдсэн бааз, хууль сахиулах байгууллага хоорондын цахим санг бий болгож, үйл ажиллагаанд ашиглах;

3.5 Мэдээ, мэдээллийг тодорхой хугацаанд, давтамжтайгаар шуурхай солилцох ажиллагаа болон гэрээний дагуу хүргүүлсэн мөрдөгчийн хүсэлтийн гүйцэтгэл, эргэх холбоонд тавих төрийн байгууллагуудын хяналтын тогтолцоог бий болгох холбогдох бусад үйл ажиллагааг нэг мөр, тодорхой болгон журамлах;

3.6 Гадаад улсад илгээгдэж байгаа болон гадаад улсаас ирүүлж байгаа хүсэлт, даалгаврын гүйцэтгэл, орчуулгын чанарт тавих хяналтыг сайжруулах, холбогдох тоо баримт, мэдээллийг нэгдсэн байдлаар хянах, бүртгэх ажлыг хариуцан гүйцэтгэх;

3.7 Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, олон улсын гэрээнд заасан шаардлагын хэмжээнд тухайн улс, орны эрх зүйн тогтолцоо, онцлогт нийцүүлэн боловсруулах аргачлал, үлгэрчилсэн загвар, стандартыг бий болгох, эдгээрийг тусгасан гарын авлага боловсруулах, энэ чиглэлээр системтэй, тогтмол сургалт зохион байгуулах.

Дөрөв. Улсын Дээд Шүүх

4.1 Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан



Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлоход судалгаа, шинжилгээ ямар үүрэг гүйцэтгэж ирсэн, судалгааны аргачлал арга зүй, үр дүн нь бодит байдлыг харуулж чадаж буй эсэх, авлигын төсөөлөл ба бодит байдлын хооронд зөрүү бий эсэх зэрэг асуудлыг хөндөн хэлэлцсэн онол практикийн бага хурлыг 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулав.



Авлигатай тэмцэх газар төрийн болон төрийн бус байгууллага, судлаач, иргэдийн төлөөллийг оролцуулан “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдөр зохион байгууллаа.

Уг хэлэлцүүлгээр боловсролын салбар дахь авлигын нөхцөл байдал, шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх талын оролцоотойгоор хангах, гарц гаргалгааны талаар албаны болон төрийн бус байгууллагын хүмүүс хэлэлцэв.



Авлигатай тэмцэх газраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран авлигын эсрэг олон улсын өдрийг угтаж “ЖДҮ-ийг хөгжүүлэх сан: Асуудал ба шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 12 дугаар сарын 6-ны өдөр “Тушин” зочид буудлын “Соёмбо” хурлын танхимд зохион байгуулав.

ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, эрх зүйн зохицуулалт, шийдвэр болон зарцуулалтыг цаашид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нээлттэй, ил тод болгох талаар тодорхой шийдэл гаргах нь уг хэлэлцүүлгийн үндсэн зорилго байв.

Хэлэлцүүлгийн төгсгөлд оролцогчдоос гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэж, холбогдох байгууллагуудад Зөвлөмж болгон хүргүүлсэн бөгөөд түүний хэрэгжилтэд Авлигатай тэмцэх газраас бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран, хяналт тавьж ажиллаж байна.

Хэлэлцүүлгүүдэд оролцогчдоос гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэж, холбогдох байгууллагуудад Зөвлөмж болгон хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтэд Авлигатай тэмцэх газраас бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран, хяналт тавьж ажиллана. Цаашид энэ төрлийн хэлэлцүүлэг, уулзалтуудыг салбар бүрт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох.

Тав. Хууль сахиулах байгууллагууд

5.1 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу хүргүүлэх хүсэлтийг тухайн улс орны эрх зүйн тогтолцоо, хууль, эрх зүйн тогтолцооны онцлогийг харгалзан боловсруулах, орчуулга болон дагалдах бичиг баримтын бүрдлийг хангахад анхаарах;

5.2 Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн нууцлал, битүүмжлэлийг хангаж, төрийн нууцын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх.

Зургаа. Монголын хуульчдын холбоо

6.1 Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагын түвшинд боловсруулах, хүсэлтэд тусгагдвал зохих мэдээ, мэдээллийг олж авах арга зам, холбогдох бусад ажиллагааны талаар хуульчдын үргэлжилсэн сургалтын хүрээнд кредитийн сургалтад оруулах, ном, гарын авлагыг боловсруулах, хүртээмжтэй болгох цогц арга хэмжээ авах.

Долоо. Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулиуд

7.1 Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт эрх зүйн харилцан туслалцаа, туслалцааны хүрээнд нотлох баримтыг олж бэхжүүлэх, үнэлэх, хүний эрхийг хангах ажиллагааны талаар сургалтын онол, дадлагын цагийг нэмэгдүүлэх, сургалтын чанар, багшийн үр чадварын түвшинг дээшлүүлэх, эрх зүйн магистр, докторын судалгааны сэдэвт эрх зүйн харилцан туслалцааны чиглэлээр оруулан онол, практикийн судалгааг хийх, өргөжүүлэхэд анхаарах.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГСОД



СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЯН

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэх хүрээнд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын эсрэг боловсролын түвшинг дээшлүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулав.



“Авлигатай тэмцэхэд залуу үеийн үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийн үеэр цаашид авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тогтмол арга хэмжээ зохион байгуулж, оюутан залуусын идэвх оролцоог өрнүүлэх зорилгоор Монголын Залуучуудын холбоо, Монголын Оюутны холбоо, Монголын Сурагчдын холбоо болон Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн оюутны холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулан ажиллав.



Үндэсний хөтөлбөрт тусгагдсан “Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд

төрийн албан хаагч, залуу хойч үед авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх “Өөр ирээдүй” аян

“Шударга ёсны төлөө клуб” байгуулан ажиллуулах

бизнес эрхлэгч, хувийн хувшилд чиглэсэн “Авлигын эсрэг нэг үйлдэл” аян

“Шударга үнэнийг дэмжинэ” уриалга гарган,

“Хүн байхын учир” лекц цувралаар зохион байгуулж

“Бид өөр ирээдүй хүсч байна” оддын давалгаа, авлигын эсрэг сурталчилгаа

зэрэг соён гэгээрүүлэх олон талт арга хэмжээг иргэний нийгэм, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор зохион байгуулав.



“Бичгийн хавчаар” аянд Татварын ерөнхий газрын албан хаагчид нэгдэв. 2018.12.06

Монголын Залуучуудын холбоо, Монголын Оюутны холбоо, Монголын Сурагчдын холбоотой хамтран төрийн байгууллагуудаар аялж, “Авлига авдаггүй, үнэнч шударга, сайн төрийн албан хаагчид олон” гэдгийг олон нийтэд мэдүүлэх, шударга төрийн албан хаагчийг алдаршуулах зорилгоор БИЧГИЙН ХАВЧААР аяныг зохион байгуулав. Аянд нийслэлийн 5 дүүргийн ерөнхий боловсролын 18 сургууль, нийслэлийн 46, 59, 68, 78, 84, 87, 111 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид болох нийт 225, татвар, шүүхийн шийдвэр, цагдаагийн байгууллага, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутгийн захиргааны байгууллагын 120, нийт 348 албан хаагч нэгдсэн байна.



“ӨӨР ИРЭЭДҮЙ” эссэ бичлэгийн уралдаанд Нийслэлийн 2 дугаар сургуулийн 96 ангийн сурагч Б.Оюунчимэг, дэд байранд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн 10в ангийн сурагч М.Бодьгэрэл, гутгаар байранд нийслэлийн 23 дугаар сургуулийн 8г ангийн сурагч Д.Дөлгөөн нар шалгарав.


- ✓ Авлигын гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах 1800-1969 утасны дугаарыг сурталчилсан радио спот
- ✓ “Тендер”, “Байцаагч”, “Эмч” сэдэвт 3 төрлийн вирал видео
- ✓ “Туулайхүүгийн адал явдал” зохиолын баатраар зохиомжилсон хүүхдэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмыг ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жижиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3D анимэйшн бэлтгэж олон нийтэд сурталчлав.



Авлигыг эсэргүүцэх ёс зүйтэй, шударгаар өрсөлдөгч аж ахуй эрхлэгчид, иргэдийн дуу хоолойг нэмэгдүүлэх, олон нийтийн хандлагыг өөрчлөх зорилгоор АВЛИГЫН ЭСРЭГ #НЭГ ҮЙЛДЭЛ аяныг зохион байгуулав.



ГАРЫН АВЛАГА, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ




Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас авлигатай тэмцэхэд анхаарах асуудал, олон улсын зохицуулалт, сайн туршлагуудыг багтаан гаргасан “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг монгол хэлнээ орчуулж прокурор, цагдаа зэрэг хууль хяналтын байгууллагын ажилтнууд болон авлигын асуудлаар судалгаа хийж буй оюутан залуус, эрдэмтэн, судлаачид, бодлого боловсруулагчдад хүргэсэн нь авлигын эсрэг орчин үеийн цогц мэдлэгийг эх хэлээрээ авах нөхцөл бүрдсэн юм.

Авлигын хор хөнөөлийг иргэд, олон нийтэд таниулах, шударга бус, ёс зүйгүй үйлдлийн эсрэг авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор

- “Авлига боловсролын эсрэг гэмт хэрэг”
- “Авлига хөгжил дэвшлийн эсрэг гэмт хэрэг”
- “Авлига байгаль орчны эсрэг гэмт хэрэг”
- “Авлига хүний эрхийн эсрэг гэмт хэрэг”
- “Авлига эдийн засгийн эсрэг гэмт хэрэг” гэсэн агуулга бүхий 5 төрлийн постер хэвлүүлэн 21 аймаг, 330 суманд 5600 ширхэг, 13 яам, 26 агентлаг, 9 дүүрэгт тус тус түгээв.



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдвээр гарын авлагыг боловсруулав.



Нийслэлийн ИТХ,
Гэмт хэргээс
урьдчилан
сэргийлэх ажлыг
зохицуулах
салбар зөвлөл,
Засаг даргын
Тамгын газартай
хамтран
нийслэлийн
төсвөөр авлигын
нийгмийн хор
хөнөөлийг
ухуулан
таниулах,
авлигыг үл
тэвчих үзлийг
төлөвшүүлэх
чиглэлээр
сурталчилгааны
материал,
гарын авлага,
5 төрлийн
сурталчилгааны
материалыг
хэвлүүлж, олон
нийтэд түгээв.



Ханын хуанли



Mouse pad



Автомашины стикер



Автобусны цахим карт



Флаш диск



Хаалганы стикер



Автомашины стикер



ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүй, төсөв, санхүү, худалдан авалт, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Иргэний хяналтын зөвлөлийг яам, агентлаг болон орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд байгуулан ажиллуулж байна. Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар төрийн байгууллагын 41 нэгжид 152 хүн иргэний хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.


ЯАМНЫ ДЭРГЭД

19 нэгж
60 гишүүн


ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

22 нэгж
108 гишүүн

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн ажил мэргэжлийн төрлийг графикаар үзүүлбэл:



Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн насны ангилал:



Иргэний хяналтын зөвлөлийн гишүүд хариуцсан багийн гишүүдийн хамт яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, 21 аймаг, зарим сумдад ажилласан бөгөөд мөн эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгт судалгаа, дүн шинжилгээ, шалган туслах ажлыг хийж гүйцэтгэсний зэрэгцээ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллав.

ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?



- Аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, түүнд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох



- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох




- Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.



Иргэний хяналтын зөвлөлийн гишүүд сургалтад хамрагдав



“Олон нийтийн хяналт ба хамтын ажиллагаа” сэдэвт сургалтад оролцогчид Олон нийтийн төвийн нээлтэд оролцов



Яам, агентлаг, нийслэл дүүргийн дэргэдэх Иргэний хяналтын зөвлөлийн гишүүд ажлаа хийж байгаа нь

Ийнхүү тодорхой салбарт шударгаар үр бүтээлтэй ажиллаж байсан, орон нутагтаа амьдарч байгаа, тухайн байгууллагын үйл ажиллагаан дахь зүй бус үйлдлийг мэддэг, асуудлыг өөр өнцгөөс харж чаддаг, түүнийг засаж залруулах чин эрмэлзэлтэй иргэнийг Иргэний хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгон авч ажиллуулснаар авлигын эсрэг олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, төр, засгийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, авлигад өртөмтгий салбар, ажил, үйлчилгээ, хүнд суртлыг илрүүлэх, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэний хөндөгдсөн эрх ашгийг хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулж байна.



ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТЫН “ОЛОН НИЙТИЙН ТӨВ”-ИЙГ БАЙГУУЛЛАА



Өдөрт 170 хүнийг хүлээн авах хүчин чадалтай их, бага танхим бүхий “Олон нийтийн төв”-ийг 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрөөс нээн ажиллуулж байна.

Энэхүү төвийг нээн ажиллуулснаар НҮБ, Олон улсын авлигын эсрэг академи, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллага, санаачилгууд болон дотоодын сургалтын байгууллагуудтай хамтран бүс нутгийн болон олон улсын түвшний байнгын ажиллагаатай авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын дэд бүтцийг бий болгох эхлэлийг тавилаа.

“ОЛОН НИЙТИЙН ТӨВ”-ИЙН ЗОРИЛГО НЬ:



Өмнөх байдал

ОЛОН НИЙТИЙН ТӨВ

Өнөөгийн төрх



Гадна тал



Үүдний хэсэг



1 дүгээр давхрын хурлын танхим



2 дугаар давхрын хурлын танхим



“Олон нийтийн төв”-д зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, уулзалт

Олон нийтийн төвд

- Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Сургагч багш бэлтгэх
- Иргэний хяналтын зөвлөлийг чадавхжуулах
- Иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох
- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна.



НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, СтАР санаачилгын санхүүгийн мөрдөн шалгах ажиллагсааны анхан шатны сургалт



“Авлигатай тэмцэхэд залуу үеийн оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг



Нийтийн албан тушаалтнуудад зориулсан нэг өдрийн сургалт

САР ТУТМЫН ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр Авлигатай тэмцэх газар төрийн бусад байгууллагад үлгэр дуурайл үзүүлж, сар тутмын 25-ны өдөр хэвлэлийн бага хурал тогтмол зохион байгуулдаг болов.

2017 оноос эхлэн сар бүрийн 25-ны өдөр тухайн сард хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга мэдээллийг сэтгүүлчдэд нээлттэй хүргэж, Авлигатай тэмцэх газрын хэлтэс, албадаас цаг үеийн шинжтэй асуултуудад хуулийн хүрээнд үнэн бодит мэдээллийг өгч байна.



Авлигатай тэмцэх газрын сар бүрийн 25-ны өдрийн хэвлэлийн бага хурал 2018.12.25



Авлигатай тэмцэх газрын сар тутмын хэвлэлийн бага хурал нь төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилгоор батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд зохицуулж буй үйл ажиллагаа юм.



Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд МҮОНТ-тэй байгуулсан гэрээний дагуу “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгээр 40 удаагийн цуврал нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтийн хүртээл болгожээ.

Энэхүү ажил ирэх онд мөн үргэлжлэх бөгөөд Монголын үндэсний олон нийтийн телевизэд 14 хоног тутамд 1 удаа цацагдах өөрийн мэдлийн буюу “АТГ-ын мэдээллийн цаг”-тай болсноороо чухал ач холбогдолтой юм.



ОЛОН УЛСЫН СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАВ

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг олон улсын түвшинд хэрэгжүүлэх зорилгоор “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны сургалт”, “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.



2017 оны 9 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд

Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сургалтыг зохион байгуулав.

Сургалтад прокурорууд, Авлигатай тэмцэх газрын болон ТЕГ, ЦЕГ-ын мөрдөгч нар, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны албан хаагчид оролцож, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Интерпол, Их Британийн Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэргэжилтнүүд явуулж, харилцан мэдлэг, туршлагаа солилцов.




2018 оны 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд

“Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Санхүүгийн гэмт хэргийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх мэргэжилтэн Игорис Кризецковскийн удирдан явуулсан энэхүү сургалтад Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэс, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, Монголбанк зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцон оффшорын асуудал болон мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлэл авч туршлага сонсов.

Цаашид СтАР буюу “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга”-тай хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтарсан сургалтыг шат ахиулан дэс дараатайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



АНУ-ын Холбооны мөрдөх товчооны атташе Роберт Стюарттай уулзалт хийв. Улаанбаатар хот, Олон нийтийн төв. 2018.04.04



Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав. Азербайжан. Баку хот, 2018.11.21

Азербайжан Улсын “АСАН” олон нийтийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцав. Улмаар “АСАН” төвийн үйл ажиллагааны сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор нийслэлийн үйлчилгээний Дүнжингарав, Мишээл, Драгон, 6 буудал дахь төвүүдэд Авлигатай тэмцэх газрын “Иргэний хяналтын төв”-ийг байгуулан ажиллаж байна. Энэ нь төрийн үйлчилгээг иргэнд ойртуулсан чухал алхам болсон юм.

Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийн гишүүнийхээ хувьд олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж ирлээ. Тус академийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулдаг зуны сургалтад Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг оролцуулан, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгч байна. Цаашид тус академийн бүс нутгийн зуны сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг урьж оролцуулахаар төлөвлөөд байна.



Швейцарийн холбооны улсын Ерөнхий прокурорын газрын төлөөлөгч нарын хамт Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, Прокурорын байгууллагын төлөөлөгчид Нидерландын вант улсын Гааг хот, ЕвроЖаст. 2018.11.30.



Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний бүгд хурал, Индонез улс, Бали хот, 2018.11.05-06

Авлигатай тэмцэх газрын нэр хүнд олон улсын түвшинд өндөр байгааг илэрхийлэх нэг жишээ бол Монгол Улсын Авлигатай тэмцэх газар нь Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (АРИН-АП)-ний 2019 оны даргалагч улсаар сонгогдсон явдал байлаа.

АРИН-АП сүлжээнд гишүүнээр оролцсоноор АРИН-Кариб, АРИН-Африк, Арин-Төв Ази, АРИН-Европ, АРИН-Өмнөд Америк тив нутгуудаас гэмт хэргийн талаар шуурхай мэдээ хүлээн авч шалган, хөрөнгийг буцаан авахад дэмжлэг үзүүлдэг онцлогтой юм. Тус сүлжээний 2019 оны 9 дүгээр сард Удирдах зөвлөлийн хурал болон Бүгд хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулна.

Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийв. Уулзалт хийснээр байгууллагууд хамтран эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож, зохих үр дүн гарч эхлээд байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны урилгаар Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гүрж Улсын төлөөлөгчдийн багтсан шинжээчдийн баг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн Словени Улс дахь хэрэгжилтийн тайланг хянаж, зөвлөмж өгч ажиллав.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Авлигатай тэмцэх газар нь авлигатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны гишүүн болохын хувьд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба энэ ажлын хүрээнд:



АНУ-ын Хууль зүйн департамент



Холбооны мөрдөх товчоо



БНХАУ-ын Ардын Дээд Ерөнхий прокурорын газар



Хонгконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо



Сингапур Улсын Авлигын гэмт хэрэг шалгах товчоо



БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо



Швейцарь улсын Ерөнхий прокурорын газар



Канад улсын Хатан хааны морьт цагдаагийн газар



ИБУИНВУ-ын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба



Авлигын эсрэг олон улсын удирдах төв



Тайланд улсын Авлигын эсрэг үндэсний хороо



Азербайжан улсын Авлигын эсрэг газар



НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба



Авлигын эсрэг олон улсын академи



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага



Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага



Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга



Ази, Номхон далайн хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ



Азийн хөгжлийн банк



Дэлхийн банк



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

зэрэг олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлж байна.



ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН ТӨВ

Төрийн байгууллагуудад илэрч байгаа зөрчил, дутагдлууд нь төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бага, хариуцлага, хяналтын тогтолцоо муу байгааг илтгэн харуулж байна.

Авлигатай тэмцэх газрын зүгээс авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа. Энэ ажлын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа явуулах зорилго бүхий “Иргэний хяналтын төв”-ийг байгууллаа.



Эхний ээлжинд нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болох Дунжингарав, Мишээл, Драгон, 6 буудал зэрэг цэгийг сонгон “Иргэний хяналтын төв”-ийг 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс үйл ажиллагааг нь эхлүүлээ.

“Иргэний хяналтын төв”



Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах



Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлах



Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, иргэдэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах арга хэмжээг авах



Иргэдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах



Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэдийн санал бодлыг хүлээн авах, сонсох, хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх



Гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдлыг хүлээн авах



Цаашид цэгийн тоог Баянгол, Чингэлтэй, Багануур дүүргүүдэд нэмж өргөжүүлэхийн зэрэгцээ Засгийн газар, яам, агентлагаас хүргэдэг нийтлэг үйлчилгээг тус цэгүүдээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.



Авлигатай тэмцэх газрын Иргэний хяналтын төв /6 буудал дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын Иргэний хяналтын төв /Драгон дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын Иргэний хяналтын төв /Дунжингарав дахь салбар/



Авлигатай тэмцэх газрын Иргэний хяналтын төв /Мишээл дэх салбар/



ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ЦАХИМ СИСТЕМИЙГ ШИНЭЧИЛЛЭЭ

Авлигатай тэмцэх газар 2016 оноос албан тушаалтны мэдүүлэг хянах үйл ажиллагааг бүрэн цахимжуулахаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн цахим системийг шинэчилж, шинэ техник, технологийг нэвтрүүлэв.

Ингэснээр хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг дан ганц бүртгэж, хүлээн авах биш судалгаа, дүн шинжилгээ хийх, мэдээ, тайланг цаг алдалгүй гаргах, ХАСХОМ-ийн хяналт шалгалтын үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, харьцуулах, судалгаа хийх ажлыг шинэ түвшинд гаргав.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем



40 МЯНГАН АЛБАН ТУШААЛТНЫ МЭДҮҮЛГИЙГ АНХ УДАА НИЙТЭД ЗАРЛАЖ ТОГТМОЛЖУУЛАВ

2018 оны 1 дүгээр улирлаас эхлэн ХОМ гаргадаг нийт албан тушаалтны мэдүүлгийг цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, олон нийтэд мэдээллээр ханган, уг ажлыг тогтмолжуулаад байна.

Мэдээллийг нээлттэй, ил тод хүргэснээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт, оролцоог дээшлүүлэх, төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинг дээшлүүлэхэд эергээр нөлөөлж байгаа төдийгүй хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд ахиц гарч байна.

ХАСХОМ-ИЙГ “БАТАЛГААНЫ МАЯГТААР”-ААР БҮРТГЭН ХҮЛЭЭН АВДАГ БОЛОВ

Мэдүүлэг гаргагч албан тушаалтнууд ХОМ гаргахдаа бүх хуудсыг цаасаар хэвлэж, баталгаажуулдаг байсныг өөрчлөн, зөвхөн “Баталгааны маягт”-ыг гарган, мэдүүлгээ баталгаажуулдаг болов. Ингэснээр эдийн засгийн бодит хэмнэлт болон мэдүүлэг гаргагч, мэдүүлгийг бүртгэж хүлээн авч байгаа эрх бүхий албан тушаалтны ажлын ачаалал, цаг хугацааг хэмнэсэн чухал арга хэмжээ болсон юм.



Хуулийн үйлчлэлд хамрагдах 40.000 гаруй албан тушаалтнаас ХАСХОМ-ээ гаргаж, “Баталгааны маягт”-аар баталгаажуулж бүртгүүлэх журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулсан. Ингэснээр мэдүүлэг гаргагч нь 3 дахь жилдээ ХАСХОМ-ээ “Баталгааны маягт”-аар баталгаажуулан өгч байна.

“Баталгааны маягт”-аар бүртгүүлдэг болсноор ХАСХОМ-ийг гаргахад зарцуулсан материалын тоо, хэмжээг судлан үзэхэд мэдүүлгийг дунджаар **12** хуудас, их хэмжээний өөрчлөлтийг дунджаар **6** хуудас байхаар тооцоход жилд **3820.4** боодол буюу **1.910.214** ширхэг бичгийн цаас, **1364.4** ширхэг принтерийн хор зарцуулж **90,6 сая** төгрөгийн зардлыг зөвхөн мэдүүлэг хэвлэн гаргахад зарцуулдаг байсныг бодитоор хэмнэхээр боллоо.

ХАСХОМ гаргасан албан тушаалтнуудын тоон үзүүлэлт, оноор

Үзүүлэлт	2016	2017	2018
Бүрдүүлбэл зохих	39742	40073	41382
Бүрдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо	39739	40067	41381
Үүнээс: Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	1	4	-
Мэдүүлгээ гаргаж өгөөгүй	2	2	1
Бүрдүүлэлтийн хувь	99.99	99.99	99.99

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд засны дагуу 2017 онд **39742**, 2018 онд **40073**, 2019 онд **41382** албан тушаалтан хуулийн үйлчлэлд хамаарч ХАСХОМ-ээ гаргаж бүртгүүлсэн байна.



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОХГҮЙ БАЙХ ХУУЛИЙН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2015 онд **40**, 2016 онд **39**, 2017 онд **39**, 2018 онд **25** этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал:

- ✓ Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Т.Батжаргал
- ✓ Гадаад харилцааны дэд сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Г.Тэнгэр
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Т.Аубакар
- ✓ Барилга, хот байгуулалтын дэд сайдаар томилогдохоор нэр дэвшсэн М.Батбаяр
- ✓ Эрчим хүчний сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Ц.Цэнгэл
- ✓ Эрүүл мэндийн сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Ж.Цолмон
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Ц.Анандбазар
- ✓ Барилга, хот байгуулалтын сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Д.Өнөрболор
- ✓ Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Н.Баярхүү, Г.Нарангэрэл
- ✓ Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Б.Гансүх
- ✓ Гадаад харилцааны яамны консулын газрын мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Ж.Дашням
- ✓ Сүхбаатар аймгийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Р.Эрдэнэцогт
- ✓ Завхан аймгийн Мал эмнэлгийн газрын даргаар томилогдохоор нэр дэвшсэн Б.Нарангэрэл

зэрэг нэр дэвшигчдийг тухайн албан тушаалд томилохоос татгалзсан хариуг өгсөн байна.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг бүртгэх, хянах, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхээр 2017 оноос эхлэн техникийн хөгжүүлэлтийг хийж, өнөөдрийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, орон нутгаас Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газартай цахим системээр холбогдон хяналтыг хэрэгжүүлж байна.

Цаашид 2019 онд бүх байгууллага, салбар нэгжтэй цахимаар холбогдон ХАСУМ-ийн бүртгэл, хяналтыг бүрэн цахимжуулж, хүний нөөц, томилгоотой холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэн ажиллаж байна.

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАСАН БАЙДАЛ (ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ОНООР)






ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖСӨН БАЙЖ БОЛОХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ХОМ-ИЙГ НАРИЙВЧЛАН ШАЛГАЖ БАЙНА

Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөмтгий байгууллага, салбарыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, нуугдмал эд хөрөнгийг илрүүлэхээс гадна цахим системийг ашиглан орлого, хөрөнгө нь хэт өссөн болон давтамжтайгаар өсөж байгаа мэдүүлэг гаргагчдын хөрөнгийн байдалд харьцуулалт, судалгаа хийж хянан үзэж байна.

ХАСХОМ-ийн хяналтаар хариуцлага тооцуулсан байдал (оноор)



2015

2016

2017

2018

Хариуцлагын төрөл /Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг/

ХАСХОМ шалгахдаа зөвхөн тухайн албан тушаалтны өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн байдлыг шалгах төдийгөөр хязгаарлалгүй тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн эд хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгийг илрүүлэхэд анхааран ажиллаж байна.

2017 онд

274 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгаж, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй үндэслэлээр 5 албан тушаалтныг шалгав

2018 онд

171 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгаж 20 албан тушаалтан нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлж нарийвчлан шалгаж байна

2018 онд 519 шүүгчийн хөрөнгө, орлогын үзүүлэлт тус бүрээр харьцуулалт, график судалгаа гаргаж нэр бүхий шүүгч нарын ХАСХОМ-ийг нарийвчлан шалгаж, улмаар 6 шүүгчийг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна

Нийтийн албан тушаалтнуудын дунд ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөлд мэдэгдэл гаргаагүй, ХАСХОМ-т орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлээгүй зэрэг зөрчил бүрэн арилаагүй, улмаар 2018 онд 197 албан тушаалтанд сахилгын арга хэмжээг авахуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО НЭМЭГДСЭЭР БАЙНА


Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар тус газарт иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо өссөн бөгөөд өргөдөл, гомдлын агуулгаар авч үзвэл, хууль бус томилгоо, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр, албаны эрх мэдлээ урвуулсан буюу хэтрүүлсэн үйлдлийн тухай гомдол, мэдээлэл зонхилж байна.

2018 онд хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлыг өнгөрсөн 2017 онтой харьцуулахад 73 буюу 11 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 66 буюу 11 хувиар тус тус өссөн байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлын хяналт шалгалт

	Нийт өргөдөл, гомдлын тоо	Албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн	Хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон	АСЗ болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан	Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн	Хууль бус томилгоо	Бусад
2015	341	68	57	105	27	78	6
2016	329	63	59	54	14	120	19
2017	599	97	97	138	19	171	77
2018	579	98	85	117	26	65	126

ИЛЭРЧ БҮЙ НИЙТЛЭГ ЗӨРЧЛҮҮД



Архангай, Баян-Өлгий, Завхан, Орхон, Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Сэлэнгэ аймгийн иргэдээс өргөдөл, гомдол, мэдээллийг илүү ихээр ирүүлж байгаа нь тухайн орон нутгийн хүн ам, нутаг дэвсгэрийн байршил, орон нутгийн сонгуулийн үр дүн, иргэдийн оролцоо, орон нутгийн удирдлагын авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл эрмэлзэл, “шүгэл үлээгч”-ийн талаарх ойлголт зэрэг олон шалтгаан, нөхцөлөөс шалтгаалж байна гэж үзэж болох юм.

МӨРДӨН ШАЛГАХ ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ



Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газартай хамтарсан ажлын хэсгээр 1702... дугаартай МАН-ын нэр бүхий удирдах албан тушаалтнууд төрийн албыг худалдах, ашиг болгон үнэлсэн гэх хэргийг шалгаж байна.




Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсгээр:

- Эрүүгийн 2016... дугаартай Зам тээврийн яамны удирдах албан тушаалтан Ж нарт холбогдох улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэг
- 2015... дугаартай Монголын төмөр зам ТӨХК болон Зам тээврийн яамны удирдлагууд албаны эрх мэдлээ хэтрүүлэн улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэг
- 2016... дугаартай Эрчим хүчний дэд сайдаар ажиллаж байсан Д нарт холбогдох хэрэг
- 1702... дугаартай төрийн албанд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа нэр бүхий албан тушаалтнууд оффшор бүсэд хөрөнгө орлогоо байршуулсан гэх хэрэг
- 1702... дугаартай Монголбанкны захирал асан 3 нь банкны хууль тогтоомжийг зөрчин, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэх хэрэг
- 1702... дугаартай Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчин ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж авсан, лизензээр баяжсан төрийн өндөр албан тушаалтнуудад холбогдох хэрэг
- 1702... дугаартай Оюу толгой бүлэг ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл явцад улс төрд нөлөө бүхий албан тушаалтнууд албаны эрх мэдлээ хэтрүүлсэн гэх хэрэг
- 1702... дугаартай Засгийн газраас агаарын бохирдлыг бүүруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг хууль бусаар завшсан гэх хэрэг
- 1841... дугаартай Ховд аймгийн Цэцэг сумын нутаг дэвсгэрт орших Мянган угалзат нурууны тусгай хамгаалалтын газарт нөхөн сэргээлт хийх нэрийдлээр хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа хууль сахиулах болон нийтийн албан тушаалтнуудад их хэмжээний хахууль өгсөн гэх хэрэг
- 1802... дугаартай Эрчим хүчний сайдаар ажиллаж байсан С нарт холбогдох хэрэг
- 2017... дугаартай Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан М нь албан тушаалын байдлаа урвуулан банкинд их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэг
- 1802... дугаартай Эдийн засгийн хөгжлийн сайдаар ажиллаж байсан Б нь албан тушаалын байдлаа ашиглан улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэг
- 2017... дугаартай Эгийн голын усан цахилгаан станцын төслийн нэгжийн удирдах албан тушаалтнууд улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэг
- 1841... дугаартай Салхитын мөнгөний орд газрыг эзэмшигч нараас шүүгч болон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудад хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс хахууль өгсөн гэх хэрэг
- 1741... дугаартай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд, үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас төрийн өндөр албан тушаалтнууд албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө болон өөрсдийн хамаарал бүхий этгээдүүдэд хууль бусаар зээл олгуулсан гэх хэрэг
- 1802... дугаартай "Кью Эс Си ХХК"-ийн удирдлагад холбогдох эрүүгийн хэрэгт тус тус мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.



ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО ХОЁР ДАХИН ӨССӨН

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо 2016 оныхтой харьцуулахад **2** дахин өссөн үзүүлэлттэй байна.



2018 онд гомдол, мэдээлэлд холбогдсон этгээдүүдийг албан тушаалаар нь ангилбал төрийн улс төрийн 127, төрийн захиргааны 232, төрийн тусгай 248, төрийн үйлчилгээний 149, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 41, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах 61 албан тушаалтан холбогдон шалгагджээ.

2018 онд хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй **858**

гомдлыг төрлөөр нь авч үзвэл:

- албан тушаалын байдлаас урвуулан ашигласан **504**
- хахууль авсан **79**
- хахууль өгсөн **29**
- албан тушаалтан өмч хөрөнгө завшсан **39**
- хөрөнгө нүүсэн буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн **7**
- худалдан авах ажиллагааны журам зөрчсөн **25**
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан **8**
- бусад **167**

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

**ХАРЬАЛЛЫН ДАГУУ
ШИЛЖҮҮЛСЭН**

70 49 93 76
2015 2016 2017 2018

**ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН
ХЭРЭГ НЭЭСЭН**

92 83 174 447
2015 2016 2017 2018

**ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН
ХЭРЭГ НЭЭХЭЭС
ТАТГАЛЗСАН**

265 274 375 327
2015 2016 2017 2018

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХЭРГИЙН ТОО 4,8 ДАХИН ӨССӨН

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо болон холбогдогчийн тоон мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар харвал шалгагдсан этгээдийн тоо **2,6 дахин**, эрүүгийн хэрэг **4,8 дахин** өссөн байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан



2018 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг төрлөөр нь ангилбал:

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 461 буюу 31.3 хувь
- Хахууль авах 140 буюу 9.5 хувь
- Хахууль өгөх 142 буюу 9.6 хувь
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 40 буюу 2.7 хувь,
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих 25 буюу 1.7 хувь
- Мөнгө угаах 6 буюу 0.4 хувь
- Хөрөнгө завших 51 буюу 3.5 хувь
- Эрүү шүүлт тулгах 42 буюу 2.9 хувь
- Бусад 568 буюу 38.6 хувийг тус тус эзэлж байна

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээд (албан тушаалын байдлаар, оноор)

	2015	2016	2017	2018
Төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан	-	112	168	82
Төрийн тусгай албан тушаалтан	44	65	168	434
Төрийн захиргааны албан тушаалтан	79	74	113	204
Иргэн	187	119	109	193
Улс төрийн албан тушаалтан	42	28	58	166
Төрийн үйлчилгээний албан тушаалтан	58	61	38	145

МӨРДӨН ШАЛГАСАН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ


2018 оныг өмнөх онтой харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг **2.6 дахин**, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг **2 дахин**, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг **4.9 дахин**, үлдэгдэл хэрэг **1.9 дахин** тус тус өссөн үзүүлэлттэй байх ба мөрдөн шалгасан хэргийн **72.4** хувийг хуулийн үндсэн хугацаанд шийдвэрлэсэн дүнтэй байна.

МӨРДӨН ШАЛГАСАН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



ЭРҮҮГИЙН 224 ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ САНАЛТАЙ ШИЛЖҮҮЛЭВ

2016 онд шүүхээр 25 эрүүгийн хэрэг, 2017 онд шүүхээр нийт 46 эрүүгийн хэрэг шийдвэрлэж байсан бол 2018 онд 84 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлээд байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг 2018 оны хувьд өмнөх оноос 42 нэгжээр өссөн.



2018 онд мөрдөн шалгасан эрүүгийн хэргээс 224 буюу нийт шалгасан хэргийн 19.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт, 467 буюу 41.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтайгаар прокурорт, 125 буюу 10.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 9 буюу 0.8 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэж, 1 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна.

2018 онд шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн тоо



2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо





ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ

- БГД-ийн 51 дүгээр дунд сургуулийн захирал Ю.Энхтуул нар
- Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын дарга Ц.Төрхүү нар
- Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч М.Гансүлд
- Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн зохицуулагч цагдаа Ч.Отгон
- Замын-Үүд дэх Гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч Ч.Насанбат, гаалийн улсын байцаагч Э.Жамьянсүрэн нар
- “Монгол цэрэг констракшн” ТӨҮГ-ын захирал М.Жаргал
- БЗД-ийн 203 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ц.Гүнгэрмаа
- Архангай аймгийн Жаргалант сумын Засаг дарга Б.Эрдэнэбаатар
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Дорноговь дахь газрын шалгагч Б.Амартүвшин, Н.Дамдинбадрах
- НӨХГ-ын Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Баяр нар
- Булган аймгийн Статистикийн хэлтсийн дарга Ц.Ганцэцэг
- Нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга асан Д.Урансүрэн
- Дархан-Уул аймаг дахь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн төвийн бүсийн салбарын дарга Г.Болд
- Өвөрхангай аймгийн Богд сумын Засаг дарга С.Мягмарсүрэн
- Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба
- “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Я.Батсуурь
- ЗГХЭГ-ын дэд дарга Г.Дэнзэн нарт холбогдох хэрэг
- “УБТЗ” ХНН-ийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Г.Сэрээнэндорж
- Зам, тээврийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Р.Онон нарт холбогдох хэрэг
- Тээврийн Прокурорын газрын хяналтын прокуророор ажиллаж байсан Х.Тамир нарт холбогдох хэрэг
- Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Х.Мөнхбатад холбогдох хэрэг
- Баян-Өлгий аймгийн Замын цагдаагийн тасгийн ахлах байцаагч Х.Ержан нарт холбогдох хэрэг
- Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг дарга Д.Энх-Эрдэнэ нарт холбогдох хэрэг
- Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч Б.Цэен нарт холбогдох хэрэг
- Баянхонгор аймгийн Заг сумын Засаг дарга Э.Мөнхбаярт холбогдох хэрэг
- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Өмч, газрын харилцааны албаны төлбөрийн байцаагчаар ажиллаж байсан Б.Батсүрэн нарт холбогдох хэрэг
- Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Л.Эрдэнэбилэг нарт холбогдох хэрэг
- Автотээврийн үндэсний төвийн Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Д.Батбаяр
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны санхүүгийн газрын даргаар ажиллаж байсан Д.Батмагнай
- Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан З.Баянсэлэнгэ
- Гаалийн Ерөнхий газрын Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байсан Б.Оюундэлгэр
- НӨХГ-ын Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Баяр, ахлах мэргэжилтэн Э.Энхтулга
- Төрийн орон сууц санхүүжилтийн корпорацийн хуулийн хэлтсийн дарга Б.Батбаатар
- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг дарга А.Мейремхан
- Чингэлтэй дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт хариуцсан байцаагч Б.Золбоо
- Баянгол дүүргийн татварын байцаагч А.Энхтүвшин
- Хан-Уул дүүргийн татварын байцаагч Н.Пүрэвдорж
- Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын орлогч дарга, хурандаа Ж.Алтансүх
- ДЦС-4 төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал С.Анхбаяр
- БНСУ-ын “Самсунг Си Энд Ти” корпорацийн төлөөлөгч Ли Жонг Гёл
- БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга асан, хурандаа Б.Батсайхан
- Нийслэлийн 1 дүгээр дунд сургуулийн захирал Г.Бум-Эрдэнэ
- Нийслэлийн тээврийн газрын дарга Д.Отгонбаатар
- “Шинэ эхлэл” бүрэн дунд лаборатори сургуулийн захирал Л.Эрдэнэ зэрэг төрийн албан тушаалтнуудад холбогдох хэргийг шүүхээр шийдвэрлүүлээд байна.

МӨРДӨН БАЙЦААЛТЫН ШАТАНД НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ 14,6 ТЭРБУМААР НЭМЭГДЖЭЭ

Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн дүн 2016 оныхоос **14,6** тэрбум төгрөгөөр өсч, мөрдөн байцаалтын шатанд битүүмжлэн хамгаалсан хөрөнгийн хэмжээ **16,9** дахин өссөн байна.


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хөрөнгө (төгрөгөөр)



2018 онд гэмт хэргийн улмаас 663,213,994,905 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 17,470,753,533 төгрөгийг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 180,650,089,526 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол **10 дахин**, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө **5 дахин**, хохирол нөхөн төлүүлэлт **6 дахин** өссөн үзүүлэлттэй байна.




Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн дүн
(тэрбум төгрөгөөр)



Мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн дүн өмнөх оныхоос
14,6 тэрбум төгрөгөөр өссөн

Мөрдөн байцаалтын шатанд битүүмжлэн хамгаалсан дүн
(тэрбум төгрөгөөр)



Мөрдөн байцаалтын шатанд битүүмжлэн
хамгаалсан дүн өмнөх оныхоос 6,1 дахин өссөн

ОФФШОР БҮСЭД БАЙРШУУЛСАН МӨНГӨ МОНГОЛ УЛСАД ОРЖ ИРЭВ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр "Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт"-ыг нэмж тусгасан.

Оффшор бүсэд данс хөрөнгө эзэмшихтэй холбоотой хуулийн хориглолт нь нийтийн албан тушаалтнуудыг хууль бусаар орлого олох, үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал зохицуулалт болсон.

Э.ИДЭРЦОГ: САНХҮҮГИЙН ХАМТАРСАН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ЯВУУЛСНЫ ҮР ДҮНД ОФФШОР БҮСЭЭС 74.9 САЯ АМ.ДОЛЛАР ОРЖ ИРСЭН



Нэр зарлагдсан иргэдээс төрийн өндөр албан тушаал хашиж байсан нэр бүхий иргэдийн оффшор бүсэд байршуулсан мөнгөн дүнгийн хэмжээ 87.9 сая орчим ам.доллар, үүнээс **74,9 сая ам.доллар** нь Монгол Улсын эдийн засагт орж ирсэн нь мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон.


Бид олон улсын санхүүгийн байгууллага, адил төстэй чиг үүргийн байгууллагуудтай мэдээ мэдээлэл солилцох, хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг явуулсаар байна. Үүний үр дүнд Монгол Улсад 74.9 сая ам.доллар орж ирсэн гэдэг нь тогтоогдсон.

Эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдсанаас хойш 4.3 сая ам.долларыг нэр бүхий иргэдээс шаардаж оруулж ирсэн. Цаашид оффшор бүсэд хууль бусаар байршуулсан албан тушаалтны хууль бус хөрөнгө мөнгийг тогтоох, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах чиглэлээр бид тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулсаар байгаа.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Э.Идэрцогийн хэвлэлийн бага хурал дээр сэтгүүлдэд өгсөн мэдээллээс. 2019.01.25

ОФФШОР БҮСЭЭС ОРУУЛЖ ИРСЭН МӨНГӨН ДҮН

68.635.452
Бэлэн мөнгө



6.358.000
Хөдлөх хөрөнгө



Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 326 дугаар тогтоолоор Оффшор бүсэд хамаарах нутаг дэвсгэрийн жагсаалтыг баталсан

Авлигатай тэмцэх газар хууль тогтоомжийн өөрчлөлтийг сурталчлан таниулж, хууль хэрэгжүүлэх талаарх ЗӨВЛӨМЖ-ийг төрийн бүх байгууллагад хүргэв



ДҮГНЭЛТ

Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоохтой холбогдуулан ИТХ-ын дарга, Засаг дарга, Сангийн сайдад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, баталсан хөрөнгийг баяр ёслол, тэмцээн уралдаан, шагнал, урамшуулал, түршлага солилцох аялал, гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдийн хоол, буудал, унаа, бэлэг зэрэгт зарцуулах нь түгээмэл байна.

Зарим аймаг, сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмыг батлан орон нутгийн төсөвт хөрөнгө тусгаж, Засаг даргын нэгэн адил хөрөнгө захиран зарцуулдаг боллоо.

Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” (шинэчлэн баталсан) нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчмыг алдагдуулсан төдийгүй албан тушаалтнаас бусдад давуу байдал олгох, дураар авирлах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн хөрөнгө захиран зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Энэхүү журамд зааснаар урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэх, шагнал урамшуулал, буцалтгүй тусламж олгох, байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зэрэг боломжийг олгосон нь өмнө гарч байсан түгээмэл зөрчил, дутагдлыг дэмжсэн төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд саад учруулсан зохицуулалт болсон гэж үзэж байна.

Захиргааны байгууллага хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад эрх хэмжээгээ хэтрүүлэн дүрэм, журам батлан мөрдүүлэх, төлбөр хураамж тогтоох асуудал түгээмэл байгаа нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, чирэгдэл учруулах шалтгаан болж байна. Ялангуяа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар ИТХ-ын Тэргүүлэгчдээс шийдвэр гарган мөрдүүлж байгаад онцгойлон анхаарах шаардлагатай.

Нийтийн албанд анх удаа томилогдох, нийтийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжин томилогдох, байгууллага дотроо албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдөн дэвшин томилогдох болон сэлгэн ажиллах, ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдөх зэрэгт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) хянуулах үндэслэлийг тодорхой болгож зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн ХАСУМ-ийн хяналтаар 2015 онд 40, 2016 онд 39, 2017 онд 39, 2018 онд 25 этгээдийг тухайн албан тушаалд томилоход илт ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг хүргүүлж, нийтийн албанд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилуулахаас урьдчилан сэргийлж, зөрчилтэй этгээдийг нийтийн албанд томилуулахгүй байх практик тогтоон ажиллаж байна.

Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан

мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн тохиолдолд тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдээ өөрийн хүсэл зоригоор томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх боломжийг нээлттэй болгосон.

Энэ нь дээрх хуулийн үндсэн үзэл баримтлалыг алдагдуулж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.1-д “шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх” зорилтыг тодорхойлон 4.1.1.1-д “...хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх”-эд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай заалтуудтай зөрчилдсөн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтоос хазайсан шийдвэр болсон гэж үзэж байна.

Түүнчлэн дээрх хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хариуцлага тооцуулах хуулийн зохицуулалт хэвээр байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, салаа утгатай агуулгыг бий болгож байна.

Сүүлийн жилүүдэд Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдах, сайд нар өөрчлөгдөх бүрт тухайн яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж нийтийн болон төрийн жинхэнэ албан тушаалтныг томилох, чөлөөлөхтэй холбоотой хувь хүний болоод улс төр, бизнесийн тодорхой хэсгийн ашиг сонирхол бүхий хууль бус нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байгаа ба тус газарт иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн 20 гаруй хувийг ашиг сонирхлын зөрчилтэй, хууль бус томилгооны талаарх асуудал эзэлж байна.

Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангах зорилгоор 2018 онд нийт мэдүүлэг гаргагчдын 2017 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын <http://www.хасхот.iaас.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулснаар иргэд мэдээлэлтэй танилцах, хяналт тавих нөхцөл байдал сайжирч төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинд эерэг хандлага үүсэх төдийгүй цахим системээр албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт, бууралтад олон нийтийн зүгээс дүн шинжилгээ хийж, бодитой дүгнэлт өгөх боломж бүрдэхээс гадна хяналт шалгалтын үйл ажиллагаа эрчимжиж хууль бус нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх нөхцөл байдал нэмэгдэж байна.

Иргэд, олон нийтийн дунд авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомжийн ойлголт сайжирч байгаатай холбоотойгоор нийтийн албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар тус газарт мэдээлэл ирүүлэх идэвх ухамсар улам бүр дээшилж байна. Үүний илрэл нь 2018 онд хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлыг өнгөрсөн 2017 онтой харьцуулахад 73 буюу 11 хувь, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 66 буюу 11 хувь тус тус өссөн явдал юм.

Нийтийн албан тушаалтантай холбогдох асуудлыг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс



урьдчилан сэргийлэх тухай хуулиар илүү нарийвчлан зохицуулсан буюу зөрчлийн хэм хэмжээнээс нь шалтгаалан сахилгын арга хэмжээ авахаар хуульчилсан байхад сүүлийн үед тус газрын хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхэд захиргааны хэрэг маргаан нэлээд шийдвэрлэгдэж, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан тушаалтанд ногдуулсан хариуцлагын асуудлыг хүчингүй болгох, Төрийн албаны тухай хуульд заасан шат дараалсан сахилгын арга хэмжээ аваагүй, Төрийн албаны тухай хуулийг баримтлаагүй, Захиргааны Ерөнхий хуульд заасан сонсох ажиллагаа, захиргааны актыг мэдэгдэх, тайлбарлах болон процессийн ажиллагааг явуулаагүй гэх үндэслэлээр зарим шийдвэрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудал гарч байна.

Мөн шүүхийн практикт авлига, ашиг сонирхлын зөрчлийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хуульд заасан сахилгын зөрчилтэй адилтган, хөөн хэлэлцэх хугацааг нэг жилээр авч үзэж байгаа нь буруу практик тогтохоос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинж чанартай уялдаагүй, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлагаас чөлөөлөгдөх эрсдэлийг бий болгож, хяналт шалгалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 2.6 дахин, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2 дахин, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4.9 дахин, үлдэгдэл хэрэг 1.9 дахин тус тус өссөн, шүүхээр эрүүгийн 84 хэрэг шийдвэрлэгдсэн нь 42 нэгжээр буюу 84 хувиар, гэмт хэргийн улмаас учирсан хохирол өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 10 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 5 дахин, хохирол нөхөн төлүүлэлт 6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Мөрдөгч нар мөрдөн шалгах ажиллагааны явцад 146 үйлдэл, хэрэг шинээр илрүүлсэн нь мөрдөгч нарын мэргэжлийн үр чадвар, бие даасан байдал, ажлын хариуцлага өндөржсөнийг мөн харуулж байна.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуулиар тус хэлтсийн мөрдөн шалгах харъяаллын хэрэг үйлдсэн этгээдийн учруулсан хохирлын хэмжээг шаардахгүй буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилсан, цагдаагийн алба хаагчид холбогдох гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, тэдний үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах болсон, мөн нийгэмд үүсэж буй нөхцөл байдал, иргэдийн хүсэлт шаардлага зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан Мөрдөн шалгах хэлтсийн хэмжээнд хүлээн авч буй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажлын ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан мөрдөгч нарын ажлын ачааллыг дунджаар авч үзвэл жилд 1 мөрдөгч 30.6 гомдол, мэдээлэл, 40.6 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оноос ажлын ачаалал 3-5 дахин нэмэгдсэн гэж дүгнэж байна.

САНАЛ

- Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулалгүйгээр томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт байхгүйгээс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төрийн бодлогод сөргөөр нөлөөлж байна. Иймд ХАСУМ хянуулалгүйгээр нийтийн албанд томилсон тохиолдолд томилох шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх заалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмэлтээр оруулах шаардлагатай гэж үзэж байна.
- Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т заасны дагуу зөвхөн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн, албан тушаалтны банкны данс, гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авах боломжтой бөгөөд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдүүдийн банкны данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах боломжийг хуульчлан тогтоогоогүй нь албан тушаалтны үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд томоохон бэрхшээл учруулж байгаа ба тухайн албан тушаалтны өөрийн гарган өгч буй мэдээллээр хязгаарлагдах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай хөндлөнгийн нотолгоог бүрэн цуглуулах боломжгүй байгаа нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.
- Зөрчил гаргасан албан тушаалтан хариуцлагаас гадуур үлдэх эрсдэлийг бий болгож, хяналт шалгалтын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа хөөн хэлэлцэх хугацааны талаар болон хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг гаргах үүрэг бүхий этгээдийн хамрах хүрээг эрхлэх албан тушаалынх нь онцлог, шийдвэр гаргах эрх мэдэл улсын өмчтэй харилцах үйл ажиллагаа зэрэг авлигад өртөх эрсдэлийг харгалзан оновчтой тогтоох, түүнчлэн Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 25 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан ХАСХОМ гаргасан мэдүүлэг гаргагчдын тоон үзүүлэлт нэмэгдэх хандлагатай болсон тул Авлигын эсрэг хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны тогтоолд тодорхой өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.
- Хөөн хэлэлцэх хугацааны талаар болон ХАСХОМ гаргадаггүй төрийн албаны бусад ангилал, зэрэглэлд хамаарах албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй үйлдэлд хяналт тавих, урьдчилан сэргийлэх хариуцлага хүлээлгэх зорилгоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд бусад төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон асуудлыг тухайн хуулийг баримтлан шийдвэрлэх талаарх заалтыг нэмж тусгах шаардлагатай болно.

- Нэг мөрдөгчид ногдох ачаалал 3-5 дахин өссөн нь гэмт хэргийг шуурхай илрүүлэхэд хүндрэл учруулж, гэмт хэрэгтэнд ял завшуулах боломж олгох нөхцөл байдал үүсгэж байгаа тул мөрдөгчийн орон тоог 2 дахин нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх талаар системтэй арга хэмжээ авах, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс орнуудтай байгуулах, авлига, мөнгө угаах, терроризм, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис наймаалах зэрэг гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр хоёр болон олон талт гэрээ байгуулж нэгдэн орох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улсад байгаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх, хураан авах, хөрөнгө буцаах ажиллагааг явуулах зорилгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэрээ байгуулах туршлага судлах, энэ чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллага /Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, хууль сахиулах байгууллага/-уудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ, эх сурвалж, хүсэлтэй холбогдсон тоо баримтуудын талаарх мэдээллийн нэгдсэн бааз, хууль сахиулах байгууллага хоорондын цахим санг бий болгож, үйл ажиллагаанд ашиглах, мэдээ, мэдээллийг тодорхой хугацаанд давтамжтайгаар шуурхай солилцох ажиллагаа болон гэрээний дагуу хүргүүлсэн мөрдөгчийн хүсэлтийн гүйцэтгэл, эргэх холбоонд тавих төрийн байгууллагуудын хяналтын тогтолцоог бий болгох, холбогдох бусад үйл ажиллагааг нэг мөр, тодорхой болгон журамлах нөхцөл бий болсны зэрэгцээ эрх зүйн туслалцааны хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан шаардлагын түвшинд боловсруулах, хүсэлтэд тусгагдвал зохих мэдээ, мэдээллийг олж авах арга зам, холбогдох бусад ажиллагааны талаар хуульчдын үргэлжилсэн сургалтын хүрээнд кредитийн сургалтад оруулах, ном, гарын авлагыг боловсруулах, хүртээмжтэй болгох цогц арга хэмжээ авах хэрэгтэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

- МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН
ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
БАЙДЛЫН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ГАРЧ БҮЙ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ

Томилгоотой холбоотой асуудлаар

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө мэргэшлийн сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилох, баталсан орон тоог хэтрүүлэх тохиолдол цөөнгүй байгаагийн зэрэгцээ хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилох, эсхүл томилсны дараа хянуулдаг, нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлдэггүй зөрчлүүд он дараалан илэрсээр байна.

2016-2017 онд

- Булган аймгийн хэмжээнд нийтийн албанд томилогдсон 117 албан тушаалтнаас 15 нь албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянуулаагүй томилсон, 34 албан тушаалтныг томилсны дараа мэдүүлгийг хянуулсан.
- Дархан-Уул аймгийн хэмжээнд 2016 онд томилогдсон 11 албан тушаалтан, 2017 онд томилогдсон 2 албан тушаалтан томилогдсон

өдрөөс хойш хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогоо мэдүүлээгүй.

- Баян-Өлгий аймгийн 16,
- Баянхонгор аймгийн 15,
- Говьсүмбэр аймгийн 21,
- Завхан аймгийн 11,
- Дорноговь аймгийн 43,
- Орхон аймгийн 9,
- Өмнөговь аймгийн 22 албан тушаалтныг тухайн албан тушаалд тус тус томилсны дараа ХАСУМ-ийг хянуулсан.

Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлдөг зөрчил Дархан-Уул аймгийн боловсролын салбарт арилахгүй байна. Тухайлбал, сүүлийн хоёр жилийн хугацаанд ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлыг 4 удаа, 6 дугаар сургуулийн захирлыг 5 удаа, 15 дугаар сургуулийн захирлыг 4 удаа, 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийг 2 удаа, 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийг 3 удаа тус тус өөрчлөн томилжээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2014 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ын дагуу иргэнийг сонгон шалгаруулж авдаг гэх боловч дээрх журам батлагдсанаас хойш нийт 14 иргэнийг албан ёсны сонгон шалгаруулалтаар авсан байх ба бусад удирдах, гүйцэтгэх албан хаагчдыг /469 хүн/ ямар сонгон шалгаруулалтаар авсан нь тогтоогдохгүй байна.

Дорноговь аймгийн хэмжээнд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан 2018 онд 6 албан тушаалтан,

Төв аймгийн хэмжээнд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ээ гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан 2018 онд 5 албан тушаалтан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын хүрээнд

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3-т “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана”, 3.1-т “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.” гэж тус тус заасныг баримтлан хэрэгжүүлэхгүй байна.

ДУНДГОВЬ АЙМАГ

2018 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 29.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар нөөц хөрөнгөөс гаргах зардлыг урьдчилан хэлэлцдэггүй, гүйцэтгэлээр нь хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж, хэлэлцэн захирамж гаргадаг.

Урамшуулал, тэмцэн уралдаан, мэндчилгээ дэвшүүлэх зэрэгт 2017 онд 196.4 сая төгрөг зарцуулсан нь батлагдсан хөрөнгийн 76.7 хувь, 2018 онд 114.8 сая төгрөгийг зарцуулсан нь батлагдсан хөрөнгийн 67.2 хувьтай тус тус тэнцэж байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаад дүгнэлт хийж, таслан зогсоох чиглэлээр Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй атал зарим аймаг, суманд ИТХ-ын даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмыг батлан орон нутгийн төсөвт хөрөнгө тусгаж, гадны зочид төлөөлөгчдийн хоол, унаа, буудал, бэлэг, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал, уралдаан, тэмцэн зэрэгт зарцуулах боллоо.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Өвөрхангай аймаг 2018 онд 28.5 сая төгрөг төсөвлөж, 23.5 сая төгрөгийг зарцуулсан

Уянга сум 2018 онд 5 сая төгрөг төсөвлөж, 3.9 сая төгрөгийг зарцуулсан

2018 онд **Сүхбаатар аймгийн** Засаг даргын нөөц хөрөнгө 350 сая төгрөг батлагдсанаас хүлээн авалт, хүндэтгэл үзүүлэхэд 55,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2018 онд **Ховд аймгийн** Засаг даргын нөөц хөрөнгөөс цагаан сар, наадам, ойн баяр тэмдэглэхэд 24.2 сая төгрөг, хүлээн авалтад 12.6 сая төгрөг, урамшуулалд 37.6 сая төгрөг гэх мэт зориулалтаар нийт 151.9 сая төгрөгийг зарцуулжээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2018 оны Үндэсний их баяр наадмын төсвийг 55.8 сая төгрөгөөр баталж, аймгийн Засаг даргаас нийт 60.1 сая төгрөгийг зарцуулах захирамж гаргажээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны нөөц хөрөнгийн үлдэгдэл 36.1 сая төгрөг буюу сангийн нийт хөрөнгийн 13 хувь, Ерөө сумын Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдэл 14.4 сая төгрөг буюу 25 хувь, Хүдэр сумын Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдэл 5.5 сая төгрөг буюу 13.3 хувьтай байна.



Хууль бус дүрэм, журмын хүрээнд

Хуулиар эрх олгоогүй байхад захиргааны акт гаргадаг, захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй мөрдүүлдэг, хүчингүй болсон хууль хэрэглэх, хуульд байхгүй зүйл, хэсэг, заалтыг иш татан шийдвэр гаргадаг, хууль бус төлбөр хураамж, торгуулийг дур мэдэн бий болгох зөрчил түгээмэл байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016 оны А/782, 2017 оны А/67 дугаар захирамжаар тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоон мөрдүүлж байна. Засаг дарга нь ИТХ-ын бүрэн эрхэд халдаж дээрх шийдвэрийг гаргахдаа спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хураамжийн хэмжээг хуульд заасан хэмжээнээс **100-200 мянган** төгрөгөөр хэтрүүлэн тогтоосныг хянан үзэж, хүчингүй болгуулах арга хэмжээг авсан.

Булган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 136 тоот тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам” болон “Тусгай зөвшөөрөлтэй цэг, салбарт орон нутгаас тавих шаардлага”-ыг баталсан байх бөгөөд тус журмын 2 дугаар хавсралтын “тусгай зөвшөөрөлтэй цэг, салбарт орон нутгаас тавих шаардлага” гэсэн хэсэгт “орон нутгийн үйлдвэрлэгчийн гэрээт борлуулагч байж нутгийнхаа хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна” гэж заасан нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага нь “Аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна. Уг журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актыг нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байна.

Нөхөн сэргээлт хийх нэрийдлээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ашигт малтмалын олборлолт явуулан түүнээсээ хандив авч, орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлж байгааг таслан зогсоох шаардлагатай.

Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө гарган нөхөн сэргээх боломж хомс, хаягдал нөөцийг авалгүй нөхөн сэргээсэн тохиолдолд гар аргаар алт олборлогч иргэд тухайн газрыг дахин ухах асуудал гарч байгаа гэсэн шалтгаанаар нөхөн сэргээлт хийх нэрээр хаягдал нөөцийг ашиглах замаар орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх асуудал түгээмэл байна. Энэ талаарх эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс орон нутгийн удирдах байгууллагаас Монгол Улсын Үндсэн хуулийн жаран хоёрдугаар зүйлийн 2-т заасан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.” гэснийг баримтлан шийдвэр гаргаж, уг ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны А/433 дугаар захирамжаар эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч нарт тавигдах шаардлага, нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах үнэлгээний хуудсыг тус тус баталж, 30 гаруй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. Уг захирамжаар баталсан “нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч нарт тавигдах шаардлага”, аж ахуйн нэгжтэй байгуулсан нөхөн сэргээлтийн гэрээний агуулга нь “нөхөн сэргээлт хийх” гэхээсээ илүү олборлолт хийх, орлого бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Төсөв, санхүүгийн нөөцийг зориулалтын бусаар зарцуулах, санхүүгийн хариуцлагыг сул, төсвийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл бүрдүүлсээр байна. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит байгууллагуудад төсвийн хөрөнгийг баяр, наадам, ой тэмдэглэх, ажлын үр дүнг харгалзахгүй бүх ажилтанд хавтгайруулан урамшуулал олгох зэргээр хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчил гарч байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар нийт албан хаагчдад 2015 онд 222.3 сая төгрөгийн урамшуулал, 2016 онд 286.5 сая төгрөг буюу сүүлийн хоёр жилийн хугацаанд үр дүнгийн гэрээний урамшуулалд нийт 508.8 сая төгрөгийг олгоходоо төрийн албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж өндөр амжилт гаргасан болон онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлснийг харгалзахгүйгээр нийт албан хаагчдад хавтгайруулан олгосон байна.



Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/223 дугаар тушаалаар Тулгар төрийн 2225 жил, Их Монгол Улсын 810 жил, Ардын хувьсгалын 95 жилийн баяр наадам тэмдэглэхтэй холбогдуулан хүлээн авалтын үйл ажиллагаанд 3.30 сая төгрөг зарцуулсан.



Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны А/99 дугаар тушаалаар Засгийн газрын гишүүдийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаанд 1.54 сая төгрөг зарцуулсан.



Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/163 дугаар тушаалаар Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 50 жил, Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 60 жилийн ойг тэмдэглэхэд сургууль тус бүрт 500 мянган төгрөг зарцуулсан.



2016 оны А/124 дүгээр тушаалаар Үйлдвэрлэл, урлалын Политехник коллеж, Монгол-Солонгосын Политехник коллежийн 50 жилийн ойн арга хэмжээнд тус бүр 1 сая төгрөгийг хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн зардлаас зарцуулсан.

2017 онд

- ✓ Өвөрхангай аймаг **35.0** сая,
- ✓ Дорноговь аймаг **43.8** сая,
- ✓ Төв аймаг **63.4** сая төгрөгийг улсын баяр наадам тэмдэглэхэд зарцуулжээ.



Эрчим хүчний салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ижил төстэй ТӨХК-ийн ажилтан, албан хаагчдын цалин, урамшууллын асуудал харилцан адилгүй байна. Тухайлбал, “Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь сар бүр албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэн сарын үндсэн цалингийн 30-50 хувь хүртэл нэмэгдэл олгодог бөгөөд үр дүнгийн урамшуулалд 2016 онд 1.9 тэрбум төгрөг, 2017 оны эхний улиралд нийт 450.6 сая төгрөг, Эрчим хүчний хөгжлийн төвийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар бүр дүгнэн 10-50 хувь хүртэл хэмжээгээр нэмэгдэл, урамшуулал олгодог бөгөөд 2015 онд 226.4 сая төгрөг, 2016 онд 258.9 сая төгрөг, 2017 оны 1 дүгээр улиралд 111.9 сая төгрөгийг тус тус олгосон.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон газрын хэмжээнээс томсгож барьсан, зориулалтыг нь өөрчилсөн, чанарын шаардлага хангахгүй баригдсан барилга, байгууламжийг ашиглалтад оруулах зөвшөөрөл олгодог, Барилгын тухай хуульд заасан барилга хоорондын зайг зөрчиж барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгодог зэрэг зөрчлүүд байна.

- Нийслэлийн газрын албанаас Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор баталсан тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд багтаагүй газрыг олгодог, төрийн байгууллагууд газар эзэмших эрхээсээ татгалзаж хувийн эзэмшилд шилжүүлэхтэй холбоотой болон газар эзэмших, ашиглуулах, өмчлүүлэх шийдвэр гаргах явцад авлига, ашиг сонирлын зөрчил үүсч байна.



Баянзүрх дүүрэг

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны Б/35 дугаар тушаалаар тус дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад гэр бүлийг дэмжих, амьдралын баталгааг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь зориулж 20 сая төгрөгийг олгосон.

Тус хэлтсийн дарга нь 5 хоногийн дараа 2017 оны Б/40 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн байна. Тушаалын үндэслэлд Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох талаар дурдсан боловч уг хөтөлбөр 2016 онд хэрэгжиж дууссан, тэтгэмж олгох асуудлаар удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй, шийдвэр гаргаагүй байна.

Түүнчлэн уг хэлтсийн даргаар өмнө нь ажиллаж байсан албан тушаалтанд ч 2016 онд 4.9 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгож байжээ. Энэ нь төрийн албан хаагчийг ажлаас нь чөлөөлөхийн тулд тэтгэмж, буцалтгүй тусламж нэрээр мөнгө олгодог байж болзошгүй асуудал гарсан байна.

Ажлаас хууль бусаар чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор шүүхийн шийдвэрээр 2016, 2017 онд



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 12 албан тушаалтныг хууль бусаар ажлаас чөлөөлсөнтэй холбоотойгоор **224.4** сая төгрөгийн нөхөн олговор олгосон.



НИЙГМИЙН ХАЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАР

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар **65.1** сая төгрөгтэй тэнцэх хэмжээний нөхөн олговрыг 2016 онд олгосон.



Оюуны өмч, улсын
Сүртэнгийн ерөнхий
Газар

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар **35.2** сая төгрөгийн нөхөн олговрыг олгохоор болжээ.



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам **30.3** сая төгрөгийн нөхөн олговор олгосон.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар **19.9** сая төгрөгийн нөхөн олговор олгосон.



Нийгмийн даатгалын ерөнхий газар **18.8** сая төгрөгийн нөхөн олговор олгосон.



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 1 албан тушаалтанд **6.1** сая төгрөгийн нөхөн олговор олгосон.

Сүхбаатар аймаг шүүхийн шийдвэрээр 74.8 сая төгрөгийн ажилгүй байх хугацааны нөхөн олговор олгохоор шийдвэрлэснээс 28.1 сая төгрөгийг, ажлаас халагдсаны тэтгэмжинд 13.7 сая төгрөгийг тус тус улсын төсвөөс гаргасан байна.

Булган аймгийн хэмжээнд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 2016-2017 онд 14 албан хаагчийг чөлөөлж 36.3 сая төгрөгийн тэтгэмж, 3 албан хаагчийг шүүхийн шийдвэрийн дагуу эргүүлэн томилж, нөхөн олговорт улсын төсвөөс 13.1 сая төгрөгийг тус тус олгосон бол 2018 онд уг зөрчил дахин давтагдаж тус аймгийн Музейн захирлыг үндэслэлгүйгээр үүрэгт ажлаас нь чөлөөлж нөхөн олговорт улсын төсвөөс 1.5 сая төгрөгийг олгосон зөрчлийг давтан гаргасан байна.



Худалдан авах ажиллагаатай холбоотой нийтлэг зөрчил, дутагдлын талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр улсын хэмжээнд 2017 онд нийт 4.17 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 8904 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 75.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээ буюу нийт худалдан авалтын 0.69 хувийг зохион байгуулсан нь яам, агентлагууд үндсэн үйл ажиллагааны худалдан авах ажиллагааг өөрсдөө зохион байгуулж байгаатай холбон тайлбарлаж болох юм. Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авалтын ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байх шаардлагатай байна.

“Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан, тендерт оролцоходоо илт худал мэдүүлсэн, авлигын гэмт хэрэг үйлдсэн” бол дахин тендер шалгаруулалтад оруулахгүй байх бүртгэлийг бүрэн, шаардлагын хэмжээнд хөтөлдөггүй.

Сангийн сайдын тушаалаар 2014 онд 42, 2016 онд 1 хуулийн этгээдийг хар жагсаалтад хамруулсан боловч тэдгээрийн 1-ээс бусдынх нь бүртгэлд байх хугацаа нь дууссан байна.

Хууль тогтоомж зөрчиж “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг явдлыг таслан зогсоох, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд үнэн зөв мэдээлдэг байх.

Өмнөговь аймгийн хувьд “Худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй нийт 710 сая төгрөгийн 5 ажил, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, нийт 612.6 сая төгрөгийн 3 ажил, арга хэмжээг “Оюу” төслийн санхүүжилтээр тус тус зохион байгуулсан зөрчил гарсан байна.

Зураг төсөвгүй, бэлтгэл хангагдаагүй ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг байдлыг таслан зогсоох шаардлагатай.

Дорнод аймгийн хэмжээнд 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 18 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас зайлшгүй зураг төсөв шаардлагатай 13 төсөл арга хэмжээний зураг, төсөв нь төсөв батлагдсанаас хойш нөхөж хийгдсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 32 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс зураг, төсөв шаардлагатай 2 төсөл арга хэмжээний зураг, төсөв мөн л төсөв батлагдсанаас хойш хийгдсэн байна. Энэ нь төсөвтөө багтааж зураг, төсвөө зохиодог, авлигын эрсдэлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж ажилладаггүй.

Өмнөговь аймгаас зохион байгуулсан тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой 2017 онд 59, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 12, нийт 71 гомдлыг Сангийн яамнаас шалган үзээд 47-г нь “захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол нь үндэслэлтэй” гэж үзсэн байна.

Засаг дарга нар гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал тохиолдсон гэх бодит бус үндэслэлээр тендер зарлахгүйгээр автомашин шууд худалдан авч байна.

Төв аймгийн Засаг дарга 180 сая төгрөгөөр автомашин (LC 200 VX), Дундговь аймгийн Засаг дарга 195 сая төгрөгөөр автомашин (LC 200) тус тус шууд худалдан авсан.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн явцад иргэн, иргэний нийгмийн байгууллага, сонирхогч этгээдээс хяналт тавих боломжийг олгох, ил тод, нээлттэй байдлыг хангахад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Аймаг орон нутгийн түвшинд нийтлэг байдлаар хуульд заасан дээрх мэдээлэл бүхий самбарыг олон нийтэд харагдахуйц газар байршуулж хэвшээгүй байна.

Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ хуульд заасан шаардлагыг хангахгүй зориудаар бусдад давуу байдал олгож буй явдал гарсаар байна.

Говьсүмбэр аймагт Сангийн сайдын 2017 оны “Эрх шилжүүлэх тухай” 374 дүгээр тушаалаар эрх шилжүүлсний дагуу 700 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй “Татварын хэлтсийн албан конторын барилга”-ын нээлттэй тендерийн техникийн тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном баталсан байх бөгөөд уг тодорхойлолтод “Барилгын үндсэн хана нь тоосгон бүтэцтэй байх”, “Найрамдал хотонд байршилтай байх” гэх зэргээр худалдан авахаар урьдчилж товлосон барилгад тохируулан тусгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд “барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй” гэж заасныг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэж болохоор байна.



Баянхонгор аймгийн сумдын Засаг даргын Тамгын газарт өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор тус бүр 10 сая төгрөг буюу 170 сая төгрөг хуваарилж “Хишиг халиун” ХХК руу шилжүүлсэн ба худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн. Сумдад гэрээ байгуулж өвс худалдаж авсан “Хишигт халиун” ХХК нь аймгийн ИТХ-ын гишүүн, Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Ойнбилэгийн компани байв. Энэ асуудалтай холбогдуулан 2018 оны 4 дүгээр сард хийж дууссан санхүүгийн тайлантай танилцахад нийт 17 суманд 170 сая төгрөгийг “Хишиг Халиун” ХХК руу шилжүүлэн гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаандаа 12 сумын 120 сая төгрөгийн өвс тэжээл нийлүүлэгдээгүй байхад бараа материалын тайланд орлогоор бүртгэж эд хөрөнгийн тооллогыг хуурамчаар үйлдсэн байх ба зөрчилд төлбөрийн акт тогтоолгосон байна.



Ховд аймгийн Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангаас 29.8 сая төгрөгийг Хот тохижуулах газарт усны машин худалдан авах тендерт зарцуулжээ. Уг тендерт шалгарсан нэр бүхий компанийн нийлүүлсэн автомашиныг шалгахад 1999 онд үйлдвэрлэгдсэн, хуучин бохирын автомашин байв.



Барилга, хот байгуулалтын яам 2015-2016 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Сангийн яамнаас тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан аж ахуйн нэгж тендерт оролцсон эсэхийг хянасан тухай тэмдэглэл, баримтгүй, үнэлгээний хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргаагүй, хурлын тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зураагүй байв.



“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь 2016 онд “Тоёота Приус 20” автомашин худалдан авахаар 40 сая төгрөг төсөвлөн харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалт зарлаж, тендерт амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулж худалдан авалтыг зохион байгуулсан байх бөгөөд 3 ширхэг приус автомашин нийлүүлсэн аж ахуйн нэгжийн гаалийн мэдүүлэгтэй танилцахад 1 приус нь 8,0 орчим сая, 2 ширхэг нь 10 орчим сая төгрөгийн үнэтэй байсан. Өөрөөр хэлбэл, 28 сая төгрөгийн үнэтэй автомашиныг 40 сая төгрөгөөр худалдаж авсан.



Эрчим хүчний хөгжлийн төв 2016 онд туулах чадвар сайтай суудлын авто машин худалдан авах үнэлгээний хороог байгуулан нээлттэй тендерийг зарлаж, “Монгол микрон кашмер” ХХК ганцаараа 198 сая төгрөгийн үнийн санал ирүүлж хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэж шалгаруулсан байна. Тендерт санал огт ирүүлээгүй “Монгол Хьюндай автмотив” ХХК-ийг 100 хувийн саналаар шалгарууллаа хэмээн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд дурдсан байна. Тендерт шалгарсан “Монгол микрон кашмер” ХХК нь авто машин худалдааны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг эсэх нь тодорхойгүй, ганцхан компаниас материалаа ирүүлж оролцсон зэргээс үзвэл тендер сонгон шалгаруулалтыг нээлттэй, нийтэд ил тод явуулсан гэж үзэх үндэслэлгүй байна.



Булган аймгийн Спорт ордны “А” блокын барилгын их засварын ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар 2 удаа явуулж “Бурхууд” ХХК шалгарч 2017 оны 5 дугаар сарын 7-ноос 2018 оны 7 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл 733.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Одоогоор 524.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Санхүүжилтийн явцын хяналтын тайлан байхгүй, ажил хүлээлцсэн актуудыг үйлдээгүй байхад санхүүжилтийг олгожээ.



Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаатай танилцахад Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2017 онд хэрэгжүүлсэн 33 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр 871 сая төгрөг батлагдаж, үлдэгдэл 62,3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2018 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явцтай танилцахад дараах зөрчил, дутагдлууд гарч байна. Тухайлбал,

1. Хэрлэн голын эргийн дагуу тохижилт, хамгаалалтын ажил хийх /зураг төсвийн хамт/ 208 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерт “Ган-Октеадр” ХХК шалгарсан ч хийсэн ажлын гүйцэтгэл байхгүй.
2. Байгалийн баялгийн зүй бус ашиглалтыг хянах, хяналт шалгалтын орчин ueийн багаж төхөөрөмж, камерийг Хэрлэн гол дээрх Баянтүмэн, Модон, Ялалтын гүүрэн дээр суурилуулах ажлын зардал 150 сая төгрөгийг ИТХ-аар батлуулж бараа материал нийлүүлэх тендер болгон зарлахад “Дорнын арвижих” ХХК шалгарч 147,9 сая төгрөгийн нийт 58 төрлийн барааг “Гэрэл, сэтгэмж” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт 2017 оны 10 дугаар сарын 6-ны өдөр хүлээлгэн өгсөн байх боловч 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар гүүрнүүдэд хяналтын камер огт суурилогдаагүй байна.



Сэлэнгэ аймагт Засгийн газрын нөөц хөрөнгөөс төрийн үйлчилгээнд ашиглагдаж буй техник хэрэгсэл, автомашины хэвийн ажиллагаа, бэлэн байдлыг хангах зориулалтаар 2017 онд 220 сая төгрөгийг хуваарилсан боловч тус аймгийн эрх бүхий албан тушаалтнууд мөн л худалдан авах ажиллагааны хуулийн дагуу төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй гэж үзэхээр байна.

Дээрх санхүүжилтээр аймгийн Засаг даргын Тамгын газар, Сайхан, Хүдэр, Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, улсын төсвийн байгууллага, Шаамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэгт автомашин, эмнэлгийн зориулалттай бүрэн тоноглогдсон 200 ширхэг ор худалдан авсан хэдий ч тухайн худалдан авах үйл ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулж худалдан авсан байна.



Архангай аймгийн Хотонт сумын алслагдсан багт явуулын шатахуун түгээх автомашин, Байгаль орчны албанд туулах чадвар сайтай автомашин худалдан авахдаа 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлд үнийн санал ирээгүй тул захиалагчид зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв гэснээс өөр ямар ч тендерийн баримт байхгүйгээр иргэн М.Тамир, Б.Нямсүрэн нартай шууд гэрээ байгуулан автомашин худалдан авсан байна.



Баянхонгор аймгийн “Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” худалдан авах 45,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг харьцуулалтын аргаар 2018 оны 7 дугаар сард зохион байгуулахад оролцогч ирээгүй тул захиалагчид шууд гэрээ байгуулах зөвлөмжийг үнэлгээний хорооноос өгсөн. Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дашцэрэн нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө давуу байдал бий болгож иргэн П.Дамбасүрэнтэй 45.1 сая төгрөгөөр тендерийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангахгүй Лексус 470 маркийн автомашиныг худалдан авахаар гэрээ байгуулж захиалагч Д.Батжаргалаар гэрээг батлуулсан. Санхүүжилт хийгдсэний дараа Ц.Дашцэрэн нь 10 сая төгрөгийг иргэн П.Дамбасүрэнгийн данснаас бэлнээр гаргуулан авсан болох нь тогтоогдсон.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр 35 сая төгрөгөөр Ниссан караван маркийн автомашиныг худалдан авахдаа харьцуулалтын арга амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулж худалдан авалтыг хийсэн. Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дашцэрэн нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө давуу байдал бий болгож Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн С.Цэвээнсүрэнгийн нөхрийн “Индранил Очир” ХХК-тай шууд гэрээ байгуулж Ниссан караван маркийн автомашиныг нийлүүлж тус компанийн дансаар 35 сая төгрөгийг шилжүүлж н.Мөнхбаатар гэх хүний данс руу дамжуулан шилжүүлсэн болох нь тогтоогдсон. Худалдан авсан гэх Ниссан караван нь 2008 онд үйлдвэрлэсэн ба 2018 онд импортоор орж ирсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын чиглэлээр:

Авлигатай тэмцэх газраас Засгийн газар, Засгийн газрын гишүүдэд 2017, 2018 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, гарсан зөрчил дутагдал арилахгүй байна.

Тухайлбал,



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хуулиар хүлээсэн чиг үүргээ бие даан гүйцэтгэх нөхцөлийг хангах,



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, батлуулах,



Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг нэр заан томилох, чөлөөлөхөөр чиглүүлж байгааг зогсоох,



ТҮЗ-ийн дарга, гишүүнийг томилохдоо өрсөлдөөнт шалгаруулалтын аргаар томилдог, үр дүнг тооцдог тогтолцоо нэвтрүүлэх,



төрийн байгууллагууд дахь мэдээлэл (бүртгэл, лавлагаа)-ийг нэгтгэсэн "Нэгдсэн цахим сүлжээ бүхий бааз"-ыг бий болгон бэхжүүлэх,



Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах,



Тусгай зөвшөөрөл хүсэгчээс хуульд заагаагүй баримт, материал шаардаж чирэгдэл учруулж буй явдлыг таслан зогсоох,



Зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар уг асуудлыг шийдвэрлэж байх,



Үйлчилгээний чанар хүртээмжид судалгаа хийж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх,



Цахим гарын үсэг олгох, хаягжуулах, баталгаажуулах ажлыг түргэтгэх,



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд хувийн хэвшлийн үл хөдлөх эд хөрөнгө (байр, талбай)-ийг түрээслэхэд жил бүр олон тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулж байгааг зохистой байдлаар шийдвэрлэх зэрэг асуудлаар салбарын яам, албан тушаалтнууд холбогдох арга хэмжээг авч ажиллахгүй байгаад дүгнэлт хийх шаардлагатай.

Засгийн газрын тусгай санд холбогдох асуудлаар:

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд Сангийн яамнаас хийсэн шалгалтын тайланг олон нийтэд мэдээлснийг эс тооцвол энэ талаар салбарын яам, албан тушаалтны зүгээс дорвитой арга хэмжээ авсангүй. Авлигатай тэмцэх газраас хийсэн шалгалтын мөрөөр салбарын сайд нарт 2017 онд хүргүүлсэн зөвлөмжид Мал хамгаалах сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан зэрэг санг онцлон, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах, иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгохыг зөвлөсөөр байтал үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар бодитой ажил арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс зарим сангийн нэр бүхий удирдах албан тушаалтнууд нь авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна.



Баян-Өлгий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 2 тэрбум төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан байна. Гэвч тус аймгийн холбогдох байгууллага нь үндсэн хөрөнгийг захиран зарцуулах, хувьчлах, худалдах, устгах, элэгдэл хорогдлыг тооцох чиглэлээр судалгаа хийгээгүй, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах, хувьчлах, устгах талаар төлөвлөгөө байхгүй байв.



Сэлэнгэ аймагт орон нутгийн өмчит 13 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас зарим байгууллага нь үйл ажиллагаа явуулдаггүй, олонх нь алдагдалтай ажиллаж байна. Жишээ нь:

“Цант-Орхон” ОНӨААТҮГ нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 11.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Гавшгай-Ус” ОНӨААТҮГ нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 143 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 577.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2017 онд 104.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь 71 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ нь 2017 онд 12.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Урсгал ус” ХХК нь 2017 онд 10,7 сая төгрөгийн, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 17.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Сэлэнгэ Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 4.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ нь 2017 онд 7.7 сая төгрөгийн алдагдалтай нийт 43 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

“Сэлэнгэ баялаг ирээдүй” ОНӨААТҮГ нь 2017 онд цалингийн 2.2 сая, ХХОАТ-ын 219 мянга, нийт 2.5 сая төгрөгийн өр төлбөртэй 2018 онд үйл ажиллагаа явуулаагүй.



Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын талаар:



Говь-Алтай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны зарцуулалтын дүн 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 1.1 тэрбум төгрөг байна. Үүнээс 24 хувь буюу 283.1 сая төгрөгийг спортын уралдаан тэмцээн, уулзалт, хурал, аян, гадаад томилолт зэрэгт зарцуулжээ. Гамшгийн сангийн өвс тэжээлийн үнэд 31.4 сая төгрөгийн зарцуулалт ИТХ-аар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалтыг зөрчиж байна.



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 2011 оноос хойш 50 иргэнд 710,4 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 5 зээлдэгчийн 54,3 сая төгрөгийн зээл байгаад анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Сүхбаатар аймгийн Наран сум 2011 оноос хойш 60 иргэнд 389,7 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй байгаа 9 зээлдэгчийн 53,5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна. Зээл олгох комиссын гишүүд ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан байна. Тухайлбал, Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны гишүүн сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байсан “И” өөрийн дүү “Э”-д 20 сая, Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны гишүүн, төслийн нарийн бичиг “О” өөрийн хамаарал бүхий этгээд болох “Б”-д 5 сая төгрөгийн зээл олгосон байна.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 2011 оноос хойш 50 иргэнд 710,4 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 5 зээлдэгчийн 54,3 сая төгрөгийн зээл байгаад анхаарал хандуулах нь зүйтэй байна.



Өмнөговь аймгийн Төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах зарыг сумын Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хаягаар олон нийтэд хүргүүлсэн, мэдээллийн самбарт байршуулсан гэх боловч энэ нь иргэдэд хүрдэггүй, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүдийн хүрээнд мэдээлэгдсэн гэж үзэхээр байна. Тухайлбал, Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газрын ня-бо, хяналтын зөвлөлийн гишүүн Ш.Хосбаярын ээж Х.Гэрэлмаа (20 сая төгрөг, санд мөнгөн хуримтлал бүрдээгүй тул 10 сая төгрөг олгосон гэх), Ханбогд сумын ерөнхий санхүүч, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн Л.Баяртогтохын төрсөн эгч Л.Отгонцэцэг (12 сая төгрөг) зэрэг иргэд зээл авчээ.

Зээл хүсэгчээс ирүүлсэн хүсэлт, төслийг асуудал хариуцсан мэргэжилтэн ёс төдий бүртгэдэг, зарим хүсэлт бүртгэгдээгүй, хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсгээр баталгаажаагүй зэрэг нь хяналт шалгалтын ажил явуулахад хүндрэлтэй, иргэний гомдлыг үнэн зөв шийдвэрлэх, захиргааны байгууллагын ажилтанд хариуцлага тооцох боломжгүйд хүргэж байна. Сангаас өмнөх жилүүдэд зээл авсан боловч зээлийн эргэн төлөлт хийгээгүй Цогтцэций сумын 19 зээлдэгч, Ханбогд сумын 2 зээлдэгч, Гурвантэс сумын 3 зээлдэгчид олгосон зээлийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх шаардлагатай байгаад анхаарч ажиллахыг зөвлөсөн байна.



Дундговь аймгийн Сум хөгжүүлэх сангаас өмнөх жилүүдэд зээл авсан боловч зээлийн эргэн төлөлт хийгээгүй Баянжаргалан сумын 6 иргэн (Г.Энхтайван авто засвар 15 сая, Э.Маралмаа сүү, сүүн бүтээгдэхүүн 5 сая, Л.Цэрэнбаяр компьютер хэвлэлийн үйлчилгээ 7 сая, Ц.Ягаанцэцэг хэрчсэн гурил, нарийн боов 10 сая, Ж.Норжин оёдол 2 сая, Г.Оюунбат гахайн аж ахуй 10 сая)-ий авсан 49 сая төгрөг, Гурвансайхан сумын 9 иргэн (Э.Отгонбаатар компьютерийн үйлчилгээ 5 сая, Х.Өлзийрагчаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүн 5 сая, Х.Булганбаатар зайрмагны цех 20 сая, Д.Жаргалсайхан автозасвар 4 сая, М.Батсүх хүнсний ногоо тариалах 3 сая, Ч.Эрдэнэцэцэг цайны газар 4,3 сая, Ц.Батболд гутал засвар, оёдол 8 сая, Ш.Гантулга блок 4 сая)-ий 53.3 сая төгрөгийг тус тус шүүхээр хянан шийдвэрлүүлэх шаардлагатай.

Дундговь аймгийн Баянжаргалан суманд үйл ажиллагаа явуулж байсан ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Эм Си Ти Ти” ХХК-иас ажиллах хүчний зөрүү гэж 2009 онд 22.5 сая төгрөг хүлээн авсныг Сум хөгжүүлэх сангийн дансанд байршуулан уг эх үүсвэрээс төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүүтэй зээл олгож, зээл болон зээлийн хүүг төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.4-т заасан буюу тус сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө уг дансанд байршуулахыг хориглосон зохицуулалтыг зөрчсөн.

Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхтуяа, Санхүүгийн албаны дарга Ү.Алимаа нар нь сонгон шалгаруулалт зарлаагүй байхад албан тушаалын давуу байдлаа ашиглан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс өөрийн хамаарал бүхий этгээдэд нийт 33 сая төгрөгийн зээлийг гаргуулсан асуудлаар Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.



Дорнод аймгийн хувьд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, сангийн хөрөнгийн захиран зарцуулалт хангалтгүй, зээлийн 30-40 хувь нь чанаргүй, эргэн төлөгдөөгүй байна. Тухайлбал,

1/ Баян-Уул сум 2011 оноос хойш 53 иргэнд 397,1 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 22 зээлдэгчийн 146,1 сая төгрөгтэй тэнцэх зээл байна.

2/ Матад сум 2011 оноос хойш 61 иргэнд 313,2 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 26 зээлдэгчийн 101,4 сая төгрөгтэй тэнцэх зээл байна.

3/ Цагаан-Овоо сум 2011 оноос хойш 94 иргэнд 384,5 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 40 зээлдэгчийн 130,6 сая төгрөгтэй тэнцэх зээл байна.

4/ Халхгол сум 2011 оноос хойш 86 иргэнд 569,5 сая төгрөгийн зээл олгосноос эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн 22 зээлдэгчийн 71,7 сая төгрөгтэй тэнцэх зээл байна.



Хуулийн хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн талаар:



Булган аймгийн 80 жилийн ой тохиохтой холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 36 дугаартай тогтоолоор ойг угтаж хийх бүтээлч ажлын жагсаалт, төлөвлөгөөг баталсан боловч үг төлөвлөгөөнд төсвөөр хийгдэх ажлуудын төсвийг тодорхой оруулж батлуулаагүй, хийгдэх ажлуудыг жагсаалтаар баталсан нь Төсвийн тухай хууль болон холбогдох дүрэм журмуудыг зөрчсөн байна. Мөн ойтой холбогдуулан “Булган инноваци клуб” төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээг Булган аймгийн Засаг даргын орлогч, ой зохион байгуулах комиссын дарга Ц.Бат-Өлзий, Булган инноваци төрийн бус байгууллагын тэргүүн Х.Энхбат нар 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсны дагуу тус төрийн бус байгууллагын дансаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс нийт 3 тэрбум орчим төгрөгийн хандив цугларсан байна. Харин хандиваар цугларсан хөрөнгөөр хэчнээн төгрөгийн ямар ажлуудыг гүйцэтгэсэн талаар тайланг гаргаагүй.



Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар Хэнтий аймаг байгуулагдсаны 95 жилийн ойн арга хэмжээнд зориулж төрийн байгууллага, хувийн хэвшил ард иргэдээс нийт 403 сая төгрөгийн хандивыг цуглуулж, “Хэнтийн хөгжил” төрийн бус байгууллагыг байгуулан дансанд нь байршуулж зарцуулсан байна. Хандиваа нийтийг хамарсан тэгшитгэсэн байдлаар цуглуулсан байх ба хандивын зарцуулалтын нэгдсэн тайлан тооцоо гаргаагүй, тус данснаас 403.3 сая төгрөгийн зарлага гүйлгээгээр гаргасан байгаа боловч санхүүгийн баримтаар 319.1 сая төгрөгийн зөрүү гарч байна.

Хэнтий аймгийн Норовлин сумын ерөнхий боловсролын сургууль 2017 онд сургуулийн 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн ба ойг тэмдэглэхэд сумын төсөвт байгууллагууд иргэдээс 51 сая төгрөгийн хандив тусламжийг авсан байна. Хандив тусламжийн талаар жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй, хандив авч болох талаар удирдах албан тушаалтнаас холбогдох зөвшөөрөл аваагүй байна.



Дорноговь аймагт иргэн, аж ахуйн нэгжээс хандив авахын тулд байгууллагын дүрмийг батлахдаа зориуд хууль бус хэм хэмжээ тусган, тухайн байгууллагад хуульд нийцээгүй хандив авах эрх олгосон зөрчил байна.

Тухайлбал, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нь 2017 оны А/72 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрын дүрмийг баталсан байна. Энэхүү дүрмийн 3 дугаар зүйлд тус газрын эрх, үүргийг тодорхойлж өгсөн байх бөгөөд дүрмийн 3.2-т “Ажилчдын нийгмийн болон ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор зарим төрлийн төлбөртэй үйлчилгээг үзүүлэх, хандив, дэмжлэг, тусламж авах” гэж заажээ. Үүний дагуу Говийн догшин ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 215 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхээр нийтдээ 152 иргэн, аж ахуйн нэгжээс 1.1 тэрбум төгрөгийн хандив цуглуулсан байна.

Дүрмийн 1.1-д Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрыг “Орон нутгийн төсөвт газар мөн” гэж тодорхойлжээ. Орон нутгийн төсөвт газар нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн

үйлчлэлд хамаарна. Уг дүрмийн 3.2 дахь хэсгийг баримтлан болон тус дүрмийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжээс хандив авсан үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй байна.



Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан “Түүхт Баянжаргалан” төрийн бус байгууллагын ХААН банкин дахь 5450604184 тоот дансанд хандив төвлөрүүлсэн байх ба хандивын хөрөнгийг сумын Засаг дарга Г.Туяа захиран зарцуулдаг. Тодруулбал, “Говьшоо” ХХК, “Тайшэндевелопмент” ХХК, “Дүнъли” ХХК, “Тайхар орд” ХХК, “Дэжиэ” ХХК, “Биг могул” ХХК, “Циркон геологи” ХХК, “Эм Жи Би” ХХК, “Аргатай” ХХК, “Окслей Айрон” ХХК-иас нийт 60.8 сая төгрөгийг 2017 оны 5 дугаар сарын 9-нөөс 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд дээрх дансанд төвлөрүүлж, малчны баяр, шинэ жил, аялал, бараа материал худалдан авах, эмнэлэг, Засаг даргын Тамгын газрын автомашины засвар, урлагийн наадам зэрэгт 56.8 сая төгрөгийг зарцуулжээ.



Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багийн сургуулийн захирал О.Мөнхтуяа нь 2014 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн Б/15 тушаалаар төрсөн хүү Ч.Ариунбаатарыг дотуур байрны багшаар, мөн өдрийн Б/12 тушаалаар хүү Ч.Ариунбаатарын эхнэр Т.Энхчимэгийг түүх, нийгмийн ухааны багшаар тус тус томилсон байна. Түүнчлэн тус сургуульд математикийн багшаар ажиллаж байгаа төрсөн охин Ч.Нямсүрэн (өмнөх захирлын тушаалаар томилогдсон) болон хүү Ч.Ариунбаатар, бэр Энхчимэг нарт үр дүнгийн урамшуулал, говийн бүсийн урамшуулал олгохдоо хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг гаргаагүй зөрчилд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх хэсэгт заасны дагуу О.Мөнхтуяад хариуцлага тооцуулаад байна.



Увс аймгийн “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь хувийн эзэмшлийн, 1995 онд Солонгост үйлдвэрлэсэн “hyundai 5 ton truck” маркийн жижиг оврын краныг төрсөн дүүгийнхээ найзын компани руу шилжүүлж, тус ТӨХК-ийн охин компани болох “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-д 47,9 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан нийлүүлсэн байв. Түүнчлэн компанийн үндсэн хөрөнгөд 102.8 сая төгрөгийн бүртгэлтэй, 2010 онд үйлдвэрлэсэн Ланд крузер-200 маркийн авто машиныг дуудлага худалдаанд оруулж зах зээлийн ханшаас хямд үнээр буюу 6,6 сая төгрөгөөр өөрийн жолоочдоо худалдсан. Мөн тус компанийн үндсэн хөрөнгөд 107,5 сая төгрөгийн бүртгэлтэй байсан автокраныг зах зээлийн үнээс илт доогуур үнээр буюу 6,4 сая төгрөгөөр худалдан борлуулсан байна. Тэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаас өмнө эдгээр авто техникүүдийг хэт хуучирсан гэж ташаа тайлбарлаж, хямд үнээр худалдах зөвшөөрлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар гаргуулсан байв.



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Боловсролын салбар дахь авлига, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр “Багшийн ёс зүйн дүрэм”-ийг багш нар мэддэггүй, сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг БСШУСЯ болон бусад салбарын төрийн удирдлагын байгууллагууд хэрэгжүүлдэггүй тухай асуудлыг хөндсөн.

Төрийн өмчит болон хувийн их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт ёс зүйн хичээлийн эзлэх хувийг судлан гаргахад ялангуяа багш, эмч зэрэг иргэдэд нийтлэг үйлчилгээ үзүүлдэг ёс зүйн өндөр хэм хэмжээг өдөр тутам чанд сахин мөрдөх шаардлагатай мэргэжилтэн бэлтгэдэг хичээлийн хөтөлбөрт ёс зүйн хичээлийн кредит цаг маш бага хувийг эзэлж байна.

Багш, эмч, эрх зүйч, инженер зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрт тавигдах дээд боловсролын стандартад “Эрх зүйч”-ээс бусдад нь ёс зүйн хичээлийг заавал болон сонгон суралцах тухай асуудлыг тусгаагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг туслуулах чиглэлээр мөн л БСШУСЯ-тай удаа дараагийн яриа хэлэлцээ хийж ирсэн ч биднээс үл шалтгаалах байдлаар хойшилж, үр дүнд хүрэхгүй байгаа дүгнэлт хийх шаардлагатай байна.

Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тодорхой хувь нь боловсролын салбарт холбогдох хууль бус төлбөр хураамж, хандив, сургууль цэцэрлэгийн элсэлт, сургууль, цэцэрлэг хууль бус төлбөр хураамж авч байгаа болон өгөөгүй хүүхдүүд, эцэг, эхэд дарамт шахалт учруулдаг, хахууль авч хүүхэд элсүүлдэг, цуглуулсан хандив, хураамжийг хувьдаа завшсан, чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн талаарх агуулгыг хамарч байна.

- Хөвсгөл аймгийн “Эрдмийн далай” цогцолбор сургууль нь 2017 онд 50 жилийн ойг тохиолдуулан багш, эцэг эхчүүд, төгсөгчдөөс 20 орчим сая төгрөг хуримтлуулж, сургуулийн нярвын арилжааны банкин дахь хувийн харилцах дансанд байршуулсан.
- “Шинэ эхлэл” сургууль “Эцэг, эхчүүдийн зөвлөл” гэсэн тамга тэмдэг бүхий албан ёсны төрийн бус байгууллага байгуулан 2016-2017 оны хичээлийн жилд 294 хүүхэд бүрээс 140 мянган төгрөгийн хураамж буюу нийт 41.1 сая төгрөгийг хураан авсан.
- “Оюуны ундраа” цогцолбор сургууль, “Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийн удирдлага нь үзвэрийн билет хүүхэд бүрт борлуулан, хандив цуглуулсан, мөнгө хурааж авсан.
- Баянгол дүүргийн 88 дугаар цэцэрлэгийн эрхлэгч 250-500 мянган төгрөгийг хандив нэрээр авч, анги бүрийн хүүхдийг хэтрүүлж 60-62 хүүхэдтэй болгосон, мөн цэцэрлэгийн хүүхэд бүрээс засварын мөнгө гэдэг нэрээр 25 мянган төгрөгийг хураасан боловч нэмж 5-10 мянган төгрөг хурааж засвар хийсэн. Засварын үлдэгдэл мөнгөнөөс БНХАУ-д аялсан байна.


- Төсөв, зураг, эзэмшил газрын асуудлыг нь урьдчилж нарийн тооцож шийдвэрлээгүйгээс нийслэлийн хэмжээнд 23 цэцэрлэг, сургууль баригдаагүй, барилгын ажил удаашралтай байна.
- Салбар хариуцсан яам нь бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаардаг, захиалагч болон ашиглагч байгууллагаас тендерийн ажлын гүйцэтгэлийн явцын хяналтыг зохих ёсоор тавьдаггүй нийтлэг зөрчил байна.



Салбар хариуцсан яам боловсролын бодлого тодорхойлох, бодлогоо хэрэгжүүлж, зохион байгуулахаас илүүтэйгээр бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд түлхүү анхаарч байна.



Боловсролын салбарын удирдлага удаа дараа солигдсон, хууль, эрх зүйн орчин суларсан, төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээнд өөрчлөлт ороогүй, цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл-хяналтын тогтолцоо байхгүй, цахим бүртгэлд хамруулж дуусаагүй байна.



Цэцэрлэг, сургуулийн элсэлт, бүртгэл, шилжилт, дүн, диплом олголтын үйл ажиллагаанд авлигын эрсдэл өндөр байна. Улмаар сургуулийн захиралд хээл хахууль өгч, эсхүл албан тушаалтны цохолтоор хотын төвийн сургуульд харьяаллын бус хүүхэд элсүүлэх зэргээр авлига, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсгэж байна. Тухайлбал, зарим сургуулийн захирлыг нэгдүгээр ангид хүүхэд элсүүлж авах болон дунд ангид өөр сургуулиас хүүхэд шилжүүлэн авахдаа бусдаас хахууль авдаг байсан үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхээр шийдвэрлүүлсэн байна.



Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Спортыг дэмжих сан зэрэг сангуудын үйл ажиллагаа ил тод биш, эрх зүйн зохицуулалт дутагдалтай учраас авлигын эрсдэл өндөр байна. Тухайлбал, Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад магистрантур, докторантур, бакалаврт суралцагч тодорхой шалтгааны улмаас сургуулиа орхисон тохиолдолд санхүүжилтийг зохицуулсан тодорхой зохицуулалт байхгүйгээс салбарын сайд дангаар сургалтын төрийн сангийн зээлээр магистрантур, докторантур, бакалаврт суралцуулах шийдвэрийг сонгон шалгаруулалтгүй, хууль бус давуу байдал олгож гаргах үндэслэл болж байна. Эдгээр сантай холбоотойгоор Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. 2014, 2015 онд гэрээ байгуулж сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад магистр, доктор, бакалаврт суралцаж байгаа нэр бүхий 12 хүний зээлийн санхүүжилтийг салбарын сайдын 2017 оны А/21, А/118 тушаалаар сонгон шалгаруулалтгүй, 2014 онд Засгийн газрын “Журам, чиглэл шинэчлэн тогтоох тухай” 71 дүгээр тогтоолоор баталсан тэргүүлэх чиглэлийн бус мэргэжлээр суралцуулахаар /бакалаврын тэтгэлгийг Улсын Их Хурлын тогтоолоор зогсоосон/ хууль бусаар давуу байдал олгож нэр бүхий 12 хүнд 2-5 жилийн тэтгэлэг шилжүүлэн өгсөн байна.



Тус яаманд гадаадын зээл, тусламжаар 20 гаруй төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Төслийн хөрөнгийг гадаад томилолт олгох, төсөл хэрэгжүүлэх багт мэргэжилтэн байсаар байтал шаардлагагүй нөхцөлд төслийн зөвлөх үйлчилгээг өндөр үнээр авах зэргээр зориулалтын бусаар зарцуулж байна. Тухайлбал, эдгээр төслүүдийн удирдагч, зөвлөхүүдийн цалин, урамшуулал 2015 онд Засгийн газрын 196 дугаар тогтоолоор баталсан “Гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-д заасан хэмжээнээс давсан /5-8.7 сая төгрөгийн цалинтай/ байна.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

- Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар У.Отгонбаяр, Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар Н.Нарантуяа, Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын үнэ тарифын судалгаа, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтнээр Т.Болорчулуун, Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар О.Лхагвацэдэн, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар Б.Соёмбоо, Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Д.Баярсайхан, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн мэдээллийн сан, техник хангамж хариуцсан мэргэжилтнээр Г.Төгөлдөр, Хот төлөвлөлтийн хэлтсийн хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр Э.Эрдэнэбаяр нарыг тухайн албан тушаалд томилсны дараагаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн.
- Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг нь төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтгүйгээр 2016-2017 онд (Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Соёмбоо, Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Эрдэнэбаатар, Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын үнэ тарифын судалгаа, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Болорчулуун, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн С.Золжаргал, Албан хэрэг, шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн Б.Баатарцэрэн, үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэмбат, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Билэгжаргал, Санхүүгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баярсайхан, Мэдээллийн систем, сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Ууганбаяр, Системийн болон хэрэглээний програм хангамж хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн О.Ууганцэцэг, Вэб админ, вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Оргил, Мэдээллийн сан, техник хангамж хариуцсан мэргэжилтэн С.Өлзийбуян, хүн амын нутагшилт суурьшлын төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Я.Амарсайхан, Газар зүй, хүрээлэн буй орчин, экологийн төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Батчимэг нарын алба хаагчдыг ямар нэгэн сонгон шалгаруулалтгүй, төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтгүйгээр үүрэг гүйцэтгэгчээр томилсон.
- Барилгын тухай хууль, Хот суурин газрыг хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журмуудыг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагын хүрээнд яаралтай боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах, барилгын тусгай зөвшөөрөл олгох явцад Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар батлагдсан хураамжаас гадна Барилгын тухай хуулийг үндэслэн “Барилга хөгжлийн төв” ТӨҮГ-т авч байгаа 195 мянган төгрөгийн хураамжийн талаар судалж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай байгааг зөвлөсөн байна.



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ



Салбарын хэмжээнд албан тушаалтнууд 2015 онд 19, 2016 онд 46, 2017 оны 3 сарын байдлаар 15 удаа ашиг сонирхлын зөрчилгүй болон зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасан боловч дээрх мэдэгдэл нь зөвхөн худалдан авах ажиллагаатай холбоотой мэдэгдэл байх ба бусад захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулахдаа мэдэгдэл огт гаргаагүй, дээрх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.



Тус яаманд 2015 онд мэргэжилтнээр томилогдсон Д.Ганзориг, Э.Мөнхбилэг, 2016 онд томилогдсон Г.Үемаа, Ц.Цогзолмаа, Д.Энхболор, Ш.Ганзориг, 2017 оны 3 дугаар сарын 11-ний өдөр төслийн нэгжийн даргаар томилогдсон Ш.Доржрагчаа нар нь тухайн албан тушаалд томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаагүй, хугацаа хоцроож мэдүүлсэн нь хуульд заасан хариуцлага тооцохоор зөрчил гаргасан.



Эрчим хүчний яам нь 2016 онд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтгүйгээр Санхүүгийн хэлтсийн урсгал зардал хариуцсан мэргэжилтэн Б.Ганцэцэг, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Р.Гантулга, тус хэлтсийн хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн А.Тэмүүжин, Бодлого төлөвлөлтийн газрын дамжуулах сүлжээний бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Алтандуулга, Нарны эх үүсвэрийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Х.Мөнхбат, Усан цахилгаан станц, бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Болд, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын эрчим хүчний хэмнэлт хариуцсан мэргэжилтэн Г.Тулга, Б.Соёл-Эрдэнэ, Сэргээгдэх эрчим хүчний эс үүсвэрийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн Б.Баясгаланбаатар, Дулаан хангамжийн горим тооцоо хариуцсан мэргэжилтэн М.Балдорж нарын нийт 10 албан хаагчийг шууд томилсон.



2015 онд 255 өргөдөл, гомдол хүлээн авснаас 50 буюу 19.6 хувийг, 2016 онд 281 өргөдөл, гомдол хүлээн авснаас 95 буюу 33.8 хувийг, 2017 оны эхний 4 сард 97 өргөдөл, гомдол хүлээн авснаас 37 буюу 38.1 хувийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн нь өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо сул, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсэхүйц нөхцөлийг бий болгож байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 02 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын нэгжийн орон тоог батлахдаа Бодлого, төлөвлөлтийн газарт Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын алба, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт Авто замын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын алба, Төмөр замын бодлогын хэрэгжилт, зохицуулалтын албыг тус тус шинээр нэмж баталсан байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 03 дугаар тогтоол, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Төрийн нарийн бичгийн дарга үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцсэн сайдын тушаал, үүрэг даалгаврыг удирдлага болгоно”, 9.6.2-т “хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, сайдаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2016 онд Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргаар томилогдсон Р.Мэргэн, Хуулийн хэлтсийн даргаар томилогдсон Н.Бат-Эрдэнэ, 2017 онд Захиргааны эрх зүйн асуудал хариуцсан хуулийн мэргэжилтнээр томилогдсон Д.Нарантуяа, 2016 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Чингис хаан” олон улсын нисэх буудлын Тэргүүн дэд даргаар томилогдсон Д.Сүхбаатар, Газрын тусгай үйлчилгээний албаны хэлтсийн даргаар томилогдсон С.Буяндэлгэрэх нарыг тухайн албан тушаалд томилсны дараа хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.

Тухайн салбарын хэмжээнд албан тушаалтнууд 2015 онд 372, 2016 онд 389, 2017 оны 3 сарын байдлаар 8 удаа ашиг сонирхлын зөрчилгүй болон зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасан боловч дээрх мэдэгдэл нь зөвхөн худалдан авах ажиллагаатай холбоотой мэдэгдэл байх ба бусад захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулахдаа мэдэгдэл огт гаргаагүй байгаа нь дээрх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй гэж үзэхээр байна.

“УБТЗ” ХНН-ийн албаны захирал Ч.Туяа (2016), ахлах нягтлан бодогч Х.Ариунжаргал, ахлах нягтлан бодогч Т.Отгонзаяа, ахлах нягтлан бодогч М.Чулуунбаатар, хэлтсийн дарга Г.Батцэцэг, ахлах нягтлан бодогч ерөнхий нягтлан бодогчийн орлогч Б.Энхнаран, хэлтсийн дарга Ё.Батсайхан (2015) нар тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй, хугацаа хоцроосон нь хуульд заасан хариуцлага тооцохоор зөрчил гаргасан байна.



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай хэрнээ тус байгууллагад ажиллаж буй албан хаагчид нь төрийн албан хаагчид хамаардаггүй, зөвхөн дарга, дэд дарга нь төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтаар томилогдож, бусад ажилтнууд нь улсын үйлдвэрийн газрын жишгээр цалинжиж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаж байгаа нь бусад агентлагтай харьцуулахад зөрчилтэй гэж үзэхээр байна.

2012–2017 онд тус газрын даргаар 6 хүн томилогдон ажилласан.

- С.Буяндалайг даргаар ажиллаж байх үед буюу 2013 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд 295 хүн чөлөөлөгдөж, 382 хүн томилогдсон.
- Т.Лхагвасүрэнг даргаар ажиллаж байх үед буюу 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд 227 хүн ажлаас чөлөөлөгдөж, 231 хүн томилогдсон.
- Ц.Эрдэнэбилэгийг даргаар ажиллаж байх үед буюу 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд 104 хүн ажлаас чөлөөлөгдөж, 115 хүн томилогдсон.
- Г.Нямдавааг даргаар ажиллаж байх үед буюу 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдрөөс 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 216 хүн ажлаас чөлөөлөгдөж, 244 хүн томилогдсон.
- Л.Бямбасүрэнгийн үед буюу 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр хүртэлх хугацаанд 158 хүн ажлаас чөлөөлж, 229 хүн томилогдсон.

Энэ хугацаанд давхардсан тоогоор 1000 хүн ажлаас чөлөөлөгдөж, 1201 хүн томилогдон ажилласан байна. Мөн 2013-2015 оны хооронд давхардсан тоогоор 30 хүн шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдон, нөхөн олговорт улсын төсвөөс 326 сая төгрөг олгосон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь өөрийн зардлаар гадаад улсад нарийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг.

2016 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар
30 төрлийн мэргэжлээр **13** улсад **107** оюутан суралцаж **25** оюутан төгссөн

Эдгээр 107 оюутны төлбөрт 2013 онд 2.7 тэрбум, 2014 онд 2.7 тэрбум, 2015 онд 3.4 тэрбум, 2016 онд 838 сая төгрөг буюу 4 жилийн хугацаанд нийт **9.8 тэрбум** төгрөгийг зарцуулсан байна.

2017 онд гадаадад суралцах тэтгэлэг авсан 19 оюутны 5 нь ажиллаж байгаад мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр суралцаж байгаа бол бусад 14 оюутны хувьд эцэг, эх нь Зам, тээврийн хөгжлийн яам, ИНЕГ, “МИАТ” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН-г ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа хүмүүс байна.



Авлигатай тэмцэх газраас Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яаманд төсвийн хөрөнгийг хуульд нийцээгүй, шаардлага хангахгүй эрх зүйн актыг үндэслэж захиран зарцуулахыг таслан зогсоох, тэдгээр эрх зүйн актыг хууль тогтоомжид нийцүүлэн өөрч-

лөх, ИНЕГ-ын олгодог тэтгэлгээр гадаад улсын их, дээд сургуулиудад оюутан суралцуулах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг бодитоор төлөвлөх, сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил

тод зохион байгуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах талаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт туйлын хангалтгүй, өмнөх онд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтагдсан байна.

- Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагаар ажиллаж байсан зарим албан тушаалтнууд албан тушаалын байдлаа урвуулан хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан журмын зарим заалтыг хүчингүй болгож, өөрт ашигтай байдлаар шийдвэрлэсэн үйлдэл мөн тогтоогдож байна.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2006 оны 635 дугаар тушаалаар баталсан Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод журмын 3.3.3.в дэх “Урьд өмнө улсын болон төрийн өмчийн аль нэг байгууллага, иргэний нисэхийн салбар байгууллагуудаас орон сууц авч байгаагүй” гэсэн заалтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Буяндалайн 2013 оны А/678 дугаар тушаалын 3 дахь заалтаар хүчингүй болгосон байна. Улмаар тэргүүн дэд дарга С.Энх-Амгалан нь Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар 55 сая төгрөгийн орон сууцны үнийн хөнгөлөлтийг ИНЕГ-ын дарга С.Буяндалайд олгохоор шийдвэрлэсэн байна. С.Буяндалай нь урьд өмнө буюу 1998 онд 1 дүгээр хороолол дахь 64 айлын орон сууцнаас 15.5 сая төгрөгийн өртөг бүхий 30.94 ам метр 2 өрөө орон сууц, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2009 оны 583 дугаар тушаалаар орон сууцны нөхцөл сайжруулахад 10 сая төгрөгийн дэмжлэг тус тус авч байсан бөгөөд өөрийн ажил, албан тушаалын давуу байдлаа ашиглан байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байсан журмын зохих заалтыг хүчингүй болгон эд хөрөнгө олж авсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.7 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.
- 2015 онд “Чингис хаан” олон улсын нисэх буудлын перрон засварын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж, “Дорно өрнө зам”, “Шинэ хөгжил зам”, “Их Богд зам”, “Урбан роуд” ХХК-д тус тус урилгыг хүргүүлсэн талаар баримт байх бөгөөд “Дорно өрнө зам” ХХК 80 сая, “Шинэ хөгжил зам” ХХК 78.2 сая, “Их Богд зам” ХХК 79.8 сая төгрөгийн үнийн санал ирүүлж, “Шинэ хөгжил зам” ХХК-ийг шалгаруулсан байна. Тендерт шалгарсан “Шинэ хөгжил зам” ХХК нь захиалагчийн даалгаварт дурдсан нисэх буудлын перрон хэсгийн 1200 ам метр хэсэг талбайг засахаар тусгасан байтал 900 гаруй ам метр талбайг зассан байхад ажлын хэсэг дутуу хийсэн ажлыг хүлээн авсан. Мөн тендерийн бичиг баримтаас харахад “Шинэ хөгжил зам”, “Дорно өрнө зам” ХХК-иуд нь дундаа Н.Пүрэвбаатар гэх нэг инженертэй, нэг нэгнээсээ замын техник, тоног төхөөрөмж түрээсэлсэн нөхцөл байдал ажиглагдаж байгаа нь энэхүү тендерт өөр хоорондоо холбоо хамааралтай 2 компанийг оролцуулсан байж болзошгүй байна.



СҮХБААТАР АЙМАГ

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2018 оны А/196 захирамжаар төрийн тахилга “Алтан дарь овоо”-ны тэнгэрийг тайх үйл ажиллагаанд зориулж хандивын концерт, хүлээн авалтыг 2018 оны 5 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Хандивын арга хэмжээг зохион байгуулах зардлыг ИТХ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлан Засаг даргын удирдлагын болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас 100 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2018 оны 5 дугаар сард “Алтан дарь овоо тэнгэрийн тайлга” төрийн бус байгууллага шинээр байгуулсан. Төрийн бус байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох ажлыг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын зөвлөх нар санаачлан, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Алтан дарь овоо”-ны тахилгыг зохион байгуулах комисст танилцуулан шийдвэр гаргасан нь аймгийн удирдлагууд уг төрийн бус байгууллагыг байгуулж хууль бусаар иргэд, олон нийтээс хандив хүлээн авах ажлыг зохион байгуулсан гэж үзэхээр байна.

Төрийн бус байгууллагаар дамжуулан “Алтан дарь овоо”-ны төрийн тахилгын 105 жилийн ойн арга хэмжээнд уул уурхайн 14 компаниас 387.6 сая төгрөг, 13 сумын нутгийн зөвлөл 268 сая төгрөг, иргэдээс 44.5 сая төгрөгийг гэх мэтээр бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудаас нийт 700.1 сая төгрөгийн хандивыг дансаар болон бэлнээр, уриалга гаргаж албадан авсан байна.

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолыг үндэслэж тус аймгийн уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 6 компанитай “Хамтран ажиллах гэрээ”-г 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр байгуулж мөн хандив авсан байхад уул уурхайн 9 компани нийгмийн хариуцлагын гэрээ байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасныг, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.



ТӨВ АЙМАГ

Төв аймгийн хэмжээнд бүтцийн өөрчлөлтөөр 2018 онд 1 албан тушаалтан шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдон, нөхөн олговорт улсын төсвөөс 9 сая төгрөгийг олгосон байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Т.Мөнхсүлд нь байгууллагын нэрийн өмнөөс өөрийн хамаарал бүхий этгээд болох төрсөн эх Н.Гансүхийн өмчлөлийн газарт 56 айлын орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах, борлуулах асуудлаар гүйцэтгэгчтэй тохиролцож, газрын үнийн дүнд тухайн барилгын 80 ам метр талбай бүхий орон сууцыг шилжүүлж авах “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г захиалагчийн хувиар 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдөр “Төмөрт өргөө” ХХК-тай байгуулсан байна.

2018 онд Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын орлогч Л.Золжаргал тухайн албан тушаалд томилогдсоны дараа хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан нь хуулийн заалтуудыг зөрчсөн.

Төв аймгийн ИТХ-ын 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Аймаг хөгжүүлэх сан”-гийн журмын 2 дугаар зүйлд сангийн хөрөнгийн эх үүсвэрийг тусгаж өгсөн байна. Ингэхдээ 2.1.б-д Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив авч бүрдүүлэх”-ээр тусгасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Төв аймгийн Засаг дарга нь орон нутгийн хөрөнгөөр аймгийн өвс тэжээл бүрдүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Жамбалдоржид үүрэг болгосон байна. Өвс нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Өгөөж сүмбэр” ХХК нь нийт 52.6 сая төгрөгийн үнэ бүхий 9000 боодол өвс нийлүүлэхээс 30.3 сая төгрөгийн 5191 боодол өвс нийлүүлж, 22.2 сая төгрөгийн үнэ бүхий 3809 боодол өвсийг гэрээнд тусгагдсанаас дутуу нийлүүлсэн, мөн “Дэвжих балир-Эрдэнэ” ХХК нийт 17.5 сая төгрөгийн үнэ бүхий 3000 боодол өвс нийлүүлэхээс 13 сая төгрөгийн 2232 боодол өвс нийлүүлж, 4.4 сая төгрөгийн 768 боодол өвсийг мөн гэрээнд заасан хэмжээнээс дутуу нийлүүлсэн байна. Гэтэл Хүнс, хөдөө аж ахуйн газрын нярав нь дээрх өвсийг тус тус хүлээн авсан мэтээр хуурамч орлогын баримт (падаан) бичиж, авлагыг хаасан байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

Засаг даргын 2018 оны нөөц хөрөнгийн батлагдсан төсөв 96.2 сая төгрөг бөгөөд 2018 оны 11 сарын байдлаар 71.8 сая төгрөг буюу нийт төсвийн 74.6 хувийг зарцуулж дуусгасан.

Сангийн сайдын 2017 оны “Эрх шилжүүлэх тухай” 374 дүгээр тушаалаар эрх шилжүүлсний дагуу 700 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй “Татварын хэлтсийн албан конторын барилга”-ыг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулж, 1 компани санал ирүүлсэн, улмаар 700 сая төгрөгийн санал ирүүлсэн “Сүмбэр бүянт” ХХК-иас баригдсан барилгыг худалдан авсан. Тендерийн техникийн тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном баталсан бөгөөд уг тодорхойлолтод “Барилгын үндсэн хана нь тоосгон бүтэцтэй байх”, “Найрамдал хотхонд байршилтай байх” гэж тусгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй” гэж заасныг зөрчсөн байна.

Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 2018 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “3 дугаар сургуулийн цахилгааны шугам шинэчлэх ажил”-д шалгарсан “Энхжих формат” ХХК (Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэлийн төрсөн ах Ш.Билэгзүмбэрэлийн үүсгэн байгуулсан) гүйцэтгэсэн, комисс хүлээн авсан ажилд чанарын шаардлага хангаж байгаа талаарх галын дүгнэлт гаргуулахаар тус аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Онцгой байдлын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, шинжээчийн баг томилуулан газар дээр нь ажиллуулаад дүгнэлт гаргуулсан.

Дүгнэлтээр “уг сургуульд хийгдсэн 2x2,5 мм хөндлөн огтлолтой зэс голтой дотор цахилгааны утас нь хэт өндөр ачаалал өгөх, анги танхимд тень асаах болон цайны газарт цахилгаан тоног төхөөрөмжийг давхардуулан зэрэг ажиллуулах үед халалт үүсэн гал гарах шалтгаан үүсээд байна. Дээрх Шивээговь сумын 1 дүгээр багт байрлах ерөнхий боловсролын сургуульд галын аюулгүй байдал болон гамшгаас хамгаалагдсан байдал нь шаардлага хангахгүй байна” гэж тогтоон дүгнэлт гаргасан болно.



ӨМНӨГОВЬ АЙМАГ

Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналт сул байна:

Цогтцэций сумын Засаг даргын захирамжаар 2017 онд 6 аж ахуйн нэгжид, 2018 онд 4 аж ахуйн нэгжид тамхи худалдаалах цэгийн зөвшөөрлийг тус тус олгосон. Тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлээгүй. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-д зааснаар тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг олгоход 100-250 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж авах ба аймгийн ИТХ-ын 2018 оны 6/6 дугаар тогтоолоор тэмдэгтийн хураамжийн хэмжээг 250 мянган (2011 оны 78 дугаар тогтоолоор тэмдэгтийн хураамжийг 175 мянган төгрөгөөр тогтоосон байсан) төгрөгөөр тогтоосон. Өөрөөр хэлбэл, 2017 онд 1 сая төгрөг, 2018 онд 700 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжтой байсан.

Эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр 2017 онд 7, 2018 онд 4-ийг тус тус олгож, мөн онуудад нийт 36 байгууллагын зөвшөөрлийг сунгасан байх ба улсын тэмдэгтийн хураамжийг огт төвлөрүүлээгүй. Өөрөөр хэлбэл, Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Засгийн газрын 199 дүгээр тогтоолын холбогдох зүйл, заалтыг зөрчсөн. Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан "Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ"-ний 23.1.1-т аймаг, нийслэлийн Засаг даргаас улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг олгоход 400 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

Хууль тогтоомж зөрчин төлбөр хураамж тогтоосон зөрчил гарав.

Цогтцэций сумын ИТХ-ын 2017 оны 3/1 дүгээр тогтоолоор сум дундын эмнэлэгт мөрдөх төлбөртэй үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулах журмыг баталж төлбөрт эмчилгээний үнэ тариф баталсан нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасныг зөрчсөн.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналт сул байна.

Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 23.1.3-т аймаг, нийслэлийн Засаг даргаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход 250 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж авахаар тогтоосон. Гэтэл аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох, сунгахдаа тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлж байгаагүй. Аймгийн хэмжээнд 2017 онд хувийн хэвшлийн 2, төрийн 1 цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг сунгасан бол 2018 онд 2 тусгай зөвшөөрөл шинээр олгож (төрийн цэцэрлэг, 1 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн), 4 бага сургуулийн зөвшөөрлийг сунгасан.

Тус аймаг 2017 оны төгсгөл хүртэл эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо тэмдэгтийн хураамжийг авдаггүй байсан бол 2017 оны 11 дүгээр сараас эхлэн авах болсон. Улсын тэмдэгтийн хураамж гэж 23 байгууллагаас аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (тусгай зөвшөөрөл, чанар магадлан итгэмжлэл хариуцдаг) Ю.Ичинноров бэлнээр мөнгө хураан авсан байв. Тэрээр бэлэн мөнгөний ордер бичиж, гарын үсэг зуруулан 4.1 сая төгрөг хураан авсны 3 сая төгрөгийг өөртөө хадгалж, 554 мянган төгрөгийг эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох аймгийн Засаг даргын дэргэдэх комиссын гишүүдийн хурлын урамшуулал, хоолонд зарцуулсан, 1.1 сая төгрөгийг хэрхэн зарцуулагдсан нь тодорхойгүй байв. Түүнчлэн зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчээс улсын тэмдэгтийн хураамжийг аваагүй болох нь тогтоогдсон.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт сул, тус сангийн дансанд бусад эх үүсвэр бүхий хөрөнгийг байршуулдаг, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар зохих арга хэмжээг аваагүй, албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгож байна. Уянга сумын төрийн сан дахь Сум хөгжүүлэх сангийн дансанд мал хамгаалах сан, байгаль орчныг хамгаалах сан, ахмадын сан, урлаг соёлын сангийн хөрөнгийг байршуулжээ.

Төсөл хүлээн авах, сонгон шалгаруулах зарыг олон нийтэд хүргэхдээ сумын Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хаяг (иргэдэд нээлттэй байдаг гэх)-аар хүргүүлсэн, төрийн байгууллагуудын үүдэн дэх мэдээллийн самбарт байршуулсан гэх боловч энэ нь иргэдэд тэр бүр хүрдэггүй, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүдийн эргэн тойронд мэдээлэгдэж байна гэж үзэхээр байна. Тухайлбал, 2017 онд төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн Г.Батжаргал (5 сая), З.Болортуяагийн хамаатан гэх Д.Ханбүргэд (8 сая), 2018 онд зөвлөлийн гишүүн Г.Болдбаатарын төрсөн эгч Т.Бэлэгт (5 сая), зөвлөлийн гишүүн Р.Батгэрэл (20 сая) нар зээл авсан.



ДУНДГОВЬ АЙМАГ

Авлигатай тэмцэх газраас 2018 онд өгсөн зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин илэрсээр байна:

Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтгүй, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй, сонгон шалгаруулалтад ороогүй, шалгалтад тэнцээгүй, нөөцөд бүртгэгдээгүй 13 иргэнийг 2016 онд, 9 иргэнийг 2017 онд төрийн захиргааны албан тушаалд томилон ажиллуулж байсан бол 2018 онд энэ төрлийн зөрчлийг давтан гаргаж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөөр байна. Тухайлбал, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын шалгалт өгөөд 2 ч удаа тэнцээгүй иргэн О.Түмэнбаатарыг Сайхан-Овоо сумын сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр, мөн шалгалтад тэнцээгүй иргэн С.Сугирсүрэнг Луус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, иргэн Э.Батцэцэгийг Адаацаг сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, иргэн Д.Энхмааг Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, шалгалт өгөөгүй иргэн Д.Болормааг Гурвансайхан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр тус тус томилсон.

Шүүхийн шийдвэрийн дагуу 2016-2017 онд ажилдаа эгүүлэн томилогдсон 9 хүнд олгосон 36.1 сая төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хяналт, аудитын албанаас 4 хүнд олгосон 17.5 сая төгрөгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан бол бусад 5 хүнд олгосон 18.5 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй.

Хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, түүнд тавих хяналт сул байна.

Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”-ний 23.1.3-т аймаг, нийслэлийн Засаг даргаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрөл олгоход 250 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж авахаар тогтоосон. Гэтэл аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох, сунгахдаа тэмдэгтийн хураамжийг төсөвт төвлөрүүлж байгаагүй. Харин тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ гэж ямар субъект тогтоосон нь тодорхойгүй 8800 төгрөгийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн М.Энхтуяа өөрийн хувийн дансаар хүлээн авч, улмаар 38 сургуулиас хүлээн авсан 334 мянган төгрөгийг газрын дарга Ц.Бумангэрэлийн хувийн дансанд шилжүүлсэн байв. Ц.Бумангэрэлтэй уулзаж, гэрчилгээний үнэ өөрийн дансанд шилжүүлсэн мөнгийг хүлээж авч, үнэт цаасны компанид шилжүүлсэн баримтыг үзүүлэхийг мэдэгдсэн боловч энэ тухай танилцуулаагүй.

АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС



CORRUPTION PERCEPTIONS INDEX 2018

The perceived levels of public sector corruption in 180 countries/territories around the world.



www.transparency.org/cpi2018

Транспэрэнси интернэшнл байгууллагаас Авлигын төсөөллийн индексийг зарладаг. Судалгаанд 2018 онд нийтдээ 180 улс орныг хамруулсан бөгөөд эдгээр улс орнуудын 123 буюу 2/3 нь 50-иас доош оноо авсан байна (100 оноо авбал авлигагүй, 0 оноо авбал өндөр авлигатай орны тоонд ордог). Дэлхийн улс орнуудын авсан онооны дундаж 43 байгаа нь өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Монгол Улс 37 оноо авч 180 улсаас 93 дугаар байрт орсон байна. Өмнөх оныхтой харьцуулахад уг индексийн оноо 1-ээр өсч, байр 10-аар ахисан дүнтэй байна. Монгол Улс энэ онд Гамби, Гайана, Косово, Македони, Панам улсуудтай ижил оноо авчээ.

Монгол Улсын Авлигын төсөөллийн индексийн дүнг, 2012-2018 оноор

Д/д	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	Байр	94	83	80	72	87	103	93
2	Оноо	36	38	39	39	38	36	37

Транспэрэнси интернэшнл байгууллага Авлигын төсөөллийн индексийн дүнг тооцоходоо 13 мэдээллийн эх сурвалжийг ашигладаг бөгөөд манай улсын индексийн дүнг тооцоходоо 9 эх сурвалжийн мэдээллийг ашигласан байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад “IMD”-Дэлхийн өрсөлдөх чадварын үнэлгээ 3-аар, “Ардчиллын олон талт байдлын төсөл”-ийн үзүүлэлт 2-оор тус тус буурсан ч “Глобал инсит” байгууллагын Улс орнуудын эрсдэлийн түвшний үнэлгээ 12-оор, “Дэлхийн эдийн засгийн форум”-ын үзэл бодлын судалгаа 1-ээр өссөн тус тус өссөн нь нийт оноо 1-ээр өсөх шалтгаан болсон байна.

Монгол Улсыг үнэлэхэд ашигласан мэдээллийн эх үүсвэр, үнэлгээ, оноор

Д/д	Байгууллага-судалгаа	2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	“Бертелсман” сан - Шилжилтийн индекс 2017-2018	32	40	40	36	36	41	41
2	“PRS” групп - Эрсдэлийн үнэлгээ 2018	31	31	31	31	32	32	32
3	Дэлхийн банк - Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2017	47	47	47	47	47	43	43
4	Дэлхийн эдийн засгийн форум - Үзэл бодлын судалгаа 2018	26	32	41	42	38	30	31
5	Дэлхийн эрх зүйн төсөл- Хууль дээдлэх ёсны индекс 2017-2018	37	33	32	35	38	36	36
6	Эдийн засгийн мэдээллийн нэгж - Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2018	38	38	38	38	37	37	37
7	“Глобал инсит” байгууллага - Улс орнуудын эрсдэлийн түвшин 2017	42	42	42	42	47	35	47
8	IMD-Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл 2018	-	-	-	37	35	33	30
9	Ардчиллын олон талт байдлын төсөл /V-Dem/ 2018	-	-	-	-	34	35	33
	Авлигын төсөөллийн индексийн оноо	36	38	39	39	38	36	37

Эх сурвалж: <https://www.transparency.org/cpi2018>




ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн гурван дэд үнэлгээнээс бүрдсэн үнэлгээ юм. Үг үнэлгээг Авлигатай тэмцэх газраас мэргэжлийн судалгааны байгууллагуудаар 2015 оноос хойш гүйцэтгүүлж байна.

Үнэлгээг 0-100 хүртэл оноогоор тооцох бөгөөд утга нь 100-тай тэнцүү бол шударга байдлын дээд түвшинг илэрхийлнэ. ШБҮ-нд 2015 онд 62, 2016 онд 60, 2018 онд 62 байгууллага (яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар)-ыг хамруулаад байна.

ШБҮ-ний 2018 оны судалгаанд нийтдээ 9411 нэгж (Гадаад шударга байдлын үнэлгээнд 7260 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, Дотоод шударга байдлын үнэлгээнд 1360 төрийн албан хаагч, Бодлогод оролцогчдын үнэлгээнд 795 (шинжээч)-ийг хамруулсан болно.




Шударга байдлын үнэлгээ, оноор



Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 онооноос 2018 онд дунджаар 68.7 оноо авсан нь өмнөх оны үзүүлэлтээс 1.0 пунктээр буурсан байна. Харин 2015 оны үзүүлэлтээс 5.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар 61.2, Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар 59.3, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар 57.8, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар 55.6, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар 55.5 гэсэн бусад байгууллагатай харьцуулахад бага үнэлгээ авсан.

Шударга байдлын үнэлгээний схем




Төрийн байгууллагууд шударга байдлаа сайжруулахын тулд ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзлийг бэхжүүлэх, авлигыг хянах дотоод хяналтын механизмыг сайжруулахад анхаарал хандуулах шаардлагатай байна гэж судалгааны тайланд дүгнэсэн байдаг.

Монгол Улсад авлига их тархсан институцийн талаарх олон нийтийн төсөөлөл


Шударга байдлын үнэлгээний судалгаагаар яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг үнэлэхээс гадна Монгол Улс дахь авлига их тархсан институцийн талаарх төсөөллийг судалгаанд оролцсон 9411 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл болон төрийн албан хаагч, шинжээчдээс асуухад дараахь байдлаар хариулж байв.

Монгол Улсад авлига их тархсан институцийн талаарх төсөөлөл, судалгаанд оролцогчдын хариулт дүнд эзлэх хувиар, 2018 онд





Шударга байдлын үнэлгээ, үнэлгээнд хамрагдсан байгууллагаар, 2018 онд



55-60

60-65

65-70

70-75

75-80

80-85


УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г 11 дэх удаагаа зохион байгуулав. Судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

2017 он хүртэл улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайланг гаргаж байсан бол 2018 оноос хоёр хүрээ тусад нь авч үзэн судалгааг гүйцэтгэж байна.

2018 онд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 3.93¹ пункт гарсан нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.06 пунктээр буурсан буюу ач холбогдол өгөх хэмжээнд өөрчлөлт гарсангүй. Харин хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 3.68 пункт гарлаа.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын түвшин, 2008-2018 онд



Шинжээчдээс Монголын нийгэмд авлига бүх түвшин, нийгмийн амьдралын бараг бүх хүрээнд нэвтэрч өдөр тутмын, хэвийн мэт үзэгдэл болсон. Авлига зөвхөн хэмжээ, хэлбэрээрээ ялгагдана. Авлигыг хүссэн хүсээгүй хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл дөжирсөн, бүх нийтийн уур амьсгал нь улс төрийн болон хууль хяналтын хүрээн дэх авлига цэцэглэх ерөнхий нөхцөлийг үүсгэж байна гэж үзжээ.

¹ Үзүүлэлтийн утгыг “1-5” гэсэн оноогоор үнэлүүлэн тооцсон. Оноо буурах тусам эерэг утгыг илэрхийлж байгаа бол өсөх тусам сөрөг утгыг илэрхийлдэг.


ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдал, ёс зүй, ёс суртахуун, төлөвшилтийг хүүхдэд ойлгомжтой, хялбар байдлаар тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршиж байна.

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспэрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулж байсан билээ. Үүнээс хойш уг арга зүйн дагуу Хүүхдийн шударга байдлын судалгааг 8 дахь удаагаа зохион байгуулаад байна.

Хүүхдийн шударга байдлын түвшин 2018 оны судалгаагаар 3.91 гэсэн дүнтэй гарсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 0.06-аар буурсан байна.


Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр тооцдог ба 2018 оны судалгааны үр дүнгээр 13 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин буурсан байна. **Говь-Алтай** (2015 онд 3.36, 2016-2017 онд 4.03, 2018 онд 4.39), **Завхан** (2015 онд 3.96, 2016 онд 4.03, 2017 онд 4.04, 2018 онд 4.21), **Сэлэнгэ** (2015 онд 3.57, 2016 онд 4.04, 2017 онд 4.10, 2018 онд 4.13) аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин 2015 оноос хойш эерэг хандлагатай байгаа бол **Орхон** (2015 онд 4.07, 2016 онд 4.04, 2017 онд 3.99, 2018 онд 3.40), **Ховд** (2015 онд 4.08, 2016 онд 4.10, 2017 онд 4.0, 2018 онд 3.97), **Улаанбаатар** (2015 онд 4.05, 2016 онд 3.98, 2017 онд 3.95, 2018 онд 3.78)-ын хүүхдийн шударга байдлын түвшин сүүлийн 4 удаагийн судалгааны үр дүнгээр буурч байна.

Энэ удаагийн судалгаагаар сургуулийн өмчийн хэлбэрээр хүүхдийн шударга байдлын түвшинг тооцов. Төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин (3.96) хувийн өмчийн хэлбэрийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин (3.81)-ээс 0.15 пунктээр их байна.

Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин анги дэвших (7 дугаар анги-4.02, 12 дугаар анги-3.86) тутам буурч байгаагаас гадна эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин (3.73) эмэгтэй хүүхдийнхээс (3.92) доогуур байна. Мөн нийслэлийн хүүхдийн шударга байдлын түвшин (3.78) орон нутгийн хүүхдүүдийнхээс (3.89) доогуур байдаг хандлага мөн энэ удаагийн судалгаанд илрэв.



Судалгааны дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин нас ахин анги дэвших тутам буурч байна. Шударга байх талаар ярилцах, шударга хандсаны төлөө сайшаан урамшуулах, шударга ёсны талаар зааж сургах, хүүхэддээ анхаарал, халамжтай байх нь хүүхдийн шударга байдалд эерэгээр нөлөөлдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.




АВЛИГЫН ХЯНАЛТ

Дэлхийн банкны Дэлхийн Засаглалын үзүүлэлт (WGI)² төслөөс 200 гаруй улс орны засаглалын түвшинг 1996 оноос хойш хэмжиж байна. Ийнхүү хэмжихдээ 30 гаруй судалгааны институт, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын судалгааны мэдээлэлд үндэслэн нэгдсэн зургаан шалгуур үзүүлэлтээр засаглалыг үнэлж байна.

Засаглалын зургаан шалгуур үзүүлэлтийн нэг болох Авлигын хяналтын үзүүлэлтээр Монгол Улс 2017 онд **-0.45**³ үнэлгээтэй байгаа нь өмнөх оныхоос 0.05 пунктээр өссөн үзүүлэлт болж байна.

Авлигын хяналт, Монгол Улс 1996-2017



Эх сурвалж: The Worldwide Governance Indicators, www.govindicators.org

2 The Worldwide Governance Indicators (WGI) project
3 Засаглалыг -2.5 (сүл)-аас +2.5 (хүчтэй)-ын хооронд хэмжиж байна.

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСНЫ ИНДЕКС⁴

“Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл” нь ашгийн бус, бие даасан байгууллага бөгөөд дэлхийн улс орнуудад хууль ёсыг дээдлэн сахиж буй байдлыг судалгаанд үндэслэн үнэлдэг.

Хууль дээдлэх ёсны 2019 оны судалгаанд 126 орныг хамруулснаас Монгол Улс 0.55 оноотойгоор 53 дугаар байранд орсон бөгөөд өмнөх оныхоос 1 байраар ахисан эерэг үзүүлэлттэй байна.

Хууль дээдлэх ёсны индексийн дэд үзүүлэлтээр, Монгол Улс

Үзүүлэлт	2014	2015	2016	2017-2018	2019
Хууль дээдлэх ёсны индекс	0.51	0.53	0.54	0.54	0.55
-авлигаас ангид байдал	0.39	0.42	0.41	0.44	0.44
-дэг журам, аюулгүй байдал	0.78	0.79	0.79	0.78	0.77
-суурь эрх, эрх чөлөө	0.61	0.61	0.60	0.59	0.58
-засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт	0.53	0.54	0.53	0.55	0.54
-иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй байдал	0.52	0.55	0.54	0.53	0.54
-эрүүгийн хэрэг шийдвэрлэж буй байдал	0.48	0.42	0.48	0.50	0.50
-хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	0.43	0.48	0.47	0.47	0.49
-нээлттэй засаг	0.33	0.46	0.48	0.49	0.51

Монгол Улс дахь авлигаас ангид байдлын үзүүлэлт нь мөн дөрвөн дэд индексээс бүрдэж байгаа бөгөөд эдгээрээс хууль тогтоох үйл ажиллагаанд авлигаас ангид байдлын индекс (0.17), гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд авлигаас ангид байдлын индекс (0.46)-ийн үнэлгээ бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй бага байна.

4 Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл, https://worldjusticeproject.org/sites/default/files/documents/WJP_ROLI_2017-18_Online-Edition_0.pdf

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР,
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ
(2016-2018 он)



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ (2016-2018 ОН)

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан билээ. Үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилго нь “Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх” явдал бөгөөд уг зорилгод хүрэхээр 11 зорилтыг дэвшүүлж, 83 үйл ажиллагааг 2016-2023 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газар үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудтай тусгайлсан уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгөх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах ажлыг тогтмол гүйцэтгэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2017 оны 1 дүгээр сард дөрвөн салбар хуралдаан бүхий “Авлигын эсрэг үндэсний чуулган”-ыг зохион байгуулж, чуулганд оролцогчдоос гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хөтөлбөрийн хүрээнд тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж байгаагийн зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх багийг байгуулан ажиллуулж байна. Ажлын баг 2017 онд Үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийн гарааны нөхцөл байдлыг тодорхойлохоор 21 аймаг, 99 сум, яам, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүргийн 94 байгууллагад ажиллан, авлигын эрсдэл, шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, ажлын үр дүнг тухайн салбар, байгууллагын удирдах албан тушаалтнуудад танилцуулж, зөвлөмж хүргүүлсэн бол 2018 онд дээрх байгууллага, орон нутагт ажиллаж, хөтөлбөрийн болон Зөвлөмжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн болно.

Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Авлигатай тэмцэх газраас Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 онд хүргүүлсэн 159 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар гүйцэтгэл 61 хувийн, 21 аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлсэн 279 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн гүйцэтгэл 40 хувьтай байв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасныг үндэслэн Авлигатай

тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2018 оны гүйцэтгэл, үр дүнг үнэлж, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг дээшлүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор 2018 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 202 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийн танилцуулж байна.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан чухал асуудлын нэг бол төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх асуудал юм. Энэ хүрээнд төрийн байгууллагууд авлигын эрсдэлийн үнэлгээ болон хэрэглэгчийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагуудаар хийлгүүлж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус шинэчлэн баталсан нь энэхүү асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсан нь шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд үлс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг бэхжүүлэх суурь тавигдлаа гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, соён гэгээрүүлэх арга хэмжээний давтамж, хамрах хүрээ, төрөл хэлбэрийг нэмэгдүүлсний зэрэгцээ төрийн байгууллагын үйл ажиллагаа, ялангуяа төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хүнд суртал, албан хаагчийн ёс зүй, албан тушаалтны шийдвэр хуульд нийцэж буй эсэх зэргийг хянахад иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлэх, хяналтыг бий болгоход чиглэсэн ажлыг эрчимтэй зохион байгуулж байна.

Транспэрэнси интернэшнл байгууллагын 2018 оны Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улс 37 оноо авч 180 улсаас 93 дугаар байрт орсон байна. Өмнөх оныхтой харьцуулахад уг индексийн оноо 1-ээр өсч, байр 10-аар ахисан дүнтэй эрэмбэлэгдсэн нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаагийн үр дүнгийн илрэл гэж үзэж болох юм.

Гэвч Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2017 онд хэрэгжүүлэхээр тусгасан 144 ажил, арга хэмжээний гүйцэтгэл 32.9 хувьтай байсан бол 2018 онд хэрэгжүүлэхээр тусгасан 202 арга хэмжээний гүйцэтгэл 35,34 хувьтай байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм. Үндэсний хөтөлбөрийн эхний үе шат 2019 онд дуусах тул байгууллага, албан тушаалтнууд шат шатандаа санаачилгатай ажиллаж, төлөвлөгөөнд тусгагдсан хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийг үр дүнтэй, шуурхай зохион байгуулж, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын идэвхтэй оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байгааг дээрх үнэлгээ илтгэж байна.

Авлигатай тэмцэх газар



Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 26 арга хэмжээ тусгагдсан. Зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.1.1-1.Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох /АТГ, ТАЗ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсч болзошгүй, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал тогтоогдсон эсэх талаарх дүгнэлтийг нэр дэвшигч тус бүрээр сар бүрийн 25-ны өдөр зохион байгуулдаг хэвлэлийн хурал, мэдээллийн хуудас, байгууллагын www.iaas.mn албан ёсны цахим хуудас болон байгууллагын фэйсбүүк, твиттер хуудас зэрэг олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлж Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг хэвшүүлэв. Түүнчлэн зарим төрийн байгууллагууд /Барилга, хот байгуулалтын яам, Стандарт, хэмжил зүйн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам/ Авлигатай тэмцэх газраас хянасан дүгнэлтийг байгууллагынхаа цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй

мэдээлж байна.

Төрийн албаны зөвлөл холбогдох дүгнэлтийг цахим хуудсан дахь “Төрийн албаны зөвлөлийн хуралдааны тойм” хэсгээр дамжуулан ил тод болгож байгаа боловч Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлэх ажлыг цогц байдлаар зохион байгуулах шаардлагатай. (Биелэлт 40 хувь)

4.1.1.1-2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх /АТГ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулж, 7 дугаар хавсралтын “Б” хэсэгт “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” БАТАЛГААНЫ МАЯГТ-ыг батлуулан ашиглаж байна. ХАСУМ-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2017 онд эхлүүлэн системийн хөгжүүлэлтийг 2018 онд дуусгав. Одоогоор туршилтын журмаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгаас Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газартай цахим системээр холбогдон хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. 2019 онд бүх байгууллага салбар нэгжтэй цахимаар холбогдон мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод хүргэнэ. (Биелэлт 60 хувь)

4.1.1.1-3. ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах /АТГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар

зүйлийн 33.12-т Төрийн албаны зөвлөл Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/ өгөх болзол, журам, Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журмуудыг батлахаар заасан. Энэхүү журмуудын төсөлд нэр дэвших болзол хангасан иргэний ХАСУМ-т Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийг хавсаргахаар тусгасан. Журмуудын төсөлтэй <http://csc.gov.mn/b/56/30> хаягаар танилцах боломжтой. (Биелэлт 40 хувь)

4.1.1.1-4. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэнтэй холбогдуулан тус газраас багийн зохион байгуулалтын хүрээнд сүүлийн 2 жилд яам, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийслэл, дүүрэг, 21 аймаг, зарим сумдад ажиллаж хуулийн хэрэгжилт болон төрийн албан дахь хүний нөөцийн томилгооны байдалд хяналт тавин ажилласан нь үр дүнгээ өгч байна. Тухайлбал, 2017 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг тухайн албан тушаалд томилсны дараа хянуулахаар ирүүлсэн тоо 844 байсан бол 2018 онд 211 болж буурсан үзүүлэлттэй байна.

Авлигатай тэмцэх газрын ажлын баг дээрх нэгжид ажиллах явцдаа албан тушаалын томилгоотой холбоотой асуудлыг нарийвчлан судалж, нөхцөл байдлыг тогтоон Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төсөл боловсруулах Хууль зүй,

дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлсэн.

Үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зорилтыг хэрэгжүүлж байхад Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд стратегитэй уялдахгүй агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийг өөрчлөн, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хянаад илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг тогтоож, хариу хүргүүлсэн байхад тухайн байгууллагын удирдлага нь нэр дэвшүүлсэн этгээдийг дур мэдэн томилох, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгүүлэх эрсдэлийг бий болгож байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дагаврын талаар УИХ, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд саналаа хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

Гэсэн хэдий ч дээрх хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн бол хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх, энэхүү зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах буюу сахилгын шийтгэл ногдуулах хуулийн зохицуулалт хэвээр үйлчилж байгаа нь хуулийг шударга ёсны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлэх боломж гарц байгааг илтгэж байна.

Төрийн албаны зөвлөлөөс 2018 оныг “Хуулийн хэрэгжилт, хариуцлага, үр дүнгийн жил” болгон зарлан төв, орон нутгийн төрийн байгууллагын удирдах ажилтны



томилгоонд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнг хуралдаанаараа хэлэлцээд зөрчлийг арилгуулах талаар томилох эрх бүхий албан тушаалтанд хугацаатай үүрэг өгснөөр хууль зөрчиж томилсон, мөн сонгон шалгаруулалтад тэнцээгүй удирдах албан тушаалтныг чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчдийг хуульд нийцүүлэн томилсон шийдвэр гаргажээ. Мөн байгууллагууд хууль бус томилгоотой байсан албан тушаалтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулах захиалгаа Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн байна. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлд хууль бус шийдвэрийг Төрийн албаны зөвлөл хүчингүй болгож төрд учирсан хохирлыг төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон зохицуулалт 2019 оноос эхлэн хэрэгжинэ. (Биелэлт 20 хувь)

4.1.1.1-5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох /ТАЗ, 2017-2019/

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын нөөцийн жагсаалтыг бүртгэж, Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хаягаар нийтэд мэдээлж байгаа бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох ажилтны нөөцөөс нэр дэвшүүлэн томилох ажлыг нээлттэй, ил тод зохион байгуулж байна. Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан мэдээг жил бүр гаргаж, түүнийг үндэслэн төрийн албанаас түр болон хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн албан хаагчдын жагсаалтыг цахим хуудас <http://www.csc.gov.mn/s/47/252/>-д байршуулж эхлээд байна.

2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс

мөрдөж эхлэх Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16 дугаар зүйлийн 16.2-т Төрийн албаны зөвлөл Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн сантай байхаар тусгасан нь нөхцөл байдлыг өөрчлөх боломжийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой зохицуулалт болсон. Дээрх хуульд Улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журмыг Засгийн газар батлахаар заасны дагуу холбогдох төслийг боловсруулж байгаа бөгөөд түүнд нөөцийн жагсаалт, бүртгэлийг ил тод, нээлттэй болгуулах саналыг тусгуулахаар ажиллаж байна. Мөн Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн санг хэрхэн бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн даалгаврыг боловсруулж нээлттэй тендер зарлаж түүний хүрээнд бүртгэлийг ил тод, нээлттэй болгох ажлуудыг хийхээр төлөвлөгөөндөө тусгасан.

2018 онд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох ажилтны нөөцөөс нэр дэвшүүлэн томилох ажлыг нээлттэй, ил тод зохион байгуулсан. Тухайлбал, 42 удирдах албан тушаалд өрсөлдөхөөр уг ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан 96 иргэн бүртгүүлснээс 80 иргэн шалгалтад тэнцсэн байна. Шалгалтын дүнг шийдвэрийн төслийн хамт Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэн “Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх, нэр дэвшүүлэх тухай” Зөвлөлийн тогтоолыг албан бичгээр томилох эрх бүхий этгээдэд хүргүүлж ажиллалаа.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул ажлын байранд 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах үүднээс “Удирдах албан тушаалд дүгнэлт гаргах тухай зөвлөмж” боловсруулж, нэр дэвшигчдийн удирдах албан тушаалд шаардагдах эрх зүйн болон удирдахуйн ухааны онол, арга зүйн мэдлэгийг “Сорилын шалгалт” болон “Ярилцлагын шалгалт”-аар үнэлж, дүгнэдэг болсон.

Төрийн албаны тухай хуулийн дагуу нэр дэвшүүлсэн албан хаагчдад дүгнэлт гаргах комиссыг Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар томилж, нэр дэвшигчдээс 1 албан хаагчийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, комиссын дүнг тухай бүр Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт шийдвэр гаргаж ажиллав.

2018 онд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний сонгон шалгаруулалтад улсын хэмжээнд 1479 орон тоонд 7851 иргэн бүртгүүлж шалгалтад орсноос 2626 иргэн тэнцэж 740 иргэн өрсөлдсөн албан тушаалдаа томилогдож нээлттэй зарлагдсан ажлын байрны 50.03 хувь нь нөхөгдсөн байна. Мөн Төрийн албаны зөвлөл харьяаллын дагуу нийт 346 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагууд нийт 62, яам, агентлагууд 274, бусад байгууллагууд 10 иргэнийг нөөцөөс нэр дэвшүүлсэн байна. (Биелэлт 40 хувь)

4.1.1.2-1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2022/

2019 онд хэрэгжиж эхлэх Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас сул орон тоог нөхөх, төрийн албанд томилохдоо чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгох талаар тусгасан болно. Дээрх хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д *“Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно” гэж, мөн 26.3-т “Энэ хуулийн 23.2-т заасан ажилласан жилийг тогтоосон*

тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, ёс зүй, мэдлэг, мэргэжил, мэргэшил, туршлага, үр чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.” гэж, 26.4-т “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газрын саналыг харгалзан төрийн албаны төв байгууллага батална. Албан тушаалд шатлан дэвшүүлж томилоход энэ журмыг баримтална” гэж зааснаас гадна мөн хуулийн 23 дугаар зүйлд төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг тодорхойлж өгсөн байна. (Биелэлт 90 хувь)

4.1.1.2-2. Мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, үр чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан ба төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлахаар мерит зарчмыг нарийвчлан тусгав. Мөн *“Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэх хөтлөх, мэдээлэл авах журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангав. (Биелэлт 90 хувь)*

4.1.1.2-3. Төрийн албаны сонгон шалгаруулалтыг олон улсын стандартад нийцүүлэх /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалтын үйл ажиллагааг түргэн шүүрхай, ил тод, хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөгүй байлгах зорилгоор шалгалтын бүртгэлд холбоотой бичиг баримтыг цахимаар бүртгэх зориулалттай Document Scanner DS-7500 color,



мэргэшлийн шалгалт, сургалтын танхимд ажиллах WI-FI router, иргэдийг хурдан шуурхай бүртгэх зориулалтаар хурууны хээ уншигч Anviz U bio аппарат, сургалт, шалгалтын танхимд иргэдийн гар утас, цүнх савыг түр хадгалах шкаф, сургалт семинар, ус цэвэршүүлэгч, тог баригч зэргийг 2017 онд худалдан авч шалгалтын танхимыг тохижуулан ашиглалтад оруулав. Шалгалт, сургалтын танхимын техник, тоног төхөөрөмжийг сайжруулснаар иргэдэд түргэн шуурхай үйлчлэх таатай орчинг бүрдүүлэх, шалгалт өгч буй иргэд нээлттэй, ил тод байдлаар сонгон шалгаруулалтад орох нөхцөл боломж бүрдэж байгаа болно. Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлүүд төстийн шалгалтуудыг бүрэн цахимаар авч байна. Мөн шалгалтын явцыг Төрийн албаны зөвлөлөөс камераар хянаж, шалгалтын танхимын гаднах дэлгэцээр харуулах ажлыг улсын хэмжээнд нэвтрүүлэв. (Биелэлт 60 хувь)

4.1.1.2-4. Шалгалтын төстийн агуулгыг сайжруулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны зөвлөлөөс 2017 онд Улсын Их Хурлаас шинээр болон шинэчлэн гаргасан хууль тогтоомжийн талаар төрийн албан хаагчдад таниулах, сурталчлах, судлуулах үүднээс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалт болон төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад бэлтгэх гарын авлагыг шинэчлэн боловсруулах хүрээнд өмнө хэвлэгдэн гарч байсан гарын авлагаас хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт орсон хуулиудын сорилыг хасч, шинээр нийт 1552 сорилыг боловсруулж, нийтийн хэрэглээнд гаргасан болно. Уг гарын авлагад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөөс бүрдсэн тус бүр 50 сорилыг эмхэтгэн оруулсан. Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд нийт 2000 сорил боловсруулах

ажлыг эрдэмтэн судлаач, холбогдох төрийн бус байгууллага, ажилтан, албан хаагчдаар гэрээлэн гүйцэтгүүлж гарын авлагыг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.1.2-5. Төрийн захиргааны албан хаагчийн сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 44 дүгээр зүйлийн 44.5-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батлахаар заасны дагуу төслийг боловсруулж (<http://csc.gov.mn/b/56/30>) Засгийн газраас төслийг дэмжсэн бөгөөд төслийг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. (Биелэлт 40 хувь)

4.1.1.2-6. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв байгууллага батлахаар заасан. Үүний дагуу Төрийн албаны зөвлөл “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-ын төсөл (<http://csc.gov.mn/b/56/30>)-ийг боловсруулж батлахад бэлэн болгов. Мөн уг нийтлэг журамд нийцүүлэн дээрх шаардлага болон албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд батлахаар хуульд тусгасан бөгөөд тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад

тохиолдолд албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглосон. “Төрийн жинхэнэ албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын төсөл (<http://www.csc.gov.mn/s/30/30/>)-д батлагдсаны дараа төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. (Биелэлт 90 хувь)

4.1.1.3-1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээний холбогдох зохицуулалтыг бий болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэх талаар тусгасан ба “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журам”-ыг Засгийн газар батлахаар хуульчилсны дагуу энэхүү журмын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.

Мөн Засгийн газрын “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулахаар заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 265/72 дугаар хамтарсан

тушаалаар Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах удирдамж, Төв комиссын бүрэлдэхүүн, үнэлгээний ажлыг зохион байгуулах хуваарийг батлан мөрдөж, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажилд 13 яам, 23 агентлаг, 21 аймаг, 330 сум, нийслэл, 9 дүүргийн төрийн жинхэнэ 44576 албан хаагч хамрагдав. (Биелэлт 60 хувь)

4.1.1.4-1. Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн нөлөөллөөс ангид томилох, чөлөөлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /ЗГХЭГ, ТАЗ, 2017-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших /мерит/ зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс томилохоор тус тус тогтоосон бөгөөд иргэнийг төрийн албанд томилох, чөлөөлөхдөө хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, үр чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах талаар тусгасан.

Мөн хуульд төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг



үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгохоор заасан. Мөн дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д “Улс төрийн албан тушаалтан энэ хуулийн 31.2, 32.2-т заасныг зөрчсөн тохиолдолд энэ нь тухайн этгээдийг огцруулах үндэслэл болно.” гэсэн зохицуулалтыг тусгаж, эрх зүйн орчинг тодорхой болгов. (Биелэлт 60 хувь)

4.1.1.5-1. Авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах / АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, арилгах, таслан зогсоох, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна. Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/185 дугаар тушаалаар батлуулсан болно. Аргачлалын дагуу 24 яам, агентлагт авлигын эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр төрийн бус болон судалгааны байгууллагатай тогтмол харилцан зөвлөгөө өгч ажиллав. Тус ажлын хүрээнд гэрээт ажил гүйцэтгэсэн 6 төрийн бус байгууллагаас 24 байгууллагын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, үр дүн, тайланг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулав. Авлигатай тэмцэх газраас гаргадаг Шударга байдлын үнэлгээ болон төрийн бус судалгааны байгууллагуудын судалгааны дүнгээр авлигын өндөр эрсдэлтэй гэж тооцогдож буй уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, гаалийн салбаруудад авлигын шалтгаан, нөхцөлийг тогтоох, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор Авлигатай тэмцэх газрын ажлын багууд өнгөрсөн хугацаанд 21 аймагт 3 удаа,

давхардсан тоогоор 144 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр нь танилцуулсан. Тухайлбал, 2018 онд цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулан 21 аймаг, 50 суманд ажилласан нь хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, нээлттэй, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, шударга ёсны үнэлэмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн гарч байгаа боловч шалгалтын явцад ажлын багаас төрийн байгууллагууд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг боломжит түвшинд хангаагүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч ажиллаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн болно. Иймд авлигын түвшинг бууруулах, авлигын эрсдэл үүсгэж буй хүчин зүйл, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийг давтан гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон нийслэл, аймаг, орон нутгийн удирдлагад, албан хаагчдад илэрсэн нөхцөл байдлын талаар танилцуулж, Засгийн газарт ЗӨВЛӨМЖ хүргүүлсэн. Мөн Засгийн газрын гишүүдэд салбар бүрийн авлигын нөхцөл байдал талаар тусгайлсан зөвлөмж хүргүүлэн, илэрсэн зарим зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2018 оны 2, 3 дугаар улиралд яам, агентлагт ажиллах явцад Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 онд хүргүүлсэн 159 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 61 хувьтай байв.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаал, Эрчим хүчний хөгжлийн төвийн захирлын Б/36 дугаар тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”, Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2009 оны 28/01 дүгээр тэмдэглэл, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/18 дугаар тушаал зэрэг 50 гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох арга хэмжээг авлаа.

Түүнчлэн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 48 журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авлаа. Тухайлбал, энэ ажлын хүрээнд Баянхонгор аймагт хамаарах 5, Говь-Алтай аймагт хамаарах 3, Завхан аймагт хамаарах 2, Өвөрхангай аймагт хамаарах 11, Өмнөговь аймагт хамаарах 3, Дундговь аймагт хамаарах 7, Увс аймагт хамаарах 4, Баян-Өлгий аймагт хамаарах 13 шийдвэрийг тус тус хянан үзсэн байна.

Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан,

нөхцөлийг арилгуулахаар 2017 онд 22, 2018 онд 8 байгууллагад хүргүүлсэн Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй 2018 онд газар дээр нь танилцахад холбогдох хариуг хуулийн хугацаанд ирүүлдэггүй, авсан арга хэмжээ нь ёс төдий байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасан “байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах”, 9.2-т заасан “Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар шүүхийн энгийн магадлал, прокурорын болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдэгдэл, зөвлөмжийг хүлээж авсан байгууллага, аж ахуйн нэгж түүний дагуу тодорхой арга хэмжээ авч, хариуг хугацаанд нь өгч байх үүрэгтэй.” гэснийг зөрчиж байсан тул цаашид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх чиглэлээр холбогдох байгууллагад анхааруулав.

Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг ихээр гарч байгаа салбарт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор багийн зохион байгуулалтаар Мэргэжлийн хяналтын газар, Автотээврийн үндэсний төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудад ажиллав. Тухайлбал, нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт, элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, урьдчилан сэргийлэх шат даралсан арга хэмжээ авч ажиллах талаар тусгайлсан ЗӨВЛӨМЖ боловсруулан хүргүүлж, 2018 оны 9 дүгээр сард нийслэлийн төвийн дүүргүүдийн сургуулиуд болох 45, 1, 84, 23, 24 дүгээр



сургуулиудын нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь танилцаж, хөндөгдсөн асуудлаар олон нийтэд мэдээлэв. (Биелэлт 60 хувь)

4.1.1.6-1. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлах, дүн шинжилгээ хийх, төрийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлуулах /ТАЗ, 2017-2019/

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмүүдийг судалж Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасны дагуу “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлсэн болно. (Биелэлт 50 хувь)

4.1.1.6-2. Үлгэрчилсэн дүрмийн хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг салбар бүрээр батлуулах /ТАЗ, ЗГХЭГ, УИХТГ 2018-2022/

Зарим байгууллагууд 2018 онд салбарын ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж баталсан. Тухайлбал, Прокурорын ёс зүйн дүрэм, прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, прокурорын сахилгын дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар Зарлигийн 1 дүгээр хавсралтаар батлуулж, Улсын ерөнхий прокурорын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/16 тоот тушаалаар Прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилжээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/243 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ыг тус тус баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3909 дугаарт бүртгүүлсэн байна.

Засгийн газраас төрийн захиргааны

болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсны дараа салбар, байгууллага түүнд нийцүүлж дүрмээ батлах ажлыг хийж гүйцэтгэнэ. (Биелэлт 10 хувь)

4.1.1.6-3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах /ТАЗ, 2017-2022/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Төрийн албаны зөвлөл нь дараа оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаарх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал зэрэг холбогдох бусад мэдээллийг багтаасан тайланг хүргүүлэх, тайланг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэн дүгнэлт гаргаж “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэхээр тус тус тусгасан. Төрийн албаны зөвлөл жил бүр ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг санг нэгтгэн хөтөлдөг бөгөөд дүн шинжилгээ, тайлан, дүгнэлт хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор энэхүү мэдээллийн санг цахим хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.

Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийн агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдал, ёс зүйн зөрчлийн бодит байдал, практикт гарч буй зөрчил, хүлээлгэсэн хариуцлага, хариуцлагын төрөл, ёс зүйн зөрчилд ногдуулж буй хариуцлага хоорондын ялгаа, Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын уялдаа холбоо, зохицуулалтын зарим асуудлыг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах зорилгоор нийслэлийн ёс зүйн хороодын үйл ажиллагаа, зөрчил шийдвэрлэлтэд төрийн бус байгууллагаар судалгаа хийлгэж дүнг төрийн байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж,

хэлэлцүүлсэн байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь заалтын дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын ёс зүйн зөрчлийн мэдээ (нэгдсэн сан)-г www.ulaanbaatar.mn цахим хуудсаар мэдээлж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.1.7-1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх /АТГ, ТАЗ, 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 70112458 дугаартай факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, 1800-1969 тусгай дугаарын утсаар болон байгууллагын байранд биеэр ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд өгөх боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд “авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах утсыг сурталчилсан 3 төрлийн видео шторкийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэв. Мөн “Скайтел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран холбогдох сурталчилгааг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулав. Авлигатай тэмцэх газар иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх зорилгоор 1800-1969 дугаарын утасны дуудлагыг хүлээн авах ажилтны тоог нэмэгдүүлж, дуудлагын бичлэгийг хадгалах, хүлээн авсан гомдол, мэдээллийг бүртгэх, шийдвэрлэлтийг

хянах програм хангамжийг боловсруулж, нэвтрүүлсэн. Гомдол мэдээлэл хүлээн авах утсыг сурталчилсан зурагт хуудас, наалт, бал, дэвтэр зэрэг сурталчилгааны материалыг шинэ загвараар боловсруулж, олон нийтэд түгээснээр гомдол, мэдээлэл хүлээн авах утасны програмд 2017 оны сүүлийн хагас жилд нийт 125, 2018 онд 249 дуудлага ирүүлснийг бүртгэн хяналт тавьж ажиллав.

Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэх арга хэмжээний журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны А/123 дугаар тушаалаар батлуулж, журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 4036 дугаарт бүртгэгдэн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөх боллоо.

Түүнчлэн бусад орны сайн туршлагыг судалж, авлигын талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, авлигын эсрэг хууль тогтоомийн талаар мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг иргэдэд ойртуулах зорилгоор Иргэний хяналтын төвүүдийг нээж ажиллуулахад бэлэн болгов.

Харин төрийн бусад байгууллагаас дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр тухайн байгууллагын албан тушаалтны ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаарын утас ажиллуулах, дотоод хяналтын албан тушаалтнуудад чадавхжуулах сургалт зохион байгуулах, харьяа нэгж, байгууллагадаа дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж, үүрэг, албан даалгавар хүргүүлэх, дотоод хяналт, шалгалт хийх, цахим хуудсандаа тусгай цэс нээх зэрэг ажлыг тогтмол зохион байгуулсан. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны зөвлөл хамтран “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөлгөөн”-ийг зохион байгуулж, “Төрийн



албан хаагчийн сахилга, хариуцлага” нэртэй салбар хуралдаанаар төрийн албан хаагчийн хариуцлага, ёс зүй, ёс зүйн олон улсын стандарт зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан санал, санаачилгыг холбогдох дүрэм, журмуудыг батлахдаа тусгасан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны болон харъяа байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 92 ажилтанд сургалт зохион байгуулж, ажлын чиглэл, зөвлөмж чиглэл өгснөөс гадна Олон улсын хөгжлийн ассоциаци /Дэлхийн банк/-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд олон улсад ашиглаж буй төсөл хөтөлбөрийн үнэлгээний аргачлалыг судлан, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийх журмыг боловсруулан батлуулсан. (Биелэлт 50 хувь)

4.1.1.8-1. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, гарсан сөрөг үр дагаврыг арилгах, учруулсан хохирлыг төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ. ШЕЗ, УЕПГ, 2018-2019/

Хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохиролтой холбоотой асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн “Хохирол барагдуулах” гэсэн тусгайлсан бүлгээр зохицуулж байгаа бөгөөд хууль зөрчсөн гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудлыг уг хуулийн 105 дугаар зүйлд заасан Хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага гэсэн бүлэгт тусгасан. Захиргааны ерөнхий хуулийн хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх зохицуулалтаас гадна Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих” гэсэн зүйл шинээр нэмж эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх

тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах тухай төрийн байгууллагаас ирүүлсэн 468 хүсэлтийн дагуу төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзсэн 34 тэрбум 190 сая төгрөгийн нэхэмжлэлийн дүн бүхий иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, мөн нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзсэн төрийн байгууллагын 12 хүсэлт болон прокурор өөрийн санаачилгаар 9, нийт 21 удаа 1 тэрбум 601 сая төгрөгийн нэхэмжлэлийн дүн бүхий иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцсон. Энэ хүрээнд прокурор анхан шатны 244 шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцсоноос 178 хэргийг прокурорын тайлбарын дагуу, 39 хэрэгт прокурорын тайлбарын зарим хэсгийг хүлээн авч, 11 тэрбум 259 сая төгрөгийг төрд ашигтайгаар шийдвэрлүүлсэн. Мөн давж заалдах шатны 24 шүүх хуралдаанд прокурор оролцсоноос 15 хэргийг прокурорын тайлбарын дагуу, 5 хэрэгт прокурорын тайлбарын зарим хэсгийг хүлээн авч, 3 тэрбум 664 сая төгрөгийг төрд ашигтайгаар шийдвэрлүүлжээ.

Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээр төлүүлэх, төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учирсан тохиолдолд хохирлыг заавал арилгуулдаг байх үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсан, чөлөөлөгдсөн, албан тушаал буурсны нөхөн төлбөрийг шийдвэр гаргасан албан тушаалтнаар гаргуулж байх талаар

харилцан мэдээлэл солилцох, чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах талаар Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллахаар бэлтгэл хангаж байна.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулж буй сургалтын хөтөлбөрт “Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг төлүүлэх эрх зүйн үндэслэл” сэдвээр хичээл тусгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.1.8-2. Хууль бус шийдвэр гаргаж, улсад хохирол учруулсныг шүүх тогтоосон тохиолдолд албан тушаалтныг нийтийн албанд дахин томилохгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлэх/ЗГХЭГ, ХЗДХЯ. ТАЗ, АТГ, ШЕЗ, УЕПГ, УАГ, 2018-2019/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэргэшлийн шалгалттай холбогдон гаргасан шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох, хууль бус шийдвэрийг Засгийн газар гаргасан бол уг шийдвэрийг төрийн албаны төв байгууллагын мэдэгдлийг үндэслэн Засгийн газар өөрөө ажлын 14 хоногийн дотор хүчингүй болгох, Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, тухайн мэдэгдлийг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Тухайлбал,

-Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-

д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ (76 дугаар зүйлийн 76.4);

-Энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ (76 дугаар зүйлийн 76.5) гэж заасан байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн болон эрүүл мэндийн доатгалын шимтгэлийг улсаас нөхөн төлүүлдэг байдал арилна. (Биелэлт 50 хувь)

4.1.1.9-1.Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /ЗГХЭГ, ХХМТГ, 2017-2022/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар байгуулсан “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах бодлогын чиглэл, холбогдох журмын хэрэгжилтэд санал, дүгнэлт гаргах” ажлын хэсгээс төрийн байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхээр дүгнэлт гаргасны дагуу төрийн байгууллагуудад Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”-ыг батлуулж, журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/25, А/29 дүгээр хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, улсын хэмжээнд төрийн байгууллагууд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж буй програм хангамжийн талаарх



судалгаа хийн, цахим хэлбэрээр архив албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах програм хангамжийн нийтлэг шаардлага болон нэгдсэн системийн үндсэн архитектур, шаардлагыг тодорхойлсон.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглахтай холбогдуулан тоон гарын үсгийн тэмдэглэгээний хэлбэржилтийг боловсруулж, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, “Монпасс СА” ХХК, Нийслэлийн архивын газарт тус тус хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Төрөөс баримтлах бодлогын чиглэлийн дагуу “Үндэсний дата төв” ҮТҮГ-ийг төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагаар ажиллуулж, 2018 оны байдлаар 739 төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгож, нийслэлийн хэмжээнд 545 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж, цахим хэлбэрээр албан хэрэг хөтөлж байна.

Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг төрийн захиргааны бүх шатны байгууллагуудад хүргүүлж, албан хаагчдад зориулан байгууллага тус бүр дээр тоон гарын үсгийн талаар ойлголт өгөх, хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр танилцуулга сургалтыг явуулж байна.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Дижитал шилжилтийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд байгууллагын нийт албан хаагчдад тоон гарын үсэг худалдан авч, байгууллагын албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагаанд ашиглах програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Хэрэглээнд нэвтрүүлсэн програм хангамжийг нэг яам, нэг аймгийг сонгон авч туршин, цаашид нийт яам, агентлаг, аймаг, дүүргийн

үйл ажиллагаанд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг боловсруулсан. Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2018 оны 4 дүгээр сард Хууль зүй, дотоод хэргийн яам, Архивын ерөнхий газар хамтран зохион байгуулж саналыг нэгтгэн хуулийн төслийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, эцсийн хувилбарыг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан бөгөөд хууль 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байна. Хууль хэрэгжиж эхэлснээр хуулиар хориглосноос бусад бүртгэлийн мэдээллийг нээлттэй ашиглуулах, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас өгөх мэдээллийг нээлттэй, хаалттай, хязгаартай байхаар ангилан зааж мэдээлэл өгөх журмыг хуулиар тогтоосон бөгөөд улсын бүртгэлийн байгууллага нь 81 төрлийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулж, 48 төрлийн лавлагаа мэдээллээр иргэдийг ханган ажиллаж төрийн үйлчилгээний 70 хувь нь бүртгэлийн мэдээлэлд үндэслэдэг тул бүртгэлийн мэдээллийг ангилан зааснаар иргэд цахим хэлбэрээр түргэн шуурхай, чирэгдэлгүйгээр мэдээлэл, лавлагаа, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.

Мөн улсын бүртгэлийн багц хуулийн

хүрээнд цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, оруулах зорилготой төрийн цахим мэдээллийн сан буюу “Үндэсний дата төв” үүсгэн ажиллуулахаар зааж улсын бүртгэлийн мэдээллийн санг хадгалуулах, тус төвөөр дамжуулан мэдээллийг бусад байгууллагатай солилцох боломжийг бүрдүүлэн, сангийн хадгалалт, хамгаалалтын чиглэлээр мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжийн хүлээх эрх, үүрэг болон иргэн, хуулийн этгээдэд мэдээллийн сангаас ашиглуулах мэдээллийн төрөл зэргийг зохицуулсан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.1.9-2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

“Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү журам болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2016 оны А/61 дүгээр тушаалаар баталсан “Төрийн мэдээлэл солилцооны системийн талаар баримтлах бодлогын чиглэл”-тэй уялдуулан Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг хөгжүүлэн 2018 оны 1 дүгээр сараас ашиглалтад оруулсан. Үүнээс хойш 78 үйлчилгээний веб сервисийг хөгжүүлж нийт 66 байгууллагад хандах эрхийг олгосон ба нийт 8 сая гаруй удаа мэдээлэл солилцох хүсэлтийг амжилттай боловсруулан ажиллав. ХУР системийг нэвтрүүлснээр байгууллага хооронд түргэн шуурхай мэдээлэл солилцох, төрөөс иргэдэд үзүүлэх цахим үйлчилгээг нэмэгдүүлэх боломжтой болсон. Системд одоогийн байдлаар Татварын ерөнхий газар, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Юнител групп ХХК, Мобиком корпораци ХХК зэрэг байгууллагууд холбогдсон бөгөөд үйлчилгээний платформын хэсгийг туршилтын байдлаар хэрэглээнд нэвтрүүлэх 6 сарын гэрээ байгуулан, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, техникийн харилцан холболтыг хийж, мэдээлэл солилцон ажиллаж байна. Засгийн газрын

2018 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах журам”-ыг, 2 дугаар хавсралтаа “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам”-ыг, 3 дугаар хавсралтаар “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг тус тус баталсан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын газраас “Ухаалаг засаг” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр “Төрийн мэдээлэл солилцооны системийн үндсэн дэд бүтцийг шинэчлэх” төсөл дэмжигдэн, холбогдох судалгаа тооцоог хийж, төслийн Удирдах хорооны хурлаар хэлэлцүүлсэн.

Холбогдох бусад байгууллагаас буюу шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын дунд эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэргийн мэдээллийн нэгдсэн сан бий болгохоор ажиллаж байгаа ба төсөлд хамрагдсан байгууллагуудын дундын мэдээллийн нэгдсэн санг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/261, А/171, А/67, А/32 дугаартай “Журам батлах тухай” хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан мэдээллийг жагсаалтын дагуу бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хоорондоо мэдээлэл солилцох програм хангамжийн нэгдсэн тогтолцоо бий болгосон. Ингэснээр цагдаагаас гомдол мэдээлэл прокурорт очих, буцаж цагдаагийн байгууллагад очих, прокуророос шүүхэд шилжүүлж байгаа эрүүгийн хэрэг цахим хэлбэрээр шүүхэд шилжих, шүүхийн шийдвэр прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт цахим хэлбэрээр очдог мэдээллийн урсгал 2017 оны 3 дугаар сараас бий болж, ашиглагдаж эхэлсэн. (Биелэлт 25 хувь)

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын



2017 оны 170 дугаар захирамжаар мэдээлэл, харилцаа холбооны салбарын хууль, тогтоомж, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, цахим засаглалыг хөгжүүлэх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдамжаар хангах үүрэг бүхий “Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл”-ийг байгуулж, зөвлөлийн ажиллах журам болон 2018 оны үйл ажиллагааны чиглэлийг баталсан болно. (Биелэлт 25 хувь)

4.1.1.10-1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2019/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан авлигын эсрэг үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэхэд иргэд, олон нийт, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийн идэвх санаачилгыг өрнүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, шударга ёсны ойлголт, мэдлэг олгох, мэдээлэл түгээх, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгөх, нийтийн албан тушаалтан, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагад авлигын эсрэг богино хугацааны болон давтан сургалт явуулах зорилго бүхий Олон нийтийн төвийг 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр ашиглалтад оруулсан ба уг төв нь их танхимдаа өдөрт 120 хүртэл хүний, бага танхимдаа 50 хүртэл хүний сургалтыг зохион байгуулах боломжтой. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Олон нийтийн төвд нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг сургалтад тасралтгүй хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 64 дүгээр зүйлийн 64.3-т “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн

менежментийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага ажиллана” гэж зохицуулалтыг тусгасан. Үүний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд Удирдлагын академийн чиг үүргийг төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулж өөрчлөн байгуулахаар Засгийн газрын 2018 оны 366 тогтоолоор шийдвэрлэсэн. Удирдлагын академид 2013 оноос өмнө элсэн бакалаврын зэрэг олгох сургалтад суралцаж байгаа суралцагчдын хичээлийн хөтөлбөрийг хэвээр үргэлжлүүлэн дуусгавар болгож, цаашид зөвхөн төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах, судалгаа хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг болно. Мөн түүнчлэн төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж байна. (Биелэлт 80 хувь)

4.1.1.10-2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах /АТГ, ТАЗ, УА, 2017-2019

Удирдлагын академи төрийн албан хаагчдад албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх богино, дунд хугацааны давтан сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж Төрийн албаны зөвлөл болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хамтарсан тушаалаар батлуулсан. Энэ хүрээнд төрийн албан тушаалын ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох иргэнийг мэргэшүүлэх багц сургалтын болон төрийн албанд шинээр томилогдсон буюу туслах, дэс түшмэлийн ангилалд хамаарах

албан тушаалд ажиллаж байгаа иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөрийг тус тус батлуулжээ.

Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж ажилласан болно. Тухайлбал Удирдлагын академитай хамтран нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын 6 модуль, гарын авлагыг боловсруулж, туршилт сургалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчдад сургалт хийхэд бэлэн болгов.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын модуль, гарын авлагыг МУИС-ийн баг, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг МУБИС-ийн баг тус тус боловсруулсан. Түүнчлэн “Шинэ хөгжлийн түлхүүр” төрийн бус байгууллагаас иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль, “Жаргалант хангай” төрийн бус байгууллага ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль, “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллага сэтгүүлчид зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж сургалтыг үе шаттай зохион байгуулж эхэлсэн байна. (Биелэлт 80 хувь)

4.1.1.10-3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах /ЗГХЭГ, АТГ, ТАЗ, УА, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсанаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд үе шаттай зохион байгуулах боломж бүрдсэн. Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд нийтийн албан тушаалтнууд, зорилтот бүлэгт зориулсан авлигын эсрэг сургалтаас гадна

иргэдэд мэдээлэл хүргэх, гомдол мэдээлэл хүлээн авах, гарын авлага, материал түгээх, дотоодын болон гадаадын хурал, зөвлөгөөн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад 2017 онд 11345, 2018 онд 14783 хүнийг авлигын эсрэг хамруулжээ. Тэдгээрээс 2018 онд 8497 хүнийг Олон нийтийн төвд сургасан бол тухайн байгууллага дээр болон аймгуудад зохион байгуулсан сургалтад 6286 хүн хамрагдсан байна.

Удирдлагын академи төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх, авлига, хээл хахуультай тэмцэх, урьдчилан сэргийлэх, удирдах албан тушаалтан, албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөө болон Удирдлагын академийн сургалтын бодлого, хөтөлбөрийн дагуу Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институт улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалтууд, төрийн байгууллагатай хамтарсан болон захиалгат сургалтуудад “Төрийн албаны ёс зүй”, “Төсвийн ил тод байдал” гэх мэт авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой сэдвээр тогтмол сургалт зохион байгуулж байна. Тухайлбал, төрийн албаны ёс зүй, манлайлал, харилцааны ур чадварын танхимын болон зайн, ажлын байран дахь сургалт, байгууллагуудын захиалгат богино сургалтад төрийн болон орон нутгийн нийт 1515 албан хаагч хамрагдсан байна. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд байгууллагын захиалгат сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, удирдах ажилтны ёс зүй, төрийн үйлчилгээний соёл, захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь нийтлэг алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, төсөв санхүүгийн хяналт, худалдан авах ажиллагаан дахь нийтлэг зөрчил, түүнээс сэргийлэх арга зам зэрэг сэдвийн хүрээнд 510 хүн хамрагдсан.

Түүнчлэн авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг төрийн зарим байгууллагууд онцлог байдлаар



зохион байгуулсан байна. Тухайлбал, нийслэлийн Засаг даргын Тамгын газар Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын сургалтын хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийн агуулга” боловсруулан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн. Мөн хөтөлбөрт тусгагдсан модуль сургалтуудыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Сургалтын төв”-ийг түшиглэн зохион байгуулав. Нийслэлийн төвийн 6 дүүрэг, хэрэгжүүлэгч 14 агентлагийн хүний нөөц хариуцсан ажилтнуудад зориулсан “Хувь хүнийг хөгжүүлэх нь” сэдэвт олон улсын сертификаттай сургалт; Герман-Монголын хамтарсан Афа академитэй хамтран “Төрийн албан хаагчийн хувь хүний хөгжил ба ёс зүй” сэдэвт сургалт; Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд зориулсан сургалт; “Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн зохицуулалт, төрийн албаны соёл, стандарт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ” сэдэвт сургалт; Дүүргийн хороодод шинээр томилогдсон хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хорооны зохион байгуулагч нарт зориулсан суурь сургалт; төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчдэд зориулсан сургалт; Төрийн жинхэнэ албан тушаалд анх удаа орж байгаа албан тушаалтнуудад ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалтыг тус тус зохион байгуулав.

Сангийн яам “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сурталчлах нэг сарын аян”-ыг өрнүүлж, “Монгол төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт өв”, “Албаны соёл, ажил хэрэгч байдал”, “Төрийн албаны үнэт зүйл, байгууллагын соёл”, “Хүний нөөцийн хөгжил, хөдөлмөрийн ёс суртахуун”, “Харилцааны чадвар” сургалт зохион байгуулж, яамны

албан хаагчдын 75 хувийг хамруулсан; Улсын бүртгэлийн ерөнхий газар 69 удаагийн сургалт зохион байгуулж 3525 /давхардсан тоогоор/ гаруй албан хаагчийг, Засгийн газрын болон байгууллагын зардлаар, бусад төрийн байгууллагын зохион байгуулж буй сургалтад 193 гаруй албан хаагчийг хамруулсан. Төрийн болон төрийн бус байгууллагын захиалгаар, иргэдэд зориулсан эрх зүйн сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд 15 удаагийн сургалт зохион байгуулж 481912 иргэнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах сургалт зохион байгуулсан.(Биелэлт 30 хувь)

Хоёр. Төрийн үйлчилгээний нээлтэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дахь зорилтын хүрээнд нийт 7 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 2017 онд 4 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд 16 арга хэмжээг хэрэгжүүлэв. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.2.1-1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах /ЗГХЭГ, ХХМТГ, ХХ: Бүх шатны төрийн байгууллагууд. 2017-2018/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний цахим систем /ezasag.mn/-д холбох төрийн 167 үйлчилгээний жагсаалтын дагуу 2017 онд 18 үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг цахим машин ашиглан иргэдэд хүргэхэд мөрдөх

“Төрийн үйлчилгээний цахим машины ашиглалт үйлчилгээний журам”-ыг шинэчлэн батлуулсан. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн www.ezasag.mn цахим хуудсыг ашиглан Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн жолооны үнэмлэх солиулах үйлчилгээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 6 төрлийн үйлчилгээний холболтыг турших, Автотээврийн үндэсний төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 3 төрлийн үйлчилгээг ТҮЦ машины үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн бол 2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 30 дугаар тушаалаар “Төрийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, төрийн үйлчилгээг иргэн төвтэй болгож, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулав. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталж, 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгов. “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-д 174 үйлчилгээг төрийн цахим мэдээлэл солилцох системд холбохоор холбогдох яам, үйлчилгээний нэрээр нь баталсан бол “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний жагсаалт”-д 38 байгууллагын 320 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхээр нэрээр нь тусгасан байна.

Гаалийн ерөнхий газар нь хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлын талаар хэрэглэгчийн үнэлгээг “Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны багаар 2018 оны 11-12 дугаар сард гүйцэтгүүлсэн бөгөөд судалгаанд

оролцогчдын 48.3 хувь нь хувийн хэвшлийн, 31.9 хувь нь энгийн иргэн, 15.9 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 3.9 хувь нь төрийн болон төрийн өмчийн байгууллагад хамаарч байв. Хэрэглэгчид гаалийн байгууллагад 3.68 буюу “дунд” гэсэн үнэлгээг өгчээ. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч сэтгэл ханамжтай байгаа хэдий ч хэрэглэгчтэй холбоотой зарим үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байгааг энэхүү индексийн утга харуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа агентлаг, байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа 27 үйлчилгээний судалгааг гарган Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлээд байна.

Татварын ерөнхий газар 2017 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд албан татварын чөлөөлөлт, хөнгөлөлт, буцаан олголтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр буюу татварын орлогын чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамрагдахад татвар төлөгчийн бүрдүүлэх материалыг төрийн үйлчилгээний нэгдсэн платформ ХҮР системийг ашиглан цахимаар 2018 оноос эхлэн татварын албанд хүлээн авах шинэ хэрэглээг нэвтрүүлэхээр Үндэсний Дата төвтэй гэрээ байгуулж, хамтарсан төлөвлөгөө гарган ажилласнаар Орон сууцны орлогын чөлөөлөлт болон сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэхэд бүрдүүлэхтэй холбогдуулан ХҮР системээс татвар төлөгчийн гарын хурууны хээг уншуулах төхөөрөмжийн тусламжтайгаар иргэний үнэмлэхийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагааг авдаг боллоо. ХҮР системийг ашиглан үйлчилгээг хөнгөвчилснөөр орон сууцны чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч 12 төрлийн материал бүрдүүлдэг байсан бол 5 ширхэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах татвар төлөгч 9 материал бүрдүүлдэг байсан бол 3 ширхэг материал бүрдүүлдэг болсон.

ХҮР системийг ашиглан 18000 гаруй иргэнээс хөнгөлөлт, чөлөөлөлтийн



материал хүлээн авсан байна. 1800-1288 дугаарын дуудлагын програмыг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/35 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг програмын явц, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид програмыг шинэчлэх зөвлөмж шаардлагатай байгааг үндэслэн 2018 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтыг тусгуулан програм шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна.

Сангийн яам Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн В7 хувилбар /цахим технологид суурилсан/ -ыг нэвтрүүлэв. Төсвийн орлогыг түргэн шуурхай, тогтмол төвлөрүүлэх зорилгоор “Татварын цахим төлбөрийн систем” төслийг Татварын ерөнхий газарт хэрэгжүүлж, системээс үүсэх давтагдашгүй нэхэмжлэхийн дугаараар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага татвараа төлөх бэлтгэл ажлыг хийв. Арилжааны 11 банкны 2887 дансаар дамждаг байсан орлого 6 банкны 6 дансанд төлөгдөх ба татварын төрлөөр уг систем ангилан Төрийн сан дахь улсын болон орон нутгийн төсвийн орлогын /аймаг, сүм, нийслэл, дүүрэг/ 5137 дансанд өдөр тутам төвлөрүүлэх болно.

Сангийн яам нь нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын банктай ТЭГ үлдэгдэлтэй дансны гурвалсан гэрээ байгуулан Замын хөдөлгөөний удирдах төвд байрлуулсан пос машинаар дамжуулан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн иргэдэд ногдуулсан торгуулийн орлогыг цахим хэлбэрээр хүлээн авч байна. Төрийн албан хаагчийн цалин хөлсний мэдээллийг төсвийн төлөвлөлтөд ашиглах замаар төсвийн орон тооны хяналт тогтоох, урсгал зардлын хуваарилалтын үр ашиг, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Цалин хөлсний тооцооны төвлөрсөн систем”-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангав.

“Олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах, боловсронгуй болгох” гэсэн зорилтот хөтөлбөрийн хүрээнд 2008 оноос хойш www.il.tod.mn цахим хуудсыг нээн ажиллуулж байна. Тус цахим хуудсанд 2008-

2018 оны хооронд нийт 400 гаруй улсын төсөвтэй холбогдолтой цаг үеийн мэдээ, мэдээлэл, гарын авлага, хууль тогтоомж, дүрэм, журмыг тогтмол тавьж, төсвийн үйл явц, төсвийн төсөл, батлагдсан төсвүүд, түүнд холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй, түргэн шуурхай хүргэхээр холбогдох мэдээллийг байршуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн мэдээллийг www.tusuv-oronnutag.mn цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлдэг бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой болсон.

Хөгжлийн банкаас төслийн санхүүжилт, зээлийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулж Зээл санхүүжилтийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх цахим систем (LOS system)-ийг ашиглалтад оруулав.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас www.mcsd.mn цахим хаягаар иргэд, олон нийтэд хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд анхаарч ажиллаж байна. Мөн уг цахим хуудсанд холбогдох бусад төрийн байгууллагын цахим хуудсанд нэвтрэх болон Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын иргэдэд “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлсэнтэй холбоотойгоор хувь хүн өөрийн регистрийн дугаараар “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг шалгах боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна. (Биелэлт 100 хувь)

4.1.2.1-2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, 2018-2022/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн www.ezasag.mn цахим хуудсыг ашиглан Хөдөлмөр, халамжийн

үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан уг портал сайтаар дамжуулан иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг хэвийн ажиллагаатай болгохоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Интерактив” ХХК, “Интерактив Би Ай” ХХК хамтран холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос Үндэсний Дата төвтэй хамтран ХУР системд Санхүүгийн зохицуулах хорооны “Зөвшөөрлийн цахим систем”-ийг бүрэн холбохоор ажиллаж байна. Сангийн яам Хөрөнгийн үнэлгээний болон Аудит, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хүрээнд тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд болон иргэдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг эхлүүлээд байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Монгол Улсын шүүхийн цахим сан”, “Эрэн сурвалжлах албадан ирүүлэх” бүртгэл тайлангийн систем, “Санал хүсэлт”-ийн систем, “Иргэний хэргийн хөдөлгөөний удирдлагын төв”-ийн систем, “Захиргааны хэргийн хөдөлгөөний удирдлагын төв”-ийн систем гэсэн 5 цахим үйлчилгээний системийг нэвтрүүлэв. Тухайлбал, Шүүхийн үүдэнд байрлах киоско төхөөрөмжөөр иргэдэд шүүхийн мэдээллийг хүргэх, иргэдээс шүүхтэй холбоотой санал хүсэлт болон судалгаа авах зорилготой “Санал хүсэлт” системийг ашиглаж байна. Түүнчлэн 2018 онд Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран шүүхэд шаардлагатай иргэн, хуулийн этгээдийн талаар лавлагаа, мэдээллийг цахимаар авах бололцоог бүрдүүлэхээр ажиллав.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 141 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний Дүнжингарав, Мишээл, Драгон болон Оргил төвийг байгуулан үйл ажиллагааг нь 2016 оны 4 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд

2018 оны жилийн эцэс гэхэд давхардсан тоогоор нийт 4,450,197 иргэнд үйлчилгээ үзүүлжээ. Тус төвийг байгуулснаар төрийн 320 үйлчилгээг төвлөрүүлэн нэг цэгээс цахим болон уламжлалт хэлбэрээр үзүүлэх боломжтой болж төрийн үйлчилгээний хүнд суртал, шийдвэрлэлтийн хугацаа багасаж, иргэдийн санхүү болон цаг хугацааг хэмнэх давуу талтай болсон. “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолын дагуу нийслэл, орон нутагт нэг цонхны үйлчилгээний нийт 45 төв (213 цонх бүхий) үйлчилгээ үзүүлж байгаагаас 150 цонх нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа нэг цонх жилд дунджаар 3150 удаа, өдөрт 13 удаа үйлчилгээ үзүүлдэг ба төрийн байгууллагуудын үйлчилгээнээс шалтгаалан цонхны ачаалал харилцан адилгүй байдаг. Эдгээр төвүүдэд байгууллага тус бүрээс төлөөлөл сууж ажилладаг, үйлчилгээний ачаалал харилцан адилгүй, үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэх явц иргэнд тодорхойгүй байдгаас хүлээлт үүсэх, дахин лавлаж ачаалал үүсгэх зэрэг асуудал тулгарч байна. Одоогийн байдлаар төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан төрийн 28 байгууллагын 85 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд бэлэн болсон.

Иймээс иргэд төрийн үйлчилгээ авахдаа олон цонх дамжиж байгаа шатлалыг арилгах, давхардсан бүтэц үүсгэхгүй байх зорилгоор төрийн дижитал шилжилтийг хийж нэг цонхны үйлчилгээ болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг өөрчлөн зохион байгуулах, сумдад төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэгдсэн төв шинээр байгуулах, тэдгээрийг операторын горимд шилжүүлэх (олон цонх дамжих шатлалыг арилгаж, тухайн нэг цонхноос бүх үйлчилгээг авах бололцоог бүрдүүлэх), үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргах эрх бүхий албан хаагчид цахим хэлбэрээр дамжуулах, шийдвэрлэлтийн явцыг иргэнд мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмж,



шийдвэрлэлтийн явцын талаар нэгдсэн хяналт хийх боломж бүхий “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн мэдээллийн системийг хөгжүүлж төрийн мэдээлэл солилцооны ХҮР системд холбон нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэн Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Прокурорын байгууллага нь 41 салбар нэгжийг сүлжээнд холбон ашиглаж байгаа бөгөөд төрийн нэгдсэн сүлжээнд мөн холбогдон бусад байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тасралтгүй ажиллах нөхцөлийг хангахад байгууллага тус бүртэй хамтран ажиллах шаардлагатай.

Засгийн газрын 2015 оны 254 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн баталсан. (Биелэлт 60 хувь)

4.1.2.2-1. Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах /ЗГХЭГ, 2017-2018/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулж байгаа Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалаар зөвшөөрлийн тоог 2-3 дахин бууруулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүнд сурталгүй хүргэх, шуурхай зохион байгуулах чиглэлээр ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулж, яамдаас санал авч байна. 2019 оны хавар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна. Сангийн яам Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.4.3-т заасны дагуу үнэт цаас үйлдвэрлэх, тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд нэмж тусгах, зөвшөөрөл олгохтой холбоотой нэмэлт нөхцөл, шаардлагыг тогтоосон холбогдох дүрэм

журмыг эрх бүхий байгууллагаас гаргаж мөрдүүлэх саналыг хүргүүлсэн. (Биелэлт 60 хувь)

4.1.2.2-2.Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх /ЗГХЭГ, 2018-2022/

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх гэж заасны дагуу Сангийн сайдын тушаалаар олгодог мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Мэргэшсэн нягтлан бодогчийн институт төрийн бус байгууллагад, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлэн ажиллаж байна. Хөрөнгийн үнэлгээний, аудит, татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаарх сонгон шалгаруулалт, мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх ажлыг зохион байгуулж Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, аудитын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй гэрээ байгуулан, жил бүр ажлын төлөвлөгөөг баталж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.2.3-1-2. Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох /СХЗГ, 2018-2020/

Үндэсний стандартын баримт бичгийн улсын үзлэгийг зохион байгуулж, одоо мөрдөж буй 367 стандартыг хүчингүй болгох, 2074 стандартыг дахин хянаж шинэчлэх, 591 стандартыг шинээр боловсруулах үндэслэлийг тусгасан жагсаалтыг гаргаж, стандартын улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар ажиллаж байна. Харин олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна. (Биелэлт 0 хувь)

4.1.2.4-1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ЗГХЭГ, МХЕГ, ТЕГ 2018-2019/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүнзгийрүүлэн төлөвшүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлийн шалгуурыг 100 бизнес эрхлэгч, улсын байцаагчаар хэлэлцүүлж, аймаг, нийслэлийн улсын байцаагчдын саналыг авч тусган сайжруулсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг системийн хэмжээнд зохион байгуулж эрсдэлийн ангилалд хамааруулах объектын жагсаалтыг Шадар сайдын “Жагсаалт батлах тухай” 2018 оны 116 дугаар тушаалаар батлуулав. Мэргэжлийн хяналтын системийн 33 нэгжийн нийт 1458 удирдлага, улсын байцаагчийн 70624 шалгуулагч этгээдийн хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 140519 объектод эрсдэлийн үнэлгээ хийв.

Нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэл их 21326 /15.1 хувь/ объект, эрсдэл дунд 80869 /57,7 хувь/ объект үнэлэгдсэн. Харин эрсдэл бага 38324 /27,2 хувь/ объект үнэлэгдсэн байна. Эрсдэл их үнэлэгдсэн объектийн тоог 2017 оныхтой харьцуулж үзэхэд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, эрсдэл 3677 объектод өссөн байна. Их болон бага эрсдэлтэй үнэлэгдсэн объектийн эзлэх хувийн өөрчлөлтийг үзвэл, өмнөх оныхоос эрсдэл ихтэй объектийн эзлэх хувь 0,8 хувиар өссөн, эрсдэл багатай объектийн эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар буурсан байна.

Импортын барааны эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг оновчлох зорилгоор Азийн хөгжлийн банкны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл”-ийн олон улсын зөвлөхүүдтэй хамтран Засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолоор баталсан эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийг олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, 2019 оны 6 дугаар сард багтаан Шадар сайдын ажлын албанд хүргүүлэх шийдвэрийн дагуу ажиллаж байна.

“Шалгуур, үзүүлэлт батлах тухай” (Хяналт шалгалтын объектийг эрсдэлийн ангилалд хамааруулах) Засгийн газрын 2012 оны 23 дугаар тогтоол, “Шалгуур, үзүүлэлт батлах тухай” (Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт) Засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолыг тус тус шинэчлэн батлуулахаар холбогдох төслийг боловсруулаад байна. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу нийт улсын байцаагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас санал авч хэлэлцүүлэг хийж, туршин сайжруулсны үндсэн дээр өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байгаа тул журмыг Засгийн газрын хуралдаанаар



2019 оны 2 дугаар улиралд хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулахаар заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар хуулийг төслийг боловсруулах, Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо Даатгалын байгууллагууд өөрийн чанарын эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг (Own risk solvency assessment-ORSA) нэвтрүүлэх бэлтгэл ажил, эрсдэлд суурилсан хөрөнгө буюу тоон үзүүлэлтийн үнэлгээг (Risk Based Capital-RBC)-г нэвтрүүлэх талаар судалгаа хийж, даатгалын компаниудын хөрөнгийн хүрэлцээт байдал, төлбөрийн чадварыг оновчтой тогтоох, нөөцийн санг тооцох аргачлалыг боловсронгуй болгох ажлууд хийж эхлээд байна.

Даатгалын компанид учирч болох эрсдэлийг урьдчилан таамаглаж тогтоох, үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгоход эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгохоор Дэлхийн банкны болон Люксембургийн төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, холбогдох саналуудыг тусгасан “Даатгагчийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх журам”-уудын төслийг боловсруулаад байна. Хадгаламж зээлийн хоршоодын эрсдэлийг үнэлснээр өндөр түвшний эрсдэлтэй хоршоодод хугацаатай үүрэг даалгавар болон холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд маш өндөр эрсдэлийн түвшинтэй буюу өөрийн хөрөнгөгүй болсон хоршоодод тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдсэн болохыг

мэдэгдэх, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд оруулах гэх мэт холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллав.

ОУВС-гийн аргачлалын дагуу Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх эрсдэлийн индикаторуудыг тодорхойлж, асуулга, судалгааны төсвийг боловсруулан, нийт зохицуулалттай этгээдүүдийг хамруулсан судалгааг өрнүүлээд байна. Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан. Тус судалгааны аргачлалыг журмын хавсралтаар баталсан ба судалгааны үр дүнд үндэслэн өндөр эрсдэлтэй байгууллагуудад газар дээр нь хяналт шалгалт хийхээр төлөвлөгдөж байна. Хэрэглээний зээлийн хувьд зээлдэгчийн өр, орлогын харьцааг 70 хувиар, зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх шийдвэрийг арилжааны банкуудын хувьд хэрэгжүүлснээр зээл шилжих эрсдэл байгаа эсэхийг судлах, уг шийдвэрийг банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг Монголбанкны Мөнгөний бодлогын газартай хамтран судлах ажлыг эхлүүлээд байна.

Мөн БНСУ-ын “Knowledge sharing program” буюу мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын болон хадгаламж зээлийн хоршоодын санхүүгийн үзүүлэлт дээр тулгуурлан эрсдэлийн зэрэглэлийг тогтоох аргачлалыг боловсруулсан. Тус аргачлалыг боловсронгуй болгох хүрээнд их сургуулийн багш, судлаач нартай хамтран ажиллаж, зөвлөгөө аван санал солилцохоор төлөвлөж байна.

Хадгаламж зээлийн хоршооны салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр Зайны хяналтын журам, эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлагын төслийг боловсруулж байна. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан өндөр эрсдэл бүхий Хадгаламж зээлийн хоршоодод авч хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг гаргасан. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчны талаар зүйл, заалтууд оруулаад байна.

Банкнаас бусад хадгаламж татдаг санхүүгийн байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлал боловсруулахтай холбоотой Монгол Улсын хадгаламж татдаг байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдал, хяналт, зохицуулалтын орчны талаар судалгааг гүйцэтгэсэн.

Сүүлийн 2 жилийн байдлаар газар дээрх шалгалтад хамрагдаагүй хадгаламж, зээлийн хоршооны судалгааг гаргав. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх хүрээнд Азийн хөгжлийн банкны зөвлөхийн зохион байгуулсан чадавхжуулах сургалтад холбогдох албан хаагчид хамруулав.

Хяналт шалгалтын аргачлалыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хадгаламж зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд тулгуурлан эрсдэлд нөлөөлөх 11 санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг тогтоож, нийт 290 хадгаламж зээлийн хоршооны сүүлийн 8 улирлын тайлан мэдээнд үндэслэн эрсдэлийн шинжилгээ хийж, улмаар хадгаламж зээлийн хоршоо тус бүрийн эрсдэлийн хандлага болон эрсдэлийн шалтгааныг тодорхойлон, эрсдэлийг 5 түвшинд ангилан (бага, дунджаас бага, дундаж, өндөр, маш өндөр) үнэлэлт дүгнэлт өгч холбогдох санал, зөвлөмжийг боловсруулав. Өндөр түвшний эрсдэлтэй хоршоодод хугацаатай үүрэг даалгавар болон холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд маш өндөр эрсдэлийн түвшинтэй буюу өөрийн хөрөнгөгүй болсон хадгаламж зээлийн хоршоодод тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл бүрдсэн болохыг мэдэгдэх, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд оруулах гэх мэт холбогдох арга хэмжээнүүдийг яаралтай авч ажиллав. Цаашид уг судалгаанд үндэслэн хадгаламж зээлийн хоршооны болон бусад салбарт эрсдэлд суурилсан

хяналт шалгалтыг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хийв.

Эрсдэлд суурилсан аудит, хяналт шинжилгээ үнэлгээг нэвтрүүлэх зорилгоор эхний ээлжид “Санхүүгийн зохицуулах хорооны дотоод аудитын гарын авлага”-ыг боловсруулсан. Мөн Хорооны үйл ажиллагааны гадаад болон дотоод эрсдэлийг тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор эрсдэлийн судалгааны асуулгыг боловсруулан судалгаа авахаар бэлтгэж байна.

Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2018 оны 4-7 дугаар сард Улаанбаатар хот, орон нутагт нэгдсэн шалгалт хийж, тус шалгалтад Хорооны зохицуулалт бүхий мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийг бүрэн хамруулав. (Биелэлт 40 хувь)

4.1.2.4-2. Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ 2018-2020/

Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх асуудлыг хариуцсан байгууллагууд хэлэлцэж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-тай давхардах нөхцөл байдал үүсэх тул ажлын хэсэг байгуулан тухайн асуудалд дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Стандарт хэмжил зүйн газрын 2019 оны ажлын төлөвлөгөөнд стандартын төслийг боловсруулах хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөөд байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь дотоод хяналтыг төлөвшүүлэх чиглэлээр түшиц 10 байгууллага, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар бүр 1-2 байгууллагыг сонгон, санамж бичгийн хүрээнд дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажиллан, бусад 100 бизнесийн байгууллагад



туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулахаар 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган Шадар сайдаар батлуулав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/07 тушаалаар “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг шинэчлэн батлуулсан. Журмын хүрээнд дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. (Биелэлт 0 хувь)

4.1.2.4-3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх /ЗГХЭГ, МХЕГ 2018-2022/

Мэргэжлийн хяналтын газраас шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нийт объектуудыг эрсдэлийн түвшингээр ангилан хяналт шалгалтыг хамгийн их эрсдэл ихтэй объектуудад шалгалтын ажил хийж шалгалтын тоог цөөрүүлэхээр ажиллаж байна. “Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөлт хийх аргачлал”-ыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны А/172 дугаар тушаалаар батлуулав. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 онд эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан 140519 объектоос их, дунд үнэлэгдсэн хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 10100 объектийг төлөвлөгөөт шалгалт, 5613 объектийг зөвлөн туслах үйлчилгээнд хамруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн 2019 онд бусад хяналтын 5 хэлбэрээр 178 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны А/175 дугаар тушаалаар батлан олон нийтэд хуулийн хугацаанд зарлалаа.

Мэргэжлийн хяналтын байгууллага зөвхөн шалгалтын хэлбэрийг ашиглаж, улсын байцаагч торгох, хаах албадлагын аргыг хэрэглэдэг байсан. Иймд шалгалтаас гадна “Зөвлөн туслах үйлчилгээ”, “Салбарын сургалт”, “Урьдчилан сэргийлэх хяналт

шалгалт”, “Баталгаажуулах үйл ажиллагаа”, “Тандалт судалгаа”, “Хяналт шинжилгээ” гэсэн 6 хяналтын хэлбэрийг хэрэгжүүлэх замаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр журам, заавруудыг боловсруулан мөрдөж байна. Тус журам, заавраар улсын байцаагч зөвхөн зөрчил илрүүлээд торгох, хаах биш илэрсэн зөрчил, шаардлага хангаагүй асуудлаар судалдаг, зөвлөгөө өгдөг байх зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр бизнес эрхлэгчид мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргаж зөвлөгөө авах эрмэлзэлтэй боллоо.

Урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн хяналт шалгалтаас гадна аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналт хамтын хяналтын хэлбэрийг нэвтрүүлж эхлэв. Аюул эрсдэл, хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүргийг зөвхөн улсын байцаагчийн үүрэг, хариуцлага гэж ойлгож, бизнес эрхлэгчид улсын байцаагчийг аргалахад л болно гэсэн хандлагыг бий болгож байсан. Энэ нь бизнес эрхлэгчид хяналтын байгууллага, улсын байцаагчийг хяналт шалгалтаар ирэх үед л бэлтгэлээ хангаж бусад үед хяналтгүй байсантай холбоотой. Иймд Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегитай болсон. Энэ стратегитай болсноор зөвхөн улсын байцаагч бизнес эрхлэгч дээр очиж эрсдэл, аюулыг бууруулах биш аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт, хэрэглэгчийн хяналтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгосон. Хэрэглэгч, үйлчлүүлэгч өдөр тутам бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа байнгын хяналт тавьж, шаардлага хангасан эсэхийг хянах 15 хэрэглэгчийн хяналтын хуудсыг бий болгосон. Ингэснээр хэрэглэгч, үйлчлүүлэгчид аюулгүй бөгөөд чанартай эсэхийг хянах мэдлэг, чадвартай болж, тодорхой эрсдэлийг хуваалцаж, бизнес дээр улсын байцаагчийн адил хяналт тавьдаг болно. Ингэснээр улсын байцаагч төдийгүй хэрэглэгч бүрийн хяналт дор аюулгүй байдлаа хангаж ашиг орлоготой ажиллахад нөлөөлж байна. Хэрэглэгч нь худалдан авч

буй бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнээс үүсч болох аливаа эрсдэлийг тооцон сонголтоо зөв хийж чадаж байгаа эсэхэд тандалт судалгаа хийх 2018 оны 01/269 удирдамжийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргаар батлуулан Өвөрхангай аймаг, нийслэлийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт судалгааны ажлыг эхлүүллээ. Тус судалгааны ажлын үр дүнд хэрэглэгч аюулгүй, чанартай бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авахад анхаарах асуудлын жагсаалтыг гаргаж, олон нийтэд мэдээлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2018 онд 1089 зохицуулалттай этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийсэн бөгөөд үүнээс 93,4 хувь буюу 1018 хуулийн этгээдэд урьдчилан сэргийлэх зорилгоор газар дээрх үзлэг хийсэн.

Өмнө нь прокурорын байгууллагын ажлыг дүгнээд алдаа зөрчил гаргасан нэгжүүдийн ажлыг иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулдаг байсан бол 2017 оноос хойш алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2 жил тутам бүх нэгжүүдийн ажлыг иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, 2018 онд Улсын ерөнхий прокурорын баталсан удирдамжийн дагуу Булган, Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Дархан-Уул, Увс, Өмнөговь, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Төв аймгийн прокурорын газруудад иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулж, гаргасан зөрчлийг газар дээр нь илрүүлж арилгуулах, цаашид дахин алдаа зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээг авч, Улсын ерөнхий прокурорын “Ажил сайжруулах” талаар албан даалгавар өгч ажиллаж байна.

Мөн прокурор, ажилтны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйг зөрчүүлэхгүй байхад анхаарч улирал тутам гэмт хэрэг, зөрчилд холбогдсон талаарх судалгааг гарган, сэтгэл зүйчтэй хамтран судалгаа хийж, сургалт зохион байгуулж байна. (Биелэлт 20 хувь)

4.1.2.5-1. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар Төрийн байгууллагын шударга байдлын судалгааг 2016, 2018 онд зохион байгуулсан бөгөөд үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна. Шударга байдлын үнэлгээгээр 2018 онд 62 байгууллагыг үнэлсэн бөгөөд үнэлгээний судалгаанд нийтдээ 9411 нэгжээс мэдээлэл цуглуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав.

Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь шударга байдлын үнэлгээний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үнэлгээгээр шударга байдлын үнэлгээ 68.8 хувь гарч өнгөрсөн оны үзүүлэлтээс 1.0 пунктээр буурсан байна.

Анх судалгаа хийгдсэн 2015 оны үнэлгээтэй харьцуулахад 5.0 пунктээр бага үзүүлэлттэй гарсан байна. Үнэлгээ буурахад гол нөлөөлж буй үзүүлэлт бол гадаад шударга байдлын үнэлгээ буюу тухайн байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч иргэдийн үнэлгээ байсан. Үйлчлүүлэгч, иргэдийн үнэлгээнээс харахад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд хамгийн их анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дотоод шударга байдлын үнэлгээний хувьд үнэлгээ бага гарахад нөлөөлж байгаа гол үзүүлэлт нь авлигын эсрэг тогтолцоо болон байгууллагын удирдлагын авлигаас ангид байх хүсэл эрмэлзэл байсан. Бодлогод оролцогчийн үнэлгээнд авлигыг хянах механизм болон байгууллагын удирдлагын авлигаас ангид байх хүсэл эрмэлзэл хамгийн



их нөлөөг үзүүлж байлаа.

Үнэлгээг байгууллагаар авч үзвэл 2018 онд Соёл, урлагийн газар, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам зэрэг байгууллагууд хамгийн өндөр үнэлгээг авсан байна. Харин яамдаас Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Засгийн газрын агентлагуудаас Татварын ерөнхий газар, Биеийн тамир, спортын газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Баян-Өлгий, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрууд харьцангуй бага оноо авчээ.

Үнэлгээнд хамрагдсан 62 байгууллагын авсан үнэлгээ нь 55.3-83.6 онооны хооронд байгаа нь цаашид үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна. Үнэлгээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гэсэн байгууллагыг хамруулсан бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дундаж үнэлгээ 66.1 гарсан нь хамгийн бага дүн болж байна. Шударга байдлын үнэлгээг сайжруулах хүрээнд төрийн байгууллагуудын хувьд ил тод байдал, авлигын эсрэг тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигыг хянах механизмыг сайжруулах талаар илүү анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн байгууллагын дотоод хяналт, аудитын үйл ажиллагаанд анхаарах нь зүйтэй юм.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.9-д “Авлигатай тэмцэх газраас гаргасан шударга байдлын түвшингийн үнэлгээ нь захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.” гэж заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт нэгтгэж, үнэлгээний үзүүлэлтээр

төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг дүгнэж хэвшсэн болно.

Авлигатай тэмцэх газрын ажлын баг бүх яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид ажиллах явцад төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах талаар фокус ярилцлага хийж, холбогдох судалгааг зохион байгуулсан.

Үндэсний аудитын газар 2018 оны жилийн эцсийн байдлаар 34969 татвар төлөгчийг хамруулан үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэлээ. Татварын нэг цэг, цахим, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээнүүд түргэн шуурхай үйлчилж буй эсэхийг асуухад судалгаанд оролцогчдын 57 хувь буюу 20092 татвар төлөгч “хангалттай” гэсэн бол 38 хувь буюу 13114 нь “дунд”, 5 хувь буюу 1787 татвар төлөгч “хангалтгүй” гэсэн байна. Татварыг интернэт, мобайл банк ашиглан төлөх нь илүү тохиромжтой байдаг гэж судалгаанд оролцогчдын олонх хариулсан байна. Иймд цаашид татвар төлөгчийг цаг хугацааг хэмнэсэн, орон зайн хувьд хязгаарлагдмал бус хаанаас ч татварын үйлчилгээг авч болох чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй байна.

Сангийн яам нь мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Шилэн дансны тухай хууль болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг хянахад shilendans.gov.mn хуудсанд 2018 онд 4 газар 22 мэдээлэл байршуулжээ.

Шүүхийн ерөнхий зөвлөл 2017 онд “Шүүхийн үйлчилгээний талаарх судалгаа”-г “ЭнПиСи энд мандал” ХХК-иар, “Байгууллагын эрүүл мэндийн төлөв байдлын талаарх судалгаа”-г “Т.У.С Солюшн” ХХК-иар тус тус хийлгүүлэн, 2018 оны 10 дугаар сард Азийн сантай хамтран “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга байдлын судалгаа”-г

хийлгүүлсэн байна. (Биелэлт 60 хувь)

4.1.2.6-1. Монгол Улсын иргэн бүрт цахим гарын үсэг олгох /ХХМТГ, 2017-2022/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэний үнэмлэхэд тоон гарын үсгийг бичих ажлын хүрээнд Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт иргэний цахим үнэмлэхэд 2048 битийн тоон гарын үсгийн гэрчилгээ суулгах туршилтын ажлыг зохион байгуулж, бэлтгэл бүрэн хангагдсан бөгөөд 2018 оны 1 дүгээр улиралд багтаан иргэний үнэмлэхэд тоон гарын үсэг суулгах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Үндэсний нийтийн түлхүүрийн тоон гарын үсгийн хэрэглээг олон нийтэд хүргэх, түүний ач холбогдлыг таниулан сурталчлах зорилго бүхий видео шторкийг телевизийн сувгуудаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Тоон гарын үсгийг олгох тусгай зөвшөөрөл эзэмшигчээр “Тридум и-Секюрити” ХХК, “Нью-Компасс” ХХК, “ВиЭсЭм” ХХК шалгарч, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журмуудад заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох хувийн түлхүүрийг олгосон.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/36 дугаар тушаалаар байгуулсан “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах бодлогын чиглэл, холбогдох журмын хэрэгжилтэд санал, дүгнэлт гаргах” ажлын хэсгээс төрийн байгууллагуудад тоон гарын үсэг олгох үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэхээр дүгнэлт гаргасны дагуу төрийн байгууллагуудад Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цахим албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг ашиглахтай холбогдуулан тоон гарын үсгийн тэмдэглэгээний хэлбэржилтийг

боловсруулж, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, “Монпасс СА” ХХК, Нийслэлийн архивын газарт тус тус хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоол, Төрөөс баримтлах бодлогын чиглэлийн дагуу “Үндэсний Дата төв” ҮТҮГ-ыг төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагаар ажиллуулж, 2018 оны байдлаар 765 төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгож, нийслэлийн хэмжээнд 545 албан хаагч тоон гарын үсгийг ашиглаж, цахим хэлбэрээр албан хэрэг хөтөлж байна. Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн байгууллага бүр дээр тоон гарын үсгийн талаар ойлголт өгөх, хэрэглээг нэвтрүүлэх чиглэлээр танилцуулга сургалтыг явуулж байна. Тоон гарын үсэг ашигладаг төрийн захиргааны албан хаагчдын тоо 40 хувиар өссөн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь 40 удирдах ажилтанд тоон гарын үсгийн төхөөрөмж авч, удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулах, тайлангийн модулийг сайжруулах ажлыг хийж байна. 2018 оны 3 дугаар сард Мэргэжлийн хяналтын системийн нийт ажилтнуудад “Интерактив” ХХК-тай хамтран онлайн сургалтыг зохион байгуулж, цахим системийн хяналт шалгалтын сайжруулсан модулийг ашиглалтад оруулснаас гадна шалгалтын удирдамжийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг боллоо. (Биелэлт 40 хувь)

4.1.2.6-2. Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх /ХХМТГ, ЗГХЭГ, ХЗДХЯ, 2018 он/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас журмыг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хийж байна. (Биелэлт 0 хувь)



4.1.2.6-3. Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлэх /АТГ, ЗГХЭГ 2018 он/

Авлигатай тэмцэх газраас өргөдөл, гомдол, мэдээллийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 70112458 дугаартай факс, www.iaac.mn цахим хуудас дахь гомдол, мэдээллийн тусгай маягт бүхий гомдол илгээх холбоос, 1800-1969 тусгай дугаарын утсаар болон байгууллагын байранд биеэр ирж гомдол, мэдээлэл, тоо бүртгэлийн ажилтанд өгөх боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах утсыг сурталчилсан 3 төрлийн видео шторкийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэв. Мөн “Скайтел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран холбогдох сурталчилгааг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй хүргэх ажлыг зохион байгуулав. Авлигатай тэмцэх газар иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх зорилгоор 1800-1969 дугаарын утасны дуудлагыг хүлээн авах ажилтны тоог нэмэгдүүлж, дуудлагын бичлэгийг хадгалах, хүлээн авсан гомдол, мэдээллийг бүртгэх, шийдвэрлэлтийг хянах програм хангамжийг боловсруулж, нэвтрүүлсэн.

Гомдол мэдээлэл хүлээн авах утсыг сурталчилсан зурагт хуудас, наалт, бал, дэвтэр зэрэг сурталчилгааны материалыг шинэ загвараар боловсруулж, олон нийтэд түгээснээр 2018 онд утсаар 294, бичгээр 1141, өөрийн биеэр 462, онлайнгаар 103, факсаар 1 өргөдөл, гомдол, мэдээллийг тус тус хүлээн авч ажилласнаас гадна иргэдээс авлига, албан тушаал ашиг сонирхлын талаарх мэдээ, мэдээллийг нээлттэй ирүүлэх талаар сурталчилгаа явуулах, өргөдөл гомдол гаргагчид мессежээр

шийдвэрлэлтийн талаар хариу мэдэгдэх зэрэг гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх програмын хөгжүүлэлтийг хийж, иргэдээс мэдээлэл авах суваг, үйл ажиллагааг өргөжүүлж байна. Түүнчлэн бусад орны сайн туршлагыг судалж, авлигын талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл, зөвлөгөө, сурталчилгааг иргэдэд ойртуулах зорилгоор Иргэний хяналтын төвүүдийг нээж ажиллуулахад бэлэн болгов. (Биелэлт 40 хувь)

4.1.2.7-1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх /ЗГХЭГ, 2017-2022/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. Олон нийтийн хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, зөвлөлийн ажиллах дүрмийг төрийн албаны төв байгууллага батлахаар тусгасан болно.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6-д “Захиргааны байгууллага нь хэрэглэгчийн үнэлгээг Хэрэг эрхлэх газрын баталсан ерөнхий удирдамжийн дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ” гэж заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг баталсан.

“Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах санал асуулгын хуудасны ерөнхий загвар нь салбар чиг үүргийн үнэлгээний 63 үзүүлэлт, үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээний 19 үзүүлэлт, 16 асуудлаас бүрдсэн.

Дээрх удирдамжийн дагуу 265 сум,

дүүргийг төлөөлүүлэн 30068 насанд хүрсэн иргэнээс судалгаа авах ажлыг төрийн захиргааны холбогдох байгууллагууд хийсэн. Судалгааны дүнгээр ерөнхий сэтгэл ханамж 58.7 хувьтай, салбарын дундаж үнэлгээ 55.3 хувьтай, чанар хүртээмжийн дундаж үнэлгээ 67.8 хувьтай гарсан байна.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх чиглэлээр Батлан хамгаалах яам нь 2018 онд “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцооны хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх удирдлага, зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авна” гэсэн зорилгыг дэвшүүлэн 6 зорилтын хүрээнд 199 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “Эрдэм сургалт судалгааны хүрээлэн”-тэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тус яамны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийлгүүлсэн. Хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн тайланг 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдөр тус яамны удирдлагад танилцуулсан. Судалгааны хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны болон харьяа агентлаг, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг 1-100 баллаар үнэлэн 1-5 оноонд шилжүүлэхэд Хууль зүй, дотоод хэргийн яамны хэрэглэгчийн үнэлгээ 3.7 гэсэн дүнтэй гарсан. 2018 онд үйлчилгээ авсан иргэдээр үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлүүлэхэд 79,05 хувь буюу 3.9 оноо авч байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 11 агентлаг, байгууллагын удирдах албан тушаалтантай хийсэн ярилцлагын үеэр тус яамтай 2018 онд холбогдон ажилласан ажил үйлчилгээг 1-100 баллаар үнэлүүлэхэд 87.2 хувийн үнэлгээ буюу 4.3 оноо авсан байна. Хуульчдын зүгээс Хууль зүй, дотоод хэргийн яам болон түүний харьяа 11 агентлаг, байгууллагын үйл ажиллагааг 59.6 хувиар үнэлсэн нь 2.9 оноо авсан байна.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах дүрмийн зорилт бүхий төрийн бус байгууллагуудаас сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, сонгогчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчдод эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх, сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий “Төрийн бус байгууллагаас сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ, ажиглалт хийх, сургалт зохион байгуулах тухай журам”-ыг тус Хорооны 2016 оны 16 дугаар тогтоолоор баталсан.

Энэхүү журамд заасны дагуу сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, мониторинг хийхээр “Нээлттэй нийгэм форум”, “Глоб интернэшнл төв”, “Филантропи хөгжлийн төлөө төв”, “Мидас”, “Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд”, “Бодлогод залуусын хяналт” зэрэг 6 төрийн бус байгууллага нэгдсэн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-нд тус Хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх зөвшөөрөл олгож, хамтран ажиллав. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв”, “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний төв” төрийн бус байгууллагын Увс аймаг дахь салбар сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, мониторинг хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэхээр зөвшөөрөл олгосон байна.

Сонгуулийн тухай хуулийн 5.5-д “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад



байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, ажиглалт хийх, сонгогчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, сонгогчид эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.” гэж зааснаар Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагын мэргэжлийн төлөөлөл шууд оролцож хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.2.7-2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх /ЗГХЭГ, ХХМТГ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018-2019 он/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд төрийн албан хаагчийн хандлага, зан үйлийн үнэлгээний ажлын цаг ашиглалтын байдал, албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан идэвх чармайлт, шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг нэгжийн дарга, багаар ажиллах чадвар үйлчилгээ үзүүлэх хандлагыг албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтын онцлогоос хамааруулан тухайн албан хаагчийн харьяалах нэгжийн хамт олон дүгнэх, Албан хаагчийн үйлчилгээ үзүүлэх хандлагыг үйлчлүүлэгчээр үнэлүүлж болох ба албан хаагчийн хандлага, зан үйлийг нэгжийн хамт олноор үнэлүүлэх ажлыг байгууллагын үнэлгээний баг зохион байгуулах бөгөөд үнэлгээг албан хаагчдаас нууцаар авч, санал тоолох ажиллагааг илээр явуулахаар тусгасан бөгөөд төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. (Биелэлт 10 хувь)

4.1.2.7-3. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор төрийн байгууллага бүрт ажил дүгнэх үзүүлэлт бий болгож мөрдүүлэх /ЗГХЭГ, ТАЗ, төрийн үйлчилгээний байгууллага, 2018 он/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин /31 үзүүлэлтээр/ болон төрийн байгууллагын ажлыг үнэлэх /70 үзүүлэлтээр/ ажлыг улсын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 5-ны өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд явуулсан. Энэ үнэлгээний хүрээнд төрийн албан хаагчийн сүүлийн 2 жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдалтай газар дээр танилцаж, албан хаагчдаас ярилцлага авах ажлыг зохион байгуулсан.

Мөн “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд 2019 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Сангийн яам төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох зорилгоор яамны цахим хяналт-шинжилгээ үнэлгээний “Лидер мониторинг” (LM) програмыг ашиглалтад оруулсан. Цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний “Лидер мониторинг” програм нь

- Бодлогын баримт бичгүүдэд туссан Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ
- Дээд байгууллагын тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар
- Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж
- Сангийн яамны дотоод аудитын

хорооноос өгсөн зөвлөмж гэх мэт байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнах шаардлагатай баримт бичиг, заавар, зөвлөмжийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэснээр ажилтнууд холбогдох мэдээллийг цаг алдалгүй тайлагнах, нэг ажлыг олон дахин тайлагнаж тэр бүрт газар хэлтсүүд хоорондоо бичиг бичих зэрэг ажлын давхардлыг арилган үйл ажиллагааг хөнгөвчилж байна.

Мөн яамны дотоод бүтцийн нэгжүүдийн долоо хоног, сар, жилийн төлөвлөгөө, тайланг тус програмаар нэгтгэн, ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг оруулж өгснөөр “Үр дүнгийн гэрээ”-г энэхүү програмыг ашиглан боловсруулж, дүгнүүлдэг болсноор илүү шударга, үнэн зөв дүгнэгдэх, нөгөө талаас гэрээ байгуулах, дүгнэх ажлыг хөнгөвчлөн цаг хугацаа хэмнэсэн, ажлын давхардал зохих хэмжээнд арилсан болно.

Энэхүү програм нь хүний нөөцийн, бичиг хэргийн, ажлын цаг ашиглалтын зэрэг програм болон яамны цахим хуудастай холбогдсоноор яамны ажилтан, албан хаагч нэг бүр өөрийн ажил үүрэгтэй холбоотой бүхий л мэдээллийг нэг дороос авах боломж бүрдэж, ажлын ачааллыг 70 орчим хувиар хөнгөлж байгаа юм. (Биелэлт 100 хувь)

Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дахь зорилтын хүрээнд нийт 10 үйл ажиллагаа, 35 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2017 онд 22 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн ба 2018 онд нийт 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон

танилцуулбал:

4.1.3.1-1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгох /СЯ, 2017-2022/

Сангийн яамнаас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын үр өгөөж, хөрөнгийн бүртгэл болон тухайн төсөл хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд иргэд, олон нийтийн сэтгэл ханамжтай байдал, мэдээллийн ил тод байдалд судалгаа хийх аргачлалыг боловсруулж, нийт 6 бүлэг /олон нийтийн оролцоо, сумын төсвийн төлөвлөлт, сумын төсвийн ил тод байдал, сумын төсвийн гүйцэтгэл, сумын хяналт, шинжилгээ үнэлгээ, сумын өмчийн удирдлага/-т хамаарах 33 асуулт бүхий шалгуур үзүүлэлтийн дагуу 330 сумыг үнэлэх ажлыг хийж байна. 21 аймаг, 9 дүүргийн, 330 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан 2019 төсвийн тогтоолыг цахим хэлбэрээр хүлээн авч аймаг, нийслэл, сум дүүргийн нэгдсэн төсвийг гаргав. Ингэснээрээ орон нутгийн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах төсвийн эмх замбараагүй байдлыг арилгах ач холбогдолтой.

Засгийн газраас 2016 онд баталсан Төрөөс төвлөрлийг сааруулах талаар баримтлах бодлогын гол суурь болох чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг батлуулж, гарын авлагыг боловсруулах талаар Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран ажиллав. Тодорхой чиг үүргийг орон нутагт шилжүүлэх, салбар хоорондын чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэсэн энэхүү аргачлалыг Сангийн яаманд хэрэгжүүлж байна. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөвт орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төсвийн төвлөрлийг сааруулах, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Зарлагын чиглэлээр:

- Сумын санхүүгийн албаны бүтэц, зохион



байгуулалтыг шинэчлэн баталсан;

- Дотоод албан томилолтын зардлыг шинэчлэн батлуулсан;
- Засаг даргын нөөц сангийн зарцуулалтын журмыг шинэчлэн батлуулсан;
- Эмнэлгийн бие даасан байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар хоёр дахь болон гурав дахь шатлалын 10 эмнэлгийг хамруулсан;
- Анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна;
- Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутагт хариуцуулсан;
- Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлж байна.

Орлогын чиглэлээр:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөр улсын төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд;
- Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30 хувийг тухайн орон нутгийн төсөвт;
- Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн төсөвт тус тус нэмж хуваарилж байна. (Биелэлт 60 хувь)

4.1.3.1-2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх /ТӨБЗГ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит 923 хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2016 оны биелэлтийг 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэж, илэрсэн зөрчлийг

арилгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 687 дугаар тогтоол гаргаж, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны биелэлтийн дүн, зөвлөмж, чиглэлийг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад хүргүүлсэн. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2016 оны биелэлтийг дүгнүүлээгүй 52 хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид албан шаардлага хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслүүлж, төрийн өмчийн түрээсийн нийт орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт төрийн өмчит 67 хуулийн этгээдийн 402 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, тухайн онд түрээсийн орлогоос улсын төсөвт нийт 2090.0 сая төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 1545,2 сая төгрөгөөр буюу 3.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тус газрын 2017 оны 276 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Сангийн яамнаас 2017 онд “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2015, 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалттай холбоотой 23,918.0 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн ба зөрчлийг арилгуулах тухай санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, улсын ахлах байцаагчийн төлбөрийн актаар 335.4 сая төгрөгийг холбогдох буруутай этгээдээр төлүүлж, төсвийн орлогод

оруулахаар шийдвэрлэсэн.

Өөрийн эзэмшлийн байргүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 16 хуулийн этгээд жилд 2,2 тэрбум гаруй төгрөгийг түрээсийн төлбөрт зарцуулсан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд хувийн компаниудаас үл хөдлөх хөрөнгө (байр, талбай)-ийг түрээслэхэд жил бүр олон тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулж байгааг зохистой байдлаар шийдвэрлэх, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай, зарцуулах арга хэмжээг авах шаардлагатай.

Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”, “Барилга байгууламжийн үнэлгээг нутаг дэвсгэрийн бүсчлэлээр тооцох итгэлцүүр”, “Инженерийн байгууламжийн нэгж хүчин чадлыг үнэлгээ”, “Нийтийн эзэмшлийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”, “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”, “Барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа”, “Гадаад улс орон дахь дипломат төлөөлөгчийн газруудын 1 ам метр газрын нэгжийн жишиг үнэ”, “Дахин үнэлгээний хураангуй тайлан”, “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан”-г батлан мөрдүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслүүлж, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулахад анхааран дараахь эрх зүйн актад нэмэлт оруулав. Үүнд:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын “1/6.14 дэх заалт: 6.14. Түрээслэгч нь барьцаа хөрөнгө байршуулсныг нь гэрчлэх үнэт цаасыг арилжааны банкнаас

авч түрээсийн гэрээний хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хадгалуулна, 1/3.3 дахь заалт: 3.3. Иргэн, хуулийн этгээд нь түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа, болгож 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (.....) төгрөгийн барьцаа болгон арилжааны банкинд энэхүү гэрээний хугацаанд байршуулна” гэсэн үүргийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 293 дугаар тогтоолоор,

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай” тогтоолын “1/2.8 дахь заалт: 2.8.Төрийн тусгай болон дотоодын цэргийн хамгаалалтад байдаг төрийн өмчийн хуулийн этгээдийн цайны газрын үйлчилгээний хэсгийн 1 ам.кв талбайн үнийг 60 хувиар хөнгөлж, талбайн хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар хянуулж байх, 2/7 дахь заалт: 7.Технологийн болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж, түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлж байна. 3/8 дахь заалт: 8.Дараах хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг зориулалтаас нь хамаарч эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдлын шимтгэл, ашиглалтын нөхцөл, зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч тогтоож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулна: 8.1.Төрийн өөрийн өмчийн хөдлөх эд хөрөнгө, 8.2.Бэлэн мөнгөний автомат машин, ундааны машин, антен, тоног төхөөрөмж, кабель, 8.3.Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууц” гэсэн заалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 59 дүгээр тогтоолоор нэмж батлан зохицуулалтыг тодорхой болгох арга хэмжээ авав.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар



тогтоолоор “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баталж, Төрийн өмчийн хорооны 2009 оны “Үлгэрчилсэн журам батлах тухай” 232 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.

“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүнгээр нийт 5 багц шалгуур үзүүлэлтийг хангасан байдлын улсын дундаж дүн “сайн” буюу 90.8 хувьтай байна. Төрийн өмчит 96 хуулийн этгээдийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал илүү хариуцлагатай, үлгэр жишээч байна. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын тогтоол шийдвэр, журам, түүний хэрэгжилтийн байдал “хангалтгүй” байгаа нь гэрээний биелэлтээс дүгнэгдэж байна. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2017 оны биелэлтийн дүнг нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргав (Биелэлт 50 хувь)

4.1.3.1-3. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх /СЯ, ХХМТГ, 2017-2020/

Сангийн яамнаас “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд шинжилгээ хийх ажлыг 2018 онд хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн болно.

Тус яам 2017 онд “Шилэн дансны систем”-ийн үйл ажиллагааны талаар 7100-1111 дуудлагын нэгдсэн систем, шилэн дансны нэгдсэн системийн захиа, support@shilendans.gov.mn цахим хаягуудаар 1850 дуудлага хүлээн авч шийдвэрлэсэн байна. Цаашид холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, ялангуяа иргэд,

байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үр дүнгийн талаар тодорхой мэдээллийг тайланд тусгах шаардлагатай.

“Шилэн дансны систем”-ийн үйл ажиллагааны талаар 7100-1111 дуудлагын нэгдсэн систем, шилэн дансны нэгдсэн системийн захиа, support@shilendans.gov.mn цахим хаягуудаар 1850 дуудлага хүлээн авч шийдвэрлэсэн байна. Цаашид холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, ялангуяа иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үр дүнгийн талаар тодорхой мэдээллийг тайланд тусгах шаардлагатай байна. Энэ ажлын хүрээнд улсын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2018 оны тайланг нэгтгэх ажил хийгдэж байна. 2019 оны 4 дүгээр сард тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор эрх зүйн орчны дүн шинжилгээг яамны холбогдох газар, хэлтсийн хүрээнд хийсэн. Журамд заасан шилэн дансны зарим мэдээллийн төрөл, мэдээлэл байршуулах ажилтнуудад ойлгомжгүй, давхардсан, ач холбогдол багатай, иргэн олон нийт ойлгоход хүндрэлтэй байгаа тул шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна гэж дүгнэсэн. Энэ хүрээнд Шилэн дансны тухай хуулийг шинэчлэн бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, нэгдсэн цахим хуудсыг хөгжүүлэх санал боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/210 дугаар тушаалаар байгуулсан. Хууль, журамд өөрчлөлт оруулах ажлын хэсгээс эхний байдлаар хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулагдсан. Мөн журмын төсөл, цахим хуудасны мэдээллийн төрлийн талаар судалгааны ажил хийгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны сайтад мэдээлэл байршуулсан байдалд дотоод аудит хийхэд Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь заалтын хүрээнд нийт 4840 мэдээллийг байршуулахаас 99,7 хувьтай мэдээлсэн байна. Тус яамны

аппарат, Төсвийн ерөнхийлөн захирагчийн багц болон харьяа байгууллагуудад Үндэсний аудитын газраас 2018 оны 10 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд явцын аудит хийсэн бөгөөд 2019 онд нэгдсэн аудит хийгдэхээр төлөвлөсөн. Төрийн аудитын байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр нийцлийн аудитыг гүйцэтгэж ажилладаг. 2018 онд тус аудитыг гүйцэтгэхээр төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан аудитыг хийсэн. Аудитаар тус журам, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдаж байгаа мэдээлэл, агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхийг судалж дүн шинжилгээг хийж байгаа. 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр тайланг УИХ болон холбогдох газруудад хүргэхээр гүйцэтгэлийг хийж байна. Тус аудитын тайлан баталгаажиг гарсан үед сайтад ил тод байршуулах болно. (Биелэлт 90 хувь)

4.1.3.1-4. Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах /СЯ, 2017-2022/

Сангийн яам Монгол Улсын төсөвтэй холбогдолтой цаг үеийн мэдээ, хууль эрх зүйн актууд, төсвийн төсөл, батлагдсан төсвүүд, төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, бусад холбогдох мэдээллийг www.iltod.mn, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг www.tusuv-oronnutag.mn цахим хуудсаар тус тус олон нийтэд мэдээлж байна. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктэй хамтран “Хөгжлийн албан ёсны тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх системийг нэвтрүүлэх техник туслалцааны төсөл”-ийг хэрэгжүүлж, www.odamis.mof.gov.mn цахим хуудсыг ажиллуулж байна. Хөгжлийн банкнаас төслийн санхүүжилт, зээлийн хүсэлтийг

хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулж, Зээл санхүүжилтийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх цахим систем (LOS system)-ийг ашиглалтад оруулав.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас mcsd.mn цахим хаягаар хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг авах, мөн Монгол Улсын иргэд өөрсдийн регистрийн дугаараар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг шалгах боломжийг нэвтрүүлэн ажилласан. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь <http://agreinsurance.mn> цахим хаягаар малын индексжүүлсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Мөн уг цахим хуудсанд холбогдох бусад төрийн байгууллагын цахим хуудас руу нэвтрэх шууд холбоосыг байршуулсан бөгөөд Олон улсын давхар даатгалын компанийн мэдээллийг байршуулсан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр www.iltod.mn цахим хуудсанд сар бүр байршуулж олон нийтэд мэдээлж байна. Олон улсын төсвийн түншлэлээс хийгддэг “Нээлттэй төсвийн индекс”-ийн 2017 оны тайлангаар Монгол Улс 46 оноо авсан нь 2015 онтой харьцуулахад 5 оноогоор ахисан үзүүлэлттэй байна. Зөвлөмжийн нэг хэсэг болох бие даасан төсвийн институци байгуулах асуудлыг Улсын Их Хурлын 2017 оны 69 дүгээр тогтоолоор шийдвэрлэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулсан.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны 10-12 дугаар сарыг дуустал хугацаанд аудит хийж, 35 төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа 4290 байгууллагыг түүвэрлэн хамруулж, 2016 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацааны хуулийн хэрэгжилтийг шалгахад тухайн жилийн төсвийг 515 байгууллага буюу 10.6 хувь нь мэдээлээгүй; төсвийн гүйцэтгэлийг 12



сарын дунджаар 212 байгууллага буюу 4.4 хувь нь мэдээлээгүй; дараа жилийн төсвийн төслийг 1058 байгууллага буюу 22.1 хувь нь мэдээлээгүй; хагас жилийн санхүүгийн тайланг 612 байгууллага буюу 13.8 хувь, бүтэн жилийн санхүүгийн тайланг 897 байгууллага буюу 20.8 хувь нь мэдээлээгүй; төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 726 байгууллага буюу 21.9 хувь, аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 943 байгууллага буюу 28.8 хувь нь мэдээлээгүй; төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг 928 байгууллага буюу 20.4 хувь нь тус тус мэдээлээгүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн ИТХ-аас тавьсан хөндлөнгийн хяналт 36.4 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг 90.9 хувьтай байсан бол Иргэдийн нийтийн хурлаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг бий болгож, нээлттэй, ил тод болгох орчинг бүрдүүлсэн байна. Дээрх цахим хуудсанд иргэд, олон нийтээс хандсан хандалт, ашиглалтын талаар мэдээлэл, судалгаа, дүгнэлт хийх шаардлагатай.

Түүнчлэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.10/Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 1-ний дотор хүргүүлнэ. Уг үнэлгээ нь захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэг үзүүлэлт болно./-т заасны дагуу Сангийн яам Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, үр дүнгийн талаарх мэдээллийг тайланд тусгаж байх

шаардлагатай.

Сангийн яам Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргаж 2018 онд сар болгон www.iltod.mn цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан. Яамны мэргэжилтнүүд Сангийн сайдын 2018 оны 01 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, 2019 оны төсвийн төслийн төлөвлөлт, тайлагналтыг ил тод, тэгш шударга, үр ашигтай, үр дүнд чиглэсэн байх зарчимд нийцүүлэн боловсронгуй болгож, сайжруулахтай холбоотой санал боловсруулж ажлын хэсгийн хүрээнд нэгтгэн Сангийн сайд болон яамны удирдлагад танилцуулж, чиглэл авч төсвийн төсөл боловсруулахад баримталсан. “Иргэдийн төсөв 2019” номыг бэлтгэхэд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймаг, салбар болгоноор нэгтгэн танилцуулга боловсруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2017 онд ашиглалтад оруулсан барилга байгууламжийн талаар Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтад заасан маягтын дагуу мэдээлэл авч нэгтгэн ил тод цахим хуудсанд байршуулсан. Яамны цахим хуудасны шинэчлэлтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалт, концессийн төсөлтэй холбоотой мэдээллийг шинэчилсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/26 тоот тушаалаар яамны цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулах, байршуулах хуваарь баталсны дагуу холбогдох мэргэжилтнийг томилж хөрөнгө оруулалтын чиглэлээр оруулах мэдээллийг тогтмолжуулсан. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, Засгийн газрын чадавхийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран “Хөгжлийн албан ёсны тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх системийг нэвтрүүлэх техник туслалцааны төсөл”-ийг хэрэгжүүлж www.odamis.mof.gov.mn цахим хуудсыг ажиллуулж байна. Энэхүү цахим хуудас нь

Засгийн газрын шугамаар түншлэгч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний систем нь төсөл, хөтөлбөрийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, ил тод, нээлттэй үйл ажиллагаа, олон нийтийн хяналтыг бий болгох боломжоор хангаж байна. Шилэн дансны тухай хуулиар гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн явц, түүнд шалгарсан аж ахуйн нэгж, хувь хүнтэй байгуулсан гэрээ, төлбөр тооцооны мэдээллийг бүрэн байршуулж байна. Засгийн газрын өрийн мэдээллийг шилэн дансны <https://shilndans.gov.mn/> цахим хуудас болон Монгол банкны <https://www.mongolbank.mn/>, Сангийн яамны <https://mof.gov.mn/> цахим хуудсанд тус тус байршуулан олон нийтэд тухай бүр мэдээлж байна.

Татварын ерөнхий газрын хэмжээнд 2018 онд Япон улсын Жайка олон улсын байгууллага, ОУВС, Азийн хөгжлийн банкны дараах 3 төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Нэг. Татварын албанд Япон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын Татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төслийн 2 дугаар шатны хэрэгжилт хийгдэж байна. 2018 онд төслийн 3 үндсэн зорилтын 31 ажлыг хийхээр төлөвлөгөөнд тусгаснаас 11 ажил хийгдэж дууссан, 14 ажил хэрэгжиж байгаа, 5 ажил нь Татварын ерөнхий хууль батлагдсаны дараа, 1 ажил нь холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсны дараа хэрэгжихээр төлөвлөгдсөн. Хойшлогдсон ажил байхгүй.

Хоёр. ОУВС, АНУ-ын Төрийн сан (Техникийн туслалцааны газрын орлогын бодлого, удирдлагын газар)-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Татвар төлөгчдийн хууль тогтоомж мөрдөлтийг

сайжруулах нь” техник туслалцааны төсөл, ОУВС, АНУ-ын Төрийн сангийн шугамаар хэрэгжиж буй “Татварын удирдлагын шинэчлэлт” төсөл, уг төслийн дэд хэсэг “Татвар төлөгчдийн хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах нь” төсөл үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 4 үндсэн модулийн хүрээнд хэрэгжүүлсэн.

Гурав. Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх нь” төсөл. Азийн хөгжлийн банкны төслийн цаашдын хамтын ажиллагааны хүрээг тогтоож, санамж бичиг байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангаж, Сангийн яам, Азийн хөгжлийн банк, Татварын ерөнхий газрын удирдлагууд 3 талт хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан байх төлөвлөгөөтэй ажилласан байна.

Энэ зорилтын хүрээнд Төрийн аудитын байгууллага нь нийцлийн болон санхүүгийн аудитыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байгаа болно. Нийцлийн аудитын газар нь холбогдох яаманд албан бичиг хүргүүлж хөтөлбөр арга хэмжээний талаар судалгааны ажил хийгдэж байна. Санхүүгийн аудитын газар нь Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг Сангийн сайдын баталсан журмын дагуу Санхүүгийн тайлан гаргадаг болгох, тайланг аудитад бүрэн хамруулж байх саналыг 2017 оны Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд Сангийн сайдад зөвлөмж өгч, хэрэгжилтийн биелэлтийг хянан ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд 2018 онд төлөвлөснөөр нийцлийн аудит хийгдэж байгаа бөгөөд тайланг нэгтгэн 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор УИХ болон олон нийтэд мэдээлэхээр гүйцэтгэж байна. Аудитын хүрээнд энэ зорилт тусгагдсан байгаа бөгөөд дүн шинжилгээ хийж тайланд тусган мэдээллийг тайлан батлагдсаны дараа байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах болно. (Биелэлт 50 хувь)



4.1.3.1-5. Олон улсын төсвийн түншлэлээс хийгддэг “Нээлттэй төсвийн индекс”-ийн үнэлгээг ахиулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2018-2022/

Нээлттэй төсвийн индексийн 2015 оны тайлангаар Монгол Улс 51 оноо авч байсан бол 2017 оны тайлангаар 46 оноо авч үзүүлэлт нь сайжирсан байна. Зөвлөмжид дурдсан бие даасан төсвийн институт байгуулах асуудлыг УИХ-ын 2017 оны 69 дүгээр тогтоолоор шийдвэрлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулсан. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Үндэсний аудитын газар жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг УИХ-д жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлдэг нь зөвлөмжид заасан арга хэмжээ юм. (Биелэлт 50 хувь)

4.1.3.1-6. Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ 2018-2022/

Хувь хүн, хуулийн этгээдээс улсын төсөвт 2017 онд 153,0 сая төгрөгийн мөнгөн хандив Төрийн сангийн дансанд төвлөрсөн ба 2018 онд зарцуулалт хийгдээгүй тул 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 153,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Харин урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн байгууллагууд 2018 онд олон улсын болон дотоодын байгууллага, хувь хүнээс авсан хандив тусламжийн санхүүжилтээс 21,201,3 сая төгрөг, Онцгой байдлын ерөнхий газар 726,4 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлт ирүүлсний дагуу эрхийг нээж, төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн байгууллагууд хандив, тусламжийн санхүүжилтийн зарцуулалтын мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад байршуулж ажиллах үүрэгтэй. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйл буюу “Нэмэлт төсөв” зүйлийн 47.1.1-т “Төсвийн захирагч нь төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан

хандив, тусламжийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болох”-оор заасан бөгөөд Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, журам”-аар хандив, тусламжийн орлогыг бүртгэх асуудлыг зохицуулсан. Шилэн дансны системд хандив тусламжийн мэдээллийг байршуулсан тухай тайлан нэгтгэл 2019 оны 4 дүгээр сарын нэгдсэн тайлангаар гарч нийтлэгдэнэ. (Биелэлт 50 хувь)

4.1.3.2-1. Улсын болон орон нутгийн төсөвт хөндлөнгийн байгууллага, эрдэмтэн, судлаачаар санхүүгийн шинжилгээ хийлгэх боломжийг судлах, холбогдох арга хэмжээг авах/СЯ, 2017-2019/

Сангийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн хүрээнд байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төсөвт шинжилгээ хийлгэн, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газраас 2016 онд баталсан Төрөөс төвлөрлийг сааруулах талаар баримтлах бодлогын гол суурь болох чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг батлуулж гарын авлагыг боловсруулах талаар Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран ажиллав.

Тодорхой чиг үүргийг орон нутагт шилжүүлэх, салбар хоорондын чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэсэн энэхүү аргачлалыг Сангийн яаманд хэрэгжүүлж байна. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөвт орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төсвийн төвлөрлийг сааруулах, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Зарлагын чиглэлээр:

- Сумын санхүүгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан;
- Дотоод албан томилолтын зардлыг шинэчлэн батлуулсан;

- Засаг даргын нөөц сангийн зарцуулалтын журмыг шинэчлэн батлуулсан;
- Эмнэлгийн бие даасан байдлыг хангаж тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар хоёр дахь болон гурав дахь шатлалын 10 эмнэлгийг хамруулсан;
- Анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна;
- Өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутагт хариуцуулсан;
- Орон нутаг дахь соёл, урлаг, спортын чиг үүргийг тухайн орон нутаг бие даан хэрэгжүүлж байна.

Орлогын чиглэлээр:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөр улсын төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд;
- Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30 хувийг тухайн орон нутгийн төсөвт;
- Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн төсөвт тус тус нэмж хуваарилж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.3.2-2. Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх /СЯ, 2017-2022/

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм” -ийн 2.1-д заасны дагуу Сангийн яам хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах,

эрсдэлийн удирдлагаар ханган ажиллаж байна. Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагыг сонгохдоо хяналт шалгалтад хамрагдсан хугацаа, өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн хэмжээ, түүнийг барагдуулах талаар зохиосон ажил зэргийг харгалзан хяналт шалгалт хийж байна. 2017 онд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас 14 байгууллагад хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр нийт 66.4 тэрбум төгрөгийн 44 хугацаатай албан шаардлагыг улсын байцаагч хүргүүлсэн байна. Шалгалтаар нийт 1.6 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 2017 оны жилийн эцсийн байдлаар 847.3 сая төгрөгийг барагдуулж, 784,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангийн яам санхүүгийн хяналт шалгалтын үр дүнд төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийн үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулж дүн шинжилгээ хийгээгүй байна.

2018 онд Сангийн яамны Дотоод аудитын хорооны хурлаар 10 байгууллагын шалгалтын материал, танилцуулгыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 102 зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Тухайлбал,

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2012-2016 он, 2017 оны эхний 9 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд,
2. Хадгаламжийн даатгалын корпорацийн 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд,
3. “Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар” ТӨҮГ-ын 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд,
4. “Зээлийн батлан даалтын сан”-гийн үйл ажиллагаанд,
5. Гадаад харилцааны яамны 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд,
6. Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан зэрэг болно.

Шалгалтын дүнгээр нийт 577.9 сая



төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд улсын байцаагчийн 10 акт тогтоож, үүнээс ашиглаж дутагдуулсан хөрөнгө 561.0 сая төгрөг байна.

Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдах байгууллагыг сонгохдоо тухайн байгууллагын хяналт шалгалтад хамрагдсан хугацааны алслалт болон өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн хэмжээ, түүний барагдуулалтын байдалд үндэслэж байна. Эрсдэлтэй гэдэгт санхүүгийн хяналт шалгалтад хамрагдаад зөрчилтэй байсан байгууллага зөрчлөө шийдвэрлэлгүй удаашрах, хяналт шалгалтад хамрагдсан хугацааны алслалт зэргийг харгалзан үзэж байгаа. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/65 тоот тушаалаар Сангийн яамны дотоод болон Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах замаар үүсч болзошгүй алдагдлыг бууруулах, удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

2018 онд 17 төсөвт болон төрийн өмчийн өмчийн оролцоотой байгууллагад Санхүүгийн хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс төлөвлөгөөт 16, төлөвлөгөөт бус 10, нийт 26 байгууллагад хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын шалгалтын дүнг Сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 3 удаагийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, тухайн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Шалгалтын дүнгээр нийт 577.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 10 улсын байцаагчийн акт тогтоосноос ашиглаж дутагдуулсан хөрөнгө 561.0 сая төгрөгийн зөрчилд тогтоосон байна. Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн шалгалтын материалыг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд хүргэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын шилэн дансны 2018 оны 3 дугаар улирлын үйл ажиллагаанд дотоод аудит

хийж, Үндэсний аудитын газарт хүргүүлсэн

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/155 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт санхүүгийн шалгалт хийж, дүнг удирдлагад танилцуулсан.

Мөн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хэнтий аймаг дахь нэгжүүдийн үйл ажиллагаа, Дорноговь аймаг дахь нэгжүүдийн үйл ажиллагаа, Өмнөговь аймаг дахь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илтгэх хуудсаар тайланг танилцуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 421 дүгээр ангийн 2014-2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж, нягтлан бодогчоор ажиллаж байсан иргэн Б.Нарангэрэлд улсын байцаагчийн 2 актаар 5100,0 мянган төгрөгийн актыг тавьж, дүнг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлсэн. (Биелэлт 50 хувь)

4.1.3.2-3. Дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох, давхардлыг арилгах /СЯ, 2017-2019/

Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалуудаар ажлын хэсгийг байгуулан, Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төсөл, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах, УИХ, Засгийн газарт өргөн барих бэлтгэл ажлыг хангасан. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хяналт шалгалтын чиг үүргийн давхардлыг арилгах үүднээс яам, нийслэл, дүүрэг, аймгуудын жилийн төлөвлөгөөг нэгтгэн бодлого, удирдамжаар ханган хяналт шалгалтыг системийн хэмжээнд хийж ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Засгийн газрын 2015 оны 483 тогтоолоор батлагдсан Дотоод аудитын

дүрмийн 4.12. дэх заалтын хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх “Дотоод аудитын хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, дотоод аудит, хяналт шалгалтын ажлын дүнг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлж, тогтоол гарган, биелэлтэд хяналт тавьж байна. Тайлант хугацаанд дотоод аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагын биелэлт, дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган хяналтад аван ажиллаж байна. Аудитын тайлан дүгнэлтийг Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газар зэрэг холбогдох байгууллагуудад тухай бүрт хүргүүлж ажилласан. Аудитын акт, дүгнэлтийг яамны цахим www.mofa.gov.mn хуудсанд хуулийн хугацаанд нь байршуулж ил тод мэдээлж байна

Хууль зүй, дотоод хэргийн яам шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Засгийн газрын тусгай сан цэсний 3 дугаарт Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан нэртэй “Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл” гэсэн ангиллаар сар бүр санхүүжилт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлж байна. www.shilendans.gov.mn цахим хуудсанд 2018 онд 16 удаагийн мэдээлэл оруулсан бөгөөд бүтэн жилээр 3, хагас жилээр 1, сар бүр 12 мэдээллийг байршуулсан.

Үндэсний аудитын газар энэ зорилтын хүрээнд нийцлийн болон санхүүгийн аудитыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байгаа болно. Нийцлийн аудитын газар нь холбогдох яаманд албан бичиг хүргүүлж хөтөлбөр арга хэмжээний талаар судалгааны ажил хийгдэж байна.

Санхүүгийн аудитын газар нь гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг Сангийн сайдын баталсан журмын дагуу санхүүгийн тайлан гаргадаг болгох ба тус тайланг аудитад бүрэн хамруулж байх саналыг 2017 оны Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд Сангийн сайдад зөвлөмж өгч, хэрэгжилтийн

биелэлтийг хянан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд 2018 онд төлөвлөснөөр нийцлийн аудит хийгдэж байгаа бөгөөд тайланг нэгтгэн 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор УИХ болон олон нийтэд мэдээлэхээр гүйцэтгэж байна.

Аудитын хүрээнд энэ зорилт тусгагдсан байгаа бөгөөд дүн шинжилгээ хийж тайланд тусган мэдээллийг тайлан батлагдсаны дараа байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах болно.

Сангийн яам Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хяналт шалгалтын чиг үүргийн давхардлыг арилгах үүднээс яамд, нийслэл, дүүрэг, аймгуудын жилийн төлөвлөгөөг нэгтгэн бодлого, удирдамжаар ханган системийн хэмжээнд хяналт шалгалт хийж ажилласан. (Биелэлт 30 хувь)

4.1.3.2-5. Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох /СЯ, УАГ 2018-2019/

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 28.1.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй буюу ашиглан болон залилангийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан албан тушаалтныг Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт гарган өгч холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.

Сангийн яамнаас санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн этгээд, аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтийг үнэн зөв гаргаагүй



албан тушаалтанд Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7.3-т “санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон” гэж заасны дагуу санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, Зөрчлийн тухай хуулийн 11.1-д заасан хариуцлага ногдуулах арга хэмжээг авч байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Аудитын тухай хуульд заасан “аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхлэх болон бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажиллахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж үндсэн орон тоонд ажиллахын хажуугаар өөр хуулийн этгээдэд давхар ажил эрхэлсэн “Улиастайван Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Б.Нарантуяа, “Гүнгийн шивэрт Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Ө.Бурмаа, “Атланта баланс Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Б.Баярмаа, “Цэгц төв богд Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Д.Өлзий-Орших, “Хүлэгт хүннү Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Ц.Магнайсүрэн, “ЗЦН Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Ч.Поотой, М.Цацрал, Д.Саранчимэг, “Латана Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Д.Амарзаяа, “Сэрэлт-дөл Аудит” ХХК-ийн мэргэшсэн нягтлан бодогч Н.Нямдулам нарт шийтгэл оногдуулж улсын төсөвт нийт 10,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн Иргэний нисэхийн газрын мэргэжилтэн Намбатаас ирүүлсэн гомдлын дагуу 1801000008 хавтаст хэрэг нээж ИНЕГ-ын ерөнхий нягтлан бодогч Наранцэцэгт зөрчил оногдуулж 400,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. (Биелэлт 40 хувь)

4.1.3.3-1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах /СЯ, 2017-2019/

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагч тус бүр дээр “Засгийн газрын тусгай сан” цэсээр тусгай сангуудын зарцуулалтын мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр гаргаж, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулж иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломж бүрдсэн. Тус яамнаас Сангийн сайдын төсвийн багцад хамаарах доорх сангуудын мэдээллийг олон нийтэд мэдээлж байна:

- Засгийн газрын нөөц сан,
- Засгийн газрын өрийн баталгааны сан,
- Тогтворжуулалтын сан,
- Ирээдүйн өв сан.

Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод байдлыг хангах чиглэлээр яамны цахим хуудсанд шилэн данс гэсэн дэд цэсийг нээж уг цэсийг шилэн дансны цахим хуудастай холбосон ба зэвсэгт хүчний хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цогц байдлаар авах боломжийг бүрдүүлсэн болно.

Зэвсэгт хүчний тусгай сангийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүн мэдээг шилэн дансны цахим хуудсанд иргэд, олон нийтэд нээлттэй танилцах боломжтойгоор байршуулсан. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого, зарлагын төлөвлөлт батлах тухай Батлан хамгаалахын сайдын 2017 онд А/40, 2018

онд А/12 тушаалаар орлогын эх үүсвэрийг баталж, сангийн гүйцэтгэлийн тайлан, гүйлгээ, аудитын дүгнэлтийг ил тод болгож шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд Үндэсний аудитын газраас Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, тус газрын 2018 оны 06/823 тоот албан бичгээр аудит хийсэн гэрчилгээг ирүүлсэн ба “зөрчилгүй” гэсэн дүгнэлтийг ирүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо шилэн дансанд 2018 оны эхний 9 сарын 9 удаагийн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл тайлбарын талаарх мэдээлэл болон “Хууль тогтоомжийн дагуу санхүүгийн зохицуулах хорооны төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаарх мэдээлэл”, мөн санхүүгийн ил тод байдлын мэдээллийг www.shilendans.gov.mn хаягийн мэдээллийн хэсэгт хуулийн хугацаанд нь оруулсан болно.

Хууль зүй, дотоод хэргийн яам Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Засгийн газрын тусгай сан цэсний 3 дугаарт Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан нэртэй “Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл” гэсэн ангиллаар сар бүр санхүүжилт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлж байна. www.Shilendans.gov.mn цахим хуудсанд 2018 онд 16 удаагийн мэдээлэл оруулсан бөгөөд бүтэн жилээр 3, хагас жилээр 1, сар бүр 12 мэдээллийг байршуулсан. (Биелэлт 50 хувь)

4.1.3.3-2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх /СЯ, тусгай санг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан, 2017-2020 он/

Сангийн яам энэ арга хэмжээг хэрэгжүүлэх талаар одоогоор тодорхой ажил хийгээгүй. Сангийн яамнаас Засгийн газрын харьяа сангуудад хийсэн шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болгов. Тусгай сангуудад хийсэн шалгалтын дүнд үндэслэн Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, зарцуулалтыг оновчтой, үр ашигтай, ил тод болгох, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилготой Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тогтоолын төсөл боловсруулав. 2018 онд Сангийн яамнаас Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангуудад шалгалт хийж Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн дүнг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд мэдээлсэн. (Биелэлт 10 хувь)

4.1.3.3-3. Тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, дүнг олон нийтэд ил тод мэдээлэх /СЯ, 2017-2022/

Сангийн яамнаас 2017 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 2018 онд Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Зарим төрлийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн санд шалгалт хийж Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн дүнг Сангийн яамны цахим хуудсанд тавьж олон нийтэд мэдээлсэн. Засгийн газрын зарим тусгай санд шалгалтын ажлыг явуулж, шалгалтын дүнг Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Шалгалтын ажлыг үргэлжлүүлэн Засгийн газрын тусгай сангуудын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол гаргахаар ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Засгийн газрын тусгай сан цэсний 3 дугаарт Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох сан нэртэй “Засгийн газрын болон орон



нутгийн тусгай сангийн орлого, зарлага Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл” гэсэн ангиллаар сар бүр санхүүжилт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.3.4-1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах /СЯ, 2017-2022/

Сангийн яам, Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд “Орон нутгийн төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх” сэдэвт бүсчилсэн сургалт-семинарыг 2 удаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/187 тоот тушаалын дагуу 21 аймаг, нийслэл, 6 дүүрэгт орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулсан. 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд нэгдсэн санхүүжилтийн эрхийн талаарх мэдээллийг Сангийн яамны нэгдүгээр давхарт байрлах дэлгэцэн дээр өдөр тутам гаргаж, олон нийтэд мэдээлсэн. Сангийн яамны нээлттэй өдөрлөгийн үеэр улсын төсвөөс болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн олон нийтэд мэдээлж, холбогдох асуултад хариулт өгөн, иргэдээс ирсэн төсвийн төсөлд тусгах саналыг хүлээн авч шийдвэрлэх боломжтой эсэхийг судлан үзсэн.

Орон нутгийн төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгах чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулаагүй байна. Төсвийн төсөлд иргэдийн саналыг авч тусгасан эсэх талаар нэгдсэн тоо баримт, мэдээлэл, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж тайланд тусгаж байх нь зүйтэй. Энэ арга хэмжээний хүрээнд Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд хийх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг

иргэдээр нээлттэй болон цахим хэлбэрээр хэлэлцүүлж, иргэдээс гарсан саналуудыг төсвийн төсөлд тусгасан. Тухайлбал, Говь-Алтай аймгийн 19 сумын 900, Дорноговь аймгийн 3030, Дундговь аймгийн 2835, Хэнтий аймгийн 3790 иргэн, Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгоны иргэдээс тус тус санал авчээ. Эдгээр аймгуудаас бусад аймгийн тайланд орон нутгийн төсвийн төсөлд иргэдээс санал авч тусгасан талаар мэдээлэл байхгүй, тоо баримтыг тусгаагүй байна. (Биелэлт 20 хувь)

4.1.3.4-2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх /СЯ, 2018-2022/

Сангийн яамнаас Төсвийн тухай хуулийн 5.1.4 болон 6.5.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах, төсвийн ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд тус газрын <http://iltod.gov.mn> сайтад дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн улсын төсөв, аймаг нийслэлийн жилийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь болон бусад холбогдох мэдээллүүдийг <https://shilendans.gov.mn/> сайтад жил бүрийн өргөн барьсан болон батлагдсан төсвийг тухай бүртнь нийтлэн олон нийтэд ил тод байдлаар тогтмол мэдээлж хэвшсэн.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд баримтлах журам”-ын төсөлд санал авах зорилгоор журмын төслийг www.iltod.mn цахим хуудсанд байршуулж санал авсан.

Концессоор эрчим хүчний салбарт 2 төсөл, зам тээврийн салбарт 6 төсөл, эрүүл мэндийн салбарт 1 төсөл хэрэгжүүлэхээр аж

ахуйн нэгжтэй концессийн гэрээ байгуулсан тухай мэдээллийг маягтын дагуу бэлтгэн www.shilendans.com цахим хуудсанд байрлуулсан. Санал авах хэлэлцүүлгийн мэдээллийг дээрх цахим хуудсуудаар мэдээлээгүй байна. (Биелэлт 10 хувь)

4.1.3.5-1. Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах/ Монголбанк, 2017-2020/

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-193/228 дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэний хувьд 15 хүртэлх хоног, аж ахуйн нэгжийн хувьд 30 хүртэлх хоногт багтаан эргэн төлөх боломжтой гэж банк үзвэл уг зээлийг хэвийн ангилалд бүртгэж болохоор журамласан. Тэтгэвэр барьцаалсан зээлийн нөхцөлийг сайжруулах зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, арилжааны банк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг арилжааны бүх банкинд адил байхаар тогтоох, тэтгэврийн тодорхой хувьд зээл олгох асуудлыг шийдвэрлэж мөрдүүлэх, тэтгэвэр барьцаалсан зээл олгох зориулалтаар арилжааны банкинд байршуулсан нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрт заавал байлгах нөөцийг тогтоохгүй байхаар тус тус шийдвэрлэсэн

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага болох Монголбанк зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийх, зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх талаар 2018 онд ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. (Биелэлт 40 хувь)

4.1.3.5-2. Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох /Монголбанк, 2017-2019/

“Зээлийн хүүг бууруулах стратеги” боловсруулах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэгт Монголбанкны мэргэжилтнүүдээс гадна Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” төрийн бус байгууллагын төлөөллүүд орсон. Тус стратеги 2018 онд батлагдах бөгөөд зээлийн хүүг бууруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлно.

Монголбанкнаас зээлийн хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэх, иргэдээс банкуудын тогтоосон зээл, шимтгэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг. Цаашид гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар тайланд тусгах шаардлагатай. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 хэсэгт “Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална” гэж заасны дагуу Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны А-236 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлан мөрдүүлж байна. Банкны салбараас санхүүгийн үйлчилгээ авах иргэд, аж ахуйн нэгжид бодит мэдээлэл өгөх зорилгоор банкуудын хадгаламж, зээлийн үйлчилгээний зарласан хүү, шимтгэл, бодит өртгийн талаарх мэдээллийг сар бүр Монголбанкны <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=6> цахим хуудсанд байршуулж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртөг болон зээлийн хүүг бууруулах, чадавхийг бэхжүүлэх зорилгоор Хорооны 2016 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг /хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоосон/ хангуулж, банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, хувь



нийлүүлсэн хөрөнгө, үйлчилгээний өгөөмж, хүртээмжийн талаар судалгаа хийн, 2016 оны 271 дүгээр тогтоолоор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2017 оны 91 дүгээр тогтоолоор үе шаттай нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Энэ шийдвэр гарснаас хойш зээлийн жигнэсэн дундаж хүү буурах хандлагатай байгаа бөгөөд зэх зээлийн өрсөлдөөний зарчмаар банк бус санхүүгийн байгууллагууд зээлийн хүүгээ бууруулж байгаагаар илэрхийлж эхлээд байна. Тухайлбал, 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 102957 зээлдэгчийн 592.8 тэрбум зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар, өмнөх улирлаас 0.1 хувиар буурч 3.4 хувьд хүрсэн байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2018 оны 1 дүгээр сарын 18-ны хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан Банкны тухай хуулийн 6.2 дахь хэсэг “Банк Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа”-нд Хорооны зүгээс холбогдох саналыг өгч ажилласан. Санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү, шимтгэлд дээд хязгаар буюу тааз тогтооход гарах нөлөөлөл болон бусад улс орнуудын туршлагын талаарх харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэн удирдлагад танилцуулсан. Банк зээл олгохдоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох чиглэлээр Монголбанк 2018 онд ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. (Биелэлт 30 хувь)

4.1.3.5-3. Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх/Монголбанк, 2017-2020/

Монголбанкнаас “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян”-ыг 2018 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд аяны хүрээнд Сагийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын банкны холбоо, Бичил санхүүгийн хөгжлийн

сан, Хадгаламжийн даатгалын корпорац, Монголын ипотекийн корпорац, Азийн хөгжлийн банктай тус тус хамтран дараах гол ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль батлуулах,
- Санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад нь туслах, эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлж, оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах,
- Санхүүгийн тэнцвэргүй байдлаас сэргийлэх зохицуулагч этгээдүүдийг эрх, үүргийн тодорхой болгох, энэ чиглэлд хяналт шалгалт хийдэг тусгай бүтэц бүрдүүлэх,
- Шимтгэл, хураамж болон санхүүгийн үйлчилгээний нэмэлт төлбөрийн талаарх ойлголтыг нийгэмд хүргэх,
- Орон сууцны ипотекийн зээл хүсэгчдэд чиглэсэн зөв, тодорхой ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх,

Зээлийн мэдээллийн сангийн ойлголт, мэдээлэл нийлүүлэгч талууд болон хэрэглэгч өөрийн мэдээллийг хэрхэн авч ашиглах, хяналт тавих талаар олон нийтэд хүргэх зэрэг арга хэмжээг авахаар төлөвлөсөн.

Төв банк /Монгол банк/-ны тухай хуульд 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн шинэ зохицуулалт тусгагдсаны дагуу Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар Санхүү хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан ба тус ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хамтран оролцож, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг судлан, хуулийн төслийг эхний байдлаар боловсруулан холбогдох

төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч ажиллаж байна. Хуулийн төслийг боловсруулах болон цаашид Монгол Улсад энэхүү тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай техникийн туслалцааг хүсэхээр Азийн хөгжлийн банктэй хэлэлцээний түвшинд ажиллаж байна. (Биелэлт 20 хувь)

4.1.3.5-4. Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах/Монголбанк, 2017-2019/

Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Банкны тухай хуульд арилжааны банкууд охин компанитай байхыг хязгаарлаж, банкууд санхүүгийн болон санхүүгийн бус салбарт тэгш бус өрсөлдөөн бий болох эрсдэлийг бууруулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулав.

Санхүүгийн зохицуулах хороо Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тус салбарын банкны салбартай өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зарим зохицуулалтыг тусгаж байна. Тухайлбал, Хадгаламж зээлийн хоршоо нь цахим үйлчилгээ эрхлэх, хадгаламж хамгаалалтын системийг нэвтрүүлэх зэрэг.

2018 оны 1 дүгээр сарын 18-ны хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан Банкны тухай хуулийн 6.2 дахь хэсэг “Банк Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа”-нд Хорооны зүгээс холбогдох саналыг өгч ажилласан. Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д холбогдох саналыг хүргүүлсэн.

Гадаадын банк санхүүгийн зах зээлд нэвтэрснээр эдийн засаг, санхүүгийн системд үзүүлэх нөлөөлөл болон бусад улс

орнуудын туршлагын талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн.

Мөн Монголбанкны ерөнхийлөгчийн 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/295 дугаар тушаалаар байгуулагдсан “ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах шаардлагын хүрээнд банкны тогтолцоог тогтворжуулах, өөрийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т ажиллаж, хуулийн төслийг хамтран боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль батлагдсан. Тус хуульд банкууд хувьцаа болон үнэт цаас гаргахыг хуульчилж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх аргаар тусгасан. Энэ нь арилжааны банкуудын хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн эх үүсвэрээ өөрийн нөөц бололцоо, нэр хүнд, чадавхиас хамааруулан бие даан босгох, нэмэгдүүлэх боломжийг олгосон хууль болсон. (Биелэлт 30 хувь)

4.1.3.5-5. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах / Монголбанк, 2017-2022/

Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанкнаас “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх бодлого баримтлахаар тусгасан. Энэ зорилтын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцааг хөрөнгийн бирж



дээр арилжаалдаг болох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн яамнаас хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээл рүү оруулах болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөрөнгийн зээлээс хямд эх үүсвэрээр хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үндэсний компаниудыг гадаад улсын хөрөнгийн бирж дээр бүртгүүлж, хөрөнгө оруулалт татах, мөн гадаад улсад бүртгэлтэй компаниудыг Монгол Улсын хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаа арилжих боломжийг бий болгох хууль эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр ажилласан. Энэ дагуу “Гадаад улсад арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх” журмыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан. Иймд гадаадын хөрөнгийн бирж дээр үндэсний компаниуд үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татах хууль эрх зүйн орчин бүрдсэн. Цаашид эдгээр компаниудыг бодлогоор дэмжиж ажиллах, мэдээллийн ил тод байдал, тайлагнал, засаглалыг сайжруулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудал, бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний талаар танилцуулга, санал дүгнэлтийг бэлтгэж, хийгдэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд голлох байр суурьтай оролцсон. JP Morgan Chase Bank манай улсад глобал кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэж, хамтран ажиллах дотоодын кастодиан банкаар Голомт банкныг сонгосон ба Хорооны зүгээс зохицуулалтын орчныг өөрчлөх ажиллагаа хийгдэж нэр бүхий 3 банкинд үнэт цаасны зах зээлд тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа

эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Ашигт малтмалын тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, зах зээлийн нэр хүндийг өсгөхөд чухал ач холбогдолтой арга хэмжээ болох үнэт цаасны давхар бүртгэлийн орчинг бүрдүүлсэн. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагууд болох дэлхийд тэргүүлэгч 26 биржийн түр жагсаалт” болон давхар бүртгэлийн журмыг боловсруулан баталсан. “Монголын үнэт цаасны бирж” ХХК буюу хөрөнгийн зах зээл дэх анхны хувийн бирж анхны үнэт цаасаа бүртгэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаа эхлүүлсэн. Японы хамтын ажиллагааны байгууллага / JICA/-аас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн багтай хамтран “Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа болон давхар бүртгэл” сэдэвт семинар, Люксембургийн санхүүгийн мэргэжлийн сургалтын “House of Training” байгууллагатай хамтран “Олон улс дахь хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалт, биржээр арилжаалагддаг сан /ETF/” сэдэвт сургалтуудыг үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчид болон хөрөнгө оруулагчдын дунд зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-ны техникийн хамтын ажиллагааны төсөл “Монгол Улсын Мөнгөний болон Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх баримт бичиг боловсруулах” төслийн хүрээнд үнэт цаасны төлбөр, тооцооны Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт (Delivery versus Payment) зарчим, дараа төлбөрт тооцооны T+2 горимыг нэвтрүүлэх төсөл амжилттай хэрэгжиж байна.

Дэлхийн банкны төслийн хүрээнд Биржийн бус зах зээлтэй холбоотойгоор санхүүжилт авах зорилгоор төслийн танилцуулга бэлтгэсэн.

2018 оны 5 дугаар сард болсон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын 43 дахь удаагийн чуулга уулзалтад Хорооны дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцож, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хандлага, ялангуяа энэ зах зээлд нэвтэрч буй финтекийн шийдэл, шинэтгэл болон хөгжүүлэлтийн хэтийн төлөв, санхүүгийн зах зээлүүдийн нэгдэл интеграцийн талаар туршлага солилцсон.

Австралийн хөрөнгийн зах зээлийн талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн. Тэр дундаа төрийн өмчит болон төрийн оролцоот байгууллагуудыг хэрхэн хувьчилсан тухай нарийн судалгааг хийж удирдлагуудад танилцуулсан. Судалгааны үр дүнд төрийн өмчийн хувьчлалыг хэрэгжүүлснээр гадны болон дотоодын хөрөнгө оруулагчид их хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж зах зээл тэлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

Австралийн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх реформ болон төрийн өмчит, мөн төрийн оролцоот байгууллагуудыг хэрхэн хувьчилсан тухай судалгааг эцэслэн боловсруулж удирдлагуудад танилцуулсан.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Хороо болон Сангийн яам, Монголбанк, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын үнэт цаасны бирж” ХК, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон бусад холбогдох байгууллагын төлөөллүүдийг хамарсан уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх II үе шатны төсөл”-ийн хүрээнд компанийн бондын зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөгөө өгөх, зэрэглэл тогтоох байгууллага байгуулах болон биржийн бус арилжааны эрх зүй, зохицуулалт, тогтолцооны зарчмыг тодорхойлж боловсруулах, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх гэсэн гурван чиглэлээр гүйцэтгэх ажлын хүрээг тодорхойлсон байна. Уг төсөл 2019 оны эхний улирлаас хэрэгжиж эхлэх бөгөөд гурван жилийн хугацаанд

үргэлжлэх байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит хуралдаанд төрийн өмчит компаниудын хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан хэрэгжүүлэх талаар олон улсын туршлага судалж, санал боловсруулж танилцуулсан. Энэ нь хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн бий болгох, уул уурхайн салбарт түшиглэсэн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, үүнтэй зэрэгцээд өмч хувьчлалын бодлогоор дамжуулан тус зах зээлийг үр ашигтайгаар дэмжих санал, санаачлагыг танилцуулах явдал байв.

Хөрөнгийн зах зээлд шинээр оролцох сонирхолтой компаниудад зах зээлийн онцлогийг тайлбарлан таниулах, тэдэнтэй зах зээл дээр амжилттай IPO гаргасан компаниуд өөрсдийн туршлага, мэдлэгээсээ хуваалцаж, амжилт, сорилтоо дэнслэх боломж олгох зорилгоор бид 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Шинээр IPO гаргасан компаниудын нээлттэй зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, тус хөтөлбөрт санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлж, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөсөн байна гэж тусгасан. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлд оруулах болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөрөнгийн зээлээс хямд эх үүсвэрээр хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй үндэсний компаниудыг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлж, хөрөнгө оруулалт татах, мөн гадаад улсад бүртгэлтэй компаниудыг Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгүүлэн хувьцаа арилжих боломжийг бий болгох хууль, эрх зүйн орчинг бий болгох ажлыг хэрэгжүүлж ажилласан. Үнэт цаасны зах



зээлийн тухай хуульд “Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани нийт гаргасан үнэт цаас болон түүнд суурилсан хадгаламжийн бичгийн тодорхой хувийг гадаад улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэн арилжиж болно” гэж заасан. Мөн дээрх заасан компани гадаад улсад үнэт цаас гаргахдаа Хороонд бүртгүүлэх бөгөөд бүртгэлийн журмыг Хороо тогтооно гэж заасан. Энэ дагуу “Гадаад улсад арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх” журмыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлаад байна. Иймд гадаадын хөрөнгийн бирж дээр үндэсний компаниуд үнэт цаас гаргах, хөрөнгө оруулалт татах хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Мэдээллийн ил тод байдал, тайлагнал, засаглалыг сайжруулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөж, JICA-ийн санхүүжилттэй “Бондын зах зээлийг хөгжүүлэх нь” төслийг 2019 оны 3 дугаар сараас эхлэн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн өрийн хэрэгслээр босгох хөрөнгийн хэмжээ өөрийн хөрөнгөнөөс ихгүй байх заалт, их байгаа тохиолдолд заавал гуравдагч талын батлан даалттай байх шаардлага нь бонд гаргагч компанид хүндрэл учруулдаг. Энэхүү хүндрэлтэй асуудлыг зохицуулах хүрээнд Зээлийн батлан даалтын сангаас нээлтэй бондод баталгаа, батлан даалт гаргах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор Зээлийн батлан даалтын сан, Монголын хөрөнгийн бирж хамтран “Санамж бичиг”-ийг байгуулан ажиллаж байна.

Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг 2018 онд Монголбанкнаас авч хэрэгжүүлээгүй байна. Харин Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос Европын сэргээн

босголт хөгжлийн банк (EBRD)-ны техникийн хамтын ажиллагааны төсөл “Монгол Улсын Мөнгөний болон Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх баримт бичиг боловсруулах” төслийн хүрээнд үнэт цаасны төлбөр, тооцооны Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт (Delivery versus Payment) зарчим, дараа төлбөрт тооцооны T+2 горимыг нэвтрүүлэх төсөл амжилттай хэрэгжиж байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, тус хөтөлбөрт санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12 хувьд хүргэн нэмэгдүүлж, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөсөн байна гэж тусгасан. Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлд оруулах болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг хөрөнгийн зээлээс хямд эх үүсвэрээр хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй үндэсний компаниудыг гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлж, хөрөнгө оруулалт татах мөн гадаад улсад бүртгэлтэй компаниудыг Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгүүлэн хувьцаа арилжих боломжийг бий болгох хууль эрх зүйн орчинг бий болгох ажлыг хэрэгжүүлж ажилласан. (Биелэлт 50 хувь)

4.1.3.6-1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, аудитын албадуудыг Сангийн яамнаас салбарын нэгдсэн бодлогоор ханган, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж ажилласан. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах болон холбогдох хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Засгийн газар, УИХ-д өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 2017 онд хийгдсэн дотоод аудитын тогтолцооны шинжилгээ, эрх зүйн орчны судалгаанд үндэслэн Дотоод аудитын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулаад байна. Уг хуулийн төсөлд санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудиторчуудын хараат бус байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхээр холбогдох зүйл, заалтыг тусгасан. (Биелэлт 40 хувь)

4.1.3.6-2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын одоогийн тогтолцоонд шинжилгээ хийх, эрх зүйн орчинг судлах, холбогдох арга хэмжээг авах/СЯ, 2017-2022/

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Засгийн газар, УИХ-д өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, 2017 онд хийгдсэн дотоод аудитын тогтолцооны шинжилгээ, эрх зүйн орчны судалгаанд үндэслэн Дотоод аудитын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулаад байна.

Дотоод аудитын тайлан, дүгнэлтэд хяналт тавих чиглэлээр Чанарын баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх ажил хийгдэж байна. 2017 онд Дотоод аудитын Чанарын баталгаажуулалтын гарын авлага боловсруулж гаргасан бөгөөд Хөвсгөл аймаг, Нийслэл, Гадаад харилцааны яам зэрэг байгууллагуудын Дотоод аудитын нэгжид түршилтаар Чанарын хяналт хийж, зөвлөмж чиглэл өгч ажилласан. Мөн эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоо нэвтрүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулагдан, журам, бодлогын

баримт бичгийг шинэчлэх ажил хийгдэж байна. Дотоод аудитын ажлын үе шатыг цахимжуулах, нэгдсэн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр програм хангамж хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Дотоод аудитын сургалтын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд Дотоод аудитын олон улсын институт зэрэг гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгааны ажил хийж байна. (Биелэлт 40 хувь)

4.1.3.7-1. Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /СЯ, УАГ 2017-2019/

Монгол Улсын ерөнхий аудитор 2017 оныг “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласан бөгөөд аяны хүрээнд зөвлөмжийн хэрэгжилт, акт, албан шаардлагын барагдуулалтын тайланг аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газраас хүлээн авсан бөгөөд аяны хүрээнд орон нутаг дахь Төрийн аудитын газраас 428,3 сая төгрөгийн 492 төлбөрийн акт, 3127,6 сая төгрөгийн 827 албан шаардлагыг барагдуулж, 2847 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулсан байна. Үндэсний аудитын газрын хэмжээнд /2017 оны хагас жилийн байдлаар/ 1666 акт тавигдсан ба хэрэгжсэн 44,5 хувь, хэрэгжээгүй 53,9 хувь, хасагдсан 1,6 хувьтай, 1979 албан шаардлага тавьж 54.9 хувь нь хэрэгжин, 44.9 хувь нь хэрэгжээгүй, 0.2 хувь хасагдсан, 8.501 зөвлөмж өгч хэрэгжсэн 45 хувь, хэрэгжсэн 55 хувийн үзүүлэлттэй байна.

Үндэсний аудитын газраас 2016 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн, Сангийн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох бусад тайлангуудад аудит хийж, өгсөн зөвлөмж болон “Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д тавьсан албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Сангийн сайдын 2017



оны 231 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд Сангийн сайдад өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 13-2/6604 албан тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. Санхүүгийн аудитын тайлангийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт-2017” эмхэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гарган хэвлүүлсэн.

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс Монгол Улсын ерөнхий аудитор, орлогч бөгөөд тэргүүлэх аудитор болон холбогдох бусад аудиторуд төсвийн ерөнхийлөн захирагч нарт акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, танилцуулга хийх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Сангийн яамнаас Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Засгийн газрын нөөц сангийн санхүүгийн тайлан, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын бонд, түүний худалдан авалт, “Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт АСЕМ, Сангийн яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох бусад тайлангуудад аудит хийж, өгсөн зөвлөмж болон Үндэсний аудитын газраас тавьсан албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Сангийн сайдын 2018 оны 223 дугаар тушаалаар батлуулсны дагуу Сангийн сайдад өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийн явцыг өссөн дүнгээр 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар гаргаж, үнэлгээ хийж хүргүүлсэн. Тус үнэлгээнд нийт 31 зөвлөмж, 8 албан шаардлага хамрагдсан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 86.5 хувь, албан шаардлага 89.6 хувийн биелэлттэй байгаа нь зарим зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй байгаатай холбоотой байна. (Биелэлт 40 хувь)

4.1.3.7-2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохиролтой холбоотой асуудлыг Захиргааны ерөнхий хуулиар зохицуулж байгаа бөгөөд хууль зөрчсөн гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг уг хуулийн 105 дугаар зүйлд заасан. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”, 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэн зохицуулалтыг тус тус тусгасан байна. Сангийн яамнаас Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж тус тус заасны дагуу Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын нэгжүүд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2018 онд албан тушаалтны буруутай шийдвэрээс болж төр хохирсон талаар гомдол шалгаагдаагүй болно.

Үндэсний аудитын газар иргэн, хуулийн

этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулж буй сургалтын хөтөлбөрт “Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг төлүүлэх эрх зүйн үндэслэл” сэдвээр хичээл тусгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. 2017 оны батлагдсан Төрийн албаны тухай хуульд тусгагдсан зохицуулалтын дагуу төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсан, чөлөөлсөн, өөр ажил, албан тушаалд шилжүүлсэн томилсноос төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, шаардлагатай тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлүүлэх талаар Төрийн албаны зөвлөл, Сангийн яамтай хамтран ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.3.7-3. Аудитын дүгнэлтийн мөрөөр хийсэн ажлын үр дүнг хянах, үнэлэх нэгдсэн журмыг батлан мөрдүүлэх /СЯ, 2018-2020/

УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 86-д Дотоод аудитын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр заасан. Энэ дагуу Сангийн сайдын 2017 оны 236, 309 тоот тушаалаар хуулийг төслийг боловсруулах болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Засгийн газар, УИХ-д өргөн барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг УИХ хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Уг хуулийн төсөл батлагдсанаар дагаж гарах дүрэм, журмаар зохицуулагдах болно. “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн

ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасны дагуу Нийслэлийн дотоод аудитын алба, Гадаад харилцааны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторчуудын аудитын дүгнэлт, ажлын материалд чанарын баталгаажуулалтын гарын авлагын дагуу баталгаажилт хийж хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгсөн. Гарын авлагыг туршилтаар дээрх 3 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж туршсан бөгөөд шинэчлэх, сайжруулах шаардлагатай байсан тул 2019 онд гарын авлагыг шинэчлэх, мөн Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын журам боловсруулах ажлыг яамны 2019 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан. (Биелэлт 10 хувь)

4.1.3.8-1. Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах /СЗХ, СЯ, 2017-2022/

2017 онд Санхүүгийн зохицуулах хороо Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 60 аудитор хамрагдаж, 11 аудитор тэнцсэн. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын Хуульчдын холбоотой хамтран үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуульч, аудиторчуудад зориулсан сургалтыг нийт 3 удаа зохион байгуулж, үнэт цаасны зах зээлийн талаарх хичээлүүдийг онол, практик хосолсон хэлбэрээр зааж, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулсан. Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтаар тус тус эрх зүйн орчинг бий болгосон бөгөөд Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-19.6, 19.4 дэх заалтад



заасан нөхцөл, шаардлагын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бүх аудитын компаниудад адил түвшний нөхцөл шаардлага тавигддаг байна. Хэрэв гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах бол Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, 19.3.7 дэх заалтад заасан нэмэлт шаардлага тавигддаг байна. 2018 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. (Биелэлт 10 хувь)

4.1.3.8-2. Тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад төрийн захиргааны байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах/СЯ, 2017-2018/

Аудитын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын тушаалаар аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аудитын компаниудад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, үр дүнг яамны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн. Сангийн сайдын 2018 оны 52 тоот тушаалаар Аудитын тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагад зайны хяналт шалгалт хийсэн дүнгийн шийдвэрийг Сангийн яамны “Ил тод” цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Сангийн яамны “Ил тод” цахим хуудсанд 2018 оны байдлаар нийт 8 удаа байршуулан олон нийтэд мэдээлэв. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн

хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.” гэж заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага өөрөө мэдээлэх боломжтой. (Биелэлт 100 хувь)

4.1.3.9-1. Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох чиглэлд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагаас 2018 онд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй. (Биелэлт 0 хувь)

4.1.3.9-2. Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хангах, аудитын байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох /ҮАГ, 2017-2018/

Монгол Улсын ерөнхий аудиторын 2017 оны А/138 дугаар тушаалаар “Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан байсныг өөрчлөн Монгол Улсын ерөнхий аудиторын 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаартай тушаалаар Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, иргэд олон нийтээс санал авахаар байгууллагын цахим хуудаст 2017 оны 12 дугаар сард байршуулсан. Түүнчлэн Хууль, тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын хэлэлцүүлгийг “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. (Биелэлт 20 хувь)

4.1.3.9-3. Удаа дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, дотоод хяналт хангалттай үнэлгээ авсан байгууллагын санхүүгийн тайланд жил бүр аудит хийдэггүй байх нөхцөл, шалгуурыг боловсронгуй болгох /ҮАГ, СЯ, 2017-2020/

Монгол Улсын ерөнхий аудиторын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу “... нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, дотоод хяналт сайтай нь тогтоогдож 3 жил дараалан санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан...” заалтуудын дагуу байгууллагуудад итгэл үзүүлэн санхүүгийн тайланд нь аудит хийхгүй өнжөөж батламж олгож байна. Уг журам Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршсан. (Биелэлт 10 хувь)

4.1.3.9-4. Төрийн аудитын байгууллага зарим чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэхдээ тэгш оролцоог хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах./2018-2020 он/

Монгол Улсын ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 26-ны А/191 дугаар тушаалаар “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг батлуулан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3806 дугаартай бүртгүүлэв. Үндэсний аудитын газраас гэрээгээр 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх Зөвлөх үйлчилгээ үзүүлэх Хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, 95 хувийн гүйцэтгэлтэй ажилласан бол “2018 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах” ҮАГ/201807025 дугаартай зөвлөх үйлчилгээний дэлгэрэнгүй зарлалыг 2018 оны 7 дугаар сарын 2-ны

өдөр “Өдрийн сонин” болон төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас www.tender.gov.mn-д тус тус байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод зарласан. Сонирхлоо илэрхийлсэн компаниудын материалыг 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 11 цаг хүртэл хүлээн авч үнэлгээний хорооны бүрэлдэхүүн үнэлгээ хийж хураангуй жагсаалт үүсгэсэн. 2018 оны 8 дугаар сарын 2-ны өдөр хураангуй жагсаалтад багтсан 66 компанид тус ажлыг 23 багц болгон тендерийн урилга болон тендерийн материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас www.tender.gov.mn-дээр дамжуулан хүргэсэн. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн тендерийн үнэлгээ багц бүрээр хийж захиалагчид шалгарсан компанийн зөвлөмжийг хүргүүлсэн. 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдөр шалгарсан компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлж, шалгараагүй компаниудад шалгараагүй тухай мэдэгдлийг хүргүүлсэн. Хуулийн хугацаанд тендерт оролцогчдоос гомдол гараагүй учраас захиалагч гэрээг байгуулсан болно. (Биелэлт 60 хувь)

4.1.3.10-1. Төрийн аудитын хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд мэдээлэх/ҮАГ, 2017-2022/

2017 онд Үндэсний аудитын газраас нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн аудитын тайланг/нууцын зэрэглэлтэйгээс бусад/www.audit.mn цахим хуудсанд байршуулсан. Үндэсний аудитын газрын төрөлжсөн аудит болох Гүйцэтгэлийн аудитын газар, Санхүүгийн аудитын газар, Нийцлийн аудитын газрын хийсэн аудитын тайлан, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын хийсэн аудитын тайланг тус тус www.audit.mn цахим хуудсанд байршуулсан. 2018 онд Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлан, акт, албан шаардлагын хамт байгууллагын албан ёсны цахим хуудсанд ил тод байршуулж олон нийтэд мэдээлсэн. Аудитын үйл ажиллагаа, акт,



албан шаардлагын хэрэгжилт биелэлтийн талаар тухай бүр тогтмол байгууллагын цахим хуудсанд байршуулж, нийт 16 хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллийг түгээсэн. (Биелэлт 70 хувь)

4.1.3.10-2. Аудит хийхдээ эрсдэлтэй сэдэв, чиглэлийн талаар олон нийтээс санал, судалгаа авах үйл ажиллагааг цахим технологи ашиглан нэвтрүүлэх/ҮАГ, 2017-2019/

Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудын 2018 онд хийж гүйцэтгэх аудитын сэдвийг иргэд олон нийт болон албан байгууллагаас санал авч хэлэлцүүлэн баталсан. Мэдээллийг www.audit.mn цахим хуудаснаас үзэх боломжтой. Мөн иргэд, төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтнүүдийн оролцоог аудитын үйл ажиллагаанд оролцуулах боломжийг тодорхой болгож Монгол Улсын ерөнхий аудиторын 2017 оны А/228 дугаар тушаалаар “Аудитын иргэний танхим болон аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагааны дүрэм”-ийг баталж, Аудитын иргэний танхимын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн. Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхимын орон тооны бус гишүүнийг сонгох сонгон шалгаруулалтыг явуулж, Ерөнхий аудиторын 2018 оны А/68 тоот тушаалаар Аудитын иргэний танхимын гишүүдийг томилсон. Үндэсний аудитын газар, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим, Хэнтий, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэдийн бүлгийг тус тус байгуулсан. Аудитын иргэний танхимын гишүүдээр Төрийн аудитын байгууллагаас 2019 онд хийх аудитын сэдвүүдийг хэлэлцүүлж, санал авсан. Олон улсын “Иргэний оролцоотой аудит” сэдэвт 2 гарын авлагыг орчуулж хэрэглээнд нэвтрүүлж байна. Мөн аудитад иргэний оролцооны стратегийн баримт бичгийг боловсруулсан. 2017 оноос хойш төрийн аудитын байгууллагын талаар олон нийтийн сүлжээнд тавьсан нийтлэлүүдийн

талаар ард, иргэдийн сэтгэгдлүүдийг нэгтгэн ажиллаж байгаа бөгөөд уг мэдээллийг байнга шинэчилж, аудитын сэдвийг сонгох судалгааны ажлыг хийж байна. Үндэсний аудитын газрын цахим хуудсанд мэргэжлийн болон төрийн бус байгууллага, олон нийтээс аудит хийх сэдвийн талаар сонголт хийх санал авах булан ажиллуулж байна. (Биелэлт 20 хувь)

4.1.3.10-3. Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг болох /СЯ, 2017-2019/

Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм журмын шинэчлэлтийг хийх ажлын хэсгийг Монгол Улсын ерөнхий аудиторын тушаалаар томилсон бөгөөд уг ажлын хэсэг “Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлдэг байх” холбогдох журмаар зохицуулалт хийхээр ажиллаж байна.

Сангийн яам Төсвийн тухай хуульд заасны дагуу аппаратын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг жил бүрийн 2 дугаар сарын 25, Сангийн сайдын багцын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 5-ны дотор тус Үндэсний аудитын газраас авсаны дараа тухай бүр шилэн дансанд байршуулдаг. Үндэсний аудитын газар аудитад хамрагдсан бүх байгууллагуудын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг эмхэтгэл болгон хэвлүүлж, акт, албан шаардлага, зөвлөмж, түүний биелэлтийг хагас, бүтэн жилийн байдлаар www.audit.mn сайтад байршуулсан. Сангийн яам нь үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд хөтөлбөрийн энэ заалтын хүрээнд нийт төрийн байгууллагууд төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан

шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн данс болон цахим хуудсаараа мэдээлж буй байдалд Үндэсний аудитын газартай хамтран хяналт тавьж, хэрэгжилтэд нэгдсэн дүгнэлт хийж, үнэлгээ өгөх шаардлагатай байна. (Биелэлт 10 хувь)

Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 15 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2017 онд 14 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд шинээр 1 арга хэмжээ хэрэгжиж эхлэхээр, нийт 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.4.1-1. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг боловсронгуй болгох үйл ажиллагааг дуусгах /СЯ, ТӨБЗГ, ХХМТГ, 2017-2019/

Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” болох www.tender.gov.mn-ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулсан бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд төрийн өмчит нийт 1133 хуулийн этгээд уг системд захиалагч байгууллагаар бүртгүүлсэн бөгөөд 2017 онд хэрэгжих 10074 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-ийн шаардлагатай хөгжүүлэлтийн ажлыг хийн, боловсронгуй болгож байгаагийн зэрэгцээ нэгдсэн системийн дэд системүүдийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлэн ашиглаж байна. 2018 онд системийг боловсронгуй болгох чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дор дурдсан ажлыг шинээр хийж гүйцэтгэв:

–“Цахим дэлгүүр”-ийн дэд системийг хэрэглээнд нэвтрүүлэв. Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолд заасан зарим ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг тус системээр дамжуулан ерөнхий гэрээний дагуу худалдаалав. Эдгээр эмийн бүтээгдэхүүний тендер шалгаруулалтад эм ханган нийлүүлэгч 10 байгууллага оролцсон бөгөөд тэдгээртэй нийт 40 ерөнхий гэрээ байгуулан ажилласан. Ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 361 удаагийн захиалга хийгдэж, 814144 ширхэг эм нийлүүлэгдэн худалдаалагдсан бөгөөд 325.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан байна.

–“Цахим дэлгүүр”-ийн бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд 2017 онд 12036 бараа, ажил, үйлчилгээ бүртгэгдсэн байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 23857 болж 2 дахин нэмэгдсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг төрийн мэдээлэл солилцооны ХҮР системтэй холбох талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулж, тендер шалгаруулалтад шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага хороонд шуурхай солилцох арга хэмжээ авав. Энэ хүрээнд Автотээврийн үндэсний төвийн веб сервисийн холболтын ажлыг эхлүүлсэн.

–“Цахим тайлан” дэд системийг хэрэглээнд нэвтрүүлж, нээлттэй гэрээний олон улсын стандарт (Open Contracting Data Standard)-ийг Монгол Улсад нутагшуулах, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг машин унших боломжтойгоор олон нийтэд



нээлттэй мэдээлэх зорилгоор www.opendata.tender.gov.mn системийн хөгжүүлэлтийг хийв. Нээлттэй гэрээний олон улсын стандартыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоонд нэвтрүүлснээр худалдан авах ажиллагаатай холбоотой тендер шалгаруулалт, түүнтэй холбоотой гэрээ, тендерт оролцогчийн талаарх мэдээлэлд иргэд, олон нийтийн зүгээс бодит хяналт тавих боломж бүрдсэн. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан тайлагналт, үнэлгээний 8 маягтаар “Цахим тайлан” дэд системээс мэдээлэл гаргах бэлтгэл ажлыг хийсэн.

–“Цахим гэрээ”-ний дэд систем хэрэглээнд нэвтэрсэн бөгөөд уламжлалт гэрээг цахим системд бүртгэдэг болсон. Худалдан авах ажиллагааны гэрээний мэдээлэл 1511 болж, өмнөх оноос 1409-өөр буюу 14 дахин (1381 хувиар) өссөн үзүүлэлттэй байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тоон гарын үсгийг үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлэх Татварын ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлэх, олон нийтэд мэдээлэл өгөх, олгох зорилготой www.esign.gov.mn вэб хуудасны бүтэц, контентийг бэлтгэж, агуулгыг боловсруулсан.

Засгийн газраас 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан. Цахим худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс Сангийн

сайдын 2013 оны 7 дугаар тушаалаар Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмыг баталсан боловч хуулийн зохицуулалт байхгүй тул цахим худалдан авах ажиллагааг бүрэн нэвтрүүлэхэд хүндрэл гарч байгаа тул хуулийн төсөлд тусгайлан оруулаад байна. (Биелэлт 90 хувь)

4.1.4.1-2. Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх /СЯ, ТӨБЗГ, ХХМТГ, 2017-2019/

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д 2017 онд нийт 962 захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааны 9531 төлөвлөгөө бүртгэгдэж байсан бол 2018 онд 1433 захиалагч байгууллагын 21417 худалдан авах ажиллагааны төлөвлөгөө олон нийтэд мэдээлэгдсэн. 2018 онд 471 захиалагч байгууллага шинээр бүртгүүлж, төлөвлөгөө 2.2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь захиалагч байгууллагууд Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахад ахиц гарч байгааг илтгэж байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нийт 10817 тендер шалгаруулалтын урилга зарлагдсанаас 9574 нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байгаа нь нийт урилгын 88.5 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 2.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр “Албан даалгавар” хүргүүлж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласнаар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийт дүнгээр 4997 төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, 2465 тендер шалгаруулалтын урилгыг зарлан цахим

системээр зарлан ил тод мэдээлснээс 2289 нь цахим тендер шалгаруулалтын урилга байгаа нь нийт тендер шалгаруулалтын 92.3 хувийг эзэлж байна. Төрийн өмчит компани, үйлдвэрийн газар нь 2017 онд нийт зарласан тендерийн 30 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулж байсан бол 2018 онд цахим системийн хэрэглээ өмнөх оноос 62.3 хувиар ахисан дүнтэй байна.

2018 онд төсвийн ерөнхийлөн захирагчид болон түүний харьяа байгууллагууд, ялангуяа яамдын хувьд тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан тоо нэмэгдсэн дүнтэй байгаа болно.

2018 онд төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ээр нийт 10202 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэнээс 1955 нь нээлтийн, 8021 нь тендер шалгаруулалтын эцсийн үр дүн, 226 нь бусад явцын үр дүнгийн нээлттэй мэдээлэл байна. Цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд нийт 89 удаа зохион байгуулж, 2814 албан хаагч, иргэнийг оролцуулж, цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах арга хэмжээ авав.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн тайланд үндэслэн хэрэгжилтийг гаргахад нийт тендер шалгаруулалтын 49 хувь нь цахим тендер зарласан бол үлдэх 51 хувь нь уламжлалт хэлбэрээр зарласан дүнтэй байна. Дээрх хэрэгжилтийн дүнг гаргахдаа зөвхөн нээлттэй тендер шалгаруулалт болон зөвлөх үйлчилгээний тендерийг оруулсан харин тендер шалгаруулалтын онцгой журмаар зарлагдсан тендерийн тоог хасаж тооцсон. Төсвийн ерөнхийлөн захирагчдыг яамд, орон нутаг, бусад бие даасан гэсэн ангиллаар авч үзэхэд яамд нийт 858 цахим зарлах тендерээс 262, орон нутагт 1510 тендерээс 868, бусад бие даасан 200 тендерээс 127 тендерийг цахимаар тус тус зарласан байна. Үүнээс үзэхэд яамдын түвшинд цахим тендер шалгаруулалт зарлах

хувь хэмжээ хамгийн бага байна.

Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн тооцоотой газар, хуулийн этгээдийн 2018 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг төсвийн ерөнхийлөн захирагч нар нэгтгэн Сангийн яаманд ирүүлэхгүй байгаа нь Сангийн яамны тоо мэдээ Худалдан авах ажиллагааны цахим систем [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn)-д нийтэлсэн мэдээнээс зөрөхөд хүргэж байна. Цаашид системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зөвхөн нэг үүсвэрээс тоо мэдээлэл гаргаж, уг системээс явцын болон жилийн эцсийн тайланг нэгтгэж байх бодлогыг 2019 оноос эхлэн хэрэгжүүлнэ.

“Цахим шалгалт”-ын дэд системээр 411 удаагийн шалгалт зохион байгуулж, 7144 иргэн, албан хаагч шалгалт өгснөөс 4161 нь тэнцэж, тэдгээрт худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (А3) олгов. Тус дэд системд бүртгэлтэй, (А3) гэрчилгээтэй бүхий хүний тоо 12970-д хүрч 94 хувиар нэмэгдсэн байна. (Биелэлт 75 хувь)

4.1.4.2-1. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хянан шийдвэрлэх чиглэлээр журам боловсруулах /СЯ, ЗГХЭГ, ТӨБЗГ, 2018-2019/

Хүчин төгөлдөр хуулиар гомдлыг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх чиглэлээр журам боловсруулах эрхийг аливаа төрийн захиргааны байгууллагад олгоогүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Сонгон шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нь сонирхлын зөрчил үүсэх, хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг эрсдэл үүсгэхээс гадна төсвийн хөрөнгийг үрэлгэн, үр ашиггүй зарцуулах, чанарын шаардлага хангахгүй бараа, ажил, үйлчилгээ худалдан



авах, иргэд, хуулийн этгээдийг өрсөлдөх тэгш боломжоор хангахгүй, нэг буюу хэсэг бүлэг этгээдэд давуу байдал олгох сөрөг үр дагавартай. Иймд хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалтад “52.1.7. энэ хуульд заасны дагуу тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдол хянан шийдвэрлэх журам батлах;” гэж тусган эрх олгох зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна. Хууль батлагдсаны дараа гомдол хянан шийдвэрлэх журмыг боловсруулан Сангийн сайдын тушаалаар батлуулах ажлыг зохион байгуулна. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам худалдан авах ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох эрх олгосон тохиолдолд журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийг батлан мөрдүүлэх юм. (Биелэлт 50 хувь)

4.1.4.2-2. Иргэд тендерийн үйл ажиллагаа, явц байдлын талаар санал, бодлоо илэрхийлэх, харилцах, гомдол гаргах асуудлыг “Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем”-д тусгах /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендерт оролцогчийн гомдлыг хүлээн авах, тухайн гомдлын шийдвэрлэлтийг мөн цахим хэлбэрээр түгээх боломжийг бүрэн тусгасан. Төрийн албан хаагчдад тоон гарын үсэг олгогдоогүй байгаагаас шалтгаалж уг технологийн шийдлийг бүрэн ашиглах боломжгүй байна. 2018 онд Сангийн яаманд тендерт оролцогчийн гомдлыг албан бичгээр (уламжлалт хэлбэрээр) хүлээн авсан бөгөөд тухайн гомдолтой холбоотой тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн материалыг цахим системээс татан авч, хянан шийдвэрлэж байна. Иргэд, олон нийт, тендерт оролцогч, захиалагч байгууллагын төлөөлөлд худалдан авах ажиллагаатай холбоотой шуурхай үйлчилгээ үзүүлэх,

зөвлөгөө өгөх чиглэлээр байгууллагын албан утас, албаны цахим хаягаар ирсэн санал хүсэлтэд шуурхай хариулахаас гадна төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-д LiveHelpDesk-ийг ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлэв. Ингэснээр ажлын бус цагаар үйлчлүүлэх, цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөөг цаг алдалгүй шуурхай авах, иргэд, олон нийт, тендерт оролцогч, захиалагч байгууллагын үлдээсэн цахим зурвас, захидал, асуултад цахим шуудангаар хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлэн зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллаж байна.

Мөн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэгдсэн тендерийн урилгыг олон нийтийн сүлжээний нийтлэг хэрэгсэл болох твиттер хуудсанд дамжуулан нийтлэх боломжийг бий болгон иргэд, олон нийтэд шуурхай мэдээлэл түгээх арга хэлбэрийг нэмэгдүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар цахим худалдан авах ажиллагаатай холбоотой байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь барагдуулж ажиллав. 2018 онд цахим системээр ирүүлсэн 4531 нийлүүлэгч байгууллагын, 510 захиалагч байгууллагын бүртгүүлэх хүсэлт, it@procurement.gov.mn цахим шуудангаар ирүүлсэн 5354 хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. Албан бичгээр бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн 688 хүсэлт, өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэв. Өмнөх онтой харьцуулахад албан бичгээр ирүүлсэн санал, өргөдөл, хүсэлт 652, цахим шуудангаар ирүүлсэн санал, хүсэлт 4547-оор тус тус нэмэгдсэн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр давхардсан тоогоор 23312 үйлчилгээг үзүүлж, 15299 удаа зөвлөгөө, мэдээллийг өгчээ. <https://tender.gov.mn>-д нийтлэг асуулт, хариултын булан (online chat) нээж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүргэх мэдээллийн шуурхай хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, 603 онлайн асуултад хариулт өгч, үйлчлүүлэгчтэй харилцан мэдээлэл солилцсон байна. (Биелэлт 50 хувь)

4.1.4.2-3. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдол мэдээллийг хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх /СЯ, ТӨБЗГ, 2017-2019/:

Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг цахим хуудсаараа дамжуулан сар бүр мэдээлж байна. Сангийн яаманд 2017 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 813 гомдол ирүүлснийг тендерт оролцогчдоор дамжуулан 453 хууль бус шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

2017 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулагдсан тендер шалгаруулалттай холбоотой давхардсан тоогоор нийт 35 гомдлыг ирүүлсэн ба нийт хянан шийдвэрлэгдсэн гомдлын 68.8 хувь нь захиалагчийн гаргасан шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 133 төсөл, арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 161 тендер шалгаруулалт зохион байгуулж, давхардсан тоогоор 888 аж ахуйн нэгж тендерт оролцсон. Тендерт оролцогч 68 компаниас давхардсан тоогоор 93 (нийт оролцогчдын 10.5 хувь) гомдлыг холбогдох байгууллагад гаргасан. Нийт гомдлын 54 буюу 58.06 хувь нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр үндэслэлтэй гэж хянагдсан, 33 нь буюу 35.4 хувь нь дахин үнэлэх буюу өөрчлөлт оруулах, 4 буюу 4.3 хувь нь хүчингүй болсон, 2 буюу 2.24 хувь нь шийдэгдээгүй, хянагдаж байна. Сангийн яаманд хянагдаж дахин үнэлэхээр шийдвэрлэгдсэн 28 (83.8 хувь) гомдолд тодруулга авч өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн 20, шийдвэрийг өөрчилсөн 8 байгаа бол 5 (16.2 хувь) гомдолд хамаарах тендерийг дахин үнэлэхээр шийдвэрлэгдсэн. Нийт хянан шийдвэрлэгдсэн гомдлын 58.1 хувь нь захиалагчийн гаргасан шийдвэр

үндэслэлтэй гэж хянагдсан байгаа бөгөөд гомдол шийдвэрлэгдэх хуулийн хугацаанд тухайн тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулах ажил хүлээгдэж, хугацаа алдах байдал үүссэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан гомдол, түүний шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээнд тусган холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлж байна. Сангийн яам гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланд дурдаж Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт үнэлгээний хороонд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллахыг даалгасан. (Биелэлт 45 хувь)

4.1.4.3-1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээг зохистой тогтоох, түүнд хяналт тавих, өөр хоорондоо зөрүүтэй авлига гарах нөхцөл бүрдүүлэх хуулийн заалтыг хянан үзэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох /СЯ, 2017-2020/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 онд дараах журам, тендерийн жишиг баримт бичгийн төсөлд тусгах санал боловсруулан, Сангийн яаманд хүргүүлсэн:

- Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл;
- Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний тендерийн жишиг баримт бичгийн төсөл;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын төсөл;
- Цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулах журмын төсөл;
- Худалдан авах ажиллагааны урилга, үр



дүнг зарлан мэдээлэх журмын төсөл.

Эдгээрээс Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар “Ерөнхий гэрээ байгуулах журам”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Сангийн яамнаас боловсруулж Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг тэлэх зохицуулалтыг оруулаад байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын худалдан авах ажиллагааны жилийн тайлан, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тендер шалгаруулалттай холбоотой өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөлт хийхдээ харьцуулалтын босго үнэд багтаах зорилгоор төсөл, арга хэмжээг жижиглэн хуваадаг, олон тооны ижил нэр төрлийн төсөл, арга хэмжээ болгон батлуулдаг асуудал улсын хэмжээнд нийтлэг байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-д “техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх” гэж заасны дагуу тодорхой тооны этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгддэг бөгөөд уг аргаар зарлагдаж буй худалдан авах ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл бүрдсэн байх боломжтой гэж дүгнэж байна. Иймд хуулийн энэхүү заалтыг хүчингүй болгох, мөн тендер шалгаруулалт эхний удаа амжилтгүй болсны дараа дахин харьцуулалтын аргаар үнийн санал авдаг байх, цахим системд үнийн санал авах урилгыг иргэд, олон нийтэд мэдээлдэг тогтолцоонд шилжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлж, Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгуулсан. (Биелэлт 70 хувь)

4.1.4.3-2. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгах /СЯ, 2017-2020/

2017 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <http://pcsp.gov.mn> цахим хуудас болон төрийн худалдан авах ажиллагааны <https://tender.gov.mn> системд тус тус байршуулж, олон нийтээс санал авч, төсөлд тусгасан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг аймгуудын Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд, яамдын холбогдох албан тушаалтнууд, төрийн бус байгууллагын төлөөллийг тус тус оролцуулан 2017 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулсан. Олон нийтийн хэлэлцүүлэгт нийт 80 гаруй хүн оролцсон. 2018 онд Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг орон даяар зохион байгуулж 21 аймгийн орон нутгийн өмчийн газар холбогдох 30 гаруй мэргэжилтэн, 830 иргэн, 180 аж ахуйн нэгжийн саналыг тусгаж боловсруулсан. 2018 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар “Цахим тендер зохион байгуулах журам”, “Тендерийн жишиг баримт бичиг”-т холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа олон нийтийн саналыг авч тусган, Сангийн яаманд хүргүүлэв. (Биелэлт 40 хувь)

4.1.4.3-3. “Цахим худалдан авах ажиллагаа”-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2020/

Зөрчлийн хуулийг батлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулан дээрх хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг Зөрчлийн хуулиар зохицуулахаар тусгасан боловч Зөрчлийн хуульд холбогдох заалт ороогүй тул хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх боломжгүй байдлыг үүсгэсэн. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.7-т заасан Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд урилга, үр дүн, мэдээллээ бүрэн оруулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох заалт хүчингүй болсон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дээрх заалтад дурдагдсан “Цахим тендер зохион байгуулах журам”-ын төсөлд тусгахаар холбогдох судалгаа хийж, хариуцлагын тогтолцоог сайжруулах асуудлыг Сангийн яаманд хүргүүлсэн саналд тусгасан. Одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасны дагуу “Цахим худалдан авах ажиллагаа”-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангах, хэрэгжүүлээгүй төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулиар хариуцлага ногдуулах болно. (Биелэлт 40 хувь)

4.1.4.3-4. Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.14-т заасны дагуу төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-ээр дамжуулан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Уг жагсаалтад орсон аж ахуйн нэгж нь тухайн хугацаанд цахим системээр дамжуулан аливаа тендер шалгаруулалтад оролцох боломжгүй байхаар цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн. Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг шинээр үүсгэх, энэ талаарх тогтолцоог бүрдүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлыг судалж, холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дээрх харилцааг зохицуулахаар ажиллаж байна. (Биелэлт 20 хувь)

4.1.4.4-1. Шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох /СЯ, 2017-2019/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-д тендер шалгаруулалтын онцгой журмын гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулах ажлын урилга, үр дүнг мэдээлэх, тендерт оролцогчоос холбогдох санал, материалыг цахим хэлбэрээр хүлээн авах



техникийн боломжийг бүрдүүлсэн. Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх аргачлал, шалгуурыг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажил хийгээгүй байна. (Биелэлт 10 хувь)

4.1.4.4-2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах /ҮХГ, 2017-2018/

Үндэсний хөгжлийн газраас 2017 онд Зардал, ашгийн тооцоолол хийх аргачлал журам, Уралдаант шалгаруулалтын журам, Санал үнэлэх журам, Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мониторингийн журам, Концессын шууд гэрээ байгуулах журмыг тус тус боловсруулахаар төлөвлөсөн. Энэ талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

(Биелэлт 10 хувь)

4.1.4.4-3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах /ҮХГ, 2017-2019/

Үндэсний хөгжлийн газар 2017 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байсныг 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Мөн Азийн хөгжлийн банктэй хамтран гадаадын болон дотоодын зөвлөх сонгон ажиллуулж, хуулийн төсөл, үзэл баримтлалын эхний хувилбарыг боловсруулав. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн үр дагаварт мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зайлшгүй шаардлагатай бөгөөд байгууллагын 2018 оны төсөвт тус судалгааг хийлгэх зардал тусгагдаагүй байснаас ажлын гүйцэтгэл удааширсан. Иймд 2019 оны төсөв болон Худалдан

авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тул мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарсны дараа холбогдох журмуудад болон аудитын тайлангаар зөвлөмж болгосон журмуудад өөрчлөлт оруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.4.5-1. Гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх /СЯ, 2017-2019/

Сангийн яам Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дээрх харилцааг зохицуулахаар ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11 дүгээр заалтад “521.3.Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” нэмэлтээр оруулахаар төсөлд тусгасан. Гэрээ үүргээ биелүүлээгүй этгээдийн талаар хэрхэн олон нийтэд шуурхай, бүрэн мэдээлэх тогтолцоог тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журамд нарийвчлан тусгах болно. (Биелэлт 40 хувь)

4.1.4.5-2. Гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах албадлагын арга хэмжээ авах эрхийг төрийн байгууллагад олгох, хариуцлагыг чангатгах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх /СЯ, 2017-2019/

Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-т заасан гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх заалт хүчингүй болж, хууль зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр болсон. Гэтэл Зөрчлийн тухай хуульд уг асуудал тусгагдаагүйгээс үүдэн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэхэд хүндрэл учирсан. Иймд Сангийн яам тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батлахаар төсөлд тусгасан. Хуулийн төсөл батлагдсны дараа холбогдох журмыг Засгийн газраар батлуулна. (Биелэлт 40 хувь)

4.1.4.5-3. Тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах/СЯ, 2017-2019/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр тусгасан байна. Иймд тухайн тендерт оролцох эрхийг хязгаарласан этгээдийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр, гэмт хэргийн шинжтэй тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлагыг хүлээлгэхээр зохицуулсан байна. Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дээрх харилцааг зохицуулахаар ажиллаж байна. (Биелэлт 40 хувь)

Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 5 дахь зорилтын хүрээнд нийт 17 үйл ажиллагаа, 34 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2017 онд 22 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд нийт 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.5.1-1. Шүүгч, прокурорын сонгон шалгаруулалт, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулсан, дэвшүүлсэн, шагнаж урамшуулсан, чөлөөлсөн, хариуцлага тооцсон байдалд судалгаа хийж, дүнг олон нийтэд мэдээлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Монгол Улсын шүүхийн тайлан-2017”-д шинээр томилогдсон, сэлгэн болон шилжин ажилласан, дээд шатны шүүхэд дэвшин томилогдсон, төрийн одон медалиар шагнагдсан, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчдийн судалгаа шинжилгээг нийтэлж, өөрийн вэб хуудсанд байрлуулан, хуулийн төв байгууллага, хууль зүйн их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад түгээсэн болно. Шүүгчийн хүний нөөцтэй холбоотой бүх мэдээллийг www.judcouncil.mn цахим хуудсанд тухай бүр нээлттэй, ил тод мэдээлж байна. Зарим мэдээллийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлсэн байна. Тухайлбал, Шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн талаарх судалгааг гаргаж, хэвлэлд нийтэлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс сар бүр зохион байгуулдаг “Нээлттэй шүүх” хэвлэлийн бага хурлаар “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ын талаар Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын албанаас мэдээлсэн ба тус хэвлэлийн бага хурал болон бусад мэдээ мэдээллийг нийт 46 хэвлэл мэдээллийн байгууллагын 67 сэтгүүлч сурвалжилж олон нийтэд хүргэсэн



байна.

Улсын ерөнхий прокурорын 2011 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 46 дугаар тушаалаар “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”-ыг батлан гаргаж, уг журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Прокурорын байгууллагын хууль шинээр батлагдсантай холбогдуулан “Прокурорыг албан тушаалд дэвшүүлэх, бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журам”, “Дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, үр чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус төслийг боловсруулан батлуулахад бэлэн болгоод байна.

2018 онд холбогдох хууль, тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалыг үндэслэж прокурорын байгууллагын хэмжээнд 2018 онд 41 прокурор, 55 туслах ажилтныг шинээр, 161 прокурор 19 туслах ажилтныг шилжүүлэн болон сэлгүүлэн томилуулж 23 прокурор, ажилтныг дэвшүүлэн ажиллуулсан байна. Прокурорын томилолтын шилжилт хөдөлгөөн (сэлгэн болон шилжүүлсэн, шинээр томилсон, халсан, чөлөөлсөн, шагнал, урамшуулал, хариуцлага тооцсон)-тэй холбоотой ажлын дүн, мэдээг байгууллагын үйл ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн ажлын тайланд нэгтгэн оруулж, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажиллаж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудаст тавьж, мөн жил бүр гаргадаг “Прокурорын байгууллага тухайн онд” гэсэн эмхэтгэлд тусган хэвлүүлж, иргэд олон нийтэд хүргэж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.5.1-2. Шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах журам, шалгуурыг шинэчлэн боловсруулах, шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг дээшлүүлэх /ШЕЗ, УЕПГ, 2017-2018/

Шүүхийн тухай багц хууль 2012 онд батлагдаж, 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш Шүүгчийг сонгон шалгаруулах журам 4 дэх удаагаа

шинэчлэгдэв (Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 165, 2015 оны 18, 2017 оны 103, 2018 оны 13 дугаар зарлиг). 2018 оны Шүүгчийг сонгон шалгаруулах журамд дараахь шинэ заалтууд тусгагдсан:

-Шүүгчийн сул орон тоо богино хугацаанд нөхөгдөх;

-Анхан болон хяналтын шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалт дотроо суурь болон тусгай шалгалтуудын төрлөөс бүрдсэн 2 багц шалгалтын хүрээнд явагдах болсон. Суурь шалгалтаар ёс зүй зан төлөвийг, тусгай шалгалтаар мэдлэг үр чадварыг шалгах бөгөөд суурь шалгалтад 60 ба түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчид тусгай шалгалтад оролцох эрхтэй болсон;

-Анхан шатны шүүхийн шүүгчээр томилогдсоны дараа шинээр томилогдсон шүүгч нарт зориулсан сургалтад хамрагддаг байсан бол шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтад тэнцсэн нэр дэвшигч “бэлтгэл сургалт”-д хамрагдаж байж Шүүхийн ерөнхий зөвлөлийн ганцаарчилсан ярилцлагад оролцох болсон;

-Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүд нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийн талаар биечлэн судалж, дүгнэлт гаргадаг болсон.

Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээний санал боловсруулах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар “Шүүгчийн хараат бус байдалд халдсан тухай гомдлыг шийдвэрлэх журам”-ыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан. Уг журмын хүрээнд шүүгчээс ирүүлсэн гомдлыг бүртгэх, нягтлан шалгах, тайлбар, залруулга гаргах, шүүгчтэй өөртэй нь зөвшилцсөнөөр шүүхэд төлөөлөх, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах зэрэг ажиллагааг хийх бөгөөд шүүгчийн хараат бус байдал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулна. Анхан болон давж

заалдах шатны шүүхийн 116 шүүгчээс шүүхийн дотоод хараат бус байдлыг тодорхойлох, дотоод хараат бус байдал алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд урьдаас бэлтгэсэн асуулгыг Google forum ашиглан, интернетээр авч, нэгтгэн дүгнэсний зэрэгцээ шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах төдийгүй хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор шүүгчдийн хамаарал бүхий этгээдийн судалгааг гаргасан.

Прокурорын байгууллага дээд шатны прокуророор ажиллах санал, хүсэлт гаргасан прокурорын мэдлэг, ур чадварыг үнэлж, дүгнэх журмыг шинэчлэн батласнаар прокурорын байгууллагын удирдах албан тушаалын ажилтнуудын эрх зүйн онолын болон ажил хэргийн мэдлэг, удирдах ур чадвар, хувь хүний сахилга, ёс зүйг зохих шалгуур үзүүлэлтээр дүгнэж томилох асуудлыг шийдвэрлэхээр болж байгаа нь тэдгээр ажилтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хараат бусаар ажил үүргээ гүйцэтгэх боломжтой болсон. Цаашид прокуророор томилогдох албан тушаалтан, захиргааны болон прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтныг сонгон шалгаруулахад мөрдөх журам, шалгуурыг боловсронгуй болгох ажлыг тасралтгүй зохион байгуулж ажиллахаар төлөвлөж байна. Прокурорын туслах ажилтнаар томилогдох хүсэлт гаргасан ажилтнуудыг сонгон шалгаруулах журмыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлан мөрдүүлж байна.

Одоогоор Монгол Улсын ерөнхий прокурорын 2011 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 46 дугаар тушаалаар баталсан “Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”, 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Дээд шатны прокуророор ажиллах прокурорын мэдлэг чадварыг үнэлж, дүгнэх журам”-ыг мөрдөж байна. Прокурорын байгууллагын тухай хуулийг 2017 онд шинэчлэн баталсан ба хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Прокурорын мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн

байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг Улсын ерөнхий прокурор батална.” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаад байна. (Биелэлт 50 хувь)

4.1.5.1-3. Шүүгчид нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзах үндэслэлийг хуулиар тодорхой болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2019/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Шүүхийн багц хуулийн /Шүүхийн захиргааны тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай/ төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс хуулиудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хийлгүүлсэн. Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж дууссан. Хуулийн төслүүдэд нэмэлт боловсруулалт хийж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.1-4. Шүүгчид нөлөөлөх үйлдэл хийсэн, нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, нөлөөллийн мэдүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ШЕЗ, 2018-2021/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан Шүүхийн багц хуулийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)



4.1.5.1-5. Шүүгч, прокурорын ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хороо, Прокурорын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах, Ёс зүйн хорооны шийдвэр шүүхийн хяналтад байгааг өөрчлөх/ШЕЗ, УЕПГ, 2017-2020/

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүгчийн Ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход шүүгч, эрдэмтэн судлаачдын санаа бодлыг тусгах, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор “Шүүгчийн ёс зүй ба сахилга” олон улсын бага хурлыг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулж, хуралдаанд оролцогчдын илтгэл, санал, зөвлөмж, дүгнэлтийг нэгтгэн зөвлөмж гаргаж олон нийтээр хэлэлцүүлж байна. Мөн “Шүүгчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо” судалгааны асуулгыг 2018 оны 3 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд нийт шүүхийн шүүгч, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдээс авч нэгтгэн дүгнэсэн нь хууль, дүрмийг боловсруулахад үр нөлөөгөө өгнө.

Шүүгчийн ёс зүйн гомдол шалгаж, шийдвэрлэх ажиллагааг шуурхай болгох зорилгоор Шүүхийн Ёс зүйн хорооны дүрмийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн боловч Ерөнхийлөгчийн Тамгын газрын 2017 оны ТГ/661 дугаар албан бичгээр “Шинэчилсэн дүрмийн төсөлд ёс зүйн хорооны хуралдааны дэг буюу гомдлыг хянан хэлэлцэх болон нийт гишүүдийн хуралдааны дэгийн зохицуулалтыг хасахаар тусгасан нь шүүхийн ёс зүйн хорооны үйл ажиллагаанд иргэдийн итгэх итгэлийг бууруулах, улмаар хуралдааны дэг алдагдах сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй байна” гэсэн үндэслэлээр буцаасан. Иймд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шүүгчийн хариуцлагын тогтолцоог сайжруулах бодлоготой уялдуулан хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаар судалгааны ажил хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, нөлөөллийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 69 дүгээр захирамжаар Шүүгчийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн Захиргааны тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

“Прокурорын сахилгын дүрэм”-ийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар зарлигаар батлуулсан ба энэ дүрэмд заасан үндэслэлийн дагуу прокурорт сахилгын шийтгэл оногдуулж хариуцлага тооцон ажиллаж байна. Улсын ерөнхий прокурорын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/16 тоот тушаалаар прокурорын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. (Биелэлт 40 хувь)

4.1.5.1-6. Шүүх хуралдаанд нууцтай холбоотой асуудал хэлэлцэх хэсгийг хаалттайгаар бусад хэсгийг нээлттэй явуулахаар эрх зүйн орчинг бүрдүүлэх /ШЕЗ, ХЗДХЯ, 2018-2019/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан Шүүхийн багц хуулийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.2-1. Ерөнхий шүүгчийг томилох шалгуур, журмыг шинэчлэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2017-2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 2 дугаар сарын 2-ны 13 дугаар зарлигаар “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталсан. Анхан болон Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтын шалгалтыг өөрчилж, зөвхөн тухайн шатны Ерөнхий шүүгчээр ажиллах мэдлэг, үр чадварыг шалгахаар журамлан мөрдөж эхэллээ.

Ерөнхий шүүгчийг томилох чөлөөлөх

шалгуур, журмыг Монгол Улсын Үндсэн хуулиар зохицуулдаг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналд “Бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчийг шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгоно. Ерөнхий шүүгчийг нэг удаа улируулан сонгож болно” гэж тусгуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2017 оны 1/524 тоот албан бичгээр хүргүүлж, төсөлд тусгагдсан болно. (Биелэлт 30 хувь)

4.1.5.3-1. Прокурор, шүүгчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг оруулах /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн ёс зүйн сургалтыг үндсэн сургалт болгосон бөгөөд сургалтын сэдэв бүрт ашиг сонирхлын зөрчлөөс шүүгч ангид байх, олон нийтэд буруу ойлголт төрүүлэхгүй байх агуулгыг тусгасан. 2017 онд батлан хэрэгжүүлсэн Шүүгчийн ёс зүйн хөтөлбөрийн агуулгад “Шүүгчийн нийтийн албанд баримтлах ёс зүй”, “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил”, “Ашиг сонирхлын зөрчил”, “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам”, “Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам” зэрэг сэдвүүдийг багтаасан болно. 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд төлөвлөгдсөн шүүгчийн сургалт, шинэ шүүгчийн болон шүүгч бэлтгэх сургалт, түүнчлэн Шүүгчийн ёс зүйн сургалтуудын хөтөлбөрийн агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх асуудлыг тогтмол тусгаж хэрэгжүүлж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 84 дүгээр тогтоолоор “Шүүхийн сургалтын үндсэн хөтөлбөр” нэртэйгээр шинэчлэн баталсан бөгөөд тус хөтөлбөрөөр шүүгч “Үндсэн хууль ба хүний эрх”, “Шүүгчийн ёс зүй” сургалтад зайлшгүй жил бүр хамрагдах бөгөөд шүүгчийн ёс

зүйн сургалтын агуулгад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгыг тусгасан. 2018 онд Шүүгчийн ёс зүйн сургалтаар бүх шатны шүүхийн нийт 510 шүүгчдийг оролцуулсан. Мөн Авлигатай тэмцэх газартай хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг сургагч багш нарыг бэлтгэж, бүх шатны шүүхийн нийт 510 шүүгчийг тус сургалтад хамруулсан.

Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/46 тушаалаар “Прокурорын сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулсан бөгөөд сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхан болон үргэжилсэн шатны сургалт тус бүрд 2-4 цагийн сургалт буюу нийтдээ 12 цагийн сургалтыг оруулсан бөгөөд “Авлигын гэмт хэргийг шалгахад анхаарах асуудал” сэдвээр сургалтын гарын авлага, модулийг боловсруулсан байна. 2017-2018 онд прокурорын болон туслах ажилтны анхан шатны болон үргэлжилсэн сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 70 прокурор, ажилтныг 12 цагийн сургалтад хамруулав. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХАСХОМ болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар прокурорын байгууллагын хэмжээнд цахим сургалтыг жил бүр зохион байгуулж байна. (Биелэлт 60 хувь)

4.1.5.3-2. Шинээр томилогдсон шүүгч, прокурорт сургалтын хөтөлбөрийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалтыг зохион байгуулах/ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Шинээр томилогдсон шүүгчдийн “Шүүгчийн анхан шатны сургалт”-ыг 2017 оны 6 дугаар сард зохион байгуулсан бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил”, “Шүүгчийн албан үүргээс бусад хувийн амьдралд баримтлах зарчим”, “Шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдох тохиолдол” зэрэг сэдвүүдийг



хөтөлбөрт оруулсан байна. 2018 онд “Шүүгчийн сонгон шалгаруулалтын журам” шинэчлэн батлагдаж, шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн бүх нэр дэвшигчдийг “Шүүгчийн бэлтгэл сургалт”-д оролцуулахаар болсон. Үүний дагуу 2018 оны 7 дугаар сард “Шүүгч бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулж, шүүгчээр томилогдохоор нэр дэвшиж буй 50 хуульчийг сургалтад хамруулж, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх онол, практикийн мэдлэг олгосон.

Улсын ерөнхий прокурорын газраас 2017 онд шинээр томилогдсон харьяа прокурорын газрын 26 прокурорт “Авлигын гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр 4 цагийн сургалт явуулсан байна. Энэ чиглэлээр Азийн хөгжлийн банкны төслөөр санхүүжүүлж байгаа сургагч багш бэлтгэх болон харьяа прокурорын газрын прокуроруудыг уг сургалтанд хамруулах ажлыг хамтран зохион байгуулахаар хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг жил бүр зохион байгуулах зорилгоор 2018 оны сургалтын төлөвлөгөөнд тусган, шинээр томилогдсон прокуроруудын “Прокурорын анхан шатны сургалт”-ыг 2018 оны 6 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулж сертификат гардууллаа. Уг сургалтад 2 жил хүртэлх хугацаанд аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын прокурорын газруудад ажиллаж байгаа шинээр томилогдсон 27 прокурор хамрагдсан. Мөн Улсын ерөнхий прокурорын орлогчоор ахлуулсан баг “Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал” сэдэвт сургалтын модуль, хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах болон сургагч багш бэлтгээд байна. Сургалтын хүрээнд шүүхээс энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол, магадлалыг авч, сан бүрдүүлэн сургалтад ашиглаж байна (Биелэлт 40 хувь)

4.1.5.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах /АТГ, 2017-2021/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцлийг арилгах талаар мөрдөгчийн мэдэгдлийг 2017 онд 40 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлснээс 27 мэдэгдлийн хариуг хүлээн авсан байна. Нийт хүргүүлсэн мэдэгдлийг байгууллагаар нь ангилж үзэхэд цагдаагийн байгууллагад 11, аймгийн Засаг даргад 7, төрийн өмчит хувьцаат компанид 4, сумын Засаг даргад 4, сайд нарт 3, татварын байгууллагад 3, гаалийн байгууллагад 2, нийслэлийн агентлагт 1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 13, Зэвсэгт хүчний жанжин штабт 1, Прокурорын байгууллагад 1, дүүргийн ИТХ-д 1 мэдэгдэл тус тус хүргүүлсэн ба Цагдаагийн ерөнхий газрын даргад Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүний хэмжээнд 2017 онд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан, нөхцөлийг судлан, цаашид бие бүрэлдэхүүний хэмжээнд анхаарах асуудлын талаар тусгайлан мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна. 2017 онд хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хариуг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй 8 мэдэгдлийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд /6.1.4/ шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын хэргийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг тусгасан бөгөөд энэ дагуу 2011–2015 онд авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр гаргасан 162 шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авч дүн шинжилгээ хийн холбогдох тайланг боловсруулсан болно. Нийт 347 шүүгдэгчид холбогдох 162 шийдвэрийн 112 нь анхан шатны, 31 нь давж заалдах шатны, 18 нь хяналтын шатны шийдвэр байна. Нийт 347 шүүгдэгчийн

47 хувь буюу 162 шүүгдэгчид ял оноосон байна. Тухайлбал, хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн 78 ялтанд 1-3 жилийн хорих ял, хээл хахууль авах гэмт хэрэг үйлдсэн 43 ялтанд 1-6 жилийн хорих ял, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг үйлдсэн 32 ялтанд 1-7 жилийн хорих ял ногдуулсан байх бөгөөд 101 ялтны ялыг тэнсэн харгалзаж, 47 ялтны ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ. Цашид авлига, албан тушаалын гэмт хэргийн 2007 оноос хойших хугацааны шийдвэрийг бүхэлд нь багтаасан сантай болох, тэдгээр шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглахаар төлөвлөн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мөрдөгчийн мэдэгдлийг 2018 онд 29 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлснээс 12 мэдэгдлийн хариуг хүлээн авсан. Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар мөрдөгчөөс 22 байгууллагад хүргүүлсэн мэдэгдэлд дурдсан нөхцөл байдал бодитой арилсан эсэхийг хянан үзэх, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан. 2018 оны сүүлийн хагаст мөрдөгчийн 8 мэдэгдлийн биелэлттэй газар дээр нь танилцахад мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд ирүүлэхгүй байх, мэдэгдлийн мөрөөр авсан арга хэмжээ нь ёс төдий байна. (Биелэлт 50 хувь)

4.1.5.4-2. Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх /Real name financial Transaction act/ эрх зүйн орчинг бий болгох /СЗХ, 2017-2018/

Санхүүгийн зохицуулах хорооноос 2016, 2017 онд гадаадын орнуудаас Монгол Улсад, Монгол Улсаас гадаадын орнуудад хийсэн гуйвуулгын дүн, тоог валютын

төрөл тус бүрээр банк бус санхүүгийн байгууллагуудаас авч нэгтгэсэн. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл /MON9152/-ийн хүрээнд олон улсын болон үндэсний зөвлөхийн гаргасан аргачлалын дагуу зайнаас эрсдэлийн тооцооллыг гүйцэтгэсэн. Газар дээрх хяналт шалгалт хийгдэж буй даатгалын компаниудад “Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ын эрсдэлд суурилсан хяналтын асуулгын болон үнэлгээний хуудасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийсэн болно. Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны цахим хуудсаар мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн гэмт хэрэг үйлдсэн, үйлдэж болзошгүй этгээдүүдийн жагсаалтыг мэдээлдэг боллоо. Ингэснээр санхүүгийн зах зээлд оролцогч, иргэд, хуулийн этгээдүүдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах боломжийг бүрдүүлэв. Системүүдийг нэгдсэн нэг ERP систем болгоход шаардагдах хүчин зүйлсийн судалгааны тайланг хийж дуусгасны зэрэгцээ судалгааны үр дүнд олон улсын стандартад нийцсэн нийт 14 дэд системээс бүрдсэн, өөр хоорондоо мэдээлэл солилцох боломж бүхий эрсдэлд суурилсан хяналт шалгалтын нэгдсэн системийн загварыг гаргасан болно. Олон улсын хөрөнгө оруулалтын банктай байгуулсан техникийн туслалцааны харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус банкны санхүүжилтээр Бүгд Найрамдах Словак Улсын “Эрнст энд Янг” компанитай хамтран салбарын хэмжээнд мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлж, холбогдох дүрэм журмуудыг боловсронгуй болгох, шинэчлэх төслийн ажлыг гүйцэтгэв. 2018 онд Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 186 ХЗХ, 460 ББСБ, 51 ҮЦК, 16 ХОМК, 71 даатгалын байгууллагуудад санхүүгийн аливаа гүйлгээг хүлээн авагчийн жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх



талаар мэдээлж ажилласан. Банкнаас бусад санхүүгийн салбарын оролцогчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигын мөнгийг бусдын нэрээр авах, мөнгө угаах, залилан мэхлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн илрүүлэлтийг сайжруулах чиглэлээр “Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд Хорооны албан ёсны цахим хуудсанд байршуулан мэргэжлийн холбоод, Монголын хөрөнгийн бирж ТӨХК болон салбарын оролцогчдын саналыг авч байна. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу салбарын зохицуулалтын журамд оруулж болох зүйл заалтын талаар санал боловсруулаад байна.

Санхүүгийн аливаа гүйлгээг хэлцэл хийгч талын нэрээр хийх зохицуулалтыг хуульчлан бий болгодог “Real Name Financial Transaction Act”-ыг олон улсад батлан мөрддөг. Энэ нь аливаа гүйлгээг тухайн хэлцлийн дагуу тухайн мөнгө, хөрөнгө, эрхийг хүлээн авах жинхэнэ этгээдийн нэрээр тухайн гүйлгээ хийгдсэн байхыг хуульчлах тухай ойлголт юм. Энэ нь оролцогчдын санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигын мөнгийг бусдын нэрээр авах, мөнгө угаах, залилан мэхлэх, санхүүгийн луйвар хийх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн илрүүлэлтийг сайжруулах ач холбогдолтой тул эрх зүйн орчинг бий болгох зорилгоор Санхүүгийн аливаа гүйлгээг жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх тухай хуулийн төслийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хамтран боловсруулахаар “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан.

Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж, зээлийн хоршооны, үнэт цаасны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын зах

зээлийн мэргэжлийн холбоодтой хамтран “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумыг зохион байгуулж ажилласан. Комплаенс бол санхүүгийн байгууллагын засаглал, дотоод хяналт, мэргэжлийн ёс зүй, мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, зогсоох тогтолцоог илэрхийлсэн багц ойлголт юм. Санхүүгийн салбарын аж ахуйн нэгжүүд комплаенсыг нэвтрүүлээгүй, аль эсвэл холбогдох ажилтан томилоогүйгээс шалтгаалан байгууллагын төдийгүй зах зээлийн нэр хүндийг унагах сөрөг үр дагаврыг авчирдаг. Тиймээс “Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт, шалгалт хийх журам”-ыг баталж үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна

Засгийн газрын 2017 оны 327 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 4.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан нэгж байгуулахыг үүрэг болгосон. Энэхүү чиг үүргийн хүрээнд Хорооны ажлын албаны даргын 2018 оны 251 дүгээр тушаалаар мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан нэгж байгуулагдан ажиллаж байна. Одоогийн төлбөр төлж байгаа үйл явц, түүнд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн тогтолцоо дээрх шаардлагын дагуу хүлээн авагчийн иргэний үнэмлэх дээрх нэр, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх нэрээр шилжиж байна. (Биелэлт 40 хувь)

4.1.5.5-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах, иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл утсаар өгөх боломжийг бүрдүүлэх /АТГ, 2017-2022/

Байгууллагын хэмжээнд 1800-1969 утсаар мэдээлэл авах ажлыг эхлүүлэн үйл

ажиллагааг нь тогтмолжуулж байна. Энэ ажлын хүрээнд “Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах 1800-1969” дугаарын утсыг сурталчилсан 3 төрлийн видео шторкийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх студи, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын гадна талбайд байрлах цахим мэдээллийн самбар зэрэгт байршуулан сурталчиллаа. “Скайтел”, “Мобиком”, “Жи Мобайл”, “Юнител” зэрэг үүрэн телефоны оператор компанийн маркетингийн албатай хамтран текст бүхий сурталчилгааг хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгууллаа. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн гомдол, мэдээлэл хүлээн авах 1800-1969 дугаарын утсаар ирсэн бүх дуудлагыг бүртгэх болон бусад хөгжүүлэлтийг хийснээр шинэчилсэн програмыг ашиглалтад оруулж, 2017 оны 7 дугаар сараас эхлэн бүртгэлийг уг програмд оруулсан. Байгууллагын хэмжээнд 2017 онд иргэд, байгууллагаас 1324 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 658 гомдол, мэдээлэл хүлээн авч хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн бол 2018 онд иргэд, байгууллагаас 1887 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 858 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал өргөдөл, гомдол, мэдээлэл 563 нэгжээр буюу 42.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 200 нэгжээр буюу 30.4 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна. Дурдсан хугацаанд Авлигатай тэмцэх газар нь нийт 294 гомдол, мэдээллийг 1800-1969 дугаарын утсаар дамжуулан хүлээн авсан байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/187 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Хууль зүйн

үндэсний хүрээлэнгээр үнэлгээ хийлгүүлж байгаа бөгөөд уг хуулийг Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулахаар судалгаа хийж байна.

Цагдаагийн ерөнхий газар 126, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1800-1890, Архивын ерөнхий газар 1800-1205, Хууль зүйн туслалцааны төв 1982 тусгай дугаар ажиллуулан иргэдээс санал, гомдол, мэдээлэл хүлээн авч, зөвлөгөө өгдөг. Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын 126 тусгай дугаарт 260 өргөдөл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 1800-1890 тусгай дугаарт 38662 иргэн хандсан байна. (Биелэлт 90 хувь)

4.1.5.5-2. Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2021/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.5.6-1. Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2019/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлыг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “МОНЦАМЭ” мэдээллийн агентлаг, “Глоб интернэшнл төв” зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулж, санал хүсэлтийг авч, хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран хууль эрх зүйн чиглэлээр дагнан бичдэг сэтгүүлчдийн дунд “Эрх зүйн сургалт,



өдөрлөг"-ийг 2018 онд зохион байгуулсан. Мөн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн клуб байгуулж, клубээс мэдээлэгчийг хамгаалах талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэв. Эрүүгийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгээс хуулийн төсөлд ирүүлсэн саналуудыг тусган гарсан саналыг үндэслэн хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.6-2. Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2019/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.4.6-3. Сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар судалгаа, хяналт мониторинг хийх/ МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, 2017-2020/

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2018 онд сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх цогц судалгааг эхлүүлсэн бөгөөд энэ хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэвлэмэл сонин, цахим сайтуудад нийтлэгдсэн сэтгүүлчийн аюулгүй байдалтай холбоотой асуудал, мэдэгдэл, нийтлэлд мониторинг хийж, агуулгын судалгааг эхлүүлэв. Энэхүү мониторингийн дүнг бусад санал асуулгын судалгаа, фокус бүлгийн ярилцлагын судалгааны үр дүнтэй нэгтгэн тайлан хэвлүүлж, сэтгүүлчид болон хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад түгээнэ. (Биелэлт 10 хувь)

4.1.5.7-1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах/ АТГ, 2017-2022/

Байгууллагын 2017 оны дотоод

сургалтын төлөвлөгөөний дагуу Монголбанктай хамтран зохион байгуулсан "Банк, мөнгөний бодлогын ойлголт, санхүүгийн хяналт шалгалт" сэдэвт тусгай хөтөлбөрт 16 цагийн сургалт, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн зарчим, үзэл баримтлал сэдэвт сургалтад нийт албан хаагчдыг, Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан шинэчлэгдсэн хуулиудын кредит хангах 16 цагийн сургалтад хуульчийн гэрчилгээтэй 39 албан хаагчийг, Худалдан авах ажиллагааны эрх олгох 3 хоногийн сургалтад 5 албан хаагчийг тус тус хамруулсан. Авлигатай тэмцэх газраас 2017 оны 4 дүгээр сард НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан "Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга" (StAR)-тай хамтран "Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь" сэдэвт хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Австри улсад болсон "Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага", БНХАУ-ын Хонконг мужид зохион байгуулагдсан "Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь", Гүрж улсад зохион байгуулагдсан "Авлигын эсрэг сургалт"-д тус тус албан хаагчдыг хамруулав. 2017 онд "Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь", "Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь" сэдэвт сургалтад албан хаагчдыг оролцуулсан.

Мөн Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран "Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь" сургалтыг зохион байгуулав. Сургалтад прокурорууд, Авлигатай тэмцэх газрын болон Цагдаагийн ерөнхий газрын мөрдөгч нар, Монголбанкны албан хаагчид оролцож, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Интерпол, Их Британийн Онц залилангийн

гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэргэжилтнүүд сургалтыг явуулж, харилцан мэдлэг, туршлагаа солилцсон. 2018 оны 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Санхүүгийн гэмт хэргийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх мэргэжилтэн Игорис Кризецковскийн удирдан явуулсан сургалтад Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэс, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцон оффшорын асуудал болон мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлэл авч туршлага сонсов. Цаашид “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга”-тай хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтарсан сургалтыг шат ахиулан дэс дараатайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2018 онд хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд Үндэсний тагнуулын академитай хамтарсан Гүйцэтгэх ажлын анхан шатны мэдлэг олгох 14 хоногийн сургалтад 21, Худалдан авах ажиллагааны эрх олгох сургалтад 6, Студийн зураглаачийн сургалтад 2, Зэвсэгт хүчний жанжин штабын англи хэлний сургалтад 7, Монголын хуульчдын холбоотой хамтран 2 кредит цагийн Хуульчийн үргэлжилсэн сургалтад хуульчийн гэрчилгээтэй 40 албан хаагчийг тус тус суралцуулсан. Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэхээр “Burton English Mongolia” ХХК-тай гэрээ байгуулж, 106 албан хаагчийг англи хэлний цахим сургалтад, АНУ-д англи хэлний сургалтад 3 албан хаагчийг хамруулав.

Мөн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Санхүүгийн зах зээл, үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн зах зээл сэдвээр 16 цагийн сургалт, “Төрийн болон албаны нууцын тухай хууль, үзэл баримтлал,

хэрэглээ” сэдэвт сургалт, “Байгууллагын сайн засаглал, нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” сэдэвт сургалт, Монголбанктай хамтран “Валютын ханш ба Монгол банкны мөнгөний бодлого”, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран “Баг бүрдүүлэлт, манлайлал” сэдэвт 8 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулав. Тайваний Хууль зүйн яамны шүүгч, прокурорын академийн багш нараас Улсын ерөнхий прокурорт зохион байгуулсан Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс үйлдэж байгаа гэмт хэрэг, хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулав. (Биелэлт 70 хувь)

4.1.5.7-2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох/АТГ, 2017-2019/

Эрүүгийн болон Зөрчлийн багц хуулийн төсөлд тусгах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулан УИХ-д хүргүүлж шийдвэрлүүлсэн. Мөн багц хуулийн ажлын хэсэгт нэр бүхий албан хаагчид ажиллав. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулж, “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай”, “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай” баталгааны маягыг тус тус батлуулан мөрдөж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.3}-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар



сарын 6-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан.

Дээрх хуулийн 10¹ дугаар зүйлийн 10^{1.4}-т заасны дагуу мэдүүлэг гаргагч нь өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тохиолдолд 3 сарын дотор нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох арга хэмжээг авч, хөрөнгө, орлогын мэдүүлэгт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлэх үүрэгтэй.

Мөн хуулийн 10¹ дугаар зүйлийн 10^{1.5}-д зааснаар мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах тохиолдолд дээрх оффшорт холбогдох хориглолт нь хамаарахгүй бөгөөд харин албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банкинд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй.

“Авлига, албан тушаалтнуудын хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах болон албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” танилцуулга,

саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл, Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журмын төслүүдэд тусгах саналыг боловсруулан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэг, Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт албан хаагчид орж ажиллаж байна.(Биелэлт 90 хувь)

4.1.5.7-3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгож, хөгжүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санг бий болгох, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авах, тайлагналтыг явцын дунд хянах, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр, “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар цахим системд мэдээллийн санг үүсгэх, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээллийг оруулж ашиглахад бэлэн болгож Авлигатай тэмцэх газар болон хэрэгжүүлэгч байгууллагын хэмжээнд туршилтын журмаар ажиллуулж

байгаа ба дуусмагц хэрэглээнд бүрэн нэвтрүүлж хэрэгжүүлэгч байгууллага нэг бүрийг холбож үйл ажиллагааг жигдрүүлнэ. (Биелэлт 80 хувь)

4.1.5.8-1. Гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар сургалт явуулах /АТГ, 2017-2022/

Энэ чиглэлээр сургалт явуулах боломжийг судалж, 2018, 2019 оны сургалтын хөтөлбөрт гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг ашиглах талаар сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. (Биелэлт 10 хувь)

4.1.5.9-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрийг мэдээлэх нэгдсэн санг бий болгох /АТГ, ХЗДХЯ 2018-2019/

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан “e-justice.mn” портал, веб сайтыг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/134 тушаалын дагуу цаашид энэхүү системийг Улсын ерөнхий прокурорын газар хариуцан ашиглаж хөгжүүлэлтийг хийхээр болсон.

Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг системийг шинэчлэн боловсруулж, нэвтрүүлэн алба хаагчдад сургалт зохион байгуулав. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сангаас мэдээлэл дуудаж бүртгэх хэсгийг шинээр боловсруулж бүртгэлийг хялбаршуулах, мэдээллийн санд үнэн зөв мэдээлэл бүртгэх

нөхцөлийг бүрдүүлсэн. Өргөдөл гомдол, гэмт хэргийн мэдээллийн сангаас график дүрслэлтэй мэдээлэл гаргах нөхцөлийг судалж, холбогдох туршилтыг хийж гүйцэтгэсэн. Одоогийн өгөгдлийн сангийн бүтцээс график дүрслэлтэй мэдээлэл гаргах боломжгүй тул 2019 онд тус системийг шинээр боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийгээд байна.

Улсын ерөнхий прокурорын газар мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон прокурор, шүүхийн байгууллагууд холбогдсон “гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн цахим сан”-тай болсон ба энэ цахим мэдээллийн санг улам боловсронгуй болгох талаар ажиллаж байна. www.prokuror.mn сайтыг шинэчилж, прокурор, ажилтны ашиг сонирхол, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах 1800-1919 тусгай дугаарын утсыг ажиллуулж, нийт 34 иргэний гомдол, мэдээллийг шууд хүлээн авч, гомдол хүсэлтийг нь шалган шийдвэрлэсэн.

Шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэргийн тоо мэдээнээс холбогдох статистик мэдээллийг боловсруулах ажлыг 2018 онд эхлүүлсэн. Нэгдсэн мэдээллийн сан дээр үндэслэсэн олон нийтэд зориулсан www.e-justice.mn портал, веб сайтыг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр албан ёсоор нээж, туршилтын журмаар ажиллуулж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.9-2. Мэдээллийн санд олон нийттэй харилцах цэс үүсгэж, хамрах хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх/АТГ, 2017-2020/

Авлигатай тэмцэх газар ирсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн тоон үзүүлэлтийг тус газрын цахим хуудсаар олон нийтэд тогтмол мэдээлж байна. Хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаа авлига, мансууруулах бодистой холбоотой хэргүүдийн шалгалтын явц, шийдвэрлэлтийн



мэдээг улирал бүрээр харьяа прокурорын газруудаас авч судлах, шалгах, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах талаар Улсын ерөнхий прокурорын газрын үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөнд тусгаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн мэдээллийн сантай болох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2017 оны 4 дүгээр улиралд Азийн сангийн санхүүжилтээр прокурорын байгууллагын цахим хуудсыг шинэчлэн Үндэсний дата төвийн серверт байршуулсан. Иргэдээс прокурор, ажилтны үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах 1800-1919 тусгай дугаартай утсыг ажиллуулахаар суурилуулсан, холбогдох журмыг боловсруулж батлуулав. Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг прокурорын байгууллага хариуцан ажиллаж байна. Мэдээллийн нэгдсэн санд иргэний портал үүсгэх, олон нийтэд нээлттэй байлгах боломжийн талаар хамтран ажиллах байгууллагуудтай хэлэлцэж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.10-1. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг олон нийтэд хүргэх арга хэлбэрийг сайжруулах /ШЕЗ, 2017-2022/

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах” журмыг баталсан. Уг журмаар иргэн, хуулийн этгээд интернэтийн сүлжээ ашиглан цахим сангаас шүүхийн шийдвэрийн мэдээлэл болон тогтоох хэсгийг үзэж болох бөгөөд бүрэн эхээр нь татаж авах боломжтой эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Одоо уг цахим хуудсанд өдөр бүр 7000-8000 хүн хандаж байна.

Төлөвлөгөөний дагуу “Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэсэн мэдээллийн нэгдсэн сан” бүрдүүлэхэд хамтран ажиллах талаар Улсын ерөнхий

прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн зүгээс уг авлига, албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээллийг цаг тухайд нь хүргэж хамтран ажиллах боломжтой талаар саналаа хүргүүлсэн. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн сан үүсгэн, дотоод сургалтад ашиглаж байна. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн мэдээг улирал бүр бүх шүүхээс хүлээн авч нэгтгэн мэдээллийн санд нэгтгэж байна. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор тус мэдээний маягтын үзүүлэлтийг шинэ хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь авлигын хэргийн статистикийг улам нарийн гаргах нөхцөл бүрэлдэв. Бусад байгууллага, судлаачдын сургалт, судалгаанд ашиглах хүсэлтээр хувь хүн, байгууллагын нууцыг хадгалах зарчмын баримтлан авлигатай холбоотой шүүн таслах ажиллагааны мэдээг сонирхсон этгээдэд өгч байна. (Биелэлт 90 хувь)

4.1.5.10-2. Авлига, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд мэдээлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх /ШЕЗ, УЕПГ, 2017-2019/

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс томилогдсон, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий зөвлөл 2018 онд авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэсэн прокурорын шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд хэрхэн мэдээлсэн байдалд дүн шинжилгээ хийсэн. 2018 онд аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрууд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл болон шалгаж буй эрүүгийн хэргийн явц байдал, шийдвэрлэлт, гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх, прокурорын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 752 мэдээ, мэдээлэл өгсөн байна. Үүнээс сонин, сэтгүүлд 115, телевизээр 200, радиогоор 30, веб сайтаар 426, бусад мэдээллийн хэрэгслээр 22 мэдээ, мэдээлэл /давхардсан тоогоор/ нийтлэгджээ. Нийслэлийн прокурорын газар 22 удаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээ өгсөн байх ба авлига, албан тушаалын гэмт хэрэгт хяналт тавьдаг тус прокурорын газрын ажлын онцлогтой холбоотойгоор энэ төрлийн хэргийн талаар зөвхөн тус газар мэдээ, мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн байна. (Биелэлт 30 хувь)

4.1.5.11-1. Авлигын гэмт хэрэг, зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээллийн санг үүсгэн, сургалтад ашиглах /АТГ, ШЕЗ, УЕПГ, 2017-2022/

Авлига, албан тушаалын 46 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн нь өмнөх оноос 21-ээр буюу 84 хувиар өссөн бөгөөд Авлигатай тэмцэх газар эдгээр хэргүүдийн шүүхийн шийтгэх тогтоолуудыг нэгтгэн гарын авлага болгон сургалтад ашиглаж байна. Улсын ерөнхий прокурорын газраас авлигын гэмт, хэрэг зөрчлийг олж илрүүлсэн, мөрдөн шалгасан, хянан шийдвэрлэсэн байдалд Гэмт хэрэг зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвөөс хийсэн дүн шинжилгээ, мэдээллийн санг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх ажлыг хийж байна. Уг ажлын хүрээнд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны төв нь е-прокурор прокурорын цахим сургалтын програм хангамжийг Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, серверт холбогдох сургалтын материал, Төвийн судлаач багш, хяналтын прокуроруудын тус сэдвийн талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, илтгэлийг байрлуулах ажлыг гүйцэтгэсэн болно. 2018 онд "Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал" сэдэвт сургалтын модуль, хөтөлбөр болон сургагч багш бэлтгэн, гарын авлага гаргасан. Авлигын хэргийн мөрдөн

шалгах ажиллагаа, шийдвэрлэлтийн хууль зүйн үндэслэлийг нэгдсэн удирдамжаар шалгаж, дээрх гэмт хэргийг шалгах явцад гаргасан алдаа зөрчлийг арилгуулахаар Авлигатай тэмцэх газар шаардлага бичиж, 8 прокурорын газарт сургалт зохион байгуулуулахаар албан бичиг хүргүүлэв. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр тусгайлан судалж, судалгааны дүнг үндэслэн хэргийг шалгах аргачлалыг боловсруулах зэрэг холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. (Биелэлт 20 хувь)

4.1.5.11-2. Олон улсын байгууллага, гадаад орноос багш, мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулах/АТГ, 2017-2019/

Азийн хөгжлийн банкны Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх сургалтыг 2017 оны 4 дүгээр сард зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Авлигатай тэмцэх газрын 10 албан хаагч, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанкны албан хаагчид хамрагдсан. Авлигатай тэмцэх газар, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтарсан Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох СтАР санаачилгатай хамтран хэрэгжүүлж буй шинэ төслийн хүрээнд хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн 2 өдрийн сургалтыг 2017 оны 4 дүгээр сард зохион байгуулж, 60 орчим алба хаагч хамрагдсан. СтАР санаачилгын ахлах мэргэжилтэн, Румын улсын Шударга ёсны газрын хянан шалгагч нар сургалтыг хамтран зохион байгуулж, Румын улсын Шударга ёсны газрын үйл ажиллагаанаас танилцуулж, кэйс дээр ажиллуулан, Монгол Улс дахь хөрөнгө, орлогын мэдүүлгийн тогтолцоонд тулгарч буй саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар харилцан ярилцсан үр дүнтэй сургалт болсон. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Авлигын эсрэг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг



нэмэгдүүлэх нь” сэдвээр сургалтыг 2017 оны 5 дугаар сард; “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сургалтыг 2017 оны 9 дүгээр сард; “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалтыг 2018 оны 6 дугаар сард тус тус зохион байгуулж, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг оролцуулав. Дээрх сургалтад Интерполын Авлигын эсрэг сүлжээний болон Их Британийн Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны ахлах мөрдөгч зэрэг мэргэжилтнүүд урилгаар оролцож, өөрсдийн орны авлигатай тэмцэх туршлагаас хуваалцсан. Сургалтад Мөрдөн шалгах хэлтсийн болон Гүйцэтгэх ажлын хэлтсийн нийт албан хаагчид хамрагдсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Оффшор бүсэд байршсан мөнгөн хөрөнгийг эргүүлэн татах боломжууд” сургалт хэлэлцүүлэгт 2 албан хаагч оролцсон.

Авлига болон хууль бусаар гадаад улс оронд байршсан нүүгдмал хөрөнгө орлогыг буцаах, царцаах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг СтАР санаачилгаас тус байгууллагын захиалгаар “Эрх зүйн туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах” чиглэлээр явагдсан 2 өдрийн хэлэлцүүлэг, 1 өдрийн сургалтад ажилтнуудыг бүрэн хамруулж, бусад улс оронд энэ чиглэлээр явуулж буй мөрдөн шалгах ажиллагааны арга, тактикийн талаар суралцах, цаашид хэрхэн хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох уулзалт ярилцлагыг зохион байгуулсан. Тайваний Хууль зүйн яамны шүүгч, прокурорын академийн багш нараас Улсын ерөнхий прокурорт зохион байгуулсан “Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээс үйлдэж байгаа гэмт хэрэг, хөрөнгө хураах ажиллагаа” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулав. СтАР санаачилгатай хамтран 2018 оны 4 дүгээр сард хууль сахиулах байгууллагуудын дундах “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”, 10 дугаар сард “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны

сургалт” зохион байгуулав.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон СтАР санаачилгатай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс жил болгон гишүүн орнуудаас цуглуулдаг Авлигын эсрэг үйл ажиллагааны явцын тайлан болон орон нутаг дахь авлигын асуудлаар мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн. (Биелэлт 80 хувь)

4.1.5.12-1. Сургуулиудын давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар тусгуулах /АТГ, ХЗДХЯ, 2017-2018/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний болон онцгой байдлын байгууллагын тасгийн дарга буюу түүнтэй адилтгах албан тушаалтны нөөцөд авагдсан албан хаагчдад “Албан тушаалын дамжаа”-г хичээллүүлж байна. Энэхүү “Албан тушаалын дамжаа”-ны хөтөлбөрт “Авлигатай тэмцэхэд төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлага” сэдэвт 4 цагийн сургалтыг оруулахаар Хууль сахиулахын их сургуулиас төлөвлөн, хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан. “Албан тушаалын дамжаа”, Удирдах ажилтны давтан сургалтын хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх талаар сургалтыг оруулж хэвшсэн. Мөн бакалаврын сургалтад “Авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “Албан тушаалын гэмт хэргийн криминологи шинж”, “Албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх арга зүй”, “Албан тушаалын гэмт хэргийн нотолгооны онол, арга зүй” гэсэн бүлэг сэдвүүдийг сургалтын хөтөлбөрт тусган мөрдөж байна.

Авлигатай тэмцэх газраас “Монголын хуульчдын холбоо” төрийн бус байгууллага, Улсын ерөнхий прокурорын газрын Сургалтын төв, Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төв зэрэг байгууллагын сургалтын

төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар хичээлийн сэдвийг тусгуулах ажлыг зохион байгуулсан. (Биелэлт 60 хувь)

4.1.5.13-1. ХАСУМ болон хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах үүрэг бүхий албан тушаалтны хамрах хүрээг эрхлэх албан тушаалынх нь онцлог, шийдвэр гаргах эрх мэдэл, улсын өмчтэй харьцах үйл ажиллагаа зэрэг авлигад өртөх эрсдэлийг харгалзан оновчтой тогтоох /АТГ, 2017-2019/

ХАСХОМ гаргах үүрэг бүхий этгээдийн хамрах хүрээг эрхлэх албан тушаалынх нь онцлог, шийдвэр гаргах эрх мэдэл, улсын өмчтэй харьцах үйл ажиллагаа зэрэг авлигад өртөх эрсдэлийг харгалзан оновчтой тогтоох, ялангуяа ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох талаар судалгаа хийж байна.

ХАСХОМ-ээ мэдүүлэх албан тушаалтны жагсаалтыг шинэчлэх, авлига ашиг сонирхлын зөрчилд өртөмтгий байгууллага, салбар, албан тушаал зэрэг өгөгдөл бүрээр судалгаа, харьцуулалтыг мэргэжлийн судалгааны байгууллага болон хөндлөнгийн шинжээчдээр хийлгүүлэхээр ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.14-1. ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох /АТГ, 2017/

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг шинэчлэн боловсруулахаар судалгаа хийж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.5.14-2. Мэдүүлгийг цахим хэлбэрээр авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх /АТГ, 2017-2022/

ХАСХОМ-ийг авах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, мэдүүлгийн программд нэмэлт сайжруулалт хийж, аюулгүй байдал, боловсруулалт, тооцоолол, интерфэйстэй холбоотой цогц шийдлийг нэвтрүүлв.

Албан тушаалтнуудын ХАСХОМ-т судалгаа, харьцуулалт хийх дүн шинжилгээний програмыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. ХАСХОМ-ийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд улсын бүртгэл, хяналтын байгууллага, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Нийслэл, дүүргийн газрын алба, Татварын байгууллага, Цагдаагийн байгууллага зэргээс шаардлагатай мэдээлэл, лавлагааг онлайнгаар авч, хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. (Биелэлт 70 хувь)

4.1.5.15-1. Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох/АТГ, 2017-2019/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.5.15-2. Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох/ЗГХЭГ, 2017-2019/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.5.16-1. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх /АТГ, 2017-2019/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.5.17-1. Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид тусгаж нэр томъёог тодорхой болгох/АТГ, 2017-2018/

Хээл хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол хариуцлагаас чөлөөлөх талаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах санал боловсруулан хүргүүлснээр Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн тайлбарт хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ



тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлөхөөр Эрүүгийн хуульд тусгагдсан. (Биелэлт 90 хувь)

Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 21 арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 2017 онд 14 арга хэмжээг нь хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд нийт 18 арга хэмжээ хэрэгжүүлээ. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.6.1-1. Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, Авлигын эсрэг түншлэл /РАСИ/-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Авлигын эсрэг түншлэлийн гол зарчмуудыг сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх / МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ 2017-2019/

2017, 2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.6.1-3. Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан сурталчлах /МҮХАҮТ, МБЗ 2017-2020/

2017 онд тодорхой ажил хийгдээгүй. 2018 онд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Азийн сантай хамтран бизнес эрхлэгчдийн авлигаас урьдчилан сэргийлэх талаар ойлголтыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг түншлэлийг сурталчлахад чиглэсэн цуврал семинарыг 4 компанийн 63 хүнийг хамруулан зохион байгуулсан.

Бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн санаачилгаар авлига болон түүнийг тойрон тэлсээр буй хууль бус, ёс зүйгүй соёл,

харилцааг ил тод болгон хэлэлцүүлэх, бизнес эрхлэгчид, авлигыг өөгшүүлсэн зохисгүй хандлагыг өөрчлөх, шударга, нийгмийн хариуцлагатай бизнесийг таниулах, авлигын эсрэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн хяналтын тогтолцоог дэмжих зорилго бүхий “Авлигын эсрэг НЭГ ҮЙЛДЭЛ” аяныг Авлигатай тэмцэх газар, “Транспэрэнси интернэшнл Монгол” төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн байгууллагуудад авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулж, дуу хоолойгоо нэгтгэхийг уриалсан танилцуулга, зурагт хуудсуудыг олон нийтийн сүлжээгээр нийтэд түгээн сурталчлав.

Монголын Бизнесийн зөвлөл нийт гишүүн байгууллагуудынхаа дунд “Авлига хээл, хахуульгүйгээр бизнес эрхлэх нь” сэдэвт арга хэмжээг зохион байгуулж, аливаа бизнесийг авлига өгөхгүй, авахгүйгээр хуулийн хүрээнд эрхлэх, авлигыг эсрэг хууль тогтоомжийг сахин биелүүлэх болон бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хуулиар олгогдсон эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг гишүүн компаниуддаа хүргүүлсэн. Мөн Монголын Бизнесийн зөвлөлөөс “Транспэрэнси Интернэшнл Монгол” төрийн бус байгууллагатай хамтарч, авлигаас урьдчилан сэргийлэх мэдэгдэхүүн олгох онлайн сургалтын модулийг боловсруулж цахим хуудсанд байршуулан авлига, хээл хахуулийн эсрэг сургалтын хэрэглэгдэхүүн, материалуудыг бүхий л компаниудын ажилтан, албан хаагч бүрт үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 10 хувь)

4.1.6.2-1.Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах /АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, ОӨУБЕГ, 2017-2019/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх газар, Монголын Бизнесийн зөвлөлтэй хамтран “Транспэрэнси Интернэшнл

Монгол” төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр 2017 оны 5 дугаар сард хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах, бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор төр, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулсан “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт 3 өдрийн модуль сургалтыг зохион байгуулсан ба сургалтыг олон улсын болон үндэсний экспертүүд удирдан явуулж Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хээл хахууль удирдлагын систем, олон нийтийн худалдан авах ажиллагааны ил тод байдал, гааль, гадаад худалдааны салбар дахь авлигын эрсдэл зэрэг асуудлуудыг хөндөж ярилцав. Өдөр бүрийн сургалтууд нь уригдсан компаниудад бизнесийн ёс зүй, шударга байдалтай холбогдох сэдвүүдийг танилцуулах, мөн хувийн хэвшил, төрийн байгууллагуудын төлөөллүүдийг нэг дор авчирч хувийн хэвшил дэх авлига, түүний гол тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн болно. Цаашид хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг арга хэмжээг үндсэн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Удирдлагын академитай хамтран боловсруулсан “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт модулийг боловсруулж туршилт сургалтыг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулсан. Цаашид уг модулиар Удирдлагын академи, Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвөөр дамжуулан сургагч багш бэлтгэж, сургалтыг тогтмол зохион байгуулахаар бэлтгэж байна.

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Азийн сан, “Транспэрэнси интернэшнл Монгол” төрийн бус байгууллагатай хамтран хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, аж ахуйн нэгжүүдэд хамтран цуврал сургалтыг хийж

эхэлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зорилтын хүрээнд 2018 онд 10 төрийн байгууллага, 12 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах санамж бичиг, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Төрөөс бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хяналт шалгалтын давхардал, хүнд суртлыг арилгах зорилгоор хамтран хяналт шалгалт хийх саналыг төрийн захиргааны байгууллагуудаас авч хяналт шалгалт, аттестатчиллыг хамтран хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, хяналт шалгалтын давхардлыг арилгах, бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл бэрхшээлийг арилгах ажилд ахиц гарсан.

Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийн дагуу дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж буй 557 аж ахуйн нэгж, байгууллагад 24 сэдвээр, бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд хууль эрх зүй, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилгоор бусад салбарын сургалтыг 39 сэдвийн хүрээнд зохион байгуулж, 6438 аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтнуудыг хамрууллаа.

Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах хүрээнд “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах нь”; “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгололт, хадгалалтад тавигдах шаардлага”; “Хөшигийн хөндийд баригдаж буй Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын цацрагийн аюулгүй байдал, барилга байгууламж, зам талбайн ашиглалт, арчлалтын талаар сургалт зохион байгуулах; “Хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй зураг төсөл зохиогч, захиалагч аж ахуйн нэгж байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулах”; “Эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, нэвтрүүлэх нь”; “Эмийн сангийн салбарын сургалт”; “Эрүүл мэндийн



салбарын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны соёл” сэдвээр сургалт, “Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалтыг тус тус зохион байгуулж, зөвлөмж гарган, холбогдох газруудад хүргүүлсэн.

Мөн “Хуулиа мөрдөнө-21” сарын аяны хүрээнд 282 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж, 2819 аж ахуйн нэгж, 36038 иргэнийг; “Зохистой хөдөлмөр-2018” сарын аяны хүрээнд 126 удаагийн сургалтад 370 аж ахуйн нэгж, байгууллагын 7437 ажилтан, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сурагчид, 4 нөхөрлөлийн 20 гишүүнийг; “Эрүүл мал-Эрсдэлгүй бүтээгдэхүүн” сарын аяны хүрээнд 268 сургалт зохион байгуулж, 99071 хүнийг хамруулсан.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар 6 хувийн хэвшлийн байгууллагын захиалгаар 260 гаруй иргэнийг хамруулан тэдэнд хууль болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хүргэн ажиллав.

Стандарт, хэмжил зүйн газар хувийн хэвшлийн байгууллагуудыг олон улсын стандарт, хэм хэмжээг үйл ажиллагаандаа тусгаж нэвтрүүлэх, чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж тайлант хугацаанд лаборатори итгэмжлэл, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, чанарын олон улсын стандартын чиглэлээр 26 сэдэвчилсэн сургалтад аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 400 орчим хүмүүсийг хамруулсан байна. Бизнес эрхлэгчдийг олон улсын сайн дадлуудтай танилцуулах, олон улс гадаад орны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх арга зүйн сургалтуудад хувийн хэвшлийн 378 хүнийг хамруулж, Хэмжих хэрэгслийн засвар тохируулгын ажилтан 72, хэмжүүрийн улсын шалгагч 15, бүтээгдэхүүний болон тогтолцооны баталгаажуулалтын шинжээч 41 хүнийг мэргэшүүлэн сургасан. (Биелэлт 30 хувь)

4.1.6.2-2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх /ҮХГ, ЗГХЭГ, СЯ, АТГ 2018-2022/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хариуцлагын жилийн хүрээнд иргэдэд давхардал чирэгдэлгүй төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх, төсвийн хөрөнгийг ил тод, үр өгөөжтэй зарцуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, төрийн албан хаагчид ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад архи, согтуурлах ундаа хэрэглэхийг хориглох, яам, агентлагууд тусгай зөвшөөрөл олгох аливаа үйл ажиллагааг ил тод болгож цахимжуулах, төрийн албан хаагчид ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэх, ажилтан бүрийн үүргийн хэрэгжилт, цаг ашиглалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг гэмт хэрэгт холбогдох хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбож үнэлгээ хийхийг зорилт тавин ажилласан. Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, аудитын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй гэрээ байгуулан, жил бүр ажлын төлөвлөгөөг баталж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. (Биелэлт 5 хувь)

4.1.6.3-1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх /ЗГХЭГ, ҮХГ, 2018-2022/

2017 онд зохион байгуулсан Авлигын эсрэг үндэсний чуулганы нэг салбар хуралдааныг “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал” гэсэн сэдвийн хүрээнд явуулж “Бизнесийн ёс зүй”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа, үнэлгээ хийх”, “Шударга өрсөлдөөнийг дэмжих нь”, “Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх асуудал”, “Олон улсын сайн туршлага” зэрэг 5 агуулгын хүрээнд эрдэмтэн, судлаач, холбогдох байгууллагын төлөөлөл, гадаад улсын зочин, төлөөлөгчдөөр тус тус илтгэл тавиулж, хэлэлцүүлэн, гарсан санал, санаачилгыг судлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 39 дүгээр захирамжийн дагуу төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт “Монголын эдийн засгийн чуулган” арга хэмжээг 3, 5 дугаар сард 2 удаа зохион тус тус зохион байгуулж, эхний уулзалтыг “Хүчээ нэгтгэе” уриан дор “Уул уурхай ба үр өгөөж”, “Утаагүй, түгжрэлгүй Улаанбаатар”, “Тогтвортой хөдөө аж ахуй хөгжлийн тулгуур”, “Хувьчлал ба шинэчлэл”, “Аялал жуулчлал ба агаарын тээврийн либералчлал”, “Татварын хуулийн шинэчлэл” гэсэн 6 салбарын хүрээнд зохион байгуулсан. Хоёр дахь зөвлөлдөх уулзалтаар “Монгол Улсын хөгжлийн бодлого ба хөрөнгө оруулалт”, “Монгол Улсын хөгжлийн загвар”, “Төр хувийн хэвшлийн диалоги ба хамтын ажиллагаа”, “Аж үйлдвэрийн IV хувьсгал”, “Бидний үнэт зүйлс, ёс зүй ба нийгмийн зөвшилцөл”, “Улаанбаатар хотын эдийн засаг ба хөрөнгө оруулалт”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, Төвлөрлийг сааруулах” зэрэг 7 салбар хуралдааныг зохион байгуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлох хэлэлцүүлэг өрнүүлэв. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах явцад төрийн болон хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын оролцоог ижил түвшинд хангах, аливаа байдлаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын дуу хоолойг

нээлттэйгээр сонсож, хүлээн авч, бодлого, үйл ажиллагаандаа тусгаж явах байнгын ажиллагаатай “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо”-г “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн дэргэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 320 дугаар тушаалаар байгуулсан. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо 2018 онд “Татварын багц хууль болон Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн хоорондын уялдаа холбоо: Бичил, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх нь”; “Монгол Улс: Төр-Хувийн хэвшлийн хэлэлцэл, Итгэлийг бий болгох, хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг сайжруулах хэрэгсэл”; “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт” арга хэмжээний хүрээнд “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх механизмыг нэвтрүүлэх нь: Итгэлцэл, зөвшилцөл, шийдэл”; “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн биржийн шимтгэлтэй холбоотой асуудал”; “Хөрөнгө оруулалтын шинэтгэлийн зураглал, түүний үр дүн, зөвлөмж” сэдвээр тус тус хурал, зөвлөгөөн зохион байгуулж, мэдээлэл, илтгэл хэлэлцүүлж, холбогдох зөвлөмжийг гаргаж ажилласан.

Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн Зөвлөмжийн дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 186 дугаар захирамжаар Нэг цэгийн үйлчилгээний төвийг Үндэсний хөгжлийн газрын дэргэд байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны эхний улиралд багтаан нэг цэгийн үйлчилгээний төвийг нээхээр ажиллаж байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг байгуулсанаар хөрөнгө оруулагчдад үзүүлж буй төрийн үйлчилгээг нэг дороос, хурдан шуурхай хүргэж, цаг хугацааг хэмнэж, цаашилбал, хөрөнгө оруулагчдын сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлж, итгэлийг сэргээн шинэ болон дахин хөрөнгө оруулалт



нэмэгдэх боломж бүрдэнэ.

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Хууль дээдлэх ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчил”, “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам”, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Асуудал ба шийдэл” сэдвээр иргэний нийгмийн төлөөлөл, хуульч, судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг, Азийн сантай хамтран “Авлигын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг цувралаар зохион байгуулж, санал, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүрүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.3-2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах /ҮХГ, СЯ 2017-2018/

Сангийн яам 2018 онд Засгийн газрын 2016 оны 165 дугаар тогтоолын дагуу Нягтлан бодох бүртгэлийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний 3.2 дахь заалтаар авлигаас урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчлөөс ангид байх заалтуудыг тусгаж ажилласан. (Биелэлт 0 хувь)

4.1.6.3-3. Олон улсын болон дотоодын бизнесийн орчин дахь авлигатай тэмцэх сайн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг судлах, нэвтрүүлэх санаачилга өрнүүлэх /МҮХАҮТ, Гишүүн байгууллага. АТГ 2018-2019/

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим бизнес эрхлэхэд хүнд суртал үзүүлж байгаа албан байгууллага, үйл явцыг үнэлэн гаргадаг “Хүнд суртлын индекс” судалгааны бэлтгэл ажлын хүрээнд

төрийн байгууллагуудаас олгож байгаа зөвшөөрөл, бүртгэл, түүнтэй адилтгах актуудын талаарх мэдээллийг шинэчлэх ажлыг явуулж байна. Нийт 50 төрийн байгууллагад албан тоот явуулснаас 39 байгууллагын 575 зөвшөөрөл, бүртгэл, түүнтэй адилтгах актуудын мэдээллийг авч нэгтгээд байна. Азийн сан хамтран Хүнд суртлын индексийг олон улсын аргачлалын дагуу асуулга, агуулгыг шинэчлэхээр ажиллаж байна. Энэхүү Хүнд суртлын индекс нь төрийн байгууллагуудын хүнд суртлын түвшинг бизнес эрхлэгчдээс бодитойгоор үнэлүүлж гарган үр дүнг холбогдох байгууллагуудын болоод олон нийтийн сонорт хүргэх, төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах чиглэлд хийх, авч хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг.

Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нь “Орон нутаг дахь авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ”-гээр дамжуулан аймаг, орон нутгийн түвшинд авлига, хүнд суртлыг бууруулах зорилгоор Булган, Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг хамруулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 80 гаруй хүнийг хамруулсан.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс боловсруулан баталсан хөтөлбөрийн дагуу Компанийн засаглалын 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 40 гаруй хүнийг хамруулсан. Дээрх сургалтад Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын сургалтад сууж гэрчилгээ авсан байхаар хуульчилсан нь тухайн аж ахуйн нэгжид засаглалын болон ёс зүйн зарчмуудыг удирдлагын хэмжээнд хэрэгжүүлэн, улмаар байгууллагын бүхий л түвшинд нэвтрүүлэх өргөн боломжийг олгож байгаагаараа онцлог юм.

Мөн компанийн нийгмийн хариуцлага ISO26000 Олон улсын стандарт MNS ISO26000:2012 Үндэсний стандартын

талаарх ойлголтыг аж ахуйн нэгж, байгууллагуудад өгөх зорилгоор 3 удаагийн сургалт зохион байгуулж 30 гаруй хүнийг хамруулсан. (Биелэлт 10 хувь)

4.1.6.4-1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын тушаалаар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа, шинжилгээний ажлыг хийн, хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулаад байна. Хуулийн төсөлд яамдаас санал авахаар ажиллаж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.6.4-2. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 22-т “Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх” гэж, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна” гэж тус тус заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан Шадар сайд болон Хууль зүйн сайдаар батлуулсан.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөлд үр нөлөөний

үнэлгээ хийж, гарсан дүгнэлт саналын хүрээнд хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтүүдийг оруулан эцэслэн боловсруулж дагалдах баримт материалын хамт Шадар сайдад хүргүүлсэн. Засгийн газар яамдуудаас хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлэв. (Биелэлт 40 хувь)

4.1.6.4-3. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /ШӨХТГ, ШСАА 2017-2019/

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох бусад судалгааг хийж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.6.4-4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх /ШӨХТГ 2018-2020/

“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, тус хөтөлбөрийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөв зэргийг боловсруулж, хөтөлбөрийн төсөл ба хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг 2018 оны 5 дугаар сард “Жайка” олон улсын байгууллагатай хамтран төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан хөтөлбөрийн төсөл, шаардлагатай баримт материалуудыг боловсруулан санал авахаар ажиллаж байна. (Биелэлт 10 хувь)



4.1.6.4-5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах /ШӨХТГ 2017-2019/

2017, 2018 онд тодорхой ажил хийгдээгүй. (Биелэлт 0 хувь)

4.1.6.4-6. Өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг жил бүр зохион байгуулах /ШӨХТГ 2017-2019/

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр нефть импортлогчид болон шингэрүүлсэн шатдаг хийн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Солонгос дахь бодлогын төвтэй хамтран 2017 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо “Дуудлага худалдаанд үгсэн тохиролцох зөрчлийг илрүүлэх нь” сэдэвт олон улсын сургалтыг амжилттай хамтран зохион байгуулав. Тус олон улсын сургалтад гадаадын 15 орны 30, Монгол Улсаас 30, нийт өрсөлдөөний байгууллагуудын 60 төлөөлөгчид оролцов. Мөн 2017 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо Индонезийн Бизнесийн өрсөлдөөнийг хянан зохицуулах хороотой хамтарсан туршлага солилцох семинарыг “Жайка” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хийв. Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон харьяа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад өрсөлдөөнийг хязгаарласан буюу хөрөнгө оруулагч болон аж ахуй эрхлэгчдэд үндэслэлгүй саад учруулах, хуулиас давсан шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор уулзалт хийж, өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Салбаруудын тулгамдаж байгаа асуудлууд, тэдний санал, хүсэлтийг сонсох зорилгоор үүрэн холбооны оператор 4

компани, даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа 16 компани, төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн болон хувийн компаниудтай уулзалт зохион байгуулж, холбогдох санал хүсэлтийг нь сонссон 3 удаагийн уулзалтыг зохион байгуулав.

Түүнчлэн хийн түлш, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн болон тендерийн гомдол ихээр ирүүлж буй захиалагч байгууллагуудын төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгүүдийг тухай бүр зохион байгуулж байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Соёл урлагийн газар, Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хамтран сургалт “Монгол киноны өрсөлдөх чадвар, кино бүтээлийн түгээлт ба зохицуулалт” уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, Өрсөлдөөний хуулийн талаар мэдээлэл хийсэн.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын маркетинг хариуцсан албан хаагчдад; эрүүл мэндийн зар сурталчилгаатай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төв, телевизүүдийн төлөөллүүдэд; дотоодын үйлдвэрлэгч болон сүлжээ дэлгүүрийн чиглэлийн аж ахуй эрхлэгчдэд тус тус Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн талаар сургалт, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. (Биелэлт 80 хувь)

4.1.6.5-1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /УУХҮЯ 2017-2019/

Боловсруулах салбарын ил тод байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, тэдгээрийг бүртгэлжүүлэн нэгдсэн мэдээллийн санг

үүсгэв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн “Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилтот хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, нөлөөллийн шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэн, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төсөл, “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, Хүнд үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, маягтын төслийг тус тус боловсруулан, аж ахуйн нэгж, иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж байна. Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн сайд, удирдлагууд сар бүрийн сүүлийн долоо хоногт “Ил тод хариуцлагатай уул уурхай” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, салбарын асуудлаар мэдээлэл өгч хэвшсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.6.5-2. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах /УУХҮЯ 2017-2019/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба болон Нээлттэй нийгэм форумын хооронд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн нэгдсэн сан байгуулах замаар эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдөр “Санамж бичиг” байгуулсан ба эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээг www.iltodgereee.mn, www.resourcecontracts.mn цахим санд байршуулж, олон нийтэд

ил тод болгох чиглэлээр хамтран ажиллаж байна.

Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр www.iltodgereee.mn цахим санг иж бүрнээр 2017 онд ашиглалтад оруулж, санг тогтмол шинэчилж, баяжуулж байх санамж бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нээлттэй нийгэм форум, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба хамтран байгуулсан бөгөөд эхний удаад 35 гэрээний эхийг ил тод болгосны дотор Загвар гэрээ- 5, Бүтээгдэхүүн хуваах гэрээ- 1, Хөрөнгө оруулалтын гэрээ- 1, Ус ашиглах -1, Газар ашиглах -6, Орон нутагтай хамтран ажиллах/нийгмийн хариуцлагын -21 гэрээг гэрээний зүйл заалтын 140 тайлбарын хамт оруулсан.

Энэхүү санамж бичгийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан эрдэс баялгийн салбарын 11 төрлийн гэрээг цуглуулж бүртгэх үүрэгтэй ажилласан бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн 434 гэрээг холбогдох газруудаас татан авах ажил хийгдэж бүрэн дууссан. Өнгөрсөн хугацаанд 248 гэрээ / буюу 58 хувь/-ийг мэдээллийн цахим санд байршуулаад байна. Үлдсэн гэрээнүүдийг 2019 оны эхний улиралд багтаан цахим санд байршуулахаар ажиллаж байна. Цаашид ажлын хэсгийг шинэчлэн байгуулж эрлийн гэрээ болон бичил уурхай эрхлэгч нартай байгуулсан гэрээнүүдийг цахим санд байршуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. (Биелэлт 60 хувь)

4.1.6.5-3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох /ЗГХЭГ, УУХҮЯ 2020-2022/

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын хүрээнд ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө хэрэгжүүлэх “Замын зураг” төлөвлөгөөг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын



санаачилгын үндэсний зөвлөлөөр 2016 оны 12 дугаар сард батлуулан хэрэгжүүлж байна. 2017 онд эздийн ил тод байдлын үндсэн тодорхойлолтуудыг боловсруулж Ажлын хэсгээр батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно. Ашиг хүртэгч (бенефициар) эздийг ил тод болгох чиглэлээр 300 гаруй мэргэжилтнийг хамруулсан нийт 9 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан ба хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр байгуулан ажиллуулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн 2016 оны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгтгэл тайланд 46 компани хувьцаа эзэмшигчдийнхээ мэдээллийг ил тод мэдээлсэн болно. (Хэрэгжүүлэх хугацаа нь болоогүй тул үнэлээгүй.)

4.1.6.5-4. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх /УУХҮЯ 2017-2020/

Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар батлуулан ажиллаж байна. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын

нэгдсэн бүртгэлд 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. Тус журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай албан бичгийг 2018 оны 3 дугаар сард Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн. Нөхөн сэргээсэн газар, эвдэгдсэн газрын хэмжээний талаар компаниуд нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайландаа мэдээ оруулж, тайлагнаж байна. (Биелэлт 30 хувь)

4.1.6.5-5. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах /УУХҮЯ 2017-2019/

“Олборлох ил тод байдлын санаачилга”-д нэгдэх талаар гэрээлэгч компаниудад зөвлөмж хүргүүлсэн ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Петро Матад” ХХК, “Сентрал Азиан Петролиум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачилгад нэгдээд байна.

Мөн газрын тосны хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг “Олборлох ил тод байдлын санаачилга”-д хамруулах зорилгоор холбогдох мэдээллийг нэгтгэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д 2018 онд хамруулсан. (Биелэлт 40 хувь)

4.1.6.5-6. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын 2016, 2017, 2018 оны тайлангийн нэгтгэлүүдийг гаргах /МОҮИТБС-ын Ажлын алба 2017-2019/

2016 онд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй 19 компаниас 15 нь

олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлан гаргасан бол 2017 онд 21 компаниас 12 нь тайлангаа гаргаж, өмнөх оноос бүүрсан үзүүлэлттэй байна. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2016 оны тайланг КейПиЭмЖи-гийн Монгол, Франц Улсын хамтарсан консорциум гаргасан байна. 213 компанийн төлбөр орлогыг нэгтгэж, олборлох салбарын үндсэн мэдээллийг дэлгэрэнгүй хэвлэн нийтлүүлсэн бөгөөд Үндэсний зөвлөлөөр 2017 оны 12 дугаар сард батлуулсан. Энэ тайлангийн дагуу Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын “баталгаажуулалт” хийгдэнэ. Өмнөх оны нэгтгэл тайланг 2018 онд гаргах аудиторын компанийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2018 оны тайлан боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд 2019 оны дөрөвдүгээр улиралд дуусгана. (Биелэлт 40 хувь)

Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд нийт 6 үйл ажиллагаа, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2017 онд 7 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2018 онд нийт 13 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Тус зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.7.1-1. Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах /АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ 2017-2018/

Авлигын эсрэг үндэсний чуулганы “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, хэвлэл мэдээллийн

болон төрийн бус байгууллагын оролцоо” салбар хуралдаан дээр “Авлигын тухай шинжлэх ухааны танин мэдэхүй ба иргэний боловсрол”, “Эрх мэдэл, их мөнгийг хянах нь: Авлигатай тэмцэхэд хараат бус хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг”, “Иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг нэмэгдүүлэх нь”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, өнөөгийн хөгжил”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох нь”, “Олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох талаарх олон улсын туршлага” зэрэг 6 сэдвийн хүрээнд эрдэмтэн, судлаач, холбогдох байгууллагын төлөөлөл, гадаад улсын зочин, төлөөлөгчдөөр тус тус илтгэл тавиулж, хэлэлцүүлгийн дүнд гарсан санал, санаачилгыг судлан хэрэгжүүлж байна.

Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/185 дугаар тушаалаар батлуулсан болно. Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу 24 яам, агентлагт авлигын эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан боловсруулах, зөвлөмж хүргүүлэх төрийн бус байгууллага болон судалгааны байгууллагатай тогтмол харилцаж, ажлын даалгавар, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллав. Тус ажлын хүрээнд гэрээт ажил гүйцэтгэсэн 6 төрийн бус байгууллагаас 24 байгууллагын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийж товч тайланг бэлтгэн үр дүнг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулав.

Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалд эрсдэлийн үнэлгээний таван үе шат (нөхцөл байдлаа тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах; эрсдэлээ үнэлж тодорхойлох; эрсдэлийн түвшинг үнэлэх, зураглал хийх; эрсдэлийн нөлөөг бууруулах, арилгах зөвлөмж боловсруулах; зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтыг бий болгосон эсэх) болон эрсдэлийн үнэлгээнд ашиглаж болох загвар асуулгыг багтаасан болно.



Мөн яам, агентлаг, аймаг, нийслэл дэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Орхон аймгийн ИТХ-аар баталсан нийт 13 шийдвэрийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх явцад иргэн, холбогдох мэргэжлийн байгууллагуудын саналыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулсан, Эрүүл мэндийн яамнаас “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-д төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид иргэн, олон нийтийн дэмжлэгт хяналтыг хөгжүүлэх, оролцоог хангах, нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн, байгууллага, олон нийтийн хариуцлагатай оролцоонд түшиглэн хэрэгжүүлэхээр тусгасан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр боловсруулахад нийгмийн түншлэгч талуудын оролцоог бүрэн хангаж, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт талуудаас тэнцүү тооны төлөөлөл, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулж, тэдгээрийн саналыг тусган боловсруулсан, цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлогыг шинэчлэх зорилгоор Монголын үйлдвэрчний эвлэл, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, аж ахуй нэгж, байгууллага болон эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан зэрэг болно.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Олон улсын хөгжлийн ассоциаци /Дэлхийн банк/-тай хамтран ажиллаж санамж бичгийн хүрээнд олон улсад ашиглаж буй төсөл хөтөлбөрийн үнэлгээний аргачлалыг өөрийн орны нөхцөлд туршиж үнэлгээ судалгааг төрийн бус байгууллагуудаар

хийлгэсэн болно. Үүнд:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж /сэтгэцийн эрүүл мэндийн хоёр дахь хөтөлбөр/-ийн үнэлгээг “Стратеги Академи” төрийн бус байгууллага;
2. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёрдугаар хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээг “IRIM хараат бус судалгааны хүрээлэн” төрийн бус байгууллага;
3. Боловсролын үндэсний хөтөлбөр, сургуулийн орчны стандартын хэрэгжилтийн үнэлгээг “Тунгаамал төв” төрийн бус байгууллага;
4. Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн үнэлгээг “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” төрийн бус байгууллагаар тус тус гүйцэтгүүлж тайланг хүлээн авав. Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж журам боловсруулан, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Азийн сан “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” төрийн бус байгууллагатай хамтран “Авлигагүй нийгмийн төлөөх иргэдийн оролцоо” төслийн хүрээнд 2017 онд 9 аймагт авлигын эсрэг уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж байсан бол 2018 онд 13 аймагт авлигын эсрэг хэлэлцүүлэг зохион байгуулж, 280 хүнийг хамруулсан байна. Түүнчлэн эдгээр аймгуудад төрийн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийж, зөвлөмж өгч, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллажээ. (Биелэлт 60 хувь)

4.1.7.1-3. Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилтын хүрээнд “Ил тод Улаанбаатар Академи”-тай хамтран ажиллах /АТГ, нийслэлийн ЗДТГ, ГХУСАЗС 2017-2019/

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим”, Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнтэй хамтран “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтыг 2017 оны 2 дугаар сарын 7, 8, 15, 21, 22, 23-ны өдрүүдэд нийслэлийн Засаг даргын дэргэдэх 33 агентлагийн дарга нар, нийслэлийн 152 хорооны зохион байгуулагч болон ажлын албаны дарга нарыг хамруулан зохион байгуулсан ба сургалтаар манлайлал, харилцаа, удирдах ажилтны ёс зүй, багийн хамтын ажиллагаа болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай зэрэг хуулийн үзэл санаа, агуулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар нэгдсэн ойлголт, мэдлэгийг олгов.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ил тод Улаанбаатар академи Зөвлөлдөх ардчиллын танхимаас 2018 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласан.

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан

шийдвэрлэх журам”, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ёс зүйн хороодын үйл ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн засаглал, эрх зүйн орчныг сайжруулах, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлуудтай холбоотой заалтууд, Авлигатай тэмцэх нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Азийн сангийн дэд суурин төлөөлөгч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын хамтарсан төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хүрээнд мэдлэг олгох, чадваржуулах сургалт, үнэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах, ёс зүйн хорооны үйл ажиллагааг нэмэгдүүлэх сургалтыг нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд зохион байгуулсан. Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан сургалт зохион байгуулж нийслэлийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагуудын 70 орчим удирдах албан тушаалтныг хамруулсан.

Төрийн жинхэнэ албан тушаалд анх удаа орж байгаа албан тушаалтнуудад ажлын байранд тавигдах үндсэн шаардлага, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулах сургалт; Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг зохион байгуулах, ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах, арга зүйн туслалцаа үзүүлэх сургалт; Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан тушаалтнуудад “Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн



найруулга/-ийн зохицуулалт, төрийн албаны соёл, стандарт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийн агуулга, түүнийг шийдвэрлэж буй байдал, ёс зүйн зөрчлийн бодит байдал, практикт гарч буй зөрчил, хүлээлгэсэн хариуцлага, зөрчлийг шалгах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор нийслэлийн ёс зүйн хороодын үйл ажиллагаа, зөрчил шийдвэрлэлтийн байдалд төрийн бус байгууллагаар судалгаа хийлгэж дүнг, танилцуулж, дүгнэсэн. (Биелэлт 40 хувь)

4.1.7.2-1. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, тогтвортой, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох эрхийг нь баталгаажуулах зэрэг чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох /ХЗДХЯ 2017-2019/

Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоо II” төслийн дэмжлэгээр “Баасанжав Консалтинг” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Энэхүү судалгаагаар төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай болон нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хүрээнд авч үзэх нь зүйтэй гэж үзсэн тул тус хуулийн төслийг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулахаар удирдлагаас шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус хуулийн төсөлд санал авахаар 2018 оны 10 дугаар сар албан бичгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хүний

эрхийн Үндэсний комисс болон яамд, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хуулийн төслийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалтыг танилцуулах, хуулийн төсөлд санал авах зорилгоор иргэд, олон нийт, судлаачид болон холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сард зохион байгуулсан. Саналуудыг хүлээн авч, судалгаа хийн, саналуудыг харгалзан нэгтгэн дүгнэж, хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийж байна.

Улсын бүртгэлийн багц хуулиуд УИХ-ын 2018 оны хаврын ээлжит чуулганаар батлагдаж, 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Улсын бүртгэлийн багц хуулиуд хэрэгжсэнээр хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээллийг нээлттэй болгосон. (Биелэлт 10 хувь)

4.1.7.2-3. Төрийн бус байгууллагуудын мэдээллийн идэвхтэй солилцоог бий болгох, хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээ, түншлэлийг дэмжих /АТГ 2018-2020/

Авлигатай тэмцэх газар Монгол Улсад залуусын оролцоо, манлайлал, ёс зүйн чиглэлээр манлайллын хөтөлбөр, сургалт, нөлөөллийн арга хэмжээ идэвхитэй зохион байгуулдаг “Зориг сан”, “World learning” төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав. Тухайлбал, “World learning” төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчдийн газраас хэрэгжүүлсэн “Lead Mongolia” хөтөлбөрийн манлайлагч залуусын “Эрүүл мэндийн салбарын ил тод байдлыг дэмжих” болон “Залуусын шударга

байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах” багийн гишүүдтэй хамтран ажиллаж оюутан болон хүүхэд залуусын дунд авлигаас ангид байх, шударга ёс түгээн дэлгэрүүлэх “Гэрэл тусгая” богино хэмжээний видео бүтээх уралдааныг зохион байгуулах, дүгнэх нэг болон хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цааш нь түгээх санал санаачилгыг дэмжин ажиллав. “Зориг сан”-гаас оюутан залуусыг хамруулан хэрэгжүүлж буй манлайллын хөтөлбөрт авлигын эсрэг сэдвийг тусгаж, хамтран ажилласан ба энэ хүрээнд “Ардчиллын элч” залуусын манлайллын хөтөлбөрт хамрагдагсдад авлигын ойлголт, шалтгаан, хор уршиг сэдвээр сургалт хийж чадавхжуулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих талаар “Монголын Залуучуудын холбоо”, “Монголын Оюутны холбоо”, “Монголын Сурагчдын Холбоо” төрийн бус байгууллагатай байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эдгээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тусгайлсан төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. (Биелэлт 20 хувь)

4.1.7.3-1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх /АТГ 2017-2019/

Авлигатай тэмцэх газрын ажлын баг тодорхой салбарт буюу барилга, хууль зүй, санхүү, байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй зэрэг чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой тулгамдаж буй асуудал, цаашид хамтран ажиллах боломж, чиглэлийг тодорхойлох зорилгоор цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь авлигын эрсдэл, нээлттэй, ил тод болгох чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон болно. Мөн Монголын Залуучуудын холбоо,

Монголын Оюутны холбоо, Монголын Сурагчдын холбоо, “Глоб интернэшнл” зэрэг төрийн бус байгууллагатай Санамж бичиг байгуулан ажиллаж байна.

2018 онд Авлигатай тэмцэх газар Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу 24 яам, агентлагт авлигын эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан боловсруулах, зөвлөмж хүргүүлэх төрийн бус байгууллага болон судалгааны байгууллагатай тогтмол харилцан, ажлын даалгавар, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллав. Тус ажлын хүрээнд гэрээт ажил гүйцэтгэсэн 6 төрийн бус байгууллагаас 24 байгууллагын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийж товч тайланг бэлтгэн үр дүнг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулав. 2019 онд эрсдэлийн үнэлгээг 15 байгууллагад хийлгэхээр судалгааны чиглэлийн төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулав. Түүнчлэн төрийн байгууллагуудаас үйл ажиллагаандаа хэрэглэгчийн үнэлгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн нь нийтлэг байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээгээр ажиллуулав. Нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт,



элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, урьдчилан сэргийлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлттэй танилцах зорилгоор 2018 оны 9 дүгээр сард Нийслэлийн төвийн дүүргүүдийн сургуулиуд болох 45, 1, 84, 23, 24 дүгээр сургуулиудын нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь ажилласан. Энэ арга хэмжээний хүрээнд Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор нийслэлийн 1, 23, 24, 11, 84, 79, 107, лаборатори Шинэ эрин, Шинэ эхлэл сургууль, 2, 19, 16 дугаар цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлттэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийн дотоод дүрэм журам, гаргасан тушаал шийдвэр, сурагчдын хувийн хэрэг, ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн байдалтай танилцаж хяналт тавьсан. (Биелэлт 30 хувь)

4.1.7.3-2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх /ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга 2018-2022/

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх үйл ажиллагааг 2018 оноос эхэлж хэрэгжүүлэхээр тусгасан боловч зарим төрийн байгууллагаас энэ чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлжээ. Тухайлбал, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 215, 216 дугаар тушаалаар Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллагуудын түншлэлийг төлөөлж “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөж

байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага “Монголын барилгын үндэсний ассоциаци” төрийн бус байгууллагуудын түншлэлтэй, Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллагуудын түншлэлийг төлөөлж “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж ажиллахаар бэлтгэл ажил хангагдаж байгаа тул төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгох ажил нь төлөвлөлтийн шатанд байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 397 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам, төрийн бус байгууллагад тавих нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт”-ийн хэрэгжилтэд судалгаа, үнэлгээ хийж, үнэлгээний дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн яамны газар, хэлтсээс гарсан саналыг тусган, эрүүл мэндийн салбарт тогтвортой үйл ажиллагаа эрхэлж буй төрийн бус байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан зөвлөмжийг тусгасан, Сангийн яамнаас Сангийн сайдын тушаалаар олгодог байсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг Мэргэшсэн нягтлан бодогчийн институт төрийн бус байгууллагад, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгт, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн үйлчилгээг Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалт хийх эрхийг төрийн бус байгууллагуудад тус тус шилжүүлсэн ба Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт хооронд байгуулсан “Төрийн байгууллагын зарим

чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ"-ний хэрэгжилтэд дотоод аудит хийж үйл ажиллагаа болон чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Сангийн яаманд нийт 12 зөвлөмж, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд 6 зөвлөмжийг тус тус өгч дотоод аудитын хорооны тогтоолоор баталгаажуулсан зэрэг болно.

Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор Барилгын тухай хуульд заасны дагуу барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг “Барилгын хөгжлийн төв” ААТТӨҮГ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, Засгийн газрын 216 дугаар тогтоолоор Барааг түр хугацаагаар оруулах тухай конвенцийн “Тээврийн хэрэгслийн тухай хавсралт С”-д заасан тээврийн хэрэгслийг гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлэх таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (CPD карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт уг дэвтэрт тэмдэглэгдсэн асуудалтай холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг Монголын автомашин, мотоциклийн спортын холбоогоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг холбогдох сайд нарт зөвшөөрсөн байна. (Биелэлт 20 хувь)

4.1.7.4-1 Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах /АТГ, ХЗДХЯ 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулахаар тусгагдсаны дагуу Авлигатай тэмцэх газар төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, тушаал шийдвэр, хүнд суртал,

авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх, үл тэвчих үзлийг иргэдэд төлөвшүүлэх үүднээс төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үйлчилгээ хуулийн дагуу явж байгаа эсэхийг иргэд, олон нийтийн хяналтад өгөх стратегийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагатай хамтран ажиллаж байна.

Энэ хүрээнд орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах чиг үүрэг бүхий авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийг 2017 онд байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Иргэний хяналтын зөвлөлийн 124 гишүүнийг 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллаж байна. (Биелэлт 90 хувь)

4.1.7.4-2. Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдийг сургах, чадавхжуулах /АТГ 2017-2022/

Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон яам, агентлагийн дэргэд ажиллах авлигаас урьдчилан сэргийлэх Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдэд “Олон нийтийн хяналт ба хамтын ажиллагаа” сэдэвт чадавхжуулах сургалтыг 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрөөс 3 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулав. Уг сургалтаар Авлигатай тэмцэх газрын албан хаагчид болон Үндэсний аудитын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн



бодлого, зохицуулалтын газар, Удирдлагын академи, “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагын зочин багш нар 20 сэдвийн хүрээнд нийт 13.5 цагийн сургалтыг орсон ба сургалтад аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллах нийт 15 гишүүнээс 142 гишүүн хамрагдав. (Биелэлт 90 хувь)

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын эрх олгох сургалтыг 2018 оны 1 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд, мөн тэднийг сургагч багшаар бэлтгэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдэвт сургалт, Удирдлагын академийн 2 модулийг түрших сургалтад тус тус хамруулав.

Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификат олгох сургалтыг 14 удаа зохион байгуулсан бөгөөд уг сургалтад 71 байгууллагын 650 гаруй албан хаагч хамрагдсан байна. Мөн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын эрх олгох сургалтыг “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” төрийн бус байгууллага, “Худалдан авах ажиллагааны боловсролын төв” төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд уг сургалтад яам, агентлаг, нийслэл, дүүргийн иргэний хяналтын зөвлөлийн 80 гишүүнийг хамруулсан.

Мөн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг эрүүл мэндийн салбарт буюу аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогооны төв, төрөх, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хорооны 5 өрхийн эмнэлэгт 2018 оны 1-2 дугаар улиралд ажиллуулан “Эрүүл мэндийн салбар дахь төрийн үйлчилгээ, анхаарах асуудлууд”, “Эрүүл мэндийн салбар дахь авлигын нөхцөл байдал”,

“Эрүүл мэндийн салбарт ажиллах чиглэл” гэсэн үндсэн 3 сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулж, онлайн хэлбэрээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулав.

“Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сургалтын модулиар сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 2018 оны 12 дугаар сард зохион байгуулж 21 аймгаас тус бүр 3 төрийн албан хаагч 63 хүн, нийслэлээс Иргэний хяналтын зөвлөлийн 69 гишүүн, нийт 132 хүнийг хамруулав. Сургагч багшийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг баталгаажуулах сургалтыг нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийтийн албан тушаалтанд зориулан сургагч багш нартай хамтран цуврал байдлаар зохион байгуулж ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, чадавхжууллаа.

Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, явц байдлыг хянан үзэх, төсөв санхүүгийн зарцуулалт худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг хянан шалгах, аймгийн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, иргэдээс гаргасан гомдол мэдээллийг хянан шалгах зорилгоор 2018 онд 21 аймаг, 32 суманд ажилласан.

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцан, заавар зөвлөгөө өгч, дэмжин туслах чиглэлээр ахмадын зөвлөлийн гишүүдтэй гэрээ байгуулан ажилласаар яам, агентлаг, нийслэл, дүүргийн иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөмж, чиглэл өгөх уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. (Биелэлт 90 хувь)

4.1.7.4-3. Олон нийтийн дэд зөвлөлийн ажиллах журмыг батлуулж, мөрдөх /АТГ 2017/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.1.7, 4.1.7.4, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.15-д заасныг үндэслэн орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд ажиллах “Олон нийтийн дэд зөвлөл ажиллах журам”-ыг 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга, Авлигатай тэмцэх газрын даргын А/53, А/44 дүгээр хамтарсан тушаалаар баталгаажуулав. Энэхүү шийдвэрт зааснаар яам, агентлагийн дэргэд 60 гишүүнтэй 19 нэгж, аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд 108 гишүүнтэй 22 нэгж, нийтдээ 168 гишүүнтэй 41 нэгж “аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, түүнд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох”, “төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох”, “Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх” зэрэг үндсэн гурван чиглэлээр аливаа сонгон шалгаруулалт, хүний нөөц, боловсон хүчний томилгоотой холбоотой зөрчил бүхий шийдвэрийг шалгуулах хүсэлтээ Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, төсөв, санхүү, төсвийн орлого, зарцуулалт, хандив, зээл тусламж, төсөл, хөтөлбөр тэдгээрийн ил тод байдалд хяналт тавих, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө,

орлогын мэдүүлэгт хяналт тавих зэрэг нийт 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахаар ажиллах журамд тусгагдсан үүрэг гүйцэтгэх эрх зүйн үндсийг тодорхойлсон болно. (Биелэлт 90 хувь)

4.1.7.5-1. Авлигын тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг боловсронгуй болгох /АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар “Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан. (Биелэлт 90 хувь)

4.1.7.5-2. Олон нийтийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, гишүүдийн урамшууллын асуудлыг шийдвэрлүүлэх /АТГ, ХЗДХЯ, АТГ-ын дэргэдэх ОНЗ 2018-2020/

Олон нийтийн зөвлөлийн ажиллах өрөө тасалгааны асуудлыг шийдвэрлэж, тохижилтыг хийж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.7.5-3. Олон улсын туршлагад тулгуурлан Олон нийтийн зөвлөлийн дэргэд Авлигын эсрэг иргэд, залуучуудын клубыг байгуулах /АТГ-ын дэргэдэх ОНЗ. АТГ 2018-2022/

2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.7.6-1. Авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан этгээдийг олон нийтэд ил тод мэдээлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх /АТГ, ХЗДХЯ, ШЕЗ, ТББ 2018-2019/

Захиргааны ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх эрх зүйн зохицуулалтын орчин бүрдсэн, мөн шүүхийн шийдвэрийн нээлттэй, ил тод байх



зарчим үйлчилж байгаа учраас асуудлаар мэдээлэх боломж бүрдсэн. Цаашид илүү нарийвчилсан зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай. (Биелэлт 50 хувь)

Найм. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 7 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.8.1-1. Баримтад суурилсан сэтгүүл зүйг хөхиүлэн дэмжих, сэтгүүлчдийн цахим орчинд мэдээлэл олж авах чадавхийг нэмэгдүүлэх /АТГ, ХХМТГ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн наймдугаар зорилт (иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх)-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллагатай 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Уг санамж бичгийн хүрээнд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтад хэвлэл, мэдээллийн байгууллагын 25 ажилтан хамрагдсан. “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдвээр хэвлэл мэдээллийн байгууллагын 30 ажилтанд 2 өдрийн сургалтыг Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион байгуулав.

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс санаачлан “Үндэсний сэтгүүл зүйн шинэ дэвшилтэт хөгжлийн төлөө”

үзэл баримтлалын дор сэтгүүл зүйн хэвлэн нийтлэх эрх, түүний дотор шинэ тутам хөгжиж байгаа цахим сэтгүүл зүйн өмнө тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэх, цахим салбарын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдээлэл олж авах, түгээх эрхтэй холбоотойгоор “Цахим сэтгүүл зүйн II форум”-ыг 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж, цахим орчин дахь мэргэжлийн сэтгүүл зүйн хөгжил, тулгамдсан асуудал, онлайн контентийн олон улсын зохицуулалт, нийгмийн сүлжээн дэх зохистой хэрэглээг бий болгох нь, цахим орчин дахь зохиогчийн эрхийн асуудал зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв. (Биелэлт 80 хувь)

4.1.8.1-2. Эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд сургалт зохион байгуулсан байх /АТГ, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, 2018-2020/

Авлигатай тэмцэх газар, “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээг 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр байгуулж сэтгүүлчдэд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг, оролцоо” сэдвийн дор 2 удаагийн модуль сургалтыг зохион байгуулахаар болсон. Уг гэрээний дагуу “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллага нь эрэн сурвалжлах сэтгүүлзүйн гарын авлага, сургалтын хөтөлбөрийг Германы “Дойчэ Вилле академи”-иас гаргасан модуль, арга зүйд тулгуурлан боловсруулж, 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Эхний сургалтад 2018 оны 3 дугаар сарын 22, 23-ны өдөр эрэн сурвалжлах сэтгүүлзүйгээр мэргэших сонирхолтой 23 сэтгүүлчийг, 12 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд 17 сэтгүүлчийг, нийт 40 сэтгүүлчийг хамруулж, чадавхжуулсан байна. (Биелэлт 60 хувь)

4.1.8.2-1. Сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тохиолдолд “Нөлөөллийн мэдүүлэг” гаргах, хууль бус нөлөөлөлд хариуцлага хүлээлгэх асуудлыг судлах, санал боловсруулах /МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, АТГ, ХЗДХЯ. 2018-2019/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлыг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хэвлэл мэдээллийн зөвлөл, “МОНЦАМЭ” мэдээллийн агентлаг, “Глоб интернэшнл төв” зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулж, санал хүсэлтийг авч, хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газартай хамтран 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Хэвлэл, мэдээллийн байгууллагын эрэн сурвалжлах сэтгүүлзүйн чиглэлээр дагнан ажилладаг сэтгүүлчдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор телевиз, сонин, сайт, богино долгионы (фм) радиогийн нийт 31 байгууллагын 36 сэтгүүлч мөн харьяа 12 агентлаг, байгууллагын хэвлэлийн төлөөлөгч нарыг хамруулан “Эрх зүйн сургалт, өдөрлөг” зохион байгуулсан. Мөн гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 20 сэтгүүлч, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх хууль зүйн туслалцааг сайжруулах зорилгоор 50 өмгөөлөгчийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа.

Авлигатай тэмцэх газар, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тоо

баримтыг бүрдүүлэхээр нийслэл болон орон нутгийн 300 сэтгүүлчийн дунд санал асуулгын судалгааг явуулж байна. Судалгааны үр дүн 2019 оны 5 дугаар сард гарна.

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс сэтгүүлчийн эрхийг хангах, аливаа хууль бус нөлөөллөөс хамгаалах чиглэлээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх зорилгоор өмгөөллийн байгууллагатай хамтран тодорхой ажлуудыг эхлүүлж, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хариуцлагад татдаг асуудлыг өөрчлөх зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, мэргэжлийн байгууллагуудтай цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав. (Биелэлт 20 хувь)

4.1.8.2-2. НҮБ-ын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй орчинг бүрдүүлэх уриалга, ЮНЕСКО-гоос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнах /ГХЯ, 2017-2020/

Гадаад харилцааны яамнаас НҮБ-аас гаргасан уриалга, ЮНЕСКО-гоос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулах гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сурвалжилга, нэвтрүүлэг хийх гадаадын сурвалжлагчдын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлэх, түр сурвалжлагчийн үнэмлэх олгох, гадаадын сурвалжлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллах журмыг шинэчлэхээр холбогдох төслийг боловсруулан Засгийн газраар батлуулахаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Харин “Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллагаас жил бүрийн 11 дүгээр сарын 2-ны өдрийг “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг



таслан зогсоох өдөр” болгон зарласантай холбогдуулан 2017 онд “IFEX” олон улсын сүлжээний дэмжлэгтэйгээр “Аюулгүй, Хамгаалагдсан, Айдасгүй” сэдвийн дор хагас жилийн кампанит аян өрнүүлж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах чиглэлээр гурван шторк бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээсэн ба энэ өдөр сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлууд болон Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын зохих зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зорилгоор “АХА” хагас өдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. Мөн 2018 оны 11 дүгээр сарын 2-нд Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Глоб интернэшнл төв”, Монголын хуульчдын холбоо хамтран гүйцэтгэж буй Монголын хэвлэл мэдээллийн орчин, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг тодорхойлох судалгааны явцын мэдээллийг танилцуулж, сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаар хэвлэлийн бага хурал хийсэн. Гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан, албан хаагч, сэтгүүлчдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сурвалжилга, нэвтрүүлэг хийх гадаадын сурвалжлагчдын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, Гадаад харилцааны яаман дээр бүртгэж, түр сурвалжлагчийн үнэмлэх олгож байна. Түүнчлэн гадаадын сурвалжлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллах журмыг Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар шинэчлэн батлуулав.

ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын Тамгын газар хооронд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурсан. Талууд хамтран ажиллах хүрээнд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл, ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах болон бусад харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааны

талаар харилцан мэдээлэл солилцохоор тохиролцсон.

“Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран цагдаагийн байгууллагын албан хаагчид болон прокуроруудад зориулан соёлын өвийг хамгаалах, авлигаас урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалт зохион байгуулах сургалтын гарын авлага, хөтөлбөрийг боловсруулж байна. Сургалтыг 2019 оны эхний хагаст зохион байгуулахаар ажиллаж байна. (Биелэлт 40 хувь)

4.1.8.3-1. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ 2017-2019/

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/233 тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдлын хангах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд салбарын болон холбогдох чиглэлийн судлаач, мэргэжилтэн, иргэдийн төлөөллийг оролцуулан “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумыг Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс 2018 оны 5 дугаар сард зохион байгуулж, сэтгүүл зүйн хөгжил, цаашдын хандлага, сэтгүүлчийн мэргэжлийн боловсрол, ажиллах орчин, нийгмийн асуудал зэрэг салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарч, шийдлийг авч хэлэлцжээ. Түүнчлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлыг хангах чиглэлээр Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс хэлэлцүүлэг, сургалтуудыг цувралаар зохион байгуулж ажилласан. Тухайлбал, “Ёс зүй, мэргэжлийн хараат бус сэтгүүл зүйг төлөвшүүлэх, сэтгүүлчдийн мэргэжил боловсролыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь” болон “Сэтгүүл зүйн салбарт санхүүгийн хараат бус байдлыг бүх түвшинд нэмэгдүүлэх” зорилгоор орон

нутгийн салбар зөвлөлүүдийг идэвхижүүлэх 18 удаагийн уулзалтыг аймгуудад цуврал байдлаар зохион байгуулсан. (Биелэлт 10 хувь)

4.1.8.4-1. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ. МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл. 2018-2022/

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбарт мэдээ, мэдээлэл олж авах, хэвлэн нийтлэх, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээлэл, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг боловсруулах зорилгоор 2018 оны 3 дугаар сард “Цахим эрин ба сэтгүүл зүй, чиг хандлага” сэдэвт сэтгүүлч, сэтгүүлзүй судлаачдын IV симпозиумыг зохион байгууллаа. (Биелэлт 0 хувь)

4.1.8.5-1. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг редакц, сэтгүүлчдэд мөрдүүлэх, таниулан сургах, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах /Хэвлэл мэдээллийн зөвлөл 2017-2019/

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015 оны 4 дүгээр сараас ёс зүйн зөрчилтэй сэтгүүл зүйн бүтээлийн эсрэг иргэдийн гомдлыг хүлээн авч эхэлсэн ба 2015-2018 онд нийт 227 гомдлыг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс 2017 онд нийт гомдлын 41 хувь буюу 16 иргэн, байгууллагаас 49 хэвлэл мэдээлэлд хаягласан гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүний зэрэгцээ 400 орчим иргэн, 600 гаруй сэтгүүлчтэй нүүр тулсан уулзалт, ярилцлага, сургалт хийж, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчмыг таниулан сурталчлах ажлыг үндэсний

хэмжээнд зохион байгуулжээ. 2018 онд нийт 100 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 14 гомдол радио телевизийн ёс зүйн хороонд, сонин, сайт, сэтгүүлийн ёс зүйн хороонд ирсэн.

Мөн Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоотой хамтран Өмнөговь, Орхон, Дорнод, Увс аймагт бүсчилсэн семинар зохион байгуулж, сэтгүүлчдээс гадна иргэдэд зориулсан сургалтууд зохион байгуулсан ба үйл ажиллагаагаа www.mediacouncil.mn сайт, Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл фэйсбүүк хуудас, улирал тутмын цахим сэтгүүлээр дамжуулан мэдээ мэдээллийг тогтмол түгээж байна. (Биелэлт 50 хувь)

Ес. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9 дэх зорилтын хүрээнд нийт 8 үйл ажиллагаа, 17 арга хэмжээг тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.9.1-1. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод мэдээлэх, мэдээлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх чиглэлээр хууль тогтоомжид байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх /CEX, 2018-2019/

Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намын санхүүжилт, тэр дундаа улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг ил тод байлгах, түүнд тавих хяналт, хариуцлагыг зайлшгүй хүлээлгэдэг байх чиглэлээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудад холбогдох зохицуулалтуудыг тусгахаар



саналаа УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлээд байна. Саналд сонгуульд оролцож буй нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг төрийн аудитын дээд байгууллагаас тогтоож нийтэд мэдээлдэг. Харин төрийн аудитын дээд байгууллагаас зардлын дээд хэмжээ тогтоосон аргачлал буюу хэрхэн тооцож дээд хэмжээг тогтоосон нь ил тод бус, тодорхойгүй байдаг. Иймд “Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагыг харгалзана.”, “Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.” гэсэн зохицуулалтыг хуулийн төслүүдэд тусгах; Сонгуулийн тухай хуульд зааснаар нэр дэвшигчийн сонгуулийн зардлын нэг бүрдэл нь хандив бөгөөд хандив нь мөнгөн болон мөнгөн бус хандив байхаар хуульчилсан. Мөнгөн бус хандив нь үйлчилгээ байж болох бөгөөд мөнгөн бус хандивын үнэлгээг гэрээгээр тохиролцоно гэж заасан. Энэ нь мөнгөн бус хандив нэртэйгээр хэдэн ч төгрөгийн үнэтэй үйлчилгээг зах зээлийн бодит үнэлгээг харгалзахгүйгээр зөвхөн гэрээгээр тохиролцож, үүнийг тайландаа тусгах боломжийг бүрдүүлж, улс төрийн намын сонгуулийн санхүүжилтэд тавигдах хуульд заасан хэмжээнээс бодитоор хэтрүүлэх боломжийг хуулиар олгож байна гэж үзсэн учир төсөлд “Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэж тусгах; Сонгуулийн зардлын тайланд тавих хяналт, түүнийг ил тод нээлттэй мэдээлэх зэрэг сонгуулийн санхүүжилтийг ил тод байлгахад төрийн аудитын байгууллагын эрх үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн зохицуулалтуудыг

хуулийн төсөлд тусгуулав. Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байх талаар зохицуулалтыг оруулахаар тусгасан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.1-2. Сонгуулийн зардлын тайлангийн хяналт, ил тод байдал, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.2-1. Улс төрийн намуудад төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлыг тайлагнах, ил тод мэдээлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх /ХЗДХЯ, 2017-2019/

Хууль зүй, дотоод хэргийн яам Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг боловсруулж, хүргүүлсэн. Уг хуулийн гол үндэслэл, зохицуулах харилцаа нь улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчинг тодорхой болгох, намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс тавих хяналт, зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах явдал юм. (Биелэлт 10 хувь)

4.1.9.2-2. Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх /ХЗДХЯ, 2018-2022/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.3-1. Парламентад суудалгүй намуудад төрөөс олгох санхүүжилтийг хүртээмжтэй болгох асуудлыг судалж шийдвэрлэх /СЕХ, 2017-2019/

Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн

сонгуулийн тухай бие даасан хуулийн төсөлд санал боловсруулан УИХ-д хүргүүлсэн. УИХ-ын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн санал боловсруулахдаа Европын Аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Сонгууль ажиглах хорооноос гаргасан 2016, 2017 оны эцсийн тайланд тусгасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.

Сонгуулийн санхүүжилт, улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй, ил тод байлгахад чиглэгдсэн саналуудыг төсөлд тусгасан. 2018 онд хуулийн төсөлд эрдэмтэн судлаачдын санал авах, улс төрийн намын төлөөлөл, судлаачдыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.3-2. Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох/СЕХ, 2017-2022/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.4-1. Сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох /СЕХ, 2018-2019/

УИХ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 195 тоот захирамжаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслүүдийн санал боловсруулсан. Мөн хуулийн төслүүдийг улс төрийн 28 нам, 9 төрийн бус байгууллагад хүргүүлсэн бөгөөд

тус Хорооны цахим хуудаст байршуулан нээлттэй санал авах ажлыг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо болон дэд ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулж байна. Сонгуулийн санхүүжилт, улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардал, түүнд тавих хяналтыг үр дүнтэй, ил тод байлгахад чиглэгдсэн саналуудыг төсөлд тусгасан болно. 2018 оны 10 дугаар сард хуулийн төсөлд эрдэмтэн судлаачдын санал авах, улс төрийн намын төлөөлөл, судлаачдыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-д заасны дагуу дээрх гурван хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцоог хийлгэсэн; 2018 оны 10 дугаар сард улс төрийн 26 намын төлөөлөл, 8 төрийн бус байгууллагын төлөөлөл, Батлан хамгаалах яам, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Хил хамгаалах ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Үндэсний аудитын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, мөн судлаачид нийт 150 гаруй хүнийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан; Хуулиудын төслийг хэвлүүлж Улсын дээд шүүхэд бүртгэлтэй нийт 28 /2018 оны 9 сар/ улс төрийн намуудад, төрийн болон төрийн бус нийт 16 байгууллагад хүргүүлж санал авах ажлыг зохион байгуулсан. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудаст хуулиудын төслийг нээлттэйгээр байршуулан санал авч байна. (Биелэлт 10 хувь)



4.1.9.4-2. Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах /ХЗДХЯ, 2018-2019/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.5-1. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах, УИХ-ын гишүүдийн шударга байдал, ёс зүйн дүрэм, шийдвэр гаргалтын үйл явцыг шинэчлэх, дагаж мөрдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2022/

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д төрийн улс төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоохоор тусгасан. (Биелэлт 10 хувь)

4.1.9.5-2. Оффшор бүсэд данс эзэмшдэг этгээдийг төрийн албанд ажиллуулахгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт тавих механизмыг бүрдүүлэх /ХЗДХЯ, АТГ, 2017-2019/

УИХ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 4 дүгээр сард, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2017 оны 5 дугаар сард тус тус баталсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.3}-т заасныг үндэслэн оффшор бүсэд хамаарах нийт 49 нутаг дэвсгэрийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 326 дугаар тогтоолоор тус тус баталсан. Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 129 дүгээр тушаалаар 2012 оны

91 дүгээр тушаалд нэмэлт оруулж, «мэдүүлэг гаргагч албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулсан талаарх бүртгэлийн маягт”-ыг баталсан.

Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт мэдүүлж, мэдэгдэж бүртгүүлсэн болно. Дээрх хуулийн хэрэгжилт болон хуулийн хугацаанд үүргээ биелүүлж мэдэгдсэн албан тушаалтнуудын талаарх мэдээллийг тус газрын цахим сайтад байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Оффшор бүсэд хамаарах хориглолтын талаар яам, агентлаг, аймаг, нийслэл болон холбогдох албан тушаалтнуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгч, хуулийг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулсан. (Биелэлт 40 хувь)

4.1.9.5-3. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх /ХЗДХЯ, 2018-2022/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд хуулийн төсөлд “Нийтийн

албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх” гэсэн зүйл нэмэхээр тусгаад байна. Ажлын хэсгийг шинэчлэн байгуулахаар байгууллагуудаас санал авч байна.

4.1.9.6-1. Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх/АТГ, 2017-2018/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй.

4.1.9.7-1. Төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэний оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төсөлд санал авахаар 2018 оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс болон яамд, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хуулийн төслийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалтыг танилцуулах, хуулийн төсөлд санал авах зорилгоор иргэд, олон нийт, судлаачид болон холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 10 дугаар сард зохион байгуулсан. Саналуудыг хүлээн авч, судалгаа хийн, саналуудыг харгалзан нэгтгэн дүгнэж, хуулийн төсөлд нэмэлт боловсруулалт хийж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.9.8-1. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох /ХЗДХЯ, 2018-2020/

Хууль зүй, дотоод хэргийн яам Төрийн

бус байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан төсөл боловсруулж байна. (Биелэлт 10 хувь)

4.1.9.8-2. Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох тогтолцоо бий болгох, иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх хэлбэрийг хуульчлан тогтоох /ХЗДХЯ, 2017-2020/

Хууль зүй, дотоод хэргийн яам “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр”-ийн үзэл баримтлалын хэлэлцүүлгийг Улаанбаатар, Хэнтий, Ховд, Өвөрхангай аймгуудад бүсчлэн зохион байгуулсан бөгөөд Улаанбаатар хот, 21 аймаг, бүх сумдын төрийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан 800 гаруй хүн уг хэлэлцүүлэгт оролцож, санал бодлоо илэрхийлсэн. “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх өнөөгийн нөөц бололцоо” сэдэвт бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга зам тус бүрт эрх зүйн үйлчилгээ үзүүлж байгаа сувгууд, тэдгээрийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай хүрч үйлчлэх сувгуудыг тодорхойлсон. Судалгаанд эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, сургалт, туслалцаа, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл /радио, телевиз, сонин, сэтгүүл, нийгмийн сүлжээ г.м/, боловсрол, өмгөөлөл, нотариат, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудыг хамруулсан бөгөөд тухайн байгууллагаас авсан мэдээлэл, тэдгээрийн албан ёсны цахим хуудас, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрөл олгодог байгууллагаас авсан тоо мэдээ, статистик судалгаа, Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн “Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” судалгааны дүн зэрэг бичиг баримт, мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийсэн. Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/60 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан



“Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албан хаагчдыг чадавхижуулах хөтөлбөр”-ийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан сургалтын жилийн төлөвлөгөө”-ний 1 ба 2 дугаар шатны сургалтыг 2 өдөр тус тус зохион байгуулж, нийт 38 албан хаагч хамрагдсан. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т заасан “Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил өрнүүлэх” зорилтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн үндэсний хороо, “Эрчүүд, гэр бүл хөгжлийн нийгэмлэг” төрийн бус байгууллага хамтран “Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Нийслэлийн цагдаагийн газрын харьяа газар, хэлтэс, төв, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 51 эрэгтэй алба хаагч хамрагдсан. Гадаадын иргэн, харьяатын газрын нийт 67 албан хаагчийг хамруулан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хүрээнд “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавхи, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг зохион байгуулж 12 аймгийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүн зэрэг 360 хүнийг хамруулсан. (Биелэлт 30 хувь)

4.1.9.8-3. Улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад сайн дураараа оролцож байгаа иргэн, иргэний нийгмийн байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг судалж шийдвэрлүүлэх /СЯ, ХЗДХЯ, 2018-2022/

2017-2018 онд тодорхой ажил хийгдээгүй. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг боловсруулж байна. Сангийн яамнаас нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн үнэлгээ, аудитын чиглэлээр зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж ажилладаг. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд нийгмийн шударга ёс, ардчилал, сайн засаглалыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг нийтэд тустай үйл ажиллагааг тогтмол, эсхүл хариу төлбөргүйгээр эрхэлж байгаа иргэний нийгмийн байгууллагыг мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг, татварын бодлогоор дэмжихээр тусгасан. (Биелэлт 10 хувь)

Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зорилтын хүрээнд 10 арга хэмжээг 2017 онд эхлүүлж, 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Зорилтын хэрэгжилтийг товч танилцуулбал:

4.1.10.1-1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах /АТГ, 2017-2022/

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд авлигын эсрэг сургалтыг зохион байгуулж байна. 2017 онд авлига, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийт 2017 онд 11345, 2018 онд 14783 хүнийг сургалтад хамруулсан байна. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны чиглэлээр Удирдлагын академи, МУИС, МУБИС, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, “Глоб интернэшнл төв”, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөгжлийн түлхүүр, Жаргалант хангай, Иргэний боловсрол төв, Онч шийдэл, Боловсролын хамтын ажиллагааны төв, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Азийн сан, Бие даасан боловсрол хөгжлийн төв, Нээлттэй нийгэм форум, Худалдан авах үйл ажиллагааны хөтөч, Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв, Хүний хөгжил судалгаа сургалтын төв, Худалдан авах ажиллагааны боловсролын төв, Төсвийн удирдлагын хүрээлэн, Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллав.

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-т иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх, тэднийг чадавхжуулах, хүний эрхийн зөрчлийг ялгаж таних, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан. Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас Цагдаагийн ерөнхий газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль сурталчлах зорилгоор олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг

зохион байгуулсан.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн телевизтэй байгуулсан гэрээний дагуу “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт 2018 онд “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” буланг нэмж, 40 цуврал нэвтрүүлэг хамтран бэлтгэж, олон нийтийн хүртээл болгосон. Энэхүү ажлыг 2019 онд өргөжүүлж Монголын үндэсний олон нийтийн телевизийн хөтөлбөрт 14 хоног тутамд 1 удаа цацагдах “Авлигатай тэмцэх газрын цаг” нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэнэ.

Түүнчлэн Монголын Үндэсний олон нийтийн радиогийн “Баримт” нэвтрүүлэгтэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг ухуулах чиглэлээр 3 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн цацав.

Байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэх нийт 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав. Хэвлэлийн бага хуралд хийх үндсэн мэдээллийг боловсруулж, дата мэдээлэл болон график дүрст мэдээллийг бэлтгэж, хэвлэлийн бага хурлын өмнө төдийгүй дараа нь мэдээлэл сурталчилгааг үргэлжлүүлэн идэвхжүүлж ажилласан болно.

Авлигын эсрэг сурталчилгааны материал, эмхэтгэл, товхимол хэвлүүлэх, түгээх ажлын хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан тэмдэглэлийн дэвтэр 1000, халаастай хавтас 1000, жижиг тэмдэглэлийн дэвтэр 1000 ширхэг хэвлүүлэн түгээв. Мөн Авлигатай тэмцэх газрын танилцуулгыг англи, монгол хэлээр бэлтгэж 1000, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл 3000 ширхэг тус тус хэвлүүлэн олон нийтэд тараав. Авлигын хор хөнөөлийг иргэд олон нийтэд таниулах, шударга бус, ёс зүйгүй үйлдлийн эсрэг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Монгол контент” ХХК-иар “Авлига боловсролын эсрэг гэмт хэрэг”, “Авлига хөгжил дэвшлийн эсрэг гэмт



хэрэг”, “Авлига байгаль орчны эсрэг гэмт хэрэг”, “Авлига хүний эрхийн эсрэг гэмт хэрэг”, “Авлига эдийн засгийн эсрэг гэмт хэрэг” гэсэн агуулга бүхий 5 төрлийн постер хэвлүүлэн 15000 ширхэг хэвлүүлж, 21 аймаг, 330 суманд 5600 ширхэг, 13 яам, агентлаг дүүрэгт 3000 ширхгийг тус тус түгээв.

Авлигын эсрэг сурталчилгаа хийж, түгээх ажлын хүрээнд: Шударга ёсыг эрхэмлэх, төлөвшүүлэх, авлигын хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гомдол, мэдээллийг хүлээн авах утасны дугаарыг сурталчилсан 6 радио спот бэлтгэж, “Тэр бүлийн радио 104.5” радиогоор 60 удаагийн цацалт хийлгэх ажлыг зохион байгуулж, дүрсжүүлэх ажлыг Азийн сантай хамтран хийж олон нийтэд түгээсэн;

“Тендер”, “Байцаагч”, “Эмч” сэдэвт 3 төрлийн вирал видео бэлтгэж сошиал сүлжээгээр олон нийтэд цацсан. Түүнчлэн 13 яам, холбогдох агентлаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад эрүүл мэндийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулан сурталчлах, Олон нийтийн төвд зохион байгуулагдсан төрийн албан хаагчдад зориулсан сургалтын үеэр оролцогчдод танилцуулах арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн. “Туулайхүүгийн адал явдал” зохиолын баатраар зохиомжилсон хүүхэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмын ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жичиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3 төрлийн 3D анимэйшн бэлтгэж цацсан.

“Шударга үнэнийг дэмжинэ” гэдэг уриалгыг дэвшүүлж, үүнийгээ бэлгэ тэмдэг болгон энгэртээ бичгийн хавчаар зүүж авлигатай тэмцэж буйгаа илэрхийлэх санаачилгыг гарган ажилласан. Бичгийн хавчаарыг сонгох болсон шалтгааныг “Нийгэмд болж бүтэхгүй байгаа муу муухай бүхнийг хавчиж гаргах ёстой” гэсэн агуулгаар илтгэж байгаа бөгөөд үүнийг таниулах ажлыг гүйцэтгэсэн нь 12611 хүнд хүрсэн. Мөн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг татан оролцуулж холбогдох яам, агентлагт ажиллаж буй

төрийн албан хаагч нарыг тус аянд нэгтгэж, цахим хуудас, фэйсбүүк профайл зургийг бичгийг хавчаараар солих ажлыг зохион байгуулан хэрэгжүүлсэн ба аянд Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын нийт 18 сургууль, нийслэлийн 46, 59, 68, 78, 84, 87, 111 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид болох нийт 225 гаруй багш, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн харьяа агентлаг, байгууллагууд, Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн байгууллагын нийт 120 албан хаагч тус тус нэгдсэн төдийгүй “Олны танил” хүмүүсийг аянд нэгдүүлэхээр “Өөр Ирээдүй” фэйсбүүк профайл солих давалгаа “Бид өөр ирээдүй хүсч байна” агуулгатай фэйсбүүк профайл фрэмийн солих давалгаанд Аанхаа, Рэй, Татар Мөөгий, дуучин Аанхаа, Гантоого, Жижгээ, Цогтоо, Амри /F Studio/, Дэлгэр, Шагж, Батдэлгэр нарын олны танил эрхмүүд өөрсдийн цахим хуудсаа өөрчлөн уг аянд нэгдсэн. Тухайлбал, Аанхаагийн “Сайн нь муугаас олон”, Шагж Гэлэнгийн “Гар луу биш тэмүүлэл рүү харах залуу үе”, “Хүүхдээ сургуульд оруулахдаа аргагүй байдалд орж хахууль өгсөн бол энэ тухайгаа Авлигатай тэмцэх газарт мэдээлээрэй” зэрэг нийтлэлийг бэлтгэн түгээсэн нь 20000-аас дээш дагагчтай давалгаа болж өргөжсөн;

Авлигын эсрэг “Нэг үйлдэл” аяны хүрээнд 3 удаагийн фэйсбүүк LIVE ярилцлага явуулсан (зочноор Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү оролцсон) нь 14000 гаруй удаагийн үзэлт авсан ба хэвлэл мэдээлэлд хандсан аяны уриалгыг боловсруулж 100 гаруй редакц, 200 сэтгүүлчид хүргүүлсний үр дүнд нь хэвлэл мэдээллийн оролцоо нэмэгдсэн. Хувийн хэвшлийн 5 байгууллага (Lhamour, BeautySecrets.mn, Монголын Хуульчды Холбоо, Цагдаагийн ерөнхий газар, Глоб Интернэшнл төрийн бус байгууллага)-ын бүтээлч нэг үйлдэл хийхэд дэмжлэг үзүүлж, гадаадад байгаа монголчуудыг уг аянд уриалах зэрэг нөлөөллийн ажлын үр дүнд нийгэмд нөлөө бүхий их сургуулийн

багш, хуульчид, бизнес эрхлэгчид, залуу мэргэжилтнүүдийн авлига, шударга бусын эсрэг дуу хоолой нэмэгдсэн болно.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2018 онд Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид (96), Зориг сангийн Ардчиллын элч манлайллын хөтөлбөрт хамрагдсан нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын (17) сурагч, “Lead Mongolia” хөтөлбөрөөс зохион байгуулсан “Гэрэл тусгая” төслийн үеэр (150) хүүхэд залуус болон Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэд (70) “Авлигын ойлголт, шалтгаан, хор хөнөөл сэдвээр” сургалт тус тус хийжээ. (Биелэлт 40 хувь)

4.1.10.1-2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материал боловсруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулахад иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг олон нийтэд хүргэхэд сэтгүүлч, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, олон нийтийг оролцоог хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулах, сургалт хийх, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэх, уулзалт, хэлэлцүүлэг хийх зэргээр хамтран ажиллаж, авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх ажлын хүрээнд сурталчилгааны материал, эмхэтгэл, товхимол хэвлүүлж тараах, видео шторк, радио спот, сошиал вирал видео, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг, ярилцлага хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх ажлыг тогтмол хийж хэрэгжүүлж байна. Тухайлбал, хүүхэд, залуучууд, олон нийтэд авлигын хор хөнөөлийг таниулах, авлигыг үл тэвчих шударга ёсны үзэл санааг

төлөвшүүлэх зорилгын хүрээнд Монголын Сурагчдын холбоо, Монголын Оюутны холбоо, Монголын Залуучуудын холбоо, “Глоб интернэшнл төв” зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, гарын авлага боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Тодорхой салбарт ажиллаж буй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан үр дүнгийн талаар “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллагатай, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээлийн хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалт хамтран зохион байгуулах, туршилтын сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, “Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг чиглэлээр Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшнл төв, Захиргааны шинэ санаачилга, Иргэний боловсрол төв, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, АНУ-ын Азийн сан, Транспэрэнси интернэшнл Монгол, “Онч шийдэл” зэрэг төрийн бус байгууллага, МУИС, МУБИС, Удирдлагын академийн багш нар, судлаач, эрдэмтэдтэй хамтран ажиллав.

Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэдэх Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг хамруулсан “Олон нийтийн хяналт ба хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хүүхэд, залуусын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Монголын Залуучуудын



холбоо, Монголын Оюутны холбоо, Монголын Сурагчдын холбоо болон зарим сургуулийн оюутны холбоо зэрэг төрийн бус 12 байгууллагын төлөөллийг оролцуулсан “Авлигатай тэмцэхэд залуу үеийн үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор богино долгионы радиотой хамтран Авлигатай тэмцэх газрын албан хаагчид, төрийн бус байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаачдыг урьж авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх, авлигын илрэх хэлбэр, шалтгаан, нөлөөлдөг хүчин зүйлс, авлигатай тэмцэхэд иргэдийн оролцоо, хяналт тавих боломж, эрх зүйн орчны талаар ойлголт мэдлэг олгох зорилгоор олон талт сэдвээр ярилцлага, нэвтрүүлгийг тус тус зохион байгуулсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих хүрээнд 2017 онд Монголын Залуучуудын холбоо, Монголын оюутны холбоо, “Монголын сурагчдын холбоо зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах САНАМЖ БИЧИГ байгуулж байсан бол 2018 онд хамтран ажиллах тусгайлсан төлөвлөгөө батлан хамтран хэрэгжүүлээ. Монголын залуучуудын холбоо төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 5 зорилт бүхий 29, “Монголын оюутны холбоо” төрийн бус байгууллагатай 7 зорилт бүхий 11 ажил, арга хэмжээ төлөвлөн хамтран хэрэгжүүлсэн бол “Монголын сурагчдын холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Сургалтын модуль” боловсруулах ажлын судалгаа хийх, “Туулайхүүгийн адал явдал” шударга ёсны номын агуулгыг зорилтот бүлэгт сургалт хэлбэрээр ухуулан таниулах ажлыг зохион байгууллаа. Тухайлбал, 2018 онд “Туулайхүүгийн адал явдал” сургалтыг олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт хоёр удаа, нийслэлийн Баянзүрх дүүргийн 84, 79 дүгээр сургууль, Сүхбаатар дүүргийн

58, 1 дүгээр сургууль, Баянгол дүүргийн 40, 19 дүгээр сургууль, Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор 1, 2, 3 дугаар бага сургууль, Багануур дүүргийн Боловсрол цогцолбор, Гүн Галуутай, 125 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн 59, 130 дугаар сургууль, Налайх дүүргийн Голомт, 103 дугаар сургууль, Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль, Чингэлтэй дүүргийн 24, 39 дүгээр сургууль зэрэг нийт 20 сургууль, Орхон, Хөвсгөл, Дорнод, Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, нийт 3848 хүүхэд хамруулсан.

Сургалтыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан жүжигчилсэн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд “Туулайхүүгийн адал явдал” ном, хүүхэд өөрийнхөө үнэнч шударга байдлыг үнэлэх зориулалттай “Шударга ёсны мод”-ыг сурагчдад танилцуулан 2000 гарын авлагыг сургалтын явцад түгээсэн. Орон нутагт “Туулайхүүгийн адал явдал” сургалтаар дамжуулан эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, ахлах, дунд ангийн сурагчид, бага ангийн сурагчдад зориулан “Хүн байхын учир”, “Сайн аав, ээж” сэдэвт сургалтыг зохион байгуулж, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдэд “2016 оны хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны дүнг танилцуулж, шударга байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

Нийслэлийн Соёл урлагийн газар, “Сурагчдын холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Эх үрсийн баяр”-ын арга хэмжээний үеэр 30 орчим сурагчдаар Туулайхүүгийн дүрээр Сүхбаатарын талбайд шударга, зөв хандлагыг уриалж, 3 төрлийн анимэйшнийг лед дэлгэцээр үзүүлэн, сурталчлав. “Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Өглөө хөтөлбөр, ROYAL телевизийн “Маамуутай өдөр” өдрийн хөтөлбөрт Монголын Сурагчдын холбоо, Туулайхүүгийн дүрийг бүтээгчид оролцож хөтөлбөрийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлаа олон нийтэд танилцуулав.

Монгол Улсад залуусын оролцоо,

манлайлал, ёс зүйн чиглэлээр манлайллын хөтөлбөр, сургалт, нөлөөллийн арга хэмжээ идэвхитэй зохион байгуулдаг Зориг сан, “World learning” төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Хэвлэлийн хүрээлэн, Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд зэрэг төрийн бус байгууллагуудыг судалж, Зориг сан, “World learning” төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав. Тухайлбал, “World learning” төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлсэн “Lead Mongolia” хөтөлбөрийн манайлагч залуусын “Эрүүл мэндийн салбарын ил тод байдлыг дэмжих” болон “Залуусын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах” багийн гишүүдтэй хамтран ажиллаж оюутан болон хүүхэд залуусын дунд авлигаас ангид байх, шударга ёс түгээн дэлгэрүүлэх “Гэрэл тусгая” богино хэмжээний видео бүтээх уралдааныг зохион байгуулах, дүгнэх нэг болон хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цааш нь түгээх санал санаачилгыг дэмжин ажиллав.

Мөн “Зориг сан”-гаас оюутан залуусыг хамруулан хэрэгжүүлж буй манлайллын хөтөлбөрт авлигын эсрэг сэдвийг тусгаж, хамтран ажилласан ба энэ хүрээнд “Ардчиллын элч” залуусын манлайллын хөтөлбөрт хамрагдсан 14 хүүхдэд авлигын ойлголт, шалтгаан, хор үршиг сэдвээр сургалт хийж чадавхжуулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа. (Биелэлт 40 хувь)

4.1.10.1-3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран зохион байгуулах чиглэлээр холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн ба 2016, 2017 онд 21 аймагт

албан томилолтоор ажиллах явцдаа Иргэний танхим хариуцсан ажилтнуудыг Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтад хамруулснаас гадна хувийн хэвшилтэй хамтран аймаг бүрт “Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд хувийн хэвшлийн үүрэг, оролцоо сэдэвт хэлэлцүүлэг хийв.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр орон нутгийн иргэний танхимын оролцоотойгоор холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газраас “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2017 оны 5 дугаар сард аймгийн төв талбайд зохион байгуулсан ба арга хэмжээний үеэр авлигын нийгмийн хор аюулын талаар таниулав. Өдөрлөгт нийт 600 орчим хүн оролцсон бөгөөд орон нутгийн захиргааны байгууллагууд 2017 онд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмыг иргэд, олон нийтэд сурталчлах, эрх зүйн зөвлөгөө өгөх, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах зэргээр ил тод байдлыг ханган ажилласан, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлэг зэргийг тус тус зохион байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газар нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн төсвөөр авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр сурталчилгааны материал, гарын авлага болох 5 төрлийн сурталчилгааны материалыг хэвлүүлж, түгээв.

Иргэний хяналтын төвийг нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн 4 төвд нээн ажиллуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан

бөгөөд 2019 оны нэгдүгээр улиралд үйл ажиллагаа явуулж эхэлнэ. (Биелэлт 30 хувь)

4.1.10.1-4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан өөрийн байгууллагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, төлөвлөгөөг албан ёсны цахим хуудас дээрээ ил тод мэдээлж, үр дүнгийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх талаар яам, агентлаг, аймаг, нийслэлд албан бичиг хүргүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын баг 2017 онд 21 аймаг, яам, агентлаг, нийслэл, дүүргийн байгууллагуудын Авлигын эсрэг төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцан зөвлөн туслах ажлыг гүйцэтгэв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, шалган зааварлах зорилгоор газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 4 дүгээр улиралд 21 аймаг, 50 суманд ажиллаж, үр дүнг орон нутгийн удирдлагад газар дээр танилцуулсан.

Ийнхүү өнгөрсөн 2 жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгүүд давхардсан тоогоор 21 аймаг, 144 суманд ажилласан нь нийт сумдын 43.6 хувийг эзэлж байна. Орон нутагт ийнхүү ажиллахдаа цөөн тооны хүчийг оновчтой зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах шалгалтад хамрагдсан байгууллага, орон нутгийн тоог 2013-2014 онтой

харьцуулахад даруй 3 дахин нэмэгдүүлсэнд оршино.

Түүнчлэн 2018 оны 2, 3 дугаар улиралд яам, агентлагт ажиллах явцад өмнөх жилүүдэд илэрсэн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, авлига үүсэх нөхцөл боломж бүрдүүлсэн дүрэм, журмыг хүчингүй болгох чиглэлээр Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 01/8723 дугаартай албан бичгээр хүргүүлсэн 159 асуудал бүхий ЗӨВЛӨМЖ-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 61 хувьтай байв. (Биелэлт 20 хувь)

4.1.10.2-1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах /БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд насан туршийн боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт 2017 онд боловсролын бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, үр чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж,

их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтыг зохион байгуулж эхлүүлэх, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, их, дээд сургууль, коллежийн багш нарт авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулж, үндэсний сургагч багшийг бэлтгэх болон нийт багш нарын сургалтыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгосон боловч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Харин Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалын хүрээнд Авлигатай тэмцэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулсан ба сургагч багш нарт зориулсан “Багшийн ёс зүй: Ёс суртахууны харилцаа” сэдэвт гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэсэн ба сургагч багш нар аймаг, нийслэлийн 36000 орчим багш нарт ёс зүйн сургалтыг 2017 оны 8 дугаар сард зохион байгуулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2017 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан “Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага боловсруулах, дунд, ахлах ангийн сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, арга зүйн шинэчлэл хийх, ахлах ангийн сургалтын төлөвлөгөө боловсруулах, суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшил болон багшийн ажлыг үнэлэх үнэлгээний журам шинэчлэх ажлыг гүйцэтгэх” ажлын

хэсгээс боловсруулсан “Сургалтын агуулгын талаар баримтлах бодлого”-ын төсөл боловсруулсан. Тус төсөлд ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн суралцагчид “Нийгмийн ухаан” сонгон суралцах хичээлийн 6 дугаар бүлэгт “Шударга ёс ба авлига” бүлэг сэдвийн хүрээнд дараах агуулгыг оруулахаар судалж байна. Үүнд: а/ Тохиолдолд шударга ёсны үүднээс шинжилгээ хийн авлигад холбогдох асуудлыг тодорхойлох; б/ Авлигын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлд үзүүлэх сөрөг үр нөлөөг тодорхойлох, тайлбарлах; в/ Авлигаас зайлсхийх иргэний санаачилгын хувилбар дэвшүүлэн хамгаалах зэрэг болно. (Биелэлт 20 хувь)

4.1.10.2-2. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах /БСШУСЯ, АТГ, 2017-2022/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/100 дугаар тушаалаар бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт нийгмийн шударга ёс, эрх тэгш байдлыг хөгжүүлэх, авлигагүй нийгмийн үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх үзэл санаа, агуулга туссан байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх, боловсролын стандарт, сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичигт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, албан болон насан туршийн боловсролын суралцагч, иргэдэд авлигыг үл тэвчих иргэний ухамсар, ур чадварыг бий болгоход чиглэсэн нэгдмэл агуулгын хүрээг боловсруулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургууль, иргэдийн сургалтад зориулсан багц ном, цахим болон нээлттэй жишиг сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэг ажил гүйцэтгэх ёстой байсан боловч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Их, дээд сургуулийн сургалтын агуулга,



хичээлийн хөтөлбөрт тусгах талаар судалгаа хийгдэж байна. 2017-2018 оны хичээлийн жилд нийт их, дээд сургуулиуд оюутан, суралцагчдын дунд хар тамхи мансууруулах бодис, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж зөрчихгүй байх талаар цагдаагийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, лекц, өдөрлөг зохион байгуулж, гарын авлага, брошур хэвлэж түгээх ажил хийгдсэн. 2018-2019 оны хичээлийн жилийн бэлтгэл, өвөлжилтийн бэлтгэл, гэнэтийн аюул, үер, гал түймэр, архи дан согтуурах явдалтай тэмцэх зэрэг болон хичээлийн жилийн зорилтоо тодорхойлон хэлэлцэх ажлын хүрээнд их, дээд сургуулиудын захирлуудын дунд “Боловсролын чанар-удирдлагын манлайлал” сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 85 их, дээд сургуулийн удирдах ажилтнууд оролцсон.

Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан “авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” зорилтын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгадаг эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн. Азийн сан, Хууль сахиулахын их сургуультай хамтран ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлаар санал солилцох уулзалтад оролцож, сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Сургалтын хөтөлбөрийн төсөлтэй танилцаж санал өгч, туршилт сургалтыг 2018 оны 11 дүгээр сард хийсэн ба тус хөтөлбөр батлагдснаар Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн сонсогчдод ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээлийн хөтөлбөрийн дагуу заавал хамрагдах боломж бүрдэнэ. (Биелэлт 20 хувь)

4.1.10.2-3. Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах / БСШУСЯ, ГБХЗХГ, АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хүүхэд, залуусын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Монголын Залуучуудын холбоо, Монголын Оюутны холбоо, Монголын Сурагчдын холбоо болон зарим сургуулийн оюутны холбоотой хамтран “Авлигатай тэмцэхэд залуу үеийн үүрэг оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. Мөн Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аян өрнүүлэн, нийтийн албан тушаалтан, иргэдэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан ба сургууль, цэцэрлэгийн эцэг, эхчүүдийн дунд “Авлигагүй нийгмийн төлөө” сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Цаашид дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас идэвх, санаачилга гарган ажиллах шаардлагатай байна. (Биелэлт 20 хувь)

“Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг “Боловсролын салбарын авлигын нөхцөл байдал”, “Боловсролын салбарын ил тод байдал”, “Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь”, “Боловсролын салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэхэд мэдээллийн технологийг ашиглах нь” гэсэн 4 сэдвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа.

“Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” төрийн бус байгууллага болон Азийн сан хамтран зохион байгуулсан “Хариуцлага оюутан залуус” төслийн хүрээнд “Дээд боловсрол: ёс зүй, ил тод, шударга байдал” уулзалт хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл солилцох, “Боловсролын

хамтын ажиллагааны нийгэмлэг” төрийн бус байгууллагатай хамтран шударга ёсны хичээл заасан 33 сургуулийн 110 багш, удирдлага, эцэг эхийн төлөөллийг оролцуулсан туршлага солилцох уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцож ажилласан ба тус төрийн бус байгууллагаас эрхлэн гаргаж улсын хэмжээний бүх ерөнхий боловсролын сургуульд хүргэгдэг “Нээлттэй сургууль” сонин дугаарт дээрх 110 багшийн сайн туршлага, шударга ёсонд суралцах нь хичээлийг зааснаар сургуулийн орчинд гарсан өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга, 10 дугаар зорилтын талаар мэдээллийг багтаасан дугаар (2018 оны 11 дүгээр)-ыг эрхлэн гаргуулаа.

Улсын хэмжээнд нийт ерөнхий боловсролын дунд ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын хууль тогтоомж зөрчихгүй байх талаар холбогдох байгууллагатай хамтран, лекц, өдөрлөгийг зохион байгуулж ажилласан. “Сургалтын төлбөр-Оюутны хөгжил” сэдэвт их, дээд сургуулиудын захирал, оюутны байгууллагуудын нэгдсэн анхдугаар хуралдаан, хэлэлцүүлэг 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Дээд боловсролын бодлогын газар, их дээд сургуулиудын захирал, оюутны холбоод, зөвлөлүүдийн тэргүүн, намын дэргэдэх оюутны байгууллагын төлөөллүүд оролцсон. Монгол Улсын дээд боловсролын салбар дахь их, дээд сургуулиудын сургалтын төлбөртэй холбоотой сургуулийн удирдлага, оюутнууд хоорондын үл ойлголцлыг тодорхойлж, харилцан зөвшилцөж, хамтран ажиллаж, цаашид Монголын оюутны хөгжлийг сайжруулах арга замыг тодорхойлон хэлэлцэн зөвшилцсөн. (Биелэлт 30 хувь)

4.1.10.3-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах/ АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсанаар соён гэгээрүүлэх ажлыг илүү өргөн хүрээнд зохион байгуулах боломж бүрдсэн. Авлигын эсрэг сургалтыг төрийн байгууллагын хүсэлтээр байгууллага дээр нь очиж мэдээлэл хийх түвшинд хийж байсныг өөрчилж, сэдвийг өргөжүүлэн, практик жишээгээр баяжуулж сургалтад хамрагдагсдыг зорилтот бүлгээр нь ангилан Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд сургалт зохион байгуулах стратегийн дагуу шинэлэг хэлбэрт шилжүүлсэн.

Авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дараах арга хэмжээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

-Удирдлагын академитай хамтран нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтын 6 модуль, гарын авлагыг боловсруулж, туршилт сургалтыг зохион байгуулж, 40 хүнийг хамруулсан. Энэхүү сургалтын модуль нь Авлигын эсрэг эрх зүйн орчин; Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал; Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа; Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх нь; Авлигын эсрэг үйл ажиллагаанд удирдах ажилтны манлайлал; Төрийн байгууллага дахь авлигын эсрэг дотоод хяналтын тогтолцоо, гомдлын менежментийн хэрэгжүүлэлт, мэдээллийн технологийн гүйцэтгэх үүрэг сэдвийг хамарсан болно.

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын модуль,



гарын авлагыг МУИС-ийн баг, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг МУБИС-ийн баг тус тус боловсруулсан. Уг модулиар сургагч багш бэлтгэх сургалтад аймгуудаас 63, нийслэлээс 69, нийт 132 хүн хамрагдсан, туршилт сургалтад Орхон, Дархан-Уул аймгаас 237, нийслэлд 300, нийт 637, бүгд 769 төрийн албан хаагч хамрагдсан байна.

-Түүнчлэн “Шинэ хөгжлийн түлхүүр” төрийн бус байгууллагаас иргэдэд зориулсан авлигын эсрэг сургалтын модуль, “Жаргалант хангай” төрийн бус байгууллага ерөнхий боловсролын сурагч, хүүхэд залууст зориулсан шударга ёсны хичээлийн сургалтын модуль, “Глоб интернэшнл төв” төрийн бус байгууллага сэтгүүлчид зориулсан сургалтын модуль, хөтөлбөрийг боловсруулж сургалтыг үе шаттай зохион байгуулж эхэлсэн байна.

Авлигын эсрэг сургалтыг зөвхөн нийтийн албан тушаалтнуудад бус оюутан, сурагч, эцэг, эх, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдэд зэрэг зорилтот бүлгүүдэд зориулан үе шаттайгаар зохион байгуулах, нийтийн албан тушаалтанд зориулсан авлигын эсрэг сургалтыг цогц буюу академик хэлбэрт шилжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тухайлбал, 2017 “Глоб Интернэшнл төв” төрийн бус байгууллага “Мэдэх эрхийг хөхиүлэн дэмжих” төслийн хүрээнд “Ус дээшээ үрсдэг” олон ангит киног ашиглан авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар кино сургалтыг Азийн сангийн санхүүжилтээр зохион байгуулсан бөгөөд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн Ирээдүй цогцолбор сургууль, 23 дугаар сургууль, Монгени цогцолбор сургууль, Хобби сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчид болон МУИС, Хууль сахиулахын их сургууль, Их засаг олон улсын их сургуулийн 1, 2 дугаар курсийн нийт 237 оюутан сурагчид сургалтад хамрагдсан байна. Багшийн хөгжлийн ордонд тус төслийн хаалт “Тусгал” нэртэй туршлага хуваалцах уулзалтыг

зохион байгуулжээ. (Биелэлт 45 хувь)

4.1.10.4-1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх /АТГ, 2017-2022/

Авлигатай тэмцэх газар 2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газраас “Багшийн ёс зүйн харилцаа” сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт “Авлигаас ангид байх нь” дэд бүлгийг хамтран боловсруулж оруулсан ба сургагч багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулж, нийслэлийн 62, орон нутгийн 760 багшийг сургагч багшаар бэлтгэж, тэдгээр багш нар орон нутгийн боловсролын салбарын багш ажилтнуудад “Ёс зүйн харилцаа” модулиар сургалт хийсэн байна. Удирдлагын академитай хамтран гэрээ байгуулж авлигын эсрэг сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийлгэж, төрийн албан хаагчдад зориулсан 6 модуль, гарын авлага боловсруулж, сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 40 хүнийг хамруулан зохион байгуулав.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр “Төрийн албан хаагчийн албан хаагчийн ёс зүй” сургалтын модуль, гарын авлагыг МУИС-ийн баг, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модуль, гарын авлагыг МУБИС-ийн баг тус тус боловсруулсан. Эдгээр модулиар хичээл заах сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулж, 21 аймгаас тус бүр 3 төрийн албан хаагч 63 хүн, нийслэлээс Иргэний хяналтын зөвлөлийн 69 гишүүн, нийт 132 хүнийг хамруулав. Сургагч багшийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг баталгаажуулах сургалтыг нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийтийн албан тушаалтанд зориулан сургагч

багш нартай хамтран цуврал байдлаар зохион байгуулж ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, чадавхжууллаа. Орхон, Дархан-Уул, Хэнтий, Дорнод аймгаас сургалтад хамрагдсан сургагч багш нар аймагтаа ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг модулийн дагуу зохион байгуулж, тайлагнасан бөгөөд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Орхон, Дархан-Уул аймагт ажиллаж сургагч багш нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллав. 2019 онд сургагч багш нарыг чадавхижуулах хоёр дахь шатны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа- Албан хаагчдыг чадавхижуулах нь” төслийн хүрээнд шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын гарын авлагыг тухайн байгууллагуудын саналыг тусган боловсруулж, 40 сургагч багш бэлтгэн нийслэлд 3 удаагийн, 7 аймагт 9 удаагийн сургалт зохион байгуулж 21 аймаг, нийслэлийн шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын нийт 353 албан хаагчийг хамруулсан. (Биелэлт 40 хувь)

4.1.10.5-1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах чиглэлээр дотоод, гадаадын сайн туршлага, оновчтой шийдлийг сурталчлах, түгээх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах/ АТГ, 2017-2022/

2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан Авлигын эсрэг үндэсний чуулган дээр

“Төрийн байгууллагын ил тод, шударга, хариуцлагатай байдал-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх асуудал-Олон улсын сайн туршлага, санаачилга”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох талаарх олон улсын туршлага”, “Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал” зэрэг 5 сэдвээр дотоод, гадаадын эрдэмтэн судлаач, шинжээчдээр илтгэл тавиулж хэлэлцүүлсэн болно.

Авлигатай тэмцэх газраас авлигын нөхцөл байдал, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, дотоод, гадаадын сайн туршлага, авлигын нөхцөл байдлын судалгааны үр дүн зэрэг сэдвээр танилцуулга, илтгэл, хэвлэлийн мэдээг тасралтгүй бэлтгэж байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээж хэвшсэн ба “Худалдан авах ажиллагаан дахь авлига, түүний шалтгаан нөхцөл, хор уршиг”, “Шударга байдлын үнэлгээ-2016”, “Монгол Улсын авлигын нөхцөл байдал”, “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн 2016 оны судалгааны дүн” зэрэг сэдвээр илтгэл бэлтгэн амжилттай хэлэлцүүлэв.

Мөн Авлигын эсрэг үндэсний чуулганд Авлигын эсрэг олон улсын академи, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олох санаачилга буюу СТАР санаачилга, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Авлигатай тэмцэх товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны Хээл хахуультай тэмцэх албанаас төлөөлөл оролцон тухайн улсын авлигатай тэмцэх сайн туршлага, оновчтой шийдлийн талаар үндэсний чуулганд оролцогчдод танилцуулсан болно.

Мөн гадаадын сайн туршлага, оновчтой



шийдлийг судлах зорилгоор БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) болон тус улсын Прокурорын дээд газраас зохион байгуулсан “Авлигын хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Шри Ланка Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хурал, Франц Улсад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан уулзалт, Египет Улсын Шарм Эль-Шейх хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон өөрчлөх тухай хэлэлцээрт оролцогч талуудын 6 дугаар хурал, Азербайжан Улсад зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хууль сахиулах сүлжээний уулзалтад, БНСУ-аас Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан хурал болон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалтад Авлигатай тэмцэх газрын албан хаагчид тус тус оролцож, харилцан мэдээлэл солилцон, туршлагаа хуваалцсан байна.

Түүнчлэн Австри Улсад зохион байгуулагдсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид оролцогч талуудын 7 дугаар хуралд оролцож, ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй уулзалт хийж цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон ба Монгол Улсын авлигын эсрэг хийж байгаа үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар туршлага судлах уулзалтыг тус тус зохион байгуулсан. Азербайжан Улсын Авлигын эсрэг газрын урилгаар тус улсад 2018 оны 11 дүгээр сард зочилж, Авлигын эсрэг газар, дүүргийн шүүх, прокурор, “АСАН” олон нийтийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, мөн Авлигын эсрэг газар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, туршлага солилцсон. Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороонд

Авлигатай тэмцэх газрын төлөөлөгчид зочилж, тус хорооны Оперативын хэлтэс, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс, дүүргийн салбар нэгжийн үйл ажиллагаатай танилцлаа. Томилолтоор ажилласны дараа Хонконгийн туршлагад тулгуурлан, нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүд Дүнжингарав, Саппоро, Оргил, Мишээл зэрэг байршилд авлигын эсрэг Иргэний хяналтын төвүүдийг байгуулан ажиллаж байна. (Биелэлт 40 хувь)

Арван нэг. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 11 дүгээр зорилтын хүрээнд нийт 5 үйл ажиллагаа, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2017 онд 8 арга хэмжээг эхлүүлж, 2018 онд нийт 13 арга хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. Зорилтын хэрэгжилтийг тоймлон танилцуулбал:

4.1.11.1-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний хүрээнд гадаадын эрх бүхий байгууллаас ирүүлсэн 168 эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаварт холбогдох ажиллагааг гүйцэтгэсэн ба Монгол Улс, БНХАУ-ын Хууль зүйн яамдын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, Ялтан шилжүүлэх тухай асуудлаарх II дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, уулзалтын протоколд гарын үсэг зурав.

Авлигатай тэмцэх газар сүүлийн 3 жилийн байдлаар НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнуудад болох 9 улс 17 хүсэлтийг хүргүүлж ажиллав. Монгол Улсын нэгдсэн орсон НҮБ-ын аливаа конвенцийг хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, улмаар Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, холбогдох байгууллагуудын ажилтнуудыг чадавхижуулж, үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээ авсан.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх хүрээнд тус Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газартай хамтарч ажиллаж байгаа бөгөөд авлигын хэрэгт холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг нууцын зэрэглэлтэй болон энгийн байдлаар хүлээн авч, конвенцийн дагуу холбогдох улсын эрх бүхий байгууллагад хүргэдэг. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хүрээнд 2018 оны байдлаар 4 эрх зүйн туслалцааны хүсэлтийг 7 улс (Англи, Панам, Сингапур, Хонгконг, Австри, Канад, БНХАУ)-д хүргүүлсэн байна.

Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Макаогийн хооронд гэрээнд 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр гарын үсэг зурав. Гэрээнд заасан төв байгууллагатай тохиролцсоны дагуу Гадаад харилцааны яамны Консулын газарт эрх зүйн туслалцааны нэгдсэн сан байгуулахаар тохиролцон, хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол”-ийн төслийг эцэслэн тохиролцсон, 2019 онд багтааж байгуулах чиглэлээр ажиллана. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцож 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр байгуулав. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын хэлэлцээр”-ийг 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр байгуулав. “Гэмт этгээд

шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын хэлэлцээр”-ийг 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр байгуулав. “Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын хэлэлцээр”-ийг 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр байгуулав. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-г 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байгуулав. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг тохиролцсон, 2019 онд байгуулах чиглэлээр ажиллана. “Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцоод энэ оны 6 дугаар сард байгуулна. (Биелэлт 30 хувь)

4.1.11.1-2. Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх /ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ 2018-2021/

Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн хооронд 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Улсын Их Хурлаар 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр соёрхон батлуулсан.

Мөн “Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-г батлуулахаар Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Цаашид шинээр байгуулах гэрээнд албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын гэмт хэрэгтэй холбоотой заалтыг тусгаж ажиллахаар төлөвлөсөн. (Биелэлт 10 хувь)



4.1.11.1-3. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх /ХЗДХЯ, УЕПГ, 2017-2022/

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор дараахь сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд: Улсын ерөнхий прокурорын газраас Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлтийг хэрхэн зөв, үндэслэлтэй боловсруулах талаар сургалт, мөн нийслэл, төвийн 6 дүүргийн прокурорын газруудын прокурор, туслах ажилтнуудад “Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхэд анхаарах асуудал”, “Гэмт этгээдийг шилжүүлэн авах ажиллагаа” сургалтыг, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас жил бүр Монгол Улсаас гадаад улсад томилогдон ажиллах дипломат ажилтнуудад “эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх” чиглэлээр сургалтыг, 2018 оны 5 дугаар сард олон улсын СтАР хөрөнгө буцаах хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр олон улсын эрх зүйн туслалцааны хүсэлт, түүндээ гадаадад хууль бусаар гарсан хөрөнгийг буцаах, мөнгө угаахтай холбоотой сургалтыг тус тус зохион байгуулж, хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг чадавхижуулсан.

Авлигатай тэмцэх, мөнгө угаах чиглэлээр 2018 онд Хонконг, Индонези улсад зохион байгуулагдсан “Авлигатай тэмцэх шинэ хандлага” олон улсын семинарт Авлигатай тэмцэх газар болон прокурорын байгууллагын төлөөлөл хамрагдсан байна.

Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлсэн. (Биелэлт 40 хувь)

4.1.11.1-4. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх /ХЗДХЯ, 2017-2022/

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар бусад материалыг орчуулахад шаардлагатай байцаан шийтгэх ажиллагааны зардалд 2017 онд 50.0 сая төгрөгийг төсөвлөн

ажилласан. Авлигатай тэмцэх газар сүүлийн 3 жилийн байдлаар нийт Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх мөрдөгчийн даалгаврыг 24 удаа бичиж 12 улсад хүргүүлсэн. Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй 3 улсад 7 мөрдөгчийн хүсэлтийг, Нэгдсэн үндэсний байгууллагын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнуудад болох 9 улс 17 хүсэлтийг хүргүүлж ажилласан. Эрх зүйн харилцаа туслалцаа үзүүлэх гэрээг Монгол Улстай байгуулсан улс орнуудаас БНСУ-аас даалгаврын 1 хариу ирсэн бөгөөд бусад даалгаврыг хүлээн авсан болохоо илэрхийлээд тодорхой мэдээлэл нэмж ирүүлэх шаардлагатай гэсэн шалтгаан даалгаварын дагуу ажиллагаа явуулахаас татгалзсан, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнуудад хандан хүргүүлсэн хүсэлтээс хариуг Канад улсаас ирүүлсэн, Швейцарь улсаас мөрдөн шалгах ажиллагааг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй учир биелүүлэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн, Америкийн нэгдсэн улс, Австрали, Герман улсуудаас мөрдөгчийн даалгаврыг хүлээн аваад ямар нэгэн хариу ирүүлээгүй үр дүнтэй байв.

Эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгавар, бусад материалын орчуулгын зардлын асуудлыг Гадаад харилцааны яамны “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-д тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаргаж, Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн.

2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар гадаад, дотоодын байгууллагаас ирүүлсэн нийт 174 эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авч зохих ажиллагааг хийжээ.

Улсын ерөнхий прокурорын газар 2019 онд мөнгө угаах чиглэлээр гадаад сургалт, Мөнгө угаахтай тэмцэх түр хороо (FATF), Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн уулзалтууд, энэ чиглэлээр ажиллах ажлын хэсгийг үйл ажиллагааг эрчимжүүлэх төсөв, санхүүгийн тооцоог гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн. (Биелэлт 30 хувь)

4.1.11.2-1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг боловсруулж НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэн, тайланг хамгаалж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх /АТГ, ХЗДХЯ, УЕПГ, СЯ, ГХЯ, ТАЗ, Монголбанк 2017-2022/

Монгол Улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг 2018 онд НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлэхтэй холбогдуулан дараагийн шатанд үнэлэгдэх 2 дугаар бүлэг/Урьдчилан сэргийлэх арга хэмжээ/, 5 дугаар бүлэг /Хөрөнгө буцаан олгох арга хэмжээ/ -ийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайланг боловсруулж байна. Монгол Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн өөрийн үнэлгээний тайланг НҮБ-аас тогтоосон журам, үнэлгээний механизмын дагуу оноолт таарсан бусад 2 улсын шинжээчдээс үнэлэх бөгөөд оноолт 2019 онд хийгдэх төлөвтэй байна. Уг оноолт хийгдсэнээс гурван долоо хоногийн дотор Монгол Улс өөрийн үнэлгээний тайланг хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтныг томилж НҮБ-д мэдэгдэх, 2 сарын дотор өөрийн үнэлгээний талаар хяналтын хуудсыг бөглөх г.м 8 шат дамжлагыг 6 сарын дотор хийж гүйцэтгэж өөрийн үнэлгээгээ хамгаалах юм. (Биелэлт 10 хувь)

Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албаны урилгаар Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гүрж Улсын төлөөлөгчдийн багтсан шинжээчдийн баг Словени Улсын Конвенцийн хэрэгжилтийн тайланг 2018 онд хянаж, зөвлөмжүүд өгч ажилласан. Одоо 2019 оны сүүлээр Конвенцийн хэрэгжилтийн тайлангаа олон улсын шинжээчдээр хянуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.(Биелэлт 20 хувь)

4.1.11.2-2. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний Авлигатай тэмцэх үйл ажиллагааны Станбулын төлөвлөгөөний тайланг гаргаж хүргүүлэх, тайлагнах, хамгаалах /АТГ 2017-2022/

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнуудад

явуулж буй авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үнэлгээ хийх зорилгоор 2003 онд байгуулагдсан. Уг төлөвлөгөөгөөр Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц болон бусад олон улсын стандарт, сайн засаглалын туршлагын хэрэгжилтийг хангахад шаардлагатай зөвлөмжийг шат дараатайгаар хийсэн үнэлгээний үндсэн дээр боловсруулан гаргаж, гишүүн улсуудын авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа шинэчлэлийг дэмжих зорилготой юм.

Монгол Улс нь Станбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2012 онд нэгдэн орсон бөгөөд 2014 онд тус байгууллагын Үнэлгээний баг манай улсын авлигын эсрэг үйл ажиллагаа, эрх зүйн орчинд анх удаа үнэлгээ хийсэн билээ. Үнэлгээний цар хүрээ нь авлигатай тэмцэх байгууллага, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дотоод хяналт шалгалт, дотоод аудит, шүүх, прокурорын байгууллага, хувийн хэвшил зэрэг байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа, эрх зүйн орчноос гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх асуудлуудыг хамарсан.

Авлигатай тэмцэх газраас 2017 онд Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Монгол Улсын тайланг бэлтгэх ажлын хэсэгт нэр бүхий албан хаагчид ажиллаж, холбогдох мэдээллийг бэлтгэн, урьдчилсан хамгаалалтад оролцсон ба Эдийн засаг хамтын ажиллагаа хөгжийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний Станбулын авлигын эсрэг төлөвлөгөөний 2016-2020 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээллийг жил бүр бэлтгэн тус байгууллагад заасан хугацаанд хүргүүлж байна.

“Станбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Монгол Улс хэрхэн хангаж буй талаарх явцын тайланг (монгол хэлээр) Авлигатай тэмцэх газар бэлтгэсэн.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжийн байгууллага Авлигын эсрэг сүлжээний 4 дэх удаагийн мониторингийн үйл ажиллагааны хүрээнд тус байгууллагаас Монгол Улсын авлигын эсрэг орчин, үйл ажиллагааны тайлангийн төслийн боловсруулсан. 2019 оны 3 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Парис хотод тус байгууллагаас зохион байгуулах уулзалтын үеэр Монгол Улсын мониторингийн тайланг эцэслэн батална. (Биелэлт 40 хувь)



4.1.11.2-3. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран төсөл хэрэгжүүлэх /АТГ 2017-2019/

Авлигатай тэмцэх газраас 2017 оны 4 дүгээр 16-17-ны өдрүүдэд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга” (StAR)-тай хамтран “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус санаачилгаас ирүүлсэн хамтын ажиллагааны шинэ төсөлд холбогдох саналыг боловсруулан хүргүүлэв.

Цаашид “StAR”-тай хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтарсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд хууль сахиулах байгууллагуудын дундах “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж, “Хөрөнгө буцаах гарын авлага”-ын төслийн талаар хэлэлцэж, байгууллагуудын саналуудын нэгтгэсний үндсэн дээр эцсийн хувилбарыг Улсын ерөнхий прокурорын газар бэлтгэн, батлахаар болсон.

“StAR”-тай хамтран 2018 оны 10 дугаар сарын 8-12-ны өдрүүдэд хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт”, мөн хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн стратеги, менежмент семинар” зохион байгуулсан. “StAR”-тай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулж, ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг сүлжээнээс жил болгон гишүүн орнуудаас цуглуулдаг Авлигын эсрэг үйл ажиллагааны асуудлын тайлан болон орон нутаг дахь авлигын асуудлаар мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн. (Биелэлт 50 хувь)

4.1.11.2-4. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай сургалт, семинар зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллах /АТГ, 2017-2022/

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Австри Улсад болсон “Сингапур улсын авлигатай тэмцэх сайн туршлага” сэдэвт сургалт, БНХАУ-ын Хонконг мужид зохион байгуулагдсан “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт, Гүрж улсад зохион байгуулагдсан “Авлигын эсрэг сургалт”-д тус тус төлөөлөл оролцуулав. Мөн тус байгууллагатай хамтран 2017 оны 5 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Авлигын эсрэг хамтын ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх нь” сэдэвт гурван өдрийн сургалт, 2017 оны 9 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сэдэвт гурван өдрийн сургалтыг тус тус хамтран зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2018 оны 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалт зохион байгуулж, хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагчийг хамруулсан. Мөн тус байгууллагын “Авлигатай тэмцэх гарын авлага”-ыг монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад тарааж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.11.3-1. Гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулах, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулах /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2019-2020/

БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамтай 2011 онд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2017-2021 онд хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөр, ОХУ-ын Дотоод хэргийн яамтай хамтран ажиллах тухай 2017 оны хэлэлцээрийн хүрээнд 2020 он хүртэл олон улсад гэмт хэрэгтэй тэмцэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хамтран ажиллах протоколыг байгуулан ажиллаж байна. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, БНСВУ хоорондын гэрээ”-г 2018 оны 10 дугаар сард үзэглэсэн бөгөөд 2019 оны 3 дугаар улиралд гарын үсэг зурахаар бэлтгэл ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам хангаж байна.

“Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын засаг захиргааны

онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр"-т 2019 оны 2 дугаар улиралд гарын үсэг зурахаар төлөвлөн ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар 2016-2019 онд Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын алба, Авлигын эсрэг олон улсын академи, Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбоо, Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох СтАР санаачилга, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжийн байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департамент, Холбооны мөрдөх товчоо, Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан хороо, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хороо, Азербайжан Улсын Авлигын эсрэг газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцаагаа өргөжүүлэн, хөгжүүлж ирсэн.

Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийн гишүүнийнхээ хувьд олон улсын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж, гишүүнчлэлийн татвар болох 18000 евро жил бүр төлдөг бөгөөд татвараа төлсөн орнуудын албан хаагчдыг тус академийн зуны сургалтад хөнгөлттэй нөхцөлөөр хаамруулдаг ба Авлигатай тэмцэх газрын албан хаагчид оролцож, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэв.

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох "СтАР санаачилга"-тай хамтран санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах анхан шатны сургалт, прокурорын байгууллага, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын дундах уулзалт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах явдалтай тэмцэх нь" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны албан хаагчдыг оролцуулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлсэн.

Мөн тус байгууллагын "Авлигатай тэмцэх гарын авлага"-ыг монгол хэлнээ орчуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудад түгээж байна.

Швейцарийн Холбооны Улсын Ерөнхий прокурорын газар, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Авлигын эсрэг олон улсын удирдах төв, Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, АНУ-ын Хууль зүйн департаментын Олон улсын хамтын ажиллагааны газар, Холбооны мөрдөх товчооны олон улсын ажиллагааны албаны төлөөлөлтэй уулзалт хийж, эрүүгийн хэрэг хамтран мөрдөн шалгаж, харилцан ашигтай мэдээлэл солилцож байна.

Түүнчлэн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба, Азербайжан Улсын Авлигын эсрэг газартай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. (Биелэлт 40 хувь)

4.1.11.3-2. Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /ХЗДХЯ, ГХЯ, АТГ 2018/

Иргэний болон аж ахуйн хэргээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хооронд байгуулах гэрээний төслийг айлын талтай эцэслэн тохирч, орчуулгыг эцэслэн, гэрээ байгуулах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаан, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж, 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдөр гэрээг байгуулав. Гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, УИХ-д өргөн мэдүүлэх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж, хуулийн төслийг 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.

"Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг УИХ-аар 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр соёрхон батлуулсан.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс болон Гүйцэтгэх ажлын хэлтсээс 2016-2019 онд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг үндэс болгон нийт 16 эрх зүйн туслалцааны хүсэлтийг гадаад орны эрх бүхий байгууллагад хүргүүлж, хоёр улсаас гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүлээн



авлаа. Энэ чиглэлээр Австри Улсын Вена хот дахь Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албаны Нэгдсэн хурал, уулзалтууд тухай бүр урилгаар оролцож, шинэ мэдээлэл авч, бусад улс орны эрх бүхий байгууллагатай харилцаа тогтоон, мэдээлэл солилцож, хамтран ажиллаж ирсэн.

Санхүүгийн гэмт хэрэг мөрдөн шалгах, гадаад улсаас эрх зүйн туслалцаа хүсэх, үзүүлэх чиглэлээр албан хаагчдынхаа мэдлэг, чадварыг “Стар санаачилга”-тай хамтран сургалт зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын Хуульчдын холбооны төлөөллүүдийг оролцуулан хамтран “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, “Зөвлөмж” гарган эрх бүхий байгууллагуудад хүргүүлэв. Монгол Улс 19 улстай оронтой эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан байдаг. Хамгийн сүүлд УИХ-ын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн чуулганаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хооронд байгуулсан Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хуулийг баталсан байна. (Биелэлт 20 хувь)

4.1.11.4-1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэх тухай дотоодын хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох / ХЗДХЯ, УЕПГ, АТГ 2018-2022/

Монгол Улс одоогийн байдлаар нийт 17 улстай гэмт этгээд шилжүүлэх тухай гэрээ, хэлэлцээрийг байгуулаад байна. “Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын Конвенц”-д нэгдэн орох ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн хариуцлагад татах, шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор хэрэгт холбогдсон этгээдийг шилжүүлэн өгч, авч байх эрх зүйн орчин бий болно. Конвенцид нэгдэн орохтой холбоотой шийдвэрийн төслийн орчуулгыг эцэслэн, дотоодын байгууллагуудын саналыг авч байна. Европын зөвлөлийн нарийн

бичгийн даргын газарт хүргүүлэх саналыг бэлтгэн яамны удирдлагад танилцуулсан бөгөөд үүний үр дүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн авчрах эрх зүйн орчин бий болно.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын хуульчдын холбооны төлөөллүүдийг оролцуулан хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж, Зөвлөмж”-ийг боловсруулан эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг хариуцан зохион байгуулсан. (Биелэлт 10 хувь)

4.1.11.5-1. Олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Олон улсын авлигын эсрэг холбоо, сүлжээ, санаачилгуудыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор олон улсад авлигатай тэмцэх чиглэлээр өрнөж буй үйл ажиллагааг судлан өдөр бүр гадаад мэдээний тойм бэлтгэн, зарим шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэсэн. Олон нийтийн төвд зохион байгуулж буй Авлигын эсрэг сургалтын агуулгад гадаад улсын сайн туршлагуудыг хуваалцахаар бэлтгэж байна.

Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Авлигын эсрэг олон улсын академи, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Ази, Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан хурал, сургалтад албан хаагчдыг тогтмол оролцуулан мэдээлэл, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. Мөн ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэдэг гадаадын байгууллагын төлөөлөгчидтэй Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаар ажил хэргийн уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

“Гэмт этгээд шилжүүлэх тухай Европын Конвенц”-д нэгдэн орох ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн хариуцлагад

татах, шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор хэрэгт холбогдсон этгээдийг шилжүүлэн өгч, авч байх эрх зүйн үндэс бүрдэх бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг конвенцид нэгдэн орохтой холбоотой шийдвэрийн төслийн орчуулгыг эцэслэн дотоодын байгууллагуудын саналыг авч байна. Европын зөвлөлийн нарийн бичгийн даргын газарт хүргүүлэх саналыг бэлтгэн танилцуулаад байна.

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийн 7 дугаар зүйлд авлигатай тэмцэх асуудлаар АНУ-тай хамтран ажиллах эрх зүйн хүрээг тодорхойлов. Энэхүү хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд: “5. Талууд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт дахь авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэхэд бүс нутгийн болон олон улсын санал санаачилга чухал болохыг хүлээн зөвшөөрнө. Талууд олон улсын хурал чуулганд холбогдох санал санаачилгыг урамшуулан дэмжих талаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ” гэж тусгасан бөгөөд цаашид уг асуудлаар АНУ-тай цаашид нягт хамтран ажиллана.

Түүнчлэн ХБНГУ-ын энэ төрлийн байгууллагатай туршлага солилцох, сургалт зохион байгуулах ажлыг судалж байна. Дипломат төлөөлөгчдийн газруудад суугаа орны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага тооцох сайн туршлагыг судалгаа хийж ирүүлэх үүргийг тус яамнаас хүргүүлсэн.

Монгол Улс Ази, номхон далайн орнуудын хулгайлагдсан хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний 2019 оны даргалагч улсаар сонгогдсон. Энэхүү сүлжээнд гишүүнээр 21 орны 28 прокурорын байгууллага, хууль сахиулах байгууллага, ажиглагчаар 6 олон улсын байгууллага оролцдог. АРИН-АП сүлжээнд гишүүнээр оролцсоноор АРИН-Кариб, АРИН-Африк, Арин-Төв Ази, АРИН-Европ, АРИН-Өмнөд Америк тив нутгуудаас гэмт хэргийн талаар шүүрхай мэдээ хүлээн авч, шолган, хөрөнгийг буцаан авахад дэмжлэг үзүүлдэг онцлогтой.

Тус сүлжээний 2019 оны 9 дүгээр сард Удирдах зөвлөлийн хурал болон Бүгд хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар бэлтгэж байна. (Биелэлт 50 хувь)

4.1.11.5-2. Олон улсын туршлага судлах, чадавхи бэхжүүлэх, үнэлгээ мониторингийн чиглэлээр олон улсын сүлжээ, санаачилгад идэвхтэй оролцох /ГХЯ, ХЗДХЯ, АТГ, Холбогдох байгууллага 2017-2022/

Мянган хөгжлийн сангийн Хоёрдугаар компакт гэрээний Монгол Улсын авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд АНУ-ын Элчин сайдын яамны урилгаар Авлигатай тэмцэх газрын удирдлага тус улсын Вашингтон, Детройт, Портланд хотуудад 2018 оны 3 дугаар сарын 5-13-ны өдрүүдэд хийсэн туршлага айлчлалыг тус улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулж, авлигатай тэмцэх чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн үулзалтуудад оролцож, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай нь танилцан, төрийн байгууллага, төрийн албан тушаалтны үйл ажиллагаан дахь иргэдийн хяналт, оролцооны талаарх туршлагыг судлан, байгууллагууд хоорондын цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна.

Бүгд найрамдах Киргиз Улс “Стамбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөх олон улсын шинжээчдийн багт Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдон ажиллаж, Киргиз Улсын нөхцөл байдлын талаарх тайланг бэлтгэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад хүргүүлэв. (Биелэлт 20 хувь)



ДҮГНЭЛТ, САНАЛ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тайлан, тэдгээртэй холбоотой баримт бичгүүд, үр дүнг нотлох холбогдох материалуудыг ашиглан гүйцэтгэсэн. Үйл ажиллагаа, арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөхдөө:

- ✓ холбогдох шийдвэр гарсан, тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн нь хүрэх түвшинд нийцсэн бол 90-100 хүртэл хувь;
- ✓ тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 50-89 хүртэл хувь;
- ✓ тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн, эсхүл тодорхой түвшинд хийгдэж эхэлсэн боловч зохион байгуулалт, төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй байгаа бол 10-49 хүртэл хувь;
- ✓ тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь байхаар тооцсон болно

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалд хийсэн үнэлгээний нэгдсэн дүн:

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо			
	2017-2023 онд	2018 оны төлөвлөгөө	2018 оны биелэлт	Биелэлт, хувь
2.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	26	25	90-100 хувийн биелэлттэй - 3 60-89 хувийн биелэлттэй - 8 31-59 хувийн биелэлттэй - 9 10-30 хувийн биелэлттэй - 5 Хэрэгжиж эхлээгүй - 0	53,8
2.2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх	18	16	90-100 хувийн биелэлттэй-2 60-89 хувийн биелэлттэй-2 31-59 хувийн биелэлттэй-2 10-30 хувийн биелэлттэй-6 Хэрэгжиж эхлээгүй-4	35,0

2.3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх	35	35	90-100 хувийн биелэлттэй-2 60-89 хувийн биелэлттэй-3 31-59 хувийн биелэлттэй-14 10-30 хувийн биелэлттэй-14 Хэрэгжиж эхлээгүй-2	36,3
2.4. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	15	15	90-100 хувийн биелэлттэй-1 60-89 хувийн биелэлттэй-2 31-59 хувийн биелэлттэй-8 10-30 хувийн биелэлттэй-4 Хэрэгжиж эхлээгүй-0	42,0
2.5. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах	34	34	90-100 хувийн биелэлттэй-4 60-89 хувийн биелэлттэй-6 31-59 хувийн биелэлттэй-6 10-30 хувийн биелэлттэй-13 Хэрэгжиж эхлээгүй-5	36,8
2.6. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;	21	18	90-100 хувийн биелэлттэй - 0 60-89 хувийн биелэлттэй - 2 31-59 хувийн биелэлттэй - 5 10-30 хувийн биелэлттэй - 7 Хэрэгжиж эхлээгүй - 4	27,2
2.7. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих	18	13	90-100 хувийн биелэлттэй - 4 60-89 хувийн биелэлттэй - 1 31-59 хувийн биелэлттэй - 2 10-30 хувийн биелэлттэй - 5 Хэрэгжиж эхлээгүй - 1	47,7

2.8. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;	9	7	90-100 хувийн биелэлттэй - 0 60-89 хувийн биелэлттэй - 2 31-59 хувийн биелэлттэй - 2 10-30 хувийн биелэлттэй - 2 Хэрэгжиж эхлээгүй-1	37,1
2.9. Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах	17	17	90-100 хувийн биелэлттэй-0 60-89 хувийн биелэлттэй-0 31-59 хувийн биелэлттэй-1 10-30 хувийн биелэлттэй-9 Хэрэгжиж эхлээгүй-7	8,8
2.10. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх	10	10	90-100 хувийн биелэлттэй - 0 60-89 хувийн биелэлттэй - 0 31-59 хувийн биелэлттэй - 5 10-30 хувийн биелэлттэй - 5 Хэрэгжиж эхлээгүй - 0	32,5
2.11. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх	13	13	90-100 хувийн биелэлттэй - 0 60-89 хувийн биелэлттэй - 0 31-59 хувийн биелэлттэй - 6 10-30 хувийн биелэлттэй - 7 Хэрэгжиж эхлээгүй - 0	31,5
ДҮН	216	202	178	35,34

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 35,34 хувьтай байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг чиглэл тус бүрээр харуулбал:

Хөтөлбөрийн 1 дэх зорилтын хүрээнд “Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх” чиглэлээр нийт 10 үйл ажиллагаа, 26 арга хэмжээ тусгасан. (Биелэлт 53,8 хувьтай)

Хөтөлбөрийн 2 дахь зорилтын хүрээнд “Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг

дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх” чиглэлээр нийт 7 үйл ажиллагаа, 18 арга хэмжээ тусгасан. Үүнээс 2017 онд 4 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд 16 арга хэмжээг хэрэгжүүлэв. (Биелэлт 35,0 хувьтай)

Хөтөлбөрийн 3 дахь зорилтын хүрээнд “Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх” чиглэлээр нийт 10 үйл ажиллагаа, 35 арга хэмжээ тусгасан бөгөөд үүнээс 2017 онд 22 арга хэмжээг хэрэгжүүлэв. (Биелэлт 36,3 хувьтай)

Хөтөлбөрийн 4 дэх зорилтын хүрээнд “Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх” чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 15 арга хэмжээ тусгагдсан бөгөөд үүнээс 2017 онд 14 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд шинээр 1 арга хэмжээ хэрэгжиж эхлэхээр, нийт 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. (Биелэлт 42,0 хувьтай)

Хөтөлбөрийн 5 дахь зорилтын хүрээнд “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах” чиглэлээр нийт 17 үйл ажиллагаа, 34 арга хэмжээ тусгасан бөгөөд үүнээс 2017 онд 22 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд нийт 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. (Биелэлт 36,8 хувьтай)

Хөтөлбөрийн 6 дахь зорилтын хүрээнд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах” чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 21 арга хэмжээ тусгасан. Үүнээс 2017 онд 14 арга хэмжээг нь хэрэгжүүлж эхэлсэн, 2018 онд нийт 18 арга хэмжээг хэрэгжүүлээ. (Биелэлт 27,2 хувьтай)

Хөтөлбөрийн 7 дахь зорилтын хүрээнд хүрээнд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” чиглэлээр нийт 6 үйл ажиллагаа, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2017 онд 7 арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2018 онд нийт 13 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. (Биелэлт 47,7 хувьтай)

Хөтөлбөрийн 8 дахь зорилтын хүрээнд “Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах” чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 7 арга хэмжээг хэрэгжүүлж байна. (Биелэлт 37,1 хувьтай)

Хөтөлбөрийн 9 дэх зорилтын хүрээнд “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах” чиглэлээр нийт 8 үйл ажиллагаа, 17 арга хэмжээг тусгасан. (Биелэлт 8,8 хувьтай)

Хөтөлбөрийн 10 дахь зорилтын хүрээнд “Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах” чиглэлээр 10 арга хэмжээг 2017 онд эхлүүлж, 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. (Биелэлт 32,5 хувьтай)

Хөтөлбөрийн 11 дэх зорилтын хүрээнд “Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах” чиглэлээр нийт 5 үйл ажиллагаа, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2017 онд 8 арга хэмжээг эхлүүлж, 2018 онд нийт 13 арга хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан. (Биелэлт 31,5 хувьтай).



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгагдсан төсвийг жил бүр бүрэн баталж өгөх нь чухал ач холбогдолтой юм. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт 216 арга хэмжээний 205 нь буюу 94,9 хувь нь хөтөлбөрийн эхний үе шат буюу 2017-2019 онд, үүнээс 202 нь буюу 93,5 хувь нь 2018 онд хэрэгжиж эхлэхээр нийт төсвийн 57,3 хувийг хөтөлбөрийн эхний үе шатанд зарцуулахаар төлөвлөсөн. 2018 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нийт 2000,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд дараах зөрчил, дутагдлууд нийтлэг илэрлээ. Үүнд:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргах, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгөх арга хэмжээг хэрэгжүүлээгүй;
2. Зарим төрийн байгууллагууд тухайн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хөтөлбөрийн зорилтыг хангах хүрээнд төлөвлөөгүй;
3. Тухайн онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрийн огноо, нэр, тоо баримтыг тайланд дурдаагүй;
4. Судалгаа, шинжилгээ, гомдол, мэдээлэл шийдвэрлэсэн байдлын үр дүнг тайланд оруулаагүй, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж дүгнээгүй, хүрсэн үр дүнг тодорхойлоогүй;
5. Зарим байгууллагууд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн 11 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа тайлагнаагүй, зөвхөн үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд холбогдох зорилтын хүрээнд тайлан боловсруулсан;
6. Хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллагууд хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд болон бусад төрийн байгууллагын хэмжээнд тухайн арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэж тайландаа тусгаагүй;
7. Зарим үйл ажиллагааны биелэлтийн байдлыг цахим хуудаснаас танилцаж болох талаар тайланд дурдсан боловч линкийг иш татаагүй, эсвэл дурдсан мэдээлэл нь байхгүй зэргээс танилцах боломжгүй байв.
8. Үндэсний хөтөлбөрийг зорилтыг хангах чиглэгдсэн арга хэмжээг шат, дараатай төлөвлөж, хэрэгжүүлээгүй, ирүүлсэн тайланд тухайн зорилт, арга хэмжээнд хамаарахгүй мэдээллийг тусгасан.

Санал:

- I. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зүйлийн 7.1.3 /Засгийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ/-т заасныг үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөлт, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, нэгдсэн дүгнэлт өгөх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулах;
- II. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар тусгагдсан байгууллага нь хариуцсан арга хэмжээний биелэлтийг гаргахдаа тухайн чиглэлээр бусад төрийн байгууллага, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хийсэн ажлыг тайланд даа нэгтгэн тусгах;
- III. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн сан үүсгэж, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээллийг оруулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авах, тайлагналтыг явцын дунд хянах, хэрэгжилтийг эрчимжүүлэх боломжтой болсон. Иймд мэдээллийн санг хөгжүүлэх, хэрэгжүүлэгч байгууллага нэг бүрийг холбож үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг сайжруулах;
- IV. Хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой гаргаж, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлж байх;
- V. Төрийн байгууллагууд тухайн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангах хүрээнд төлөвлөж, хэрэгжилтийг хангах;
- VI. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэг дэх үе шатанд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь эхлүүлэхэд анхаарах, биелэлтийг хугацаанд нь хангаж ажиллах;
- VII. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн эхний үе шат 2019 онд дуусах бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2017, 2018 онд хэрэгжилтийн явц, биелэлт хангалтгүй, төлөвлөгөөнд тусгасан дийлэнх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн боловч үр дүнд хүрээгүй, удаашралтай байгаа учраас хөтөлбөрийн энхий үе шатанд хэрэгжүүлж дууссан байх ёстой арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай юм. Нэн ялангуяа 2018 оны үнэлгээгээр эхний үе шатанд хэрэгжиж дуусахаар төлөвлөгөөнд тусгагдсан боловч бодитой үр дүнд хүрээгүй, хэрэгжилтийн явц удааширсан, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээгүй байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулахад анхаарч, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх чухал байна. Тухайлбал,
 - 1) Авлигын эрсдэлийг үүсгэж болзошгүй төрийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод болгон, тэдгээрийг багтаасан “Ил тод мэдээллийн сан” нэгдсэн цахим хуудсыг Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудастай холбоостойгоор нээн ажиллуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, тухайн цахим хуудсанд төрийн үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээллийг байршуулж, ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс буюу тухайн цахим хуудаснаас бүх мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх (АТГ);
 - 2) Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлөх, олон шат дамжлагыг багасгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсруулах, зарим төрлийн зөвшөөрөл олгох,



хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх (ЗГХЭГ, ХЗДХЯ);

- 3) Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх (СХЗГ, ХЗДХЯ);
- 4) Стандартын тоог цөөрүүлэх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох, Олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх (СХЗГ, ХЗДХЯ);
- 5) Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулж нэвтрүүлэх (ЗГХЭГ, МХЕГ, СХЗГ, ТӨБЗГ: ХЗДХЯ, ШӨХТГ);
- 6) Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх (ХХМТГ, ЗГХЭГ, ХЗДХЯ);
- 7) Төсвийн хяналтын сонсголын журмыг боловсруулж батлуулах (СЯ);
- 8) Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох (ХЗДХЯ, ҮАГ);
- 9) Мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх (АТГ, ХЗДХЯ);
- 10) Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх (МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, ТББ);
- 11) Хууль бус нөлөөллийн хэлбэрийг оновчтой тодорхойлох (АТГ);
- 12) Хууль бус нөлөөлөл үзүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох (ЗГХЭГ);
- 13) Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх (АТГ, ЗГХЭГ);
- 14) Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, Авлигын эсрэг түншлэл /РАСИ/-ийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Авлигын эсрэг түншлэлийн гол зарчмуудыг сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх (МҮХАҮТ, МАОЭНХ, МБЗ 2017-2019)-ээр тусгасан боловч хэрэгжиж эхлээгүй;
- 15) Авлигын эсрэг түншлэлийн үйл ажиллагааг гишүүн байгууллага болон төрийн байгууллагуудын нөөц боломжийг ашиглан сурталчлах (МҮХАҮТ, МБЗ);
- 16) Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах (АТГ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ТЕГ, СХЗГ, ОӨУБЕГ);
- 17) Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх (ҮХГ, ЗГХЭГ, СЯ, АТГ);
- 18) Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах (ҮХГ, СЯ);
- 19) Олон улсын болон дотоодын бизнесийн орчин дахь авлигатай тэмцэх сайн туршлага, эрсдэлийн менежментийн стратегийг судлах, нэвтрүүлэх санаачилга өрнүүлэх (МҮХАҮТ, Гишүүн байгууллага. АТГ);

- 20) Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах (ШӨХТГ, ШСАА);
- 21) Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (ШӨХТГ, ШСАА);
- 22) Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (ШӨХТГ, ШСАА);
- 23) Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх (ШӨХТГ);
- 24) Төрийн байгууллага, албан тушаалтнаас зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлсөн, аль нэг аж ахуйн нэгжид давуу байдал олгосон шийдвэр, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах (ШӨХТГ);
- 25) Өрсөлдөөний хууль тогтоомжийг сурталчлах, шударга өрсөлдөөнийг дэмжсэн сургалтыг жил бүр зохион байгуулах (ШӨХТГ);
- 26) Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаарх эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх (ҮҮХҮЯ);
- 27) Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх (ҮҮХҮЯ);
- 28) Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах (АТГ, яам, агентлаг, аймаг, нийслэл дэх ГХУСАЗСЗ);
- 29) Нийслэлийн хэмжээнд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагын оролцоог хангах зорилтын хүрээнд “Ил тод Улаанбаатар Академи”-тай хамтран ажиллах (АТГ, нийслэлийн ЗДТГ, ГХУСАЗСЗ);
- 30) Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх (ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга);
- 31) Сонгуулийн зардлын тайлангийн хяналт, ил тод байдал, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох (ХЗДХЯ);
- 32) Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр олон нийтэд мэдээлэх (ХЗДХЯ);
- 33) Төрөөс улс төрийн намуудад үзүүлэх дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох, сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч, улс төрийн намуудыг төлөвших, санхүүгийн хувьд нөлөөнд автахгүй байх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, оновчтой арга замыг тодорхойлох (СЕХ, АТГ);
- 34) Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох, улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн болон олон нийтийн зүгээс хяналт тавих зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах (ХЗДХЯ, Улс төрийн намууд);
- 35) Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх (ХЗДХЯ, АТГ);



- 36) Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх (АТГ);
- 37) Улс төрийн намын дарга, удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын талаар олон нийтэд мэдээлэх (АТГ);
- 38) Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах; Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах (БСШУСЯ);
- 39) Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох (ХЗДХЯ, ГХЯ. АТГ);
- 40) Сэтгүүлчдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн, заналхийлсэн тохиолдолд "Нөлөөллийн мэдүүлэг" гаргах, хууль бус нөлөөлөлд хариуцлага хүлээлгэх асуудлыг судлах, санал боловсруулах (МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл, АТГ, ХЗДХЯ);
- 41) Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах (ХЗДХЯ);
- 42) Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой ажлаа ил тод мэдээлэх, гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх (ХЗДХЯ, МСНЭ, Хэвлэл мэдээллийн зөвлөл).

Авлигатай тэмцэх газар